

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2022 №04 (83)
20 дахь жилдээ

СЭТГҮҮЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Пүрэвдорж БАТБААТАР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жигжидсүрэн БОЛДБААТАР

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Галбат ГАНТӨМӨР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Думбурай МЯГМАРЦЭРЭН

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Очирхуяг ЗОРИГТ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Чойжил НЯМСҮРЭН

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Тамжид ОЮУНЧИМЭГ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Заяатхүү ТӨРМАНДАХ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХВАН И ГАБ

ДОКТОР, ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Улсын бүртгэлийн дугаар 237

ISSN 2957-4285

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Вандан-Иш АМАРСАНАА

ДОКТОР (Ph.D)

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батсүх АЛТАНСҮХ

ДОКТОР (Ph.D)

Шаравдорж АРИУНБИЛЭГ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Лувсан БАТ-ОЧИР

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Рагчаасүрэн БАЯРМАГНАЙ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Сэнгээ ГАНТУЛГА

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Амарсайхан МАНЛАЙ

ДОКТОР (Ph.D)

Жаргалсайхан МӨНХБОЛД

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Намжилдорж МӨНХЗУЛ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бат-Ерөөл МӨНХДОРЖ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бадарч НАРМАНДАХ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жутьяа НЯМДУЛАМ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батхишиг ЛХАГВАСҮРЭН

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Буриад ЛХАГВАРАГЧАА

ДОКТОР (Ph.D)

Шархүү ЧУЛУУНБАТ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батзэвэг ЭНХБОЛД

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Магмадорж ЭРДЭНЭБАЯР

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Дорж ЭНХТӨР

ДОКТОР (Ph.D)

ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Улсын онц чухал объектод үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл	Л.Бат-Очир	5
Гадаадын зарим улсад өрнөсөн өнгөт хувьсгалын үйл явц	В.Амарсанаа	11
Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийн шалтгаан, хүчин зүйл	Г.Болор-Эрдэнэ	20
Нийгмийн хөгжилд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам	Г.Баттулга	26
Зам тээврийн ослын улмаас хүний амь нас, эрүүл мэндэд учрах хохирлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээнд хийсэн дүн шинжилгээ	О.Болорцэцэг	38
Хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалж буй өнөөгийн байдал, анхаарах асуудал	С.Гүндэгмаа	49
Гэр бүлийн хүчирхийлэл хүний эрхийн зөрчил болох нь	У.Уранцэцэг	53

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Төрийн албаны шинэтгэл ба ялын бодлого	Ж.Нямдулам	64
Албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал	Б.Мөнх-Эрдэнэ	71
Авлигын гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, олон улсын туршлага	Б.Ганхуяг	81
Олон Улсын эрүүгийн эрх зүйн онолын асуудал	Б.Досжан	90

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Цагдаагийн алба хаагч тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой дуудлага, мэдээллийн дагуу авах арга хэмжээ	Б.Баянмөнх	96
--	------------	----

ШИНЖЛЭХ МАГАДЛАХУЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Монгол Улс дахь бичгийн зохиогчийг магадлах шинжилгээний өнөөгийн байдал	М.Эрдэнэжаргал	105
--	----------------	-----

ЭРДЭМТЭН, СУДЛААЧДЫН ҮЗЭЛ БОДОЛ

Төрийн албан дахь хууль зүйн хариуцлагын эрх зүйн үр дагавар	Н.Мөнхзул	112
Монгол Улс дахь өндөр насны тэтгэврийн эрх зүйн шинэчлэл, чиг хандлага	Ц.Мөнхдэлгэр	125
Программные информационные продукты как инструмент унификации и оптимизации юридических текстов	Макович Г.В	132
Төсвийн тогтвортой байдлын тусгай шаардлагын хэрэгжилт, анхаарах асуудал	С.Жанхор	136
Монгол Улс, БНХАУ-ын дээд боловсролын тогтолцоонд хийсэн дүн шинжилгээ	Ц.Түвшинбаяр	143

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТОД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

IT IS WORKING AT STATE FACILITIES CAUSES OF CRIMES AND VIOLATIONS

Л.Бат-Очир

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Bat-Ochir L

Head of the Department of Criminal Law and Criminology of the University of Internal Affairs of Mongolia, Candidate of Law, Associate Professor, Police Lieutenant Colonel

Хураангуй: Монгол Улсын онц чухал объектод үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар түүнд нөлөөлж буй шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, цаашид анхаарах асуудлын талаар тодорхой санал дэвшүүлсэн.

Abstract: Analyzing the statistical data of crimes and violations committed in the most important objects of Mongolia, the causes and conditions affecting them were determined, and specific suggestions were made about the issues to be considered in the future.

Түлхүүр үгс: Аюулгүй байдал, гэмт хэрэг, зөрчил, онц чухал объект, хамгаалалтын бүс, хорлон саатуулах, хорлон сүйтгэх, шалтгаан, нөхцөл.

Keywords: Security, crime, violation, critical objects, security zone, causality, sabotage, causes, conditions.

Монгол Улсын Дотоодын цэргийн байгууллага нь Монгол Улсын Засгийн газраас тогтоосон онцгой ач холбогдол бүхий байгууллага, үйлдвэр, барилга байгууламж буюу улсын онц чухал объектын хэвийн ажиллагааг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг шалгах, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм, журмыг сахиулах, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах болон хуулиар тогтоосон бусад үүргийг биелүүлэх бие даасан үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Дотоодын цэргийн байгууллага нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх буюу улсын онц чухал объектын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах нь Үндэсний аюулгүй байдлын тулгуур асуудлын нэг юм. Улсын онц чухал объектод үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх нь, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Тийм учраас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь Дотоодын цэргийн байгууллагын үндсэн үүрэг гэж үзэх үндэстэй¹.

Сүүлийн үед улсын онц чухал объектод хууль бусаар нэвтрэх, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших, үзэл бодлоо илэрхийлэх, иргэний нийгмийн хөдөлгөөн нэрээр ард нийтийг хууль бус үйлдэлд турхирах, уриалах, жагсаал цуглааныг зохион байгуулах мэтээр эмх замбараагүй байдлыг бий болгох, онц чухал объектод нэвтрэхийг завдах үйлдэл багагүй гарах боллоо. Ийм учраас

¹ Дотоодын цэргийн тухай хуулийн 11.1 дүгээр зүйлийн 6, 12.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг

нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах болон хуулиар тогтоосон бусад үүргийг биелүүлэх явцад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах шаардлага үүсэж байна.


Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил гэдэг нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч байгаа цогцолбор арга хэмжээг хэлнэ².

Энэхүү судалгааны ажлын зорилго нь сүүлийн 3 жилийн байдлаар улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж улсын онц чухал объектод үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тодорхойлохыг зорьсон. Нийт зөрчлийн нөхцөл байдлаас дүгнэхэд 6 төрлийн зөрчил нийтлэг үйлдэгдэж байна. Үүнд:

1. Бичиг баримтын зөрчил
2. Объектод зориулалтын бус газраар нэвтрэхийг оролдсон
3. Объектоос хулгай хийсэн
4. Объектод архидан согтуурсан
5. Объектод тогтоосон дэг журам зөрчсөн
6. Албан хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн зэрэг багтана.

Зөвхөн бичиг баримтын зөрчил сүүлийн 3 жилийн байдлаар өссөн үзүүлэлттэй байна. 2020 онд объектод тогтоосон дэг журам зөрчсөн үйлдэл давамгайлж байсан бол 2021, 2022 онд бичиг баримтын зөрчил хамгийн их үйлдэгдсэн байна³. Нийт гэмт хэрэг, зөрчлийн дийлэнх нь дээр дурдсан зөрчлүүд эзэлж байна. Тухайлбал, улсын онц чухал объект руу зохих зөвшөөрөлгүй, хуурамч бичиг баримтаар, эсвэл эрх бүхий этгээдийн бичиг баримтаар нэвтрэх үйлдлүүд бүртгэгдэх болсон нь бичиг баримтын шалгалтыг эрчимжүүлэх, шалгах ажиллагаанд техник технологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх шаардлагатай болохыг илтгэнэ.

График №1.




Мөн онц чухал объектын бүс рүү иргэд хууль бусаар нэвтрэх архидан согтуурах явдал тогтмол гарч байна. Энэ нь дулааны улиралд ялангуяа цэвэр усны хамгаалалт бүхий бүсэд цагдаагийн хяналт байхгүй, иргэдийн хөл хөдөлгөөн багатай орчинд, сул чөлөөтэй согтууруулах ундаа хэрэглэх, тэндээ унтаж амрах зорилгоор объект руу, санаатайгаар явган болон автомашинтай нэвтрэх үйлдэл хийж байна. Гэр хорооллын орчмын хамгаалалтын бүс рүү нэвтрэх, амрах, зугаалах, чөлөөт цагаа

² 1994 оны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль

³ Дотоодын цэргийн мэдээ. УБ. 2022. 6 дахь тал


өнгөрүүлэх зорилгоор ч нэвтрэх тохиолдол байгааг нь цаашид анхаарч тодорхой хязгаарлалт хийхгүй бол шинэ төрлийн гэмт хэрэг, зөрчил ч үйлдэгдэхийг үгүйсгэхгүй.
График №2.



2020 онд нийт зөрчлийн дүнд бичиг баримтын зөрчил 31 хувийг эзэлж байсан бол 2021 онд 47 хувийг, 2022 онд 79 хувь болж өссөн байна. 2022 онд үйлдэгдсэн бичиг баримтын зөрчил нь өнгөрсөн оныхоос 32 хувиар өссөн нь анхаарал татаж байна⁴. Энэ нь тухайн объектод үйл ажиллагаа явуулж буй байгууллагын бичиг, баримтын шинэчлэл, үйл ажиллагааны журам, дүрмийн зохицуулалт, албан хаагчдын хувийн хариуцлага, хандлага, ухамсар соёлтой холбоотой.


Албан байгууллагын үнэмлэхийн хугацаа дууссан, шинэчлээгүй, шинээр ажилд орсон ажилчдад заавар зөвлөгөө өгдөггүй, нэвтрэх зөвшөөрлийн төрөл ихтэй, зөвшөөрөл авах шат дамжлага их байдагтай холбоотой байж болох юм. Ийм нөхцөлд улсын онц чухал объектод нэвтэрч хорлон сүйтгэх болон хорлон саатуулах ажиллагаа явуулах, устгах, гэмтээх, дэлбэлэх, шатаах үйлдэл хийхийг үгүйсгэхгүй.

График №3.



⁴ Дотоодын цэргийн мэдээ. УБ. 2022. 8 дахь тал

График №4.




Мөн энэ төрлийн зөрчлийг ямар субъект үйлдэгдэж буйг тогтоож дүгнэлт хийх нь чухал. Өөрөөр хэлбэл субъектийн онцлогийг тодорхойлсны үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх арга замыг төлөвлөх шаардлагатай.

Улсын онц чухал объектод харуулын үүрэг гүйцэтгэж буй албан хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлдэггүй, эсэргүүцдэг, доромжилж, басамжилдаг, үл биелүүлэх үйлдэл гарах боллоо. Энэ нь нэг талаар иргэдийн эрх зүйн ухамсар, ёс суртахуун, зан төлөв, соёлын түвшинтэй холбоотой, нөгөө талаас албан хаагч шаардлагаа хуулийн хүрээнд тавих, шаардах, харилцааны соёл, хандлагатай холбоотой.

Хэсэгчилсэн судалгаанаас үзэхэд⁵, улсын онц чухал объектод ажиллаж буй төрийн болон бусад албан хаагчид өөрсдөө тогтоосон дэглэм зөрчих, архиан согтуурах, хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх, онц чухал объектоос хулгайлах үйлдэл хийх явдал буурахгүй байгаа нь Дотоодын цэргийн байгууллагын хамгаалалтад буй объектод ажил үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдад чиглэсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах хэрэгцээ, шаардлага байгааг харуулна.

График №5.



Бичиг баримтын зөрчил 05 дугаар анги, 810 дугаар анги, багахангай тусгай салбар дээр ихэвчлэн илэрдэг байна.

График №6.

⁵ Улсын онц чухал объектод үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. УБ. 2022. 11 дэх тал

2020 онд анги салбарууд зөрчлийг шийдвэрлэсэн байдал




График №7.

2021 онд анги салбарууд зөрчлийг шийдвэрлэсэн байдал





График №8.

2022 онд анги салбарууд зөрчлийг шийдвэрлэсэн байдал



Анги, салбаруудыг зөрчлийг шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл, Дорнод тусгай салбар, 05 дугаар анги, 810-р тусгай салбар, Дархан, Дорнод, Багахангай зэрэг тусгай салбарууд ихэвчлэн байгууллагад нь мэдэгдэж арга хэмжээ авдаг бол 805-р анги ихэвчлэн харьяалах дүүргийн цагдаагийн байгууллагад шилжүүлж хэргийг шийдвэрлүүлсэн байна. Ижил төстэй гэмт хэрэг, зөрчлийг өөр чиг үүрэг бүхий байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлж байгаа нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлын мөн чанар алдагдах, хэлбэр төдий хандах, гэмт хэрэг үйлдсэн хүн ял завших, эсвэл хүний эрх зөрчигдөх нөхцөл үүснэ.

Дүгнэлт

Дотоодын цэрэг судлалын салбарыг хөгжүүлэх шаардлага байгаа болох нь дээрх судалгааны дүнгээс харагдаж байна. Энэ салбарт үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд шинжлэх ухааны үүднээс дүн шинжилгээ хийж, шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох шаардлагатай байна.

Санал

- Дотоодын цэргийн албан хаагчийн харьяалан шийдвэрлэх зөрчлүүдийг төрөлжүүлэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Дотоодын цэргийн байгууллагын хамгаалалтад буй объектод үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдад чиглэсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах;
- Улсын онц чухал объектод үүрэг гүйцэтгэх чиг үүрэг бүхий албан хаагчдын гэмт хэрэгтэй тэмцэх талаарх мэдлэг, ур чадвар, хандлагыг дээшлүүлэх талаар үе шаттай арга хэмжээ зохион байгуулах;
- Ажилчдын хувийн бичиг баримт, зөвшөөрлийг тогтмол шинэчилж, албажуулах, нэвтрэх зөвшөөрлийн төрлийг тодорхой болгох;
- Улсын онц чухал объектын харуул, хамгаалалтын үйл ажиллагааг орчин үеийн техник, технологиор хангах, алба хаагчдыг энэ чиглэлээр мэргэшүүлэх;
- Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн бүтцэд Дотоодын цэрэг судлалын төв байгуулж, энэ чиглэлийн судалгааг дагнан хийх зэрэг болно.

Ашигласан материал

Хууль тогтоомж

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. 1994
- Дотоодын цэргийн тухай хууль. 2017

Судалгаа, тайлан

- Дотоодын цэргийн мэдээ. УБ. 2022
- Улсын онц чухал объектод үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. УБ. 2022

ГАДААДЫН ЗАРИМ УЛСАД ӨРНӨСӨН ӨНГӨТ ХУВЬСГАЛЫН ҮЙЛ ЯВЦ

IN SOME FOREIGN COUNTRIES SIGNS OF COLOR REVOLUTION

В.Амарсанаа

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч

Amarsanaa V.

Doctor (Ph.D) of Criminal Law and Criminology Department of the Police School of Internal Affairs University, Police Major

Хураангуй: Гадаадын зарим улсад (Гүрж, Серби) өрнөж, төрийн эрхийг өөрчлөх хүртэл үр дүнд хүрч байсан өнгөт хувьсгалын үйл явцын талаар судалж, бодит нөхцөл байдлыг нээн илрүүлэх, дүгнэлт гаргахыг зорилго.

Abstract: The article aims to examine in a specific sequence the processes of color revolutions in some foreign countries, specifically Georgia and Serbia, and to uncover the real situation and draw conclusions.

Түлхүүр үгс: Америкийн Нэгдсэн Улс, бульдозерын хувьсгал, өнгөт хувьсгал, сарнайн хувьсгал, эмх замбараагүй байдал.

Keywords: United States of America, bulldozer revolution, color revolution, rose revolution, chaos.

Иргэдийн эмх замбараагүй байдал бий болох шалтгаан нь нийгэм, эдийн засаг, улс төрийн шинжтэй стресс, бухимдал удаанаар хуримтлагдсаны улмаас нийгмийн давалгаагаар илрэн гарах явдал юм. Түүхийн бүхий л мөчлөгт эмх замбараагүй байдал нь нийгэм, соёлын том өөрчлөлтийг бий болгодог. Жишээлбэл, 1848 онд Францын иргэдийн засаглалд сэтгэл ханамжгүй байдлаас үүссэн эмх замбараагүй байдал даамжирсаар Европ болон Латин Америкийн ихэнх хэсгийг хамарсан бол 1960 онд Америкийн Нэгдсэн Улс (Цаашид – АНУ гэх)-ын хотуудад арьс өнгөөр ялгаварлахын эсрэг хөдөлгөөн ихээхэн газар авсан. Мөн 1989 онд Төв ба Зүүн Европын орнуудад коммунизмын эсрэг тэмцэл нь “Берлины хананы уналт” бэлэг тэмдэг дор өрнөсөн байна. Харин сүүлийн үед Арабын ертөнцөд нийгмийн тогтвортой бус байдал ихсэж буй явдал нь Тунис болон Египетэд хүч үл хэрэглэх замаар өрнөж, засгийн дарангуйллыг түлхэн унагаасан тэмцлийн хөдөлгөөнөөс эхлээд, Ливи улсад өргөн хүрээг хамарсан иргэний дайн болон өөрчлөгдсөн эсэргүүцлийн хөдөлгөөнүүдийг нэрлэж болох юм⁶.

“Арабын хавар” хэмээх өнгөт хувьсгал нь хамгийн их хохирол дагуулж, арабын хүрээний 20 гаруй улсыг засаглалын доройтолд оруулан, Ирак, Ливи зэрэг 10 орчим улс төр засаггүй, хуваагдмал иргэний дайны нөхцөл байдалд орсон байна. Уг хувьсгалыг АНУ-ын тусгай албад зохион байгуулсан гэх мэдээлэл түгээмэл байдаг. АНУ нь бусад улсын дотоод хэрэгт хэрхэн түрэмгийлж оролцсон талаар судлаач У.Блумын гаргасан тооцооноос харж болох юм.

Сүүлийн 20 жилийн хугацаанд дэлхийд XX зууны туршид өрнөснөөс их хэмжээний хувьсгал өрнөсөн статистик мэдээ байна. “Алтан зул цэцгийн”, “Бульдозерын”, “Сарнайн” гэх нэршилтэй хувьсгалуудыг өргөн хүрээг хамарсан байдлаар нь жишээ авч болох юм. XX зууны сүүлчээр өрнөх болсон хувьсгалын шинжтэй эсэргүүцэл, тэмцэл, нийтийг хамарсан үймээн, самууныг эс тооцвол XXI зууны эхний хорин жилийн хугацаанд дэлхий дахинд өнгөт хувьсгалын оргил үе

⁶ Dan Braha. A Universal Model of Global Civil Unrest. New England Complex Systems Institute, 238 Main St., Suite 319, Cambridge, MA 02142, USA. University of Massachusetts Dartmouth, Dartmouth, MA 02747, USA (Dated: May 2012).

байсан гэхэд хилсдэхгүй. Тухайлбал, 1989 онд Бүгд Найрамдах Чех Улсад өрнөсөн “Хамба хилэн хувьсгал”, Хятадын Тяньаньмэний талбайд болсон их хядлага нь XX зууны сүүлээр дэгдэж, ихээхэн хор, хохирол учруулсан байна. Үүнтэй төстэй ажиллагаа Зүүн Европын зарим оронд гарч байжээ. Үүнээс гадна XXI зуун гарсаар олон тооны өнгөт хувьсгал өрнөх болсон бөгөөд, тэдгээрээс хавьгүй өргөн хүрээг хамарсан хувьсгалыг он цагийн дарааллаар авч үзвэл:

- 2000 онд Сербид өрнөсөн “Бульдозерийн хувьсгал”;
- 2003 оны Гүржид өрнөсөн “Сарнайн хувьсгал”;
- 2003-2005 онд Иракт өрнөсөн “Улаан ягаан” хувьсгал;
- 2004-2005 оны зааг дээр Украинд өрнөсөн “Улбар шар хувьсгал”;
- 2005 онд Кыргызстанд өрнөсөн “Алтанзулын хувьсгал”;
- 2005 онд Ливанд өрнөсөн “Хуш модны хувьсгал”;
- 2006 онд Беларусь улсад өрнөсөн хувьсгал;
- 2009 онд Молдавт өрнөсөн хувьсгал;
- 2010 онд Кыргызстанд өрнөсөн 2 дахь хувьсгал;
- 2014 оны “Евромайдан Европын холбоог сонгох Украины сонголт” зэргийг тус

тус нэрлэж болох юм.

Хүснэгт №1 Олон улсад 2000 оноос хойш өрнөсөн өнгөт хувьсгалын жагсаалт⁷

д/д	Улсын нэр	Өнгөт хувьсгалын оноосон нэр	Он
1.	Югослав	Бульдозер	2000
2.	Гүрж	Сарнай	2003
3.	Украин	Улбар шар	2004
4.	Ирак	Ягаан	2005
5.	Кыргызстан	Алтанзул	2005
6.	Ливан	Арцат мод	2005
7.	Кувейт	Цэнхэр	2005
8.	Беларусь	Жинс	2006
9.	Мяньмар	Сафрон лам нар	2007
10.	Иран	Ногоон	2009
11.	Молдав	Усан үзэм	2009
12.	Кыргызстан	Тарвас	2010
13.	Тунис	Жасмин, Арабын хавар	2010
14.	Египет	Цагаан, Арабын хавар	2011
15.	Йемен	Кофе, Арабын хавар	2011
16.	БНХАУ	Жасмин цэцэг	2011
17.	ОХУ	Цас	2011
18.	Украин	Майдан	2014
19.	Македон	Өнгөлөг	2016
20.	Армен	Хамба хилэн	2018
21.	Ливан	Х сар	2019
22.	Болив	Питита	2019
23.	Беларус	Шаахай	2020

Мөн Узбекистанд бослого гаргахыг завдсан, Азербайжанд төрийн эргэлт хийх бэлтгэлийг илчилсэн зэрэг тогтворгүй байдлыг бий болгох урсгал нь (2003-2005) онд гэнэтийн байгаагүй гэдэг. Үнэхээр сүүлийн хэдэн арав гаруй жилийн хугацаанд улс төрийн хямралын цикл нь Ойрхи Дорнод, Магриб, Хятад, Бразилд ч болж байсан.

Дэлхийн хэмжээнд ардчиллыг төлөвшүүлэн хөгжүүлэх бодлогыг АНУ-ын үе үеийн ерөнхийлөгч нар өнөөг хүртэл хэрэгжүүлсээр ирсэн байна. Дэлхийн хэмжээнд ноёрхлоо бататгах зорилгоор АНУ нь бусад улсын дотоод хэрэгт хэрхэн түрэмгийлж оролцсон талаар Америкийн судлаач Уильям Блумын тооцоогоор:

⁷ Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны танилцуулга. 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр.

- Гадаад улсын засгийн эрх мэдлийг унагах 50 гаруй оролдлого хийсэн. (Эдгээр улсын төр засгийн тэргүүн нь ардчилсан сонгуулиар сонгогдсон байжээ);
- 30 гаруй улсын ардчилсан сонгуульд хөндлөнгөөс бүдүүлгээр оролцсон;
- Гадаад улсын төр, засгийн удирдагчийн амь насанд 50 гаруй удаа халдсан;
- 30 гаруй улсын хүн амыг бөмбөгдсөн;
- 20 гаруй улсын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг нухчин дарахад хөндлөнгөөс оролцсон⁸ зэрэг тоон мэдээллийг урьд тэмдэглэж байсан билээ.

Мөн өөр нэгэн судлаачийн тэмдэглэснээр Вашингтоны дэмжлэгтэйгээр Югославын дэглэмийг 1999 онд унагаснаас хойш АНУ дэлхийн 64 улсад засгийн эрхийг хууль бусаар булаан авахад оролцсон байна.

Сербид өрнөсөн “Бульдозерийн хувьсгал”-ын талаар: XX зууны 80-аад он хүртэл хугацаанд үнэн алдартны, исламын болон бусад төрлийн шашин шүтлэгтэй хорь гаруй үндэс, угсаатныг багтаасан, зургаан тусгаар улс, өөртөө засах хоёр улсаас бүрдсэн Холбооны Бүгд Найрамдах Социалист Югослав Улсад нөхцөл байдал тайван байжээ. Гэтэл 1991 оны зунаас эхлээд холбооны улсууд задарч эхэлсэн байна. Словени, Хорват улсууд холбооны бүрэлдэхүүнээс гарах болсон талаараа 6 дугаар сард мэдэгдсэн бол Македон улс 9 дүгээр сард тусгаар тогтнолоо зарлаж, 1992 оны 3 дугаар сард Босни ба Херцеговина улс тусгаар тогтносон байна. Үүний үр дүнд Македон болон Словени улсууд ямар ч хүндрэлгүйгээр тусгаар тогтнож чадсан бол Хорват болон Босни ба Херцеговина улсуудад иргэний дайн дэгдсэн байна.

Холбооны Бүгд Найрамдах Социалист Югослав улсаас зөвхөн Серб болон Черногор гэх хоёр улс үлдэж, 1992 онд Холбооны Бүгд Найрамдах Югослав улсыг үүсгэсэн байна. Тухайн үед төрийг Сербид үндэстэй болох Слободан Милошевич удирдаж байсан юм. Энэ үед хүйтэн дайнд ялалт байгуулаад байсан АНУ-ын хараанаас Холбооны Бүгд Найрамдах Югослав Улс гарч чадсангүй.

АНУ болон түүний Европын холбоотнууд болон НАТО-гийн улсууд Югославын дотоод үйл явдалд идэвхтэй оролцох болжээ. Бүр 1994 оны 2 дугаар сард АНУ-ын ерөнхийлөгч Б.Клинтон Тагнуулын төв газарт С.Милошевичийг засгийн эрхээс түлхэн унагаах нууц ажиллагааг эхлүүлэх заавар өгч байсан ажээ. Цагаан Ордоноос С.Милошевичийн засаглалыг түлхэн унагаах ажиллагааг Югославын ард иргэдийн сэтгэл ханамжгүй байдлаас үүссэн мэтээр харагдуулах санаархал нуугдаж байсан хэдий ч, үнэн хэрэгтэй АНУ улс төрийн дайны бүхий л технологийг хэрэгжүүлж байжээ⁹.

Боснид өрнөсөн дайн 1995 оны намар дуусав. Сербийн бараг бүхий л фронтод хохирол амссан Милошевичийн талынхан энх тайвны хэлэлцээрийг зөвшөөрөхөд хүрсэн байна. Ингээд 1995 оны 11 дүгээр сард Оросын төлөөлөгчдийн оролцоотойгоор АНУ болон Европын Холбооны лидерүүд, Сербид, Хорват, Босни ба Херцеговина улсууд Боснийн мөргөлдөөнийг энх тайван замаар зохицуулах тухай хэлэлцээрт гарын үсэг зурлаа. Хэлэлцээрт зааснаар Боснийн Сербид өөрийн хяналтад 70 хувь нь байсан газар нутгийнхаа ердөө 49 хувийг авсан байна. НҮБ-ын Аюулгүй Зөвлөлийн 1031 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хянахаар далан мянган хүнээс бүрдсэн Олон Улсын зэвсэгт хүчнийг Сербийн нутагт оруулсан бөгөөд, түүний хорин мянгийг АНУ-ын арми бүрдүүлж байжээ. Сербийн талаас хэлэлцээрт С.Милошевич гарын үсэг зурсан байна. Тухайн үед С.Милошевич олон нийтийн дэмжлэг авч байсан учир АНУ-аас түүний дэглэмийг шахан унагаах ажлыг эрчимжүүлж байв.

1996 оны эцсээр явагдсан сонгуульд ардчилсан намаас нэр дэвшсэн С.Милошевич 48.5 хувийн санал авсан боловч, эсэргүүцлийн хөдөлгөөн бүхий л томоохон хотуудад хүчээ авсан байна. Энэхүү сонгуулийн үр дүнг Сонгуулийн төв комисс хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд, 1996-1997 онд шилжих өвөл нийтийг хамарсан

⁸ Аюулгүй байдал судлалын хүрээлэн. Интернет холбоос: <https://niss.gov.mn/archives/1221>.

⁹ Наумов А.О. Бульдозерная революция в Сербии 2000 года: Технологии смены политического режима. Вестник СПбГУ. Сер. 6. 2016. Вып. 4. С. 120.

эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөсөн бөгөөд, үндсэн хэсгийг оюутнууд бүрдүүлж байжээ. Эсэргүүцлийн хөдөлгөөнд оролцогчдын тоо 1997 оны 1 дүгээр сар гэхэд гурван зуун мянганд хүрсэн байна. Эсэргүүцлийн хөдөлгөөнийг барууны нийгэмлэгүүд мэдээллийн сүлжээгээр идэвхтэй дэмжсэн байна. С.Милошевичийн зүгээс буулт хийхээс өөр аргагүй байжээ. 1996-1997 онд өрнөсөн энэхүү эсэргүүцлийн хөдөлгөөн нь 2000 онд өрнөсөн бульдозерын хувьсгалын сургуулилт болсон гэж үзэх хүмүүс их байдаг ажээ.

Хэдийгээр Сербийн газар нутгийн түүхэн чухал хэсгийг бусдад алдсан боловч, С.Милошевич засгийн эрхэнд суусан хэвээр байв. Үнэн хэрэгтээ АНУ болон түүний холбоотнууд Сербийн дэглэмийг хүч хэрэглэх замаар унагаах боломжтой болохыг мэдэж байжээ. Гэвч зэвсгийн оролцоотой явагдсан хөдөлгөөнүүд хүссэн үр дүнд хүргээгүй учир 1999 онд С.Милошевичийг түлхэн унагаах ажиллагааг зөөлөн хүчний технологид суурилсан, хүч үл хэрэглэх аргаар явуулах хэлбэрт шилжсэн байна.

С.Милошевичийн засгийг унагаах ажиллагаанд албаны хүмүүс болон арми болон цагдаагийн өндөр албан тушаалтнуудыг татан оролцуулах болсноос гадна, С.Милошевичтой эн тэнцэхүйц нэр хүндтэй хэн нэгнийг түүний эсрэг тэмцэлд оролцуулах ажиллагаа байв. Харвардын профессор, Сербийн асуудлаарх мэргэжилтэн Д.Шон 1999 оны намар Будапешт хотноо өөрийн биеэр ирж, Сербийн эсэргүүцлийн хөдөлгөөний улс төрчидтэй уулзаж, С.Милошевичийн эсрэг нэр дэвшүүлэх хүнийг Коштуницаар сонгох санал тавьсан байна. Учир нь Коштуницын сөрөг рейтинг 29 хувь, эерэг рейтинг 49 хувьтай байжээ.

Барууны улс төрийн технологчдийн санаархаж буйгаар Коштуница Югославын ерөнхийлөгч болж, З.Жинджич ерөнхий сайдаар томилогдох шаардлагатай байв. Энэ үеэс С.Милошевичийн засгийн эсрэг мэдээллийн хүчтэй дайралт эхэлж, мянгаад идэвхтнийг цуглуулан сургаж эхэлсэн байна. Дээр дурдсанчлан, эсэргүүцэгчдийн үндсэн хэсгийн 1998 онд тусгай бэлтгэгдсэн оюутнуудаас бүрдсэн “Отпор” гэх нэртэй бүлгэм эзэлж байжээ. Эсэргүүцлийн хөдөлгөөнд тусгай бэлтгэгдсэн эдгээр оюутнууд, цагдаагийн байгууллагаас ирэх дарамт, шахалт, баривчилгаа болон хүч хэрэглэх ажиллагаа зэргээс шантралгүй, эцсийн ялалтад хүрэх итгэлтэй байлаа.

“Отпор” бүлгэмийн санаачлагаар Сербийн хоёр дахь том хот Нови Садад Ж.Шарпын “Дарангуйллаас ардчилал руу” номыг хэдэн мянгаар нь хэвлэн гаргаж, үнэ төлбөргүй тараах ажил явагджээ. 1999 оны зунаас эхлэн “Отпор” бүлгэмийг гадаадаас идэвхтэйгээр санхүүжүүлж эхэлжээ. Эсэргүүцлийн хөдөлгөөний идэвхтнүүдийг хүч үл хэрэглэх тэмцэлд сургах ажиллагааг түлхүү явуулсан байна. 2000 оны эхээр Будапешт хотноо эсэргүүцлийн хөдөлгөөний идэвхтнүүдтэй АНУ-ын шилдэг мэргэжилтнүүдийн (хүч үл хэрэглэх тэмцлийн мэргэжилтэн) нэг болох Р.Хелви өөрийн биеэр уулзаж, “Отпор” бүлгэмийн гишүүдэд С.Милошевичийн дэглэмийн эсрэг тактик, стратегийн аргыг зааварлах болсон байна¹⁰. Р.Хелвийн удирдлага дор “Отпор” бүлгэм Ж.Шарпын бичсэн “Хүч үл хэрэглэх тэмцлийн 198 арга”-д суралцаж, 2000 гэхэд үндсэндээ туршлагатай, нэгдмэл, олныг хамарсан бүлгэм болон тэлсэн байна.

С.Милошевич энэ үед өөрийн алдар хүндэд дулдуйдан улс төрийн хавьгүй зоригтой алхам хийж, 2000 оны 7 дугаар сард Үндсэн хуульд хэд хэдэн өөрчлөлт оруулсан байна. Үүнд: ерөнхийлөгчийг парламентаар сонгох журмыг өөрчилж, бүх нийтийн шууд сонгуулиар сонгодог болгосон байна. Хэдийгээр С.Милошевичийн төр барих хугацаа 2001 онд дуусгавар болох байсан ч, тэрээр сонгуулийн хугацааг 2000 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр зохион явуулах тухай зарлиг гаргасан байна. Өөрөөр хэлбэл, тэрээр өөрийн ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас нэг жилийн өмнө дараагийн сонгууль явуулах зарлиг гаргасан юм.

Энэ мөчөөс эхлээд С.Милошевичийн засгийг түлхэн унагаах АНУ-ын оролцоотой эцсийн, шийдвэрлэх тэмцлийн хөдөлгөөн эхэлсэн бөгөөд, “Отпор” бүлгэм

¹⁰ Наумов А.О. Бульдозерная революция в Сербии 2000 года: Технологии смены политического режима. Вестник СПбГУ. Сер. 6. 2016. Вып. 4. С. 127.

хүчийг хоёр хэсэгт хувааж, “Явж сонгуулиа өг!”, “Тэр бэлэн” гэсэн хоёр кампанит ажил явуулсан бөгөөд, эхний хэсэг нь “Цаг нь ирлээ” гэх уриан дор нэгдэж, 18-27 насны залуусыг олноор нь эсэргүүцэлд оролцуулсан байна.

“Отпор” бүлгэм төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр Сербийн 60 орчим хотод рок тоглолт зохион байгуулж, 10 орчим оршин суугчдыг хамруулсан байна. Тоглолтын үеэр хүрэлцэн ирсэн хүмүүст “Отпор” бүлгэмийн бэлгэ тэмдэг бүхий богино ханцуйтай цамц болон тухайн үед хит болоод байсан Югославын дуучин Ж.Балашевичийн дуулсан “Жить свободно” буюу “Амьдрах эрх чөлөөтэй” дууны хуурцаг зэргийг үнэгүй тараах ажиллагаа явагджээ.

Харин хоёрдугаар хэсэг (Он готов) нь хүчний байгууллагын анхаарлыг өөртөө татаж, ерөнхийлөгчийн талынхныг ёс суртахуунгүй гэж харагдуулах, улмаар шантраах ажлыг зохион байгуулж байв.

Ингээд 2000 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр Югославт ерөнхийлөгчийн болон парламентын сонгууль эхэлжээ. Сонгууль эхлэхтэй зэрэгцэн АНУ-аас Сербийн төр баригчдыг сонгуулийн үйл ажиллагааг хуурамчаар явуулсан гэх утгатай зүйлсийг холбоо мэдээллийн хэрэгслээр цацсан байна. Энэхүү мэдээлэл нь дэлхий нийтээр цацагдах болсон бөгөөд, Барууны зүгээс цэрэг, улс төрийн нөлөөлөл хүчээ авав. НАТО-ийн зүгээс цэргийн сургуулилтыг Сербийн хөрш орнууд болох Болгор, Румынд явуулж эхлэв. Мөн Их Британы Гадаад хэргийн сайд Р.Кук олон нийтийн холбоо, мэдээллийн хэрэгслээр “НАТО-ийн цэргүүд дэргэд чинь үргэлж байгаа болохыг мартаж болохгүй”¹¹ гэсэн мэдэгдэл хийжээ.

9 дүгээр сарын 24-ний өдрийн сонгуулийн эхний шатанд В.Коштуница нийт сонгогчдын 52 хувийн санал авсан бол С.Милошевич ердөө 33 хувийн санал авсан байна. Сонгуулийн ерөнхий хорооноос эхний шатны сонгуулиар нэр дэвшигчдийн аль нь ч сонгуульд ялалт байгуулах хэмжээний 50 хувийн санал аваагүй гэх үндэслэлээр дараагийн шатыг явуулахаар тогтов. 10 дугаар сарын 03-наас 04-ний хооронд сонгуулийн эцсийн шийдвэр гарсан бөгөөд, В.Коштуница 48.22, С.Милошевич 40.25 хувийн санал авчээ. Хоёрдахь шат 10 дугаар сарын 08-ны өдөр явагдах байсан боловч, В.Коштуницийн талаас “эхний санал хураалтын дүнгээр үнэмлэхүй санал авч ялалт байгуулсан учир дараагийн шатанд оролцохгүй” гэж мэдэгдэв. Цаг хугацааг жаахан ухрааж үзвэл, эсэргүүцлийн хөдөлгөөний удирдагчид 2000 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Белград хотноо нууц хуралдаан зохион байгуулж, С.Милошевичийн эсрэг хувьсгал хийж, түүнийг засгийн эрхээс түлхэн унагаах стратеги гарган, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсгэх зорилгоор Белград хотод бүх ард түмний марш хийж, хууль сахиулагчдын зүгээс зэвсэг хэрэглэсэн тохиолдолд, хариу зэвсэгт мөргөлдөөн хийхээр бүрэн шийдсэн байна.

2000 оны 10 дугаар сарын эхээр Югославын цэргийн тагнуулын байгууллагын дээд албан тушаалтнууд НАТО-ийн талын хүмүүстэй уулзаж, Сербийн талаас төрийн эргэлт хийгдвэл цэрэг, зэвсгийн хүч хэрэглэхгүй гэдгээ илэрхийлжээ. Өөрөөр хэлбэл, эсэргүүцлийн хөдөлгөөн өрнүүлэгчдийн зүгээс нийтийг хамарсан бослого, үймээн дэгдээсэн тохиолдолд, Сербийн зүгээс цэрэг, зэвсэг хөдөлгөхгүй гэсэн үг юм.

2000 оны 10 дугаар сарын 05-ны өглөө Белград хотруу чиглэсэн арван мянган хүн, 52 ширхэг автобус, 230 ширхэг ачааны машин, хэдэн зуун автомашинаас бүрдсэн 65 километр үргэлжилсэн маш том хэмжээний жагсаал болжээ. Зарим гэрчүүд “Югославын гудамжуудаар нийт таван зуун мянга орчим хүн жагссан” гэж ярьдаг байна. С.Милошевич ерөнхийлөгчийн хувьд эсэргүүцлийн жагсаалыг цагдаа, цэргийн хүчээр таслан зогсоохоор тооцоолсон боловч, хүчний байгууллагын зүгээс түүний тушаалыг огт гүйцэтгээгүй байна. Ингээд босогчид парламентын байранд тулан ирээд, үндсэн хүч бүрэлдэхийг хүлээлгүйгээр бульдозерын тусламжтайгаар дотогш нэвтрэн орж, Сербийн тугыг гартаа атгав.

Энэхүү бульдозер нь фермерч Л.Иокичийн эзэмшлийнх бөгөөд, тэрээр өөрийн элс, цементийн бизнес С.Милошевичийн удирдсан авилгын засгийн газраас болж

¹¹ Мөн тэнд. С. 130.

дампурсан гэж бүрнээ итгэдэг нэгэн байжээ. Ингээд 2000 оны Сербийн хувьсгал “Бульдозерийн хувьсгал” гэж нэрлэгдэх болов. Парламентын байрыг хүчээр эзэлсэн согтуу босогчид цааш хөдөлж, Улсын радио телевизийн редакцийн байранд халдах үед Л.Иокичийн бульдозер оролцсон байна.

Дан ганц Дотоод хэргийн яамны хүчээр бослогыг зогсоох боломжгүй гэдгийг ойлгосон С.Милошевич Ерөнхий штабын генерал Павковичед “Төрийн бэлгэдэл шатлаа” арга хэмжээ ав гэхэд, Павкович хариуд нь “Шатсаан, гэхдээ хохирогч алга” гэж хэлсэн байна. Ингээд үндсэндээ Сербийн хүчний байгууллага бүхэлдээ С.Милошевичийн удирдлагаас гарсан учир эсэргүүцлийн хөдөлгөөн эцсийн зорилгодоо бараг хүрчээ.

10 дугаар сарын 06-ны орой С.Милошевич, А.Коштуницатай хийсэн уулзалтын дараа үндэсний телевизээр “сонгуульд ялагдах хүлээсэн” гэж мэдэгдэв.

Тэгэхээр, 2000 онд Сербид өрнөсөн бульдозерын хувьсгал амжилттай өрнөж, засгийн эрхийг өөрчлөхөд АНУ болон түүний холбоотнуудын зүгээс гаргасан эдийн засгийн, цэрэг улс төрийн болон мэдээллийн дэмжлэг шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн байна. Америкийн ул төр судлаач Г.Элих “2000 онд Сербид болсон ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө явагдсан хувьсгалын бэлтгэл ажиллагаанд АНУ-ын зүгээс гучин таван сая (35.000.000) доллар гаргасан” гэж тооцоолол хийсэн байна. Гэхдээ энэ мөнгөн дүн нь зөвхөн хувьсгалын өмнөх бэлтгэл ажилд зарцуулагдсан төсөв гэдгийг тодотгох хэрэгтэй юм. Мөн энэ явдлын үр дүнд Серб улс нь өнгөт хувьсгал явуулах туршилтын улс болсон бөгөөд, цаашид энэ технологиор дэлхийд олон өнгөт хувьсгал амжилттай өрнөхөд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Гүржид өрнөсөн “Сарнайн хувьсгал”-ын талаар: 2003 онд Гүржид парламентын сонгууль явагдаж үед өрнөсөн сарнайн хувьсгал нь ерөнхийлөгч Э.Швардназе болон түүний дэглэмийг унагаах зорилготой байжээ. Энэхүү хувьсгалыг дотоодын сөрөг хүчин гадаадын тусгай албадын удирдлага дор, тэдний санхүүгийн дэмжлэгтэйгээр, сайтар зохион байгуулалттай явуулсан гэж үздэг.

Гүржид хувьсгал гарах үед түлхэгдсэн унасан Ерөнхийлөгч агсан Э.Шевардназе Тбилиссийн “Асавал дасавали” сонинд өгсөн ярилцлагадаа: “Зэвсэглэсэн этгээдүүд парламентын байранд орж ирэх үед надад хоёр сонголт байсан. Тухайн үед би Ерөнхийлөгч, Ерөнхий командлагч хэвээрээ байсан болохоор хүч хэрэглэж болох байсан. Тэгвэл цус урсгасан хэрэг гарна. Өөр нэгэн сонголт нь огцрох. Би хоёр дахийг нь сонгож, энхийн замаар суудлаа өгсөн. Тухайн үед надад хугацаанаасаа өмнө суудлаасаа буухаас өөр арга зам байгаагүй” гэж ярьжээ¹².

Гүрж нь түүхий эдийн экспортоос илүү гарах орлогогүй байснаас гадна, Э.Швардназе хүчний болон төрийн бусад байгууллагыг олигтойхон цалинжуулах чадваргүй байжээ. Жишээлбэл, 2004 он хүртэл хугацаанд сайд нар нь 75 доллар, жирийн цагдаа нар 40-50 долларын цалинтай байв. Мөн Транспрэнси интернешнелээс 2003 онд гаргасан авилгын дүнгээр дэлхийн 133 орноос Гүрж улс 124 дүгээр байранд¹³ бичигдэж байсныг, энэ улс нь дотоодын ямар хэмжээний хямралтай байсныг тод харуулж байна. Авилгаас гадна элдэв төрлийн гэмт хэрэг, хуйвалдаан нь нийгмийн тулгамдсан асуудал болж, улмаар хүн ам нь аюулгүй байдлаа өөрсдөө хамгаалахад хүргэсэн нөхцөл үүссэн байна. Иймд Гүржэд олон тооны төрийн бус байгууллагууд ар араасаа байгуулагдаж эхэлсэн байна. Төрийн бус байгууллагын тоогоор Гүрж улс нь Пост Зөвлөлтийн улсууд дотроос Эстоний дараа буюу хоёрдугаарт бичигдэж байв¹⁴. Гүржийн төрийн удирдлага, хүчний байгууллагууд сандарч, тэвдсэн байдалтай боловч, шийдвэртэй арга хэмжээ авч чадахгүй байв. Энэ нь нэг талаасаа нэгдсэн зохицуулалттай, урьдаас бэлтгэсэн төлөвлөгөө байгаагүй

¹² <https://updown.mn/71820.html>.

¹³ Батсайхан, А., Эрдэнэбат, Б. Гадаадын зарим оронд явагдсан “өнгөт хувьсгал”. Түүний сургамж, урьдчилан сэргийлэх талаар анхаарах туршлага. УБ. 2019. 3 дахь тал.

¹⁴ Шкель С.Н. Авторитаризм в постсоветских государствах Центральной Азии и Кавказа: факторы устойчивости и режимной динамики. Диссертация на соискание ученой степени доктора политических наук. Уфимский государственный нефтяной университет. Уфа. 2015. С.337.

боловч, нөгөө талаасаа эдгээр төрийн бус байгууллагын удирдлага сөрөг хүчнийг дэмжээд эхэлсэн байжээ¹⁵.

Хүн амын амьжиргааны түвшин Гүржид хэт доошилж, баян, ядуугийн зөрүү хэт их болсноос үүссэн нийгмийн доторх ялгарал ихсэж, улмаар жижиг дунд бизнес эрхлэгч, залуучууд болон тэтгэврийн насны болон нийгмийн эмзэг бүлгийн зүгээс эрх баригч засагтаа үл итгэх байдал нэмэгдэж эхэлсэн байна. Үүнээс гадна, эрх баригч дэглэмийн тогтвортой байх эсэх нь зөвхөн ерөнхийлөгчийн зөв шийдвэрээс шалтгаалж байсан бөгөөд, ерөнхийлөгчийн зүгээс улс орны элит хэсэгт тавих хяналтын тогтолцоо үндсэндээ алдагдсан байдал болон элитүүдийн хоорондын эв найрамдалгүй, хагаралтай байдлын нөлөө нь өнгөт хувьсгал гарах шалтгаан болсон гэж үздэг байна. Мөн үндэсний хэмжээний нэгдсэн үзэл сурталгүй, нутгархах харьцаа, жалга довын үзэл газар авсан, цаашлаад ардчиллыг урагшлуулах гэсэн санаагаар гадаадын үзэл суртал илүү идэвхтэй дэлгэрч байсан явдал нь сарнайн хувьсгал огцом өрнөхөд хүчтэй нөлөөлжээ¹⁶.

2003 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Гүржид орон даяар парламентын сонгууль явагдсан байна. Дараа өдөр нь буюу 11 дүгээр сарын 03-нд сөрөг хүчний талд ажиллаж байсан “Рустави-2” телевизээр хийсэн мэдээллээр “Саакашвили – Үндэсний хөдөлгөөн” гэдэг сөрөг хүчний блок сонгуульд санал авалтаар тэргүүлж байгаа тухай зарласан бол Гүржийн Сонгуулийн ерөнхий хорооноос саналын хуудсын 50 хувийг тоолоод байсан урьдчилсан дүнд тулгуурлаж, “...ерөнхийлөгчийн талын “Шинэ Гүржийн төлөө” блок ялалт байгуулж байна” гэж мэдэгдсэн байна¹⁷.

Сөрөг хүчний зүгээс “эрх баригчид сонгуулийн дүнг хуурамчаар тоолж, будилуулсан” хэмээн эсэргүүцэл илэрхийлж, улмаар энэ сонгуулийг хүчингүй болгохыг шаарджээ. Сонгуулийн дараа шууд л олон нийтийн эсэргүүцлийн жагсаал, цуглаан зохион байгуулагдаж, парламентын сонгуулийг дахиж явуулах, ерөнхийлөгчийг огцруулах тухай шаардлага тавьсан.

Тбилист, парламентын ордны гадаа, өдөр бүр олон мянган иргэд эсэргүүцэл илэрхийлсэн цуглаан хийж байсан ба заримдаа цугласаи хүний тоо арван мянгад хүрч байжээ. Гүржийн бусад хот, сууринд ч ялгаагүй олон нийт оролцсон эсэргүүцлийн жагсаал, цуглаан болж байлаа. Өрсөлдөгч талууд яриа хэлэлцээр хийж чадахгүй байв. 11 дүгээр сарын 09-ний өдөр ерөнхийлөгч Э.Шевардназе сөрөг хүчний удирдагч болох М.Саакашвили, Н.Буржаназе, З.Жвани нартай хэлэлцээр хийсэн боловч тодорхой үр дүнд хүрэлгүй тарцгаав. 11 дүгээр сарыг 10-ны өдөр “Саакашвили - Үндэсний хөдөлгөөн” ба “Буржаназе - ардчилалчид” гэдэг сөрөг хүчний блок хамтарч өлсгөлөн зарласан байна. 11 дүгээр сарын 11-ний өдөр АНУ, ОХУ-ын Элчин сайдын яамны өмнө Гүржийн 15 төрийн бус байгууллагыг нэгтгэсэн “Төрийн бус байгууллагын нийгмийн штаб”-ын зүгээс эсэргүүцлийн цуглаан зохион байгуулсан ба Ажар, Квем, Картли бүсийн сонгуулийн дүнг хүчингүй болгоход дэмжлэг үзүүлэхийг америкийн дипломатуудаас хүссэн байна.

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Сонгуулийн ерөнхий хорооноос сонгуулийн дүнг эцэслэн гаргасан талаар мэдээг танилцуулсан бөгөөд, “Шинэ Гүржийн төлөө” блок 21.3 хувь, Ажарын удирдагч А.Абашизегийн “Сэргэн мандалт” нам 18.84 хувь, М.Саакашвилийн “Үндэсний хөдөлгөөн” 18.3 хувийн санал тус тус авчээ. Сөрөг хүчний зүгээс сонгуулийн үр дүнг “доромжлол” хэмээн үзээд, жагсаал, цуглаан хийж, улмаар олон тооны автомашиныг Гүржийн нийслэлд оруулсан байна. Ингээд нийтдээ 50 мянга орчим хүн оролцсон том хэмжээний эсэргүүцлийн жагсаал болж, парламентын анхдугаар хуралдаанд Э.Шевардназег үг хэлж байх үед дайран

¹⁵ Захаров С.М. Студенческая молодежь как политический фактор в постсоветских трансформациях. Диссертация на соискание ученой степени кандидата политических наук. Российский университет дружбы народов. Екатеринбург. 2016. С. 107.

¹⁶ Батсайхан, А., Эрдэнэбат, Б. Гадаадын зарим оронд явагдсан “өнгөт хувьсгал”. Түүний сургаж, урьдчилан сэргийлэх талаар анхаарах туршлага. Улаанбаатар. 2019. 4-5 дахь тал.

¹⁷ Иррегулярные конфликты: “цветные революции”. Анализ и оценка форм, приемов и способов ведения операций по смене режимов в суверенных государствах /Под общ. ред С.Н. Гриняева. М. 2015. С.83.

орсон тул ерөнхийлөгч арга буюу индрийг орхин гарсан байна. Э.Шевардназе онц байдал зарлаж, өөрийн байрандаа цэрэг, цагдаагийн хамгаалалт ирүүлэх үүрэг тавьсан боловч, цагдаагийн байгууллагаас түүнд туслахаас татгалзсан байна. Ингээд сарнайн хувьсгалын үр дүнд ерөнхийлөгч асан Э.Шевардназе сөрөг хүчний удирдагчидтай хийсэн уулзалтын дараа огцорсноо мэдэгдсэн байна.

Тэгэхээр, Гүржийн сарнайн хувьсгал нь Сербийн бульдозерын хувьсгалтай тун төстэй байдлаар өрнөсөн болох нь харагдаж байна. Уг өнгөт хувьсгал амжилттай явагдахад гадаадын, тэр дундаа АНУ-ын олон тооны төрийн бус байгууллагууд нөлөө үзүүлж байсан болох нь тухайн үед Гүржид хүчээ авч, хувьсгал болоход чухал нөлөө үзүүлсэн залуучуудын “Кмара” бүлгийг санхүүжүүлсэн байдлаас харагдаж байна. Тодруулбал, төрийн бус байгууллагуудын зүгээс “Кмара” хөдөлгөөний үйл ажиллагааны дэмжлэг болох гурван зуун мянган (300.000) долларын санхүүжүүлэлт хийгдсэн байна. АНУ-ын Конгресс Гүрж улстай хүмүүнлэг, иргэний болон цэргийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд 1992 оноос 2002 оны хооронд нийтдээ 1.1 тэрбум доллар зарцуулсан бол Төрийн департамент нь 2003 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр болсон Гүржийн ардчилсан сонгуульд зориулж 2.4 сая доллар олгох тухай мэдэгдсэн байна¹⁸.

Өнгөт хувьсгал хийх санхүүгийн гол эх үүсвэрийг “Зүүн Европ дахь ардчиллыг дэмжих” чиглэл бүхий америкийн сангуудаас гаргасан талаар мэдээлэл байдаг. Энэ хөрөнгө нь АНУ-ын Төрийн департаментын төсвийн тал хувийг эзэлдэг байна. Сербид дээрх сангуудаар дамжуулан 90 сая долларын санхүүжилт, харин Украинд 85 сая долларын санхүүжилтийг тус тус гаргажээ. Жорж Сорос 2004 онд Давосын эдийн засгийн чуулган дээр Гүржийн идэвхтнүүд “сарнайн хувьсгал” хийхдээ түүний санхүүжилтийг авсан гэж албан ёсоор мэдэгдсэн байна.

Ашигласан материал

1. Батсайхан, А., Эрдэнэбат, Б. Гадаадын зарим оронд явагдсан “өнгөт хувьсгал”. Түүний сургамж, урьдчилан сэргийлэх талаар анхаарах туршлага. УБ. 2019.

2. Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны танилцуулга. 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр.

Гадаад эх сурвалж

3. Dan Braha. A Universal Model of Global Civil Unrest. New England Complex Systems Institute, 238 Main St., Suite 319, Cambridge, MA 02142, USA. University of Massachusetts Dartmouth, Dartmouth, MA 02747, USA (Dated: May 2012).

4. Авдеев В.Е., Наумова А.Ю., Наумов А.О. “Цветные революции” на постсоветском пространстве. СПб. Алетейя. 2013.

5. Захаров С.М. Студенческая молодежь как политический фактор в постсоветских трансформациях. Диссертация на соискание ученой степени кандидата политических наук. Российский университет дружбы народов. Екатеринбург. 2016.

6. Иррегулярные конфликты: “цветные революции”. Анализ и оценка форм, приемов и способов ведения операций по смене режимов в суверенных государствах /Под общ. ред С.Н. Гриняева. М. 2015.

7. Наумов А.О. Бульдозерная революция в Сербии 2000 года: Технологии смены политического режима. Вестник СПбГУ. Сер. 6. 2016. Вып. 4.

8. Наумов А.О. Бульдозерная революция в Сербии 2000 года: Технологии смены политического режима. Вестник СПбГУ. Сер. 6. 2016. Вып. 4.

9. Наумов А.О. Бульдозерная революция в Сербии 2000 года: Технологии смены политического режима. Вестник СПбГУ. Сер. 6. 2016. Вып. 4.

¹⁸ Авдеев В.Е., Наумова А.Ю., Наумов А.О. “Цветные революции” на постсоветском пространстве. СПб. Алетейя. 2013. С. 38.

10.Шкель С.Н. Авторитаризм в постсоветских государствах Центральной Азии и Кавказа: факторы устойчивости и режимной динамики. Диссертация на соискание ученой степени доктора политических наук. Уфимский государственный нефтяной университет. Уфа. 2015.

Цахим эх сурвалж

11.<https://updown.mn/71820.html>.

12.Аюулгүй байдал судлалын хүрээлэн. <https://niss.gov.mn/archives/1221>.

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, ХҮЧИН ЗҮЙЛ

CAUSES AND FACTORS OF CRIMES COMMITTED BY BORDER SECURITY PERSONNEL

Г.Болор-Эрдэнэ

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч

Bolor-Erdene G.

University of internal affairs, Mongolia Department of criminal justice and criminology teacher doctor (Ph.D), Police Major

Хураангуй: Энэхүү өгүүлэлд хил хамгаалах байгууллагын алба хаагчдаас үйлдсэн, холбогдон шалгагдсан гэмт хэргийн шалтгаан, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийг тодорхойлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулж, социологийн болон сэтгэл зүйн онолын үүднээс гэмт хэргийн шалтгаан, хүчин зүйлийг тайлбарласан.

Abstract: In this article, it is possible to determine the causes of the crimes committed by the officers of the Border Guard Organization, to determine the measures that can be taken to prevent crimes, and the causes of crimes are explained from the perspective of sociological and psychological theories.

Түлхүүр үгс: Застав, социологийн болон сэтгэл зүйн судалгаа, хил хамгаалах байгууллага, хилийн отряд, хилийн харуул.

Keywords: Outposts, sociological and psychological research, border protection organizations, border detachments, border guards.

Удиртгал

Хил хамгаалах байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын Олон Улсын гэрээ, хэлэлцээрүүд, Монгол Улсын хилийн тухай хууль, Монгол Улсын хил хамгаалалтын дүрэм, Монгол Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам, Бүсчилсэн хил хамгаалах хөтөлбөр, Хил хамгаалах байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөрийн дагуу улсын хил хамгаалалтыг хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчид, ахлагч, офицер гэсэн бүрэлдэхүүнээр зохион байгуулж байна. Сүүлийн жилүүдэд Хил хамгаалах байгууллагын алба хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн талаарх мэдээлэл нийгмийн сүлжээнд нэлээдгүй маргаан дагуулсан асуудлын нэг болж байна.

Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээгээр 2011-2021 оны хооронд хил хамгаалах байгууллагын 123 ажилтан, алба хаагч 108 гэмт хэрэгт холбогдон шалгагдсан бөгөөд жилд дунджаар 12 ажилтан, албан хаагч 10 гэмт хэрэгт холбогдон шалгагдсан мэдээтэй байна. Уг тоон үзүүлэлтээс харахад, хил хамгаалах чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг ажилтан, албан хаагчдаас гэмт хэрэг үйлдэх явдал харьцангуй ихссэн, цаашид нэмэгдэх хандлагатай байгаа учир алба хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн шалтгааныг тогтоохоор зорилгоор 300 гаруй хугацаат цэргийн албан хаагч, ахлагч, офицер бүрэлдэхүүний дунд социологийн болон сэтгэл зүйн судалгаа явуулж, дүн шинжилгээ хийлээ.

Үндсэн хэсэг

1. Социологийн судалгааны үр дүн

Судалгаанд оролцсон офицер бүрэлдэхүүний 35 хувийг 30-33 хүртэлх насны алба хаагчид эзэлж байгаа бол ахлагч болон хугацаат цэргийн алба хаагчтай насны үзүүлэлтээр нь харьцуулан авч үзэхэд, ахлагч бүрэлдэхүүний нийт судалгаанд

хамрагдагсдын 40 хувийг 18-23 хүртэлх насны алба хаагчид эзэлж байгаа бол хугацаат цэргийн албанд татагдсан алба хаагчдын 86 хувь нь 19-21 насныхан байна.

Хугацаат цэргийн албанд татагдан ирж, алба хааж байгаа залуусын 55 хувь нь бүрэн дунд боловсролтой, 29 хувь нь тусгай дунд, 6 хувь нь дээд, 6 хувь нь бага боловсролтой, хилийн отряд, застав, хилийн харуулд үүрэг гүйцэтгэж байгаа ахлагч бүрэлдэхүүний 54 хувь нь бүрэн дунд боловсролтой, 39 хувь нь тусгай дунд боловсролтой, 7 хувь нь дээд боловсрол эзэмшсэн бол хугацаат цэргийн албанд татагдан ирэхээсээ өмнө нийт санал асуулганд оролцогсдын 4 хувь нь гэмт хэрэгт холбогдон шалгагдсан байна. Эдгээр үзүүлэлтүүдийг судалгаанд оролцсон хугацаат цэргийн алба хаагчдын тоон үзүүлэлттэй харьцуулан авч үзэхэд, 23 хүн тутмын нэг нь гэмт хэрэгт холбогдож, 13 хүн тутмын нэг нь гэмт хэргийн хохирогч болж байжээ.

Хугацаат цэргийн албанд татагдан ирсэн залуусаас согтууруулах ундаа болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний талаарх тандалт, судалгааны үр дүнд нийт судалгаанд оролцогчид “Согтууруулах ундаа хэрэглэдэг” гэж хариулснаас гадна 4 хувь нь “Уг зуршлаасаа салах гэж цэргийн албанд татагдсан” гэж хариулсан байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж үзэж байсан эсэх талаар тандан судлахад, нийт асуулгад оролцогчдын 4 хувь буюу 7 хүн “хэрэглэж үзсэн” гэж хариулсан байна. Тэгэхээр нийт судалгаанд оролцогчид нь согтуурч байсан, харин 29 хүн тутмын нэг нь ямар нэгэн байдлаар мансуурч үзэж байсан гэж дүгнэж болохоор байна.

Судалгаанд хамрагдсан ахлагч бүрэлдэхүүний 13 хувь нь согтууруулах ундаа огт хэрэглэдэггүй бол 79 хувь нь баяр ёслол, тэмлэглэлт үйл явдлын үеэр хэрэглэдэг, харин 2 хувь нь согтууруулах ундааны зүйл байнга хэрэглэдэг буюу хамааралтай болсон байна. Ахлагч бүрэлдэхүүний 98 хувь нь “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж үзээгүй” гэж хариулсан бол 2 хувь нь “мансууруулах бодис хэрэглэж үзэж байсан” гэж тус тус хариулсан.

Судалгаанд оролцогчдын 96 хувь нь Хил хамгаалах байгуулагад хугацаат цэргийн алба хаасандаа сэтгэл ханамжтай байгаа болохоо илэрхийлсэн бол 4 хувь нь эсрэгээрээ цэргийн алба хаасандаа харамсаж байгаагаа илэрхийлсэн байна. Алба хаагчдын 80 хувь нь “хилийн отряд, заставт алба хаахад бэрхшээл учирч байгаагүй” гэсэн бол 10 хувь нь “аж ахуйн ажил их хийлгэдэг”, 10 хувь нь “хоол, хүнс, хувцасны хангалт муу, дутагдалтай байсан” гэж тус тус хариулсан байна. Ахлагч бүрэлдэхүүний 60 хувь нь “бэрхшээл байхгүй” гэж хариулсан бол 28 хувь нь “хувцасны чанар болон унаа, хөсгийн хүрэлцээтэй байдал тааруу” гэсэн бол 6 хувь нь “хүн хүчний дутагдалтай байдлаас шалтгаалж, олон хоногоор үүрэг гүйцэтгэхэд бэрхшээлтэй байдаг” гэж тус тус хариулсан байна.

Офицер бүрэлдэхүүнээс авсан хилийн отряд, застав, хилийн харуулд, хил хамгаалалт зохион байгуулахад учирч байгаа бэрхшээлийн талаарх санал асуулгад оролцогчдын 69 хувь нь “бэрхшээл байхгүй” гэж хариулсан бол 19 хувь нь “техник, хэрэгслийн нөхөн хангалт муу хийдэг”, 4 хувь нь “хувцасны чанар, хангалт муу” гэж, 5 хувь нь “унаа, хөсөг байхгүй, дутагдалтай” гэж, 2 хувь нь “явганаар үүрэг гүйцэтгэхэд хүндрэлтэй байдаг” гэж тус тус хариулсан байна.

Алба хаах хугацаандаа судалгаанд оролцсон хугацаат цэргийн алба хаагчдын 4 хувь буюу 20 хүн тутмын нэг нь бусдад зодуулах, дэглүүлэх зэргээр дүрмийн бус харьцаанд өртөж байсан бол 96 хувь нь дүрмийн бус харьцаанд өртөж байгаагүй талаараа илэрхийлжээ.

2. Сэтгэл зүйн судалгааны үр дүн

Улсын хилийн зурвасыг сахин хамгаалах журамт үүрэг хүлээсэн цэргийн албан хаагчид өөрийн өсөж, төрсөн нутаг, эцэг, эх, ахан дүүс, найз нөхдөөсөө алс хол оршиж, цэргийн тодорхой дүрэм, журмыг сахин биелүүлж, энгийн иргэний зарим эрхийн хязгаарлалт амсаж, өдөр тутмын цаг хугацаатай үүрэг, даалгавар биелүүлж ажилладгийн хувьд сэтгэл санааны байдал тогтворгүй болж өөрчлөгдөх, албанаас халшрах, стресс, бухимдалд автах явдал цөөнгүй тохиолддог. Тиймээс удирдлагын зүгээс алба хаагчдын сэтгэл зүйн байдлын талаарх судалгааг тогтмол явуулж,

стресс, бухимдал, тэр ч байтугай депресст өртөх аюулаас урьдчилан сэргийлэх шаардлагатай байна.

Судалгаанд оролцогчдоос “Алба хаах хугацаанд таны сэтгэл санааны байдал ямар байсан бэ?” гэсэн асуултад, 85.9 хувь нь “сэтгэл санаа хэвийн байсан”, 8.2 хувь нь “үе үе хямардаг байсан”, 0.5 хувь (нэг алба хаагч) нь “байнга хямардаг” гэж хариулсан бол 5.4 хувь нь уг асуултад хариулт өгөхөөс татгалзжээ.

Хүснэгт №1.

№	Хариулт	Тоо	Хувь
1	Хэвийн байсан	158	85.9%
2	Үе үе хямардаг байсан	15	8.2%
3	Байнга хямардаг байсан	1	0.5%
4	Хариулт өгөөгүй	10	5.4%
5	Нийт	184	100%


Хилийн алба нь ажил, үүргийн хуваарийн онцлогтойг тооцогдох учир алба хаагчид ямар байршилд үүрэг гүйцэтгэж байгаагаас хамаарч сэтгэл санаа хямрах асуудал үүсэх боломжтой бөгөөд үр дүнд нь элдэв зөрчил, цаашлаад гэмт хэрэгт холбогдох явдал гарахыг үгүйсгэхгүй юм. Судалгаанд оролцогчдоос “Ямар байршилд үүрэг гүйцэтгэхэд сэтгэл санаа хямрах зүйл ажиглагдаж байсан бэ?” гэх асуултад, 34.9 хувь нь “хилийн заставт үүрэг гүйцэтгэхэд сэтгэл санаа илүү ихээр хямардаг” гэж хариулжээ. Харин бусад газарт үүрэг гүйцэтгэхэд сэтгэл санаа хямарч, өөрчлөлт орох явдал харьцангуй бага тохиолдсон болохыг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт №2.

№	байрлал	Тоо	Хувь
1	Отряд	22	12%
2	Харуул	24	13%
3	Бүх байрлалд	25	13.6%
4	Застав	38	20.7%
5	Хариулахаас татгалзсан	75	40.8%
6	Нийт	184	100%

Судалгаанд оролцсон алба хаагчдын 89.3 хувь нь “эхний 3 хоногтоо тайвширдаг” гэсэн бол 10.4 хувь нь “сэтгэл санааны тавгүй байдал, хямрал гурваас дээш хоногоор үргэлжилдэг” гэжээ.

График №1.



Сэтгэл санаа хямарсан, тавгүй үед 38.7 хувь нь “найз нөхөдтэйгээ ярилцмаар санагддаг” гэж хариулсан бол, 19.4 хувьд нь ар гэрийхэнтэйгээ утсаар ярих, мөн хэмжээний хувьд нь сэтгэл зүйчтэй уулзах зэрэг харилцааны хэрэгцээ бий болж байна. Харин 16.1 хувь нь буюу 6 хугацаат цэргийн алба хаагч тутмын 1 нь “сэтгэл санаа тавгүй үед оргох тухай бодол төрдөг”, 15 алба хаагч тутмын 1 нь “удирдлагад

өс санасан, хариугаа авах тухай бодол төрдөг” гэж хариулсан явдал нь анхаарал татаж байна.

График №2.



Стрессийн үед илрэх ерөнхий хариу урвалыг Сонди тестийн хураангуй хувилбараар судалж үзэхэд дараах үр дүн гарав. Үүнд:

Е-үзүүлэлт хамгийн бага буюу 5.5 хувьд илэрч байна. 20 хүн тутмын нэгт илэрч буй энэхүү үзүүлэлт нь өс санах, хорсох, бухимдах, үзэн ядах, хардах, бусдыг хороох хүсэлтэй байж болохыг илэрхийлдэг. Үүнийг цаашид сэтгэл зүйн нарийвчилсан шинжилгээгээр тодруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Сонди

		тоо	хувь	хүчинтэй
	h-	15	8.2	10.3
	e-	8	4.3	5.5
	s-	28	15.2	19.2
	m-	13	7.1	8.9
	k-	17	9.2	11.6
	d-	23	12.5	15.8
	hy-	25	13.6	17.1
	p-	17	9.2	11.6
	нийт	146	79.3	100
	хариулаагүй	38	20.7	
		184	100	

Тайлбар:

	Хувь	Сэтгэл зүйн утга
s-	19.2	Бүрэг, идэвхгүй байдал. Өөрт хандсан түрэмгийлэл үйлдэх эрсдэлтэй. Үнэнч, шударга, өөрийгөө үл хайхрах байдлыг илэрхийлнэ.
hy-	17.1	Бусдын анхааралд өртөхийг хүсдэггүй. Бодит байдлаас зайлсхийх эрмэлзэлтэй. Нийтээр тогтсон хэм хэмжээг баримталдаг. Өөрийгөө дутуу үнэлж, байгаагаар нь хүлээн авч чаддаггүй. Сэтгэл зүйн дотоод таагүй асуудалтай, үүнийг нууцлах хүсэлтэй.
d-	15.8	Шинэ харилцаа тогтоох чадвар сул, эцэг эхээс хэт хамааралтай, инцест хандлага илэрч болно. Асуудлыг эмзэг хүлээн авах талтай.

k-	11.6	Бусдын аяыг дагах хандлагатай. Орчин тойрондоо зохицон амьдрах чадвартай хэдий ч, үгүйсгэх, хүлээн зөвшөөрөхгүй байх хандлага илэрдэг.
p-	1 1.6	Өөрийгөө бусадтай харьцуулах хандлага нь тодорхойгүй нөхцөл байдал, үйл явдалд дасан зохицох чадварыг нэмэгдүүлдэг.

		Сэтгэл санаа	байрлал	Хугацаа	Тавгүй үед	Хариу үйлдэл
Спирмена	Сэтгэл санаа	1.000	087	173	091	071
	байрлал	087	1.000	053	130	011
	Тайвшрах хугацаа	173	053	1,000	241*	219*
	Тавгүй үед	091	130	241*	1.000	090
	Хариу үйлдэл	071	011	219*	090	1.000

Сэтгэл зүйн үзэгдлүүдийн хоорондын хамаарлаас харахад:

Тайвшрах хугацаа удаан байх нь тавгүй үед төрдөг мэдрэмж, бодол санаанд нөлөөлж байна. Тодруулбал, сэтгэл санааны хямрал удаан үргэлжлэх тусам оргох болон өс санах, хариугаа авмаар санагдахад хүргэж байгаа байдал нь гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, холбогдогч болох суурь шалтгаан гэж үзэж байна.

Судалгааны үр дүнд харилцааны хэрэгцээ маш ихээр үүсдэг болох нь ажиглагдаж байна. Энэ хэрэгцээг хангах нөхцөл боломжийг бүрдүүлж чадвал алба хаагчид амархан тайвширч, ямар нэгэн гэмт санаа, бодол бий болох нөхцөл бүрэлдэхгүй байх сайн талтай юм. Иймд алба хаагчдын харилцааны хэрэгцээг хангах, тодруулбал, сэтгэл зүйчтэй уулзуулах, ар гэрийнхэнтэйгээ ойр ойрхон холбоо тогтоох боломж, нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй юм.

Дүгнэлт

1. Хил хамгаалах байгууллагын үндсэн бие бүрэлдэхүүний дийлэнх хувийг 18-24 насны эрчүүд эзэлж байна. Энэ насны хүмүүс зан төлөв, харилцаа, хандлага бүрэн төлөвшөөгүй, ахмадын үг, сургааль, ахимаг насны хүмүүсийн хатуу үгийг даах, ойлгож авах чадвар дутмаг байдлаас шалтгаалж гэмт хэрэг үйлдэх явдал харьцангуй их байх хандлага ажиглагдаж байна.

2. Олон хоногоор нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж, сэтгэл гутрал, стресст орох нь гэмт хэрэг, зөрчил үйлдэх нэг шалтгаан болж байна. Сэтгэл санааны хямралаас гарч, тайвшрах хугацаа удаан байх нь тавгүй үед төрдөг мэдрэмж, бодол санаанд шууд болон шууд бусаар нөлөөлж байна. Тодруулбал, сэтгэл санааны хямралд байх хугацаа удаашрах тусам албан үүргээ гүйцэтгэхээс халшрах, цаашлаад оргох, эсхүл шууд удирдах албан тушаалтнуудын тавьсан шаардлага, хууль ёсны тушаалыг биелүүлэхээс татгалзах, өс санах, хариугаа авах сэдэл төрүүлэхэд түлхэц өгч байна.

3. Судалгаанд оролцсон алба хаагчдын 4 хувь нь гэмт хэргийн улмаас хохирч байсан бол мөн хэмжээний албан хаагч гэмт хэрэгт холбогдож байжээ. Түүнээс гадна энэ хэмжээний албан хаагчид согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж байсан талаар харуулсан судалгааны үр дүнгээс дүгнэхэд, урьд өмнө авсан сэтгэл зүйн гэмтэл нь олон хоногоор нийгмээс тусгаарлагдан үүрэг гүйцэтгэхэд дахин сэргэж, гэмт хэрэг, зөрчил үйлдэх шалтгаан болж байна.

4. Сэтгэл санаа хямарсан, тавгүй үедээ 58.1 буюу ихэнх хувь нь ойр дотны хүмүүс (найз нөхөд, ар гэрийнхэн)-тэйгээ ярилцахыг илүүд үздэг болох нь судалгаанаас ажиглагдсан. Харин 19.4 хувьд нь сэтгэл зүйчтэй уулзах зэрэг харилцааны хэрэгцээ бий болж байгаа явдал нь хилийн зурваст алба хаагчдыг мэргэжлийн сэтгэл зүйчээр хангаж, стресс, бухимдал үүссэн тохиолдолд тэр даруйд нь хэвийн болгох тал дээр анхаарах шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1992. №01
2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (шинэчилсэн найруулга), “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2019. №42
3. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2002. №03
4. Хил хамгаалах байгууллагын алба хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн судалгааны тайлан. Улаанбаатар. 2021

НИЙГМИЙН ХӨГЖИЛД СУУРИЛСАН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

THEORIES CRIME PREVENTION THROUGH SOCIAL DEVELOPMENT

Г.Баттулга

ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургуулийн Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн эрхлэгч, хурандаа

Battulga G.

Colonel Head of the Department of Security, School of Court Decision Executive Studies, UIA

Хураангуй: Энэхүү өгүүллээр нийгмийн хөгжилд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам, гэмт хэрэг, зөрчлийн уг шалтгааныг судлан тогтоодог онол, стратегийн талаар авч үзэхийг зорилоо. Нийгмийн хөгжлийг дэмжих замаар өсвөр насны хүмүүсийг гэмт хэрэг, зөрчилд өртөх, холбогдохоос урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох боломжтой юм. Өөрөөр хэлбэл, гэмт зан үйл, хандлага үүсэж бий болох, эрт үед нь урьдчилан сэргийлэх боломжтой хэмээн үздэг онолуудыг харьцуулан судалсан.

Abstract: The article focuses on social development approaches to crime prevention, that is, theories and strategies that attempt to address the root causes of criminal and delinquent behavior of the youth. In other words, preventing criminal predispositions from developing in the first place.

Түлхүүр үгс: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэн, гэмт хэргийн шалтгаан, нийгэмд харш зан үйл, нийгмийн хөгжил, нийгмээс суралцахуйн онол, нийгмийн дотно харилцааны онол, хяналтын онол, эрсдэлт хүчин зүйлс, эрсдэлт гэр бүл.

Keywords: Crime prevention through social development approaches, crime prevention, offender, risk factor, antisocial behavior, at-risk family, cause of crime, social learning theory, control theory, social bond theory.

Үндсэн хэсэг

Нийгмийн хөгжилд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх (Цаашид – НХСГХУС гэх) арга зам нь гэмт хэрэг үйлдэх, гэмт хэрэгтэн болох суурь шалтгаан нь нийгмийн орчны эрсдэлт хүчин зүйлс (ядуурал, бусдын муу үлгэр дуурайлал, эцэг эхийн хүчирхийлэл болон хайхрамжгүй байдал, хангалтгүй боловсрол гэх мэт) болон хувийн эрсдэлт хүчин зүйлсийн (зан үйлийн, сэтгэл зүйн, оюун санаа, танин мэдэхүйн асуудлууд гэх мэт) нэгдлээс үүдэлтэй гэсэн үзэл санаанд суурилдаг¹⁹. Тиймээс, гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж болзошгүй эдгээр эрсдэлт хүчин зүйлсийг багасгах, эсвэл үгүй хийхийн тулд дээрх 2 эрсдэлт хүчин зүйлсийг олж илрүүлэн, шийдвэрлэхэд чиглэсэн нарийн аргачлалуудыг ашигладаг. Эдгээр аргачлалуудыг хүүхэд наснаас нь хэрэглэвэл хамгийн тохиромжтой бөгөөд НХСГХУС арга зам нь дараах хоёр хүчин зүйлсийн аль нэг рүү чиглэж байх ёстой. Үүнд:

1. Хүүхдэд сөрөг нөлөөтэй нийгмийн орчин (эцэг эхийн эерэг нөлөөллийг бий болгох, хүүхдээ хүмүүжүүлэх үр дүнтэй аргад сургах, дэмжлэг үзүүлэх г.м);

2. Хүүхдийн зан үйлийн, сэтгэл хөдлөлийн, сэтгэл зүйн, оюун ухааны эрсдэлт хүчин зүйлс (суурь боловсрол олгох болон нэмэлт хичээлд хамруулах, сурлагад анхаарах, нийгмийн ур чадвар олгох сургалт болон сэтгэл засал хамруулах г.м).

Өөрөөр хэлбэл, НХСГХУС аргаар дамжин хэрэгжиж буй интервенцүүдийн тусламжтайгаар шууд бус буюу хүүхдийн нийгмийн орчныг өөрчилснөөр эсвэл шууд аргаар хүүхэдтэй ганцаарчлан ажиллаж, үйлчилгээ үзүүлснээр тэдэнд нөлөөлөл үзүүлэх боломжтой юм. Эрсдэл бүхий хүүхэд залуучуудад туслах, нийгмийн

¹⁹ Schneider, S., Crime Prevention:Theory and Practice, CRS Press Tylor & Francis Group. 2010. p 77.

тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хамгийн тохиромжтой аргачлал нь нийгмийн болон хувийн эрсдэлт хүчин зүйлсэд анхаарахын зэрэгцээ хүүхэд бүрийн онцлог байдлыг (сул болон давуу тал) харгалзан ажиллах явдал юм.

НХСГХУС нь өсвөр насны хүмүүс, залуучууд болон насанд хүрсэн хүмүүст ч мөн адил чиглэсэн байдаг. Хүүхэд, залуусыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийн гол зорилго нь эерэг нийгэмшил болон өөрсдийн оршин сууж буй газар, орчинд түшиглэн интервенц хэрэглэх, түүнд идэвхтэй хамрагдах боломжийг олгож, хувь хүний хөгжлийг дэмжих байдлаар хэрэгжинэ. Гол зорилго нь хүүхэд, залууст чиглэсэн боловсрол олгох хөтөлбөр, спорт, урлаг зэрэг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг боломжуудыг олгосноор биеллээ олдог. Хүүхэд, залуус өөрсдийгөө үнэ цэнэтэй бөгөөд хэрэгтэй гэж мэдэрч, итгэснээр, нийгмийн нэг гишүүн гэдгээ ухамсарлаж эхэлдэг бөгөөд энэ үед нь тэдний зүгээс хийсэн аливаа (сайн бөгөөд саар) үйлдлийн учир холбогдлыг анхааран үзэх нь чухал юм.

Тэднийг эерэг тийш нь чиглүүлж, “шударга, ёс зүйтэй байх нь утга учиртай зүйл” гэдгийг тогтмол ойлгуулж байх ёстой. Тухайлбал, зарим оронд эрсдэл бүхий өсвөр насны хөвгүүд рүү чиглэсэн цагдаагийн байгууллагын туршлагатай, удирдах ажилтнуудын идэвх, оролцоотой бий болсон клубүүд үйл ажиллагаа явуулдаг. Английн мужуудын хэмжээнд цагдаагийн байгууллагын санаачилгаар “Цагдаагийн манлайлал ба хөвгүүд” нэртэй клуб олон жилийн турш үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй өсвөр насны хөвгүүдэд чиглэсэн боловсрол, эрүүл мэнд, хувь хүний хөгжил, спортын сургалтуудыг зохион байгуулсан нь ихээхэн эерэг үр дүнд хүрсэн байна²⁰.

Өсвөр насны болон насанд хүрсэн хүмүүст зориулсан хамгийн нийтлэг НХСГХУС аргууд нь хөдөлмөр эрхлэлтэд суурилсан хөтөлбөрүүд (хөдөлмөрийн дадлага, мэргэжил олгох сургалт болон ажил олгох) байдаг. Өсвөр насны болон насанд хүрсэн хүмүүсийн зүгээс давтан гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга нь “олон систем” бүхий сэтгэл заслын эрчимтэй аргыг хэрэглэх явдал бөгөөд ингэхдээ тэднийг нийгэм, олон нийтийн дунд байлгаж, тэдний дэмжлэгийг авч хэрэгжүүлэх үр дүнтэй болох нь нотлогдсон²¹.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэхэд шууд нөлөө үзүүлэх боломжтой, үр дүнтэй, нийгмийн хөгжилд суурилсан арга замыг дараах байдлаар дөрвөн хэсэгт ангилж болно. Үүнд:

1. Нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн арга хэмжээ, чиглэл ба нийгмийн институтууд. Гэмт хэрэг, нийгмийн эсрэг зан үйл, хууль бус үйлдлүүдийг зогсоож чадах нийгмийн хамгийн чухал арга хэрэгсэл бол тогтвортой, сайн зохион байгуулагдсан нийгмийн институт, тогтолцоо юм. Үүнд гэр бүл, сургууль, хамт олон, эрүүл мэндийн тогтолцоо, хөдөлмөрийн зах зээл, эдийн засгийн байдал зэрэг бүгд багтана. Эцэг эхийн хайр халамж, гэр бүлийн хүмүүжил, эерэг тогтвортой гэр бүл, амар амгалан, эрч хүчтэй, идэвхтэй санаачилгатай иргэд оршин суугчтай хороолол, сум, дүүрэг, ерөнхий боловсролын хийгээд бүх нийтийн боловсролын сайн тогтолцоо, тогтвортой, ашигтай ажлын байрыг бий болгож чадахуйц бат бөх эдийн засаг, хүртээмжтэй эрүүл мэндийн тогтолцоо, нийгэм, улс төрийн амьдрал дахь иргэдийн оролцоо, олон ургалч үзэл, хүний үндсэн эрхийг хүндэлдэг нийгмийг бүрдүүлэх явдал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамгийн сайн арга хэмжээ юм.

2. Бүх нийтийн нийгмийн халамжийн бодлого, үйлчилгээ. Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш маш олон засгийн газрууд нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг ашиглан эдгээр нийгмийн институтуудийг бэхжүүлсэн байдаг. Засгийн газраас хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн (боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, ажилгүйдлийн даатгал, гэр бүлүүдэд зориулсан санхүүгийн дэмжлэг) ихэнх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, таслан зогсоох зорилготой байгаагүй. Гэсэн

²⁰ Wilburn, E., Police-Led Boys' Clubs in England and Wales. 1918-1951. PhD thesis, The Open University. 2020.

²¹ Schneider, S., Crime Prevention: Theory and Practice, CRS Press Tylor & Francis Group. 2010. p 78.

хэдий ч, эдгээр нийгмийн халамжийн хөтөлбөр болон бодлогууд хүүхэд, залуус, насанд хүрэгчдийг нийгэмшүүлэх, тэдний урт хугацааны хөгжилд нөлөөлж, нийгэмд хувь нэмрээ оруулж чадах нийгмийн нэг гишүүн болгосноор гэмт хэрэг, нийгмийн эсрэг зан үйл, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэхэд маш чухал үүргийг гүйцэтгэж чаддаг.

3.Эрсдэлт гэр бүлүүд рүү чиглэсэн хөтөлбөр, үйлчилгээнүүд. Үүнд: Ядуу, бага орлоготой гэр бүл, дүүрэг, хороололд зориулсан хөтөлбөр, үйлчилгээ багтана. Тухайлбал, үнэ төлбөргүй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, хүүхэд асрах үйлчилгээ, сургуулийн өмнөх боловсрол, хоол хүнсний тусламж, хичээлийн дараах хөтөлбөр, нэмэлт хичээл, мэргэжил олгох сургалтууд юм. Өмнө нь дурдсан нийгмийн халамжийн бодлого, үйлчилгээтэй нэгэн адил гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгайлан зорилгыг агуулаагүй, түүнд чиглээгүй боловч эдгээр хөтөлбөрүүдээр дамжин ядуу, орлого багатай гэр бүлд өсөж буй хүүхдүүдэд амьдралын хэрэгцээг хангах, нийгэмшүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжсэнээр тэднийг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэхэд чухал нөлөө үзүүлдэг.

4.Тодорхой бүлэгт чиглэсэн НХСГХУС интервенцүүд. Энэ ангилалд ирээдүйд гэмт хэрэг, зөрчил үйлдэх эрсдэлтэй хүүхэд, залуус, насанд хүрэгсдэд туслах тусгайлан боловсруулсан аргачлал болон хөтөлбөрүүд багтана. Сүүлийн хоёр ангиллын чиглэл, зорилго, аргачлалын зарим хэсэг нь нэлээд давхцана. Нийгмийн хөгжилд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аргын дээр дурдсан 4 ангиллын интервенцүүдийн аль аль нь нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байдгаараа өөр хоорондоо төстэй. Нийгмийн хөгжилд суурилсан интервенц нь криминологийн шинжлэх ухааны “Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх” ойлголтоос ялгаатай юм²². Нийгмийн хөгжилд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга нь сэтгэл зүй, боловсрол, нийгмийн ажил, эрүүл мэндийн үйлчилгээгээр дамжин иргэд, олон нийтийн хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн нийгмийн хөгжилд тулгуурлан хэрэгждэг.

Тэгэхээр нийгмийн хөгжилд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүй гэдэг нь улс, орон нутгийн түвшинд хэрэгжиж байгаа нийгмийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө, зорилтот бүлгүүдэд чиглэсэн үйл ажиллагаа, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хүүхэд хамгааллын үйлчилгээ, тусламж, дэмжлэгт тулгуурласан урьдчилан сэргийлэх ажлыг хэлэх бөгөөд үүнд төрийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулах боломжтой байдаг²³.

НХСГХУС арга замын суурь гэгдэх гэмт хэргийн шалтгааны онолууд:

НХСГХУС арга зам нь хувь хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэх, нийгмийн эсрэг зан үйл төлөвшихөд хүргэдэг учир шалтгааны талаарх онолын үзэл баримтлал дээр суурилдаг учир уг арга замын талаарх гүнзгий ойлголттой болохын тулд гэмт хэргийн уг шалтгааныг тайлбарладаг дараах онолуудыг харьцуулан үзэх нь зүйтэй юм. Учир нь гэмт хэрэг зөрчил үйлдэгдэх болсон зонхилох ганцхан шалтгаан, эх үүсвэр гэж үгүй. Тухайн үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил бүр өөр өөр учир шалтгаантай, өөр нөхцөл байдалд, өөр ухамсар, хүмүүжил, зан төлөвтэй хүмүүсийн зүгээс үйлдэгддэг. Гэмт зан үйл яагаад бий болдог вэ? гэх асуултад шууд хариулт өгөх, эсхүл гэмт хэргийн учир шалтгаануудыг цогцоор нь, хангалттай байдлаар тайлбарлаж чадахуйц цор ганц онол гэж мөн адил байдаггүй. Гэсэн хэдий ч, бид дараах онолуудыг сонгох болсон шалтгаан нь өсвөр насны хүмүүст гэмт зан төлөв бий болох, улмаар гэмт хэрэг, зөрчилд холбогдох эрсдэл үүсгэдэг гол шалтгаан нь тэдний амьдарч, өсөж, хүмүүжиж буй нийгмийн орчин нөхцөл болохыг эдгээр онол, арга зүйн тусламжтай судалж тогтоон, тодорхой хөтөлбөр, нөлөөллийн ажлаар дамжуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, бууруулж чадсан явдал юм. Өөрөөр хэлбэл, гэмт явдал нь тухайн хүүхдэд төрөлхийн өвлөгдөн ирдэг эмгэг биш бөгөөд өсвөр насны хүмүүсийн өсөж, хүмүүжиж, амьдарч буй нийгмийн орчин нь өөрөө эрсдэлтэй

²² Schneider. S., Crime Prevention: Theory and Practice, CRS Press Tylor & Francis Group. 2010. p 79.

²³ Г.Оюунболд. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. Улаанбаатар. 2017. 69 дэх тал.

(эмгэгтэй), аюултай байх нь хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөх үндсэн шалтгаан²⁴ гэж үздэгт оршино.

НХСГХУС дараах онолуудыг судалснаар ирээдүйн гэмт зан үйлээс урьдчилан сэргийлэх, хэвийн бус нийгмийн орчныг засаж сайжруулах арга зүйд суралцах юм. Наад зах нь цагдаагийн байгууллагын алба хаагчид, хууль сахиулагчдын зүгээс өсвөр насны хүмүүст нийгмийн хэвийн бус орчин нөхцөлийн улмаас үүссэн хүндрэлтэй асуудал, сэтгэл санааны хямралыг даван туулах тэсвэр тэвчээр, уян хатан байдлыг бий болгоход нь туслах, “хамгаалалтын хүчин зүйлс”-ийг тодорхойлох мэдлэг, чадвар эзэмших шаардлага бий болж байна. Учир нь гэмт хэрэг, зөрчилд холбогдох эрсдэл өндөртэй өсвөр насны хүмүүс цагдаагийн байгууллагын бүртгэл, судалгаанд ордог хэдий ч, цагдаагийн байгууллагын зүгээс тэдэнд чиглэсэн нөлөөллийн ажил, арга хэмжээг дангаараа болон иргэд, олон нийт, боловсролын байгууллагатай хамтран зохион байгуулах ажил хангалтгүй байна. Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж буй 25 хүүхдээс ярилцлагын аргаар судалгаа авахад “Цагдаагийн байгууллагад итгэдэггүй, цагдаа зөвхөн тэднийг болон эцэг, эх, асран хамгаалагчийг торгодог, баривчилдаг” гэж 80% нь хариулжээ.

Английн эрдэмтэн Дэвид Фаррингтон (David Farrington) эрсдэлт хүчин зүйлсийг “Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх эхлэл тавигдах, давтамж, үргэлжлэх хугацааны эрсдэлийг нэмэгдүүлж байдаг урьдач нөхцөл байдал”²⁵ хэмээн тодорхойлжээ. Мөн тэрээр бусад улс, оронд хийгдсэн судалгааны үр дүнгээс эш татахдаа “Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлдөг олон хүчин зүйлс нь үндэслэл, шалтгаан бүхий, мөн дахин давтагдах бүрэн боломжтой байсан”²⁶ гэжээ. Жишээлбэл, тэрээр London and Pittsburgh – ын хоёр судалгааг хураангуйлж²⁷, тодорхой цаг хугацаанд, тодорхой газарт гэмт хэрэг, зөрчил гарч болох, цочмог зан авир, хэт их хөдөлгөөнтэй, идэвхтэй, анхаарал төвлөрлийн асуудалтай, түрэмгий, боловсрол нимгэн, эцэг эхийн хараа хяналт сул, эцэг эх өөрсдөө хоорондоо зөрчилтэй, эцэг эхийн аль нэг нь нийгмийн эсрэг санаа бодолтой, хэт залуу ээж, ядуурал, эрүүл бус харилцаатай, асуудалтай гэр бүл зэрэг урьдчилан таамаглагдахуйц хувь хүний болон нийгмийн хэд хэдэн хүчин зүйлсийг тодорхойлжээ.

Фаррингтон болон бусад судлаачдын зүгээс цаашид гэмт хэрэг үйлдэх зан үйлийг бий болгох эрсдэл бүхий хүчин зүйлсийг дараах байдлаар ангилж үзсэн байна. Үүнд:

Хувь хүний эрсдэлт хүчин зүйлс	
✓	Нийгэм биологийн ба социо-биологийн хүчин зүйлс (сэтгэл мэдрэлийн эсвэл танин мэдэхүйн хомсдол, тархины гэмтэл, зүрхний хэм алдагдал, жирэмсэн үедээ архи хэрэглэдэг эхээс төрсөн хүүхэд);
✓	Эрт үеийн нийгмийн эсрэг зан үйл, асуудал таригч (түрэмгий зан авир, уур бухимдлаа удирдаж чадахгүй байх);
✓	Өөрийгөө хянах чадвар сул, түргэн, цочмог зан байдал;
✓	Асуудал шийдвэрлэх чадвар сул, бүтээлч сэтгэлгээ болон хийсвэр ойлголтыг тунгаах чадваргүй, өөрийн хийсэн үйлдлийн үр дагаврыг таньж, ойлгож чаддаггүй, асуудлыг эерэгээр шийдвэрлэх чадваргүй;
✓	Бусдыг ойлгож, мэдрэх чадвар сул;
✓	Сэтгэцийн эмгэг өвчтэй;
✓	Сэтгэлзүйн тодорхой эмгэгтэй (ADHD, ODD, нийгмийн эсрэг эмгэг/Conduct Disorder)

²⁴ Schneider. S., Crime Prevention: Theory and Practice, CRS Press Tylor & Francis Group. 2010. p 79.

²⁵ Farrington, D.P., Childhood risk factors and risk-focused prevention, in The Oxford Handbook of Criminology, 4th edn., Maguire, M., Morgan, R., and Reiner, R., Eds., Oxford University Press, Oxford, U.K., 2007, pp. 602–640.

²⁶ Мөн тэнд.

²⁷ Farrington, D.P. and Loeber, R., Transatlantic replicability of risk factors in the development of delinquency, in Historical and Geographical Influences on Psychopathology, Cohen, P., Slomkowski, C., and Robins, L.N., Eds., Lawrence Erlbaum, Mahwah, NJ, 1999, pp. 299–329.

✓	Паранойд шизофрени;
✓	Архи, мансууруулах бодисын хэт хэрэглээ;
✓	Сурлага муудах, хичээлдээ явахгүй байх, сургуулиа хаях, сургуулиас хасагдах.
Гэр бүлийн эрсдэлт хүчин зүйлс	
⇒ Эцэг эхийн онцлог шинж чанар	
✓	Эцэг, эх сэтгэцийн эмгэг өвчтэй байх;
✓	Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн;
✓	Архи, мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэдэг;
✓	Гэр бүлийн хүчирхийлэл (эхнэр, нөхрийн аль нэг нь нөгөөхөө хүчирхийлэх);
✓	Эцэг, эхийн зөрчил;
⇒ Хүүхэд хүмүүжүүлэх, халамжлах	
✓	Хүүхэдтэйгээ зөрчилдөх;
✓	Хатуу, чанга гараар хүмүүжүүлэх;
✓	Эцэг, эхийн хүүхэдтэй тавих хараа, хяналт сул байх;
✓	Үл хайхрах;
✓	Хүйтэн хөндий хандах, үл тоомсорлох, хүүхдээсээ татгалзах;
✓	Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл, хүүхэдтэй зүй бус харьцах;
⇒ Гэр бүлийн онцлог шинж чанар	
✓	Хэт олуулаа гэр бүл;
✓	Гэр бүл салалт, тусгаарлалт;
✓	Нийгэм, эдийн засгийн байдал доогуур байх, ядуурал;
Сургуулийн орчин, суралцах үйл ажиллагаатай холбоотой эрсдэл	
✓	Сургуулийн зүгээс ирэх хүчирхийлэл, дарамт, дээрэлхэлтийг үл хайхрах;
✓	Хичээл таслалт өндөр байх, сургуулиас хөөж байсан тохиолдол олон байх, сургууль завсардах;
✓	Сургуулийн зүгээс хүүхдийг залхаах, шийтгэх арга техник ашигладаг байх;
✓	Хүнд нөхцөлд орсон, эсвэл асуудал тулгарсан хүүхдэд нотолгоонд суурилсан дэмжлэг үзүүлэх систем байдаггүй.
Орон нутгийн буюу амьдарч буй орчин, хүмүүсийн зүгээс үзүүлэх эрсдэлт хүчин зүйлс	
✓	Таагүй, эмх замбараагүй орчин;
✓	Амьдарч буй орон сууц, байшин, орчны хүнд нөхцөл;
✓	Хүчирхийллийн зан үйлтэй үе тэнгийнхэнтэй ойр амьдрах;
✓	Тухайн оршин суугаа газарт гэмт хэрэг, зөрчлийн гаралт өндөр байх;
✓	Гэмт хэрэг үйлдэх өдөөгч хүчин зүйлс болох архи, мансууруулах бодис, зэвсэг зэргийг тухайн оршин суугаа газраас хялбархан олж авах боломжтой байх зэрэг эрсдэлүүд ордог байна.

Хичээл сургууль, хүүхэд хүмүүжлийн арга, залуу ээжүүд, хүүхдийн хүчирхийлэл, эцэг эхийн зөрчлийн асуудлууд, хагаралдсан, асуудалтай гэр бүл, ядуурал, гэмт хэрэг, зөрчилд орооцолдсон өсвөр насныхан, гэмт хэргийн гаралт ихтэй орон нутаг зэрэг гэмт хэргийн эрсдэлт хүчин зүйлсийг төрөл бүрийн төсөл хөтөлбөр, үйл ажиллагаагаар дамжуулан нийгмийн хөгжилд суурилсан аргачлалаар урьдчилан сэргийлэх, шийдвэрлэхэд анхаарах үзэх зайлшгүй шаардлагатай.

Нийгмийн гажуудлын болон аномийн онол

Францын нийгэм судлаач Эмиль Дюркгейм (Emile Durkheim) “аноми” (anomie) гэдэг санааг анх 1893 онд бичсэн “Нийгэм дэх хөдөлмөрийн хуваагдал” бүтээлдээ илэрхийлсэн юм. Эмиль Дюркгейм нийгэмд хүмүүс хоорондоо хэрхэн харьцах, биеэ

хэрхэн авч явах талаар тогтоосон эрх зүй, ёс зүйн аливаа хэм хэмжээ алдагдсаны улмаас үүссэн зохицуулалтгүй хоосон орон зайг “аноми” гэдэг үгээр илэрхийлсэн. Тэрээр “аноми” нь нийгмийн хэм хэмжээ нь ойлгомжгүй, төөрөгдүүлсэн, эсвэл хүмүүст хүлээн зөвшөөрөгдөхгүй байдлыг үүсгэдэг”²⁸ гэж үзсэн.

Эмиль Дюркгейм “Гэмт хэрэг болон нийгэмд харш зан үйл нь “аноми”-н үр дүнд бий болдог. Учир нь нийгмийн нийтлэг хэм хэмжээ, үнэт зүйл алдагдаж, энэ нь нийгэмд харш зан үйл рүү хүмүүсийг хөтөлдөг. Зарим хүмүүс өөрийн дотоод үнэт зүйлс, зан төлөвтөө дасан зохицсон байдаг нь нийгмийн нийтлэг хэм хэмжээ, үнэт зүйлтэй нийцдэггүй байна. Энэ нь ихэвчлэн нийгмийн хурдтай өөрчлөлт, шилжилтийн үйл явц, түүнээс үүдэлтэй төвөгтэй, нийгмийн эмх замбараагүй байдал үүсэхэд илүү тод харагддаг бөгөөд гэр бүл, хамт олон, олон нийтийн хяналт алдагдаж, тэр нь нийгэмд нөлөө үзүүлж чадахаа больж эхлэх үед тод илэрдэг”²⁹ гэж үзсэн.

Дюркгеймийн үзэл санааг өөрийнх нь амьдарч байсан цаг үетэй холбон үзэхээс өөр аргагүй. Тэрээр өөрийн бүтээлдээ “XIX зууны сүүлээр Европ болон Америкт аж үйлдвэржилт, хотжилт, олон улсын шилжилт хөдөлгөөн гэх мэт томоохон өөрчлөлтүүд өрнөж байлаа. Эдгээр нь нийгмийг тогтворгүй болгож, нийгмийн нийтлэг хэм хэмжээнд “аноми” байдал үүсгэж, үүнээс шалтгаалаад нийгэмд харш гэмт зан үйл, гэмт хэрэг, зөрчил өсөхөд хүргэдэг”³⁰ гэж үзсэн. Гэмт хэрэг, зөрчил, нийгэмд харш зан үйл нь нийгмийн орчин нөхцөлөөс үүсдэг гэсэн таамаглал дэвшүүлж, онолын шинжтэй үзэл баримтлал боловсруулсан анхны эрдэмтдийн нэг нь Эмиль Дюркгейм байсан юм.

Нийгмийн гажуудлын эх үүсвэр, учир шалтгааныг нийгмийн өргөн хүрээнд орчин нөхцөлтэй холбон тайлбарласан түүний үзэл санаа дээр үндэслэн Роберт Мертон (Robert Merton) гэмт хэргийн талаар шинэ онол дэвшүүлсэн. Түүний үзэж байгаагаар хүмүүсийн зорилгодоо хүрэх боломж, арга болон нийгмийн бодит байдал хоёрын хооронд зөрчил, сөргөлдөөн үүсэж, үр дүнд нь “дарамт” бий болдог. Энэхүү “дарамт” нь зарим хүмүүсийг зорилгодоо хүрэх замаа буруу сонгоход хүргэж, гэмт зан үйл бий болох, улмаар гэмт хэрэг үйлдэхэд хүргэдэг байна³¹. Тэрээр энэ үзэл санаагаа “strain” буюу “дарамт” гэж томъёолсон.

Хүрэх ёстой хэмээн үзэж буй зорилго (эд хөрөнгө, баялаг), тэрхүү зорилгодоо бодитойгоор хүрэх бололцоо хоёрын хоорондох зөрчилдөөн үүсэхэд хүмүүс дарамт мэдэрдэг.

Нийгмийн бусад гишүүдтэй ижил нийтлэг зорилгод (сайн боловсрол эзэмших, хангалуун сайхан амьдрах г.м) хүрэхэд боломжгүй болсон үед хүмүүс дарамт мэдэрч, нийгмийн нийтлэг хэм хэмжээг хүлээн зөвшөөрөхгүй болж, гэмт хэрэг үйлддэг. Нийгмийн баялгийн тэгш бус хуваарилалт, хүмүүсийн нийгэм, эдийн засгийн зорилгодоо хүрэх боломжийг адил тэнцүү олгохгүй (баян хоосны ялгаа, ялгаварлан гадуурхалт, хүйсийн тэгш бус байдал, хөдөө хотын ялгаа, улс, орон нутгийн эдийн засгийн доройтол г.м) байгааг харвал Мертоны онол ойлгомжтой болно.

Тэрээр үүний хамгийн тод жишээ бол алдартай “Америк мөрөөдөл” (American Dream) гэж үзсэн. Мертон “Бүх иргэдээ “...амжилтад хүр” гэж уриалдаг мөртлөө, амжилтад хүрэх боломж бололцоог нь тэгш бусаар хуваасан”³² гэж шүүмжлээд “эдийн засгийн баялгийг бий болгож, нийгмийн давхарга, амьдралын нөхцөлөө дээшлүүлэх тэгш боломж, зам нь тухайн нийгэмд хаагдсан, эсвэл нарийссан байх аваас түүний үр дүнд нийгэмд харш, гэмт зан үйл бий болох өндөр магадлалтай”³³ гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, гэмт явдал нь нийгмийн зарим гишүүддээ амалж, итгүүлсэн боломж нь бодит байдал дээр эсрэгээрээ байгаагаас шалтгаалан үүсдэг гэсэн үзэл санаа юм. Энэ санаа нь нийгмийн доод давхаргын буюу ядуу, орлого багатай, бидний

²⁸ Schneider. S., Crime Prevention: Theory and Practice, CRS Press Tylor & Francis Group. 2010. p 79.

²⁹ <https://www.britannica.com/topic/anomie>.

³⁰ Д.Зүмбэрэллхам. Криминологийн онол, Улаанбаатар, 2022, 175 дахь тал.

³¹ Merton. R, Social Structure and Anomie, American Sociology Review, 3, 672-682, 1938.

³² Мөн тэнд.

³³ Мөн тэнд.

хэлж заншсанаар, эмзэг давхаргын хүсэл, зорилгыг ойлгоход нэн чухал юм. Санхүүгийн боломжгүй, орлого багатай хүн зорилгодоо хүрэх хүсэл нь хүчтэй, бухимдлын мэдрэмж өндөр байх тусмаа гэмт хэрэг үйлдэх эрсдэл өндөр байна. Мертоны үзэж байгаагаар нийгмийн гажуудал, гэмт хэрэг, зөрчил гарах гол шалтгаан нь нийгмийн гишүүдийн хүсэл эрмэлзэл, зорилго ба тэрхүү зорилгодоо хүрэхийн тулд ашиглаж буй арга хэрэгслүүдийн зөрчилдөөнд оршдог байна.

Мертон “Нийгэмд дийлэнхээр хүлээн зөвшөөрөгдсөн, цөөнхөөр сайшаагдсан цөөн тооны арга хэрэгслүүд байдаг. Харин тодорхой зорилгод хүрэх боломжийн тэгш бус байдлаас шалтгаалаад дийлэнхээр хүлээн зөвшөөрөгдсөн арга хэрэгслээс өөр байдлаар зорилгодоо хүрэх эрмэлзлэлийг олон нийтийн дунд бий болгодог. Үүнээс үүдэлтэйгээр бие хүний зорилго, арга хэрэгслийн хоорондын зөрчилдөөн нийгмийн гажуудлыг бий болгодог”³⁴ гэж үзжээ.

Зарим хүмүүс “...амжилттай болно” хэмээн үзэж, гэмт хэргийн арга замыг сонгодог. Учир нь тэдэнд зорилгодоо хүрэх нь л хамгийн чухал байдаг. Харин зорилгодоо хэрхэн хүрэх эсэх нь чухал биш. Энэ нь нийгэмд харш гэмт зан үйл үүсэх, гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан болдог байна.

НХСГХУС стратеги хөтөлбөрүүд нь дарамтын улмаас нийгмийн эсрэг гэмт зан үйл, гажуудалтай болсон эрсдэл бүхий хүмүүст хамгийн тохиромжтой гэж үздэг. Нийгмийн дарамттай холбоотой эрсдэл бүхий хүүхэд, залуусыг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зан үйл, сэтгэл хөдлөл, боловсрол, мэргэжлийн сургалт болон нийгмийн хөгжлийн хөтөлбөрүүдэд хамруулснаар үүсэж болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлж, бууруулахад чухал шаардлагатай юм. Тухайлбал:

1.Нийгмийн дунд байж хөгжиж дэвжих, амжилтад хүрэх боломж, давуу талыг олж авна;

2.Амьдралын таагүй байдал, дарамтаас үүдэлтэй бий болох гажууд зан үйлээс зайлсхийж чадна;

3.Тэдний гаднаас буюу хүрээлэн байгаа нийгмийн орчноос ирэх, өөрсдөө шийдэж чадахгүй байгаа урмыг нь хугалсан, бухимдал төрүүлсэн аливаа асуудлыг нь шийдвэрлэхэд туслах боломжтой.

Ялгамжтай байдлын холбооны онол

Дифференциал буюу ялгамжтай байдлын холбооны онолын байр сууринаас нийгэмд харш, гэмт зан үйлийг маш энгийнээр тайлбарлавал, хаагдмал хүсэл тэмүүллийн хариу үйлдэл, эсвэл уур бухимдал, сэтгэл гутарлаа зөнгөөрөө илэрхийлж буй үйлдэл биш юм. Эдвин Сатерлендын (Adwin Sutherland) үзсэнээр, хүмүүс нийгмийн харилцаанд оролцох явцад нийгэмд мөрдөгдөж буй хэм хэмжээг хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Харин нийгмийн харилцаанд оролцохдоо тэрхүү хэм хэмжээг үл хүндэтгэх, үл мөрдөх аваас тэд гэмт хэрэгтэн болдог. Энэхүү онолын үзэл баримтлалын гол санаа нь нийгмийн зан үйл нь нийгмээс суралцсаны үр дүнд бий болдог гэх үзэл юм. Нийгэмд харш, гэмт зан үйл ч мөн ялгаагүй. Түүнийхээр бол гэмт чиг хандлага нь зөвхөн гутранги нөхцөл байдал дээр үүсдэггүй. Харин тэрхүү чиг хандлага нь тухайн хүний амьдарч буй орчинд хэрэв нийгэмд харш, гэмт зан үйл ажиглагдаж, суралцах, даган дуурайх, хэн нэгэнтэй холбогдох, тэр нь ялангуяа түүнтэй ойрын харьцаатай гэр бүл, найз нөхөд, хүндэлдэг, даган дуурайдаг хүн байж таарвал түүний нийгэмд харш зан үйл нь шууд гэмт хэрэг үйлдэхэд хүчтэй нөлөөлдөг. Цаашлаад нийгмийн тогтсон хэм хэмжээ, хууль дүрмийг үзэн ядаж, шигших үзэлтэй хүмүүс эргэн тойронд нь байвал “сурагч” нь тэдэнтэй яг адил алхмыг хийж, даган дуурайдаг. Товчхондоо гэмт болон бусад нийгэмд харш зан төлөв нийгмийн тогтсон харилцаа, холбооны үр дүнд бий болж, түүгээр дамжиж нийгмийн нийтлэг эрх, ашиг сонирхолд харш, хууль тогтоомж, хэм хэмжээг зөрчигсөдтэй харилцаа холбоо үүсгэгч үл бүтэх хүмүүстэй хэдийнээ холбоо тогтоогоод амждаг. Ингэснээр тэдний болон

³⁴ Schneider. S., Crime Prevention: Theory and Practice, CRS Press Tylor & Francis Group. 2010. p 80.

нийгмийн хэм хэмжээ, хууль дүрмийг дагаж мөрддөг жирийн хүмүүс хоёрын хооронд зааг ялгаа үүсдэг болохыг тогтоожээ.

Уг онол нь криминологийн шинжлэх ухаанд маш хүчтэй байр суурийг эзэлдэг. Учир нь энэ онолын тусламжтайгаар гэмт зан үйлийн учир шалтгааны талаар, тодруулбал, архаг гэмт хэрэгтнүүдийн хүүхэд ахуй насанд нь бий болсон сөрөг зан үйл нь үл бүтэх хүмүүсийг үлгэр дуурайллаа болгож, тэднээс суралцдаг, эцэстээ гэмт хэрэг үйлддэг талаар танин мэдэж байдаг. “Галууг дуурайж хэрээ хөлөө хөлдөөх”-ийн үлгэрээр зохисгүй зүйлсийг дуурайж хохирох эрсдэл өндөр байдаг ажээ.

Мөн эцэг, эх нь хүчирхийлэл үйлддэг гэр бүлд өссөн хүүхэд хүчирхийлэгч болох эрсдэл өндөр байдаг нь судалгаагаар тогтоогдсон. Мөн эцэг, эх нь архи, мансууруулах бодис хэрэглэдэг гэр бүлд өссөн хүүхэд архи, мансууруулах бодис хэрэглэх өндөр эрсдэлтэй байдаг. Өсвөр насны хүмүүс гэмт хэрэгтнүүдтэй нийлдэг бол тэднээс байнгын зүй бус дарамт, шахалтыг амсаж, гэмт хэрэгт суралцан, улмаар гэмт хэрэгтэн болдог³⁵. Үүнээс гадна телевиз, цахим орчинд хүчирхийлэл, гэмт хэргийг үзүүлсэн кино, бичлэг, тоглоом тоглох нь өсвөр насны хүмүүсийг хүчирхийлэгч болгох зам руу түлхдэг хүчин зүйл болдог.

Өсвөр насны хүүхдүүдэд гэмт зан төлөв, нийгэмд харш зан үйл бий болоход тэдний өсөж, хүмүүжсэн таагүй орчин, ядуу зүдүү байдал, эмх цэгцгүй нийгмийн орчин, үл бүтэх хүмүүсийн нөлөө зэргээс шалтгаалан үүсдэг болох нь судалгаагаар тогтоогджээ. Бидний авч үзэж буй нийгмийн хөгжилд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам нь туршиж нотлогдсон хөтөлбөр, стратегийн тусламжтайгаар өсвөр насны хүмүүст нийгмийн эерэг орчныг бий болгож, тэдний зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг. Хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн анхаарал, халамж, гэр бүлийн тогтвортой орчин чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймд зөвхөн хүүхдийг биш хүчирхийлэл үйлдэгч, үйлдэх магадлалтай эцэг, эхийг зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах замаар асуудлыг шийдэх боломжтой юм.

Мөн хүүхдүүдийг эрсдэлтэй, сөрөг нийгмийн орчин, гэр бүлээс түр болон удаан хугацаагаар холдуулж, эерэг орчинд байлгах аргыг хэрэглэж болно. Тухайлбал, спортын бэлтгэл, зуны сургалтад хамруулах, асрамжийн төвд байлгах зэргээр таагүй орчноос нь холдуулах арга хэмжээ авах боломжтой. Түүнчлэн олны танил, нийгэмд нэр хүндтэй насанд хүрсэн хүмүүсийн дэмжлэгийг авч, ментор хөтөлбөрт хамруулан, тэднээс биеэ хэрхэн авч явахаас эхлээд бусад эерэг зан үйлийг даган дуурайх боломжийг бүрдүүлэх нь өсвөр насны хүмүүсийн төлөвшилд ихээхэн үр дүнтэй аргын нэг болдог. Нэгэнт нийгмийн таагүй орчинд амьдарч, өсөж хүмүүжиж байгаа хүүхдэд таагүй байдлыг даван туулах, тэсвэр, тэвчээр суулгах, үүссэн асуудлыг оновчтой шийдвэрлэх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сэтгэл зүйн сургалт зохион байгуулах шаардлага үүсдэг.

Нийгмийн орчноос суралцахуйн онол

Криминологийн салбарт өргөн хэрэглэгддэг энэ онол нь Адвин Шатерландын ялгамжтай байдлын холбооны онолын үзэл баримтлалтай тун төстэй юм. Тухайлбал, уг хоёр онолын гол үзэл санаа нь гэмт зан үйл төлөвших явдал нь нийгмийн таагүй орчны нөлөөгөөр бий болдог, гэмт хэрэгтэн болох эсэх нь тухайн хүний чухам ямар орчинд өсөж, хэнтэй нийлж, хэнийг даган дуурайж байснаас ихээхэн шалтгаалдаг гэж үздэг явдал юм.

Уг онолыг үндэслэгч Альберт Бандура (Albert Bandura) нь “Хүний зан үйл, төлөвшилд хэд хэдэн хүчин зүйлс хүчтэй нөлөөлдөг. Хүний зан үйл, танин мэдэхүйн хүрээ, орчин гэсэн гурван хүчин зүйлийн хүрээнд тасралтгүй эргэлдэж байдаг”³⁶ гэж үзсэн.

³⁵ Ross L. Matsueda. The current State of Differential Association Theory <https://faculty.washington.edu/matsueda/Papers/Current>.

³⁶ Bandura, A., Social Learning Theory, General Learning Press, New York, 1977.

Мөн Бандура “Хүний зан үйл төлөвшихөд орчин нөлөөлдөг” гэж үздэг ч, “...эргээд орчин нь хүний үйл ажиллагааны үр дүн болдог учраас хүмүүс өөрөө өөрийнхөө зан үйлд ямар нэгэн нөлөө үзүүлэх боломжтой. Хүнээс ямар зан үйл гарна түүнээс нь шалтгаалан хүний орчин өөрчлөгддөг”³⁷ гэжээ. Үүнд үндэслэн тэрээр түрэмгий зан авир өсвөр насныхны дунд хэрхэн бий болдог гэдгийг тайлбарласан. Түрэмгий, хүчирхийлэгч зан чанар бүрэлдэх явдал нь тухайн хүүхдүүдийн дотоод ухамсараас үүсдэг гэхээсээ илүүтэйгээр, тэдний гэр бүлийн гишүүд, мэдээллийн хэрэгсэл, эргэн тойрон дахь нийгмийн орчноос ерөнхийдөө шалтгаалдаг байна. Хүүхэд эцэг, эх бусад хүмүүсийг, гадна орчин тойрноо ажигласнаар танин мэдэх, өөрийн зан үйлийг бий болгох боломжтой. Жишээ нь: хэрэв хүүхдийг бүр багаас нь хүүхэлдэйтэйгээ чихрээ хувааж идэх “зан үйлийн загварчлал”-д сургавал улмаар найзтайгаа, бусадтай хуваалцах, насанд хүрээд бусдад туслах боломжтой юм. Тиймээс хүүхэд түрэмгий зан чанарыг хөндлөнгийн “зан үйлийн загвар”, процессоор дамжуулан суралцдаг. Ялангуяа хүүхэд насанд хүрэгсэд, эцэг, эхчүүдийн үзүүлж буй түрэмгий зан үйлийг даган дуурайж, суралцаж, улмаар уг зан авир нь дадал, зуршил болон тогтдог. Эцэг эхийн зүгээс үүссэн аливаа асуудлыг уур уцаар, хүчирхийллийн замаар шийдвэрлэдэг бол хүүхэд хожим нь үүссэн асуудалд эцэг, эхийн мөн адил хандаж, хариу үйлдэл үзүүлдэг. Энэ нь байгалийн хариу үйлдэл бөгөөд асуудлыг даван туулах механизм болдог. Тиймээс гэр бүлийн орчин хүүхдийн эерэг болон сөрөг зан үйл төлөвшихөд маш чухал нөлөө үзүүлдэг. Бандура “үлгэр жишээ үзүүлэх байдлаар хүүхдийг сургаж болно” гэсэн нь чухал санаа бөгөөд хүүхэд хүмүүсийн юу хийж байгааг эхлээд ажиглана, дараа нь дуурайж эхэлдэг байна.

Нийгмийн хөгжилд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга нь дийлэнхдээ түрэмгийлэл, хүчирхийллийн зан үйлтэй хүүхдүүдийн сэтгэл зүйн байдлыг тогтоож, урьдчилан сэргийлэх болон сэтгэл зүйн эерэг нөлөөлөл үзүүлэх хөтөлбөрт хамруулдаг³⁸. Үүнд: уур уцаараа хэрхэн барих (anger management), зөрчлийг хэрхэн шийдвэрлэх (conflict management) чадвар, үүссэн асуудлыг эергээр шийдвэрлэх чадвар, өөрийгөө бусдын оронд тавих чадвар, сэтгэл хөдлөлөө хянах, нийгэмд харш зан үйлийн сөрөг үр дагаврыг ойлгож, ухамсарлах чадвар суулгах зэрэг хөтөлбөр, нөлөөллийн арга хэмжээнүүд багтана. Мөн түрэмгий зан, нийгэмд харш зан, хандлагыг өөрчлөхөд танин мэдэхүйн зан үйлийн сэтгэл заслын арга үр дүнтэй байдаг. Хүүхдийг хүчирхийлэлтэй, эрсдэлт орчноос холдуулж, илүү аюулгүй орчинд байлгах хөтөлбөр нь нийгмийн орчноос суралцахуйн болон дифференциал холбооны онол дээр бүрэн тулгуурлан явагддаг. Түүнчлэн эрсдэлт бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн ментор хөтөлбөрөөр дамжуулж, тэднийг сөрөг, муу нөлөөтэй хүмүүсээс хөндийрүүлж, эерэг үлгэр дуурайлал болох хүмүүс, зөвлөгчийн туслалцаатай засаж авах бололцоотой юм.

Хяналтын болон нийгмийн холбооны онол

Америкийн Нэгдсэн Улсын социологич Трэвис Хирши (Travis Hirschi) 1960-аад оны сүүлчээр гэмт явдлын талаар судалж, энэхүү онолыг боловсруулсан байна. Тэрээр яагаад хүмүүс гэмт хэрэг үйлддэг вэ? гэдэгт бус харин яавал хүмүүс гэмт хэрэг үйлдэхгүй байх вэ? гэсэн асуултад хариулж, үүнийг тайлбарлахыг зорьсон. Энэхүү асуултын хариултаа нийгмийн хяналт гэсэн үзэл баримтлалд тулгуурлан гаргаж тавьсан. Тэрээр “Нийгмийн дотно холбоо, нэгдлээр дамжуулан, тухайн хүнийг хувиа хичээсэн үзлээ тэвчиж, хууль, дүрэмд нийцүүлэн амьдрахад дэмжлэг үзүүлэх боломжтой”³⁹ гэж үзсэн. Нийгмийн ийм харилцаа, холбоо байхгүй газар хүмүүст аминч үзэл, сонирхол бий болох өндөр эрсдэлтэй байдаг. Энэ нь цаашлаад гэмт зан үйл рүү хөтлөх магадлалтай.

³⁷ Мөн тэнд http://www.asecib.ase.ro/mps/Bandura_SocialLearningTheory.pdf.

³⁸ Goldstein, A.P., Glick, B., Gibbs, J.C., Aggression Replacement Training: A Comprehensive Intervention for Aggressive Youth, Research Press, Champaign, IL, 1998.

³⁹ Schneider, S., Crime Prevention: Theory and Practice, CRS Press Tylor & Francis Group. 2010. p 83.

Мөн Хирши “Өөрийгөө хянах үзэл бодол нь эрт төлөвшиж, гүн шингэсэн хүн нийгэмд харш буруу зүйлд уруу татагдахгүй, гэмт хэрэгт холбогдохгүй байх чадвартай байдаг”⁴⁰ гэжээ. Гэмт зан үйл нь хоромхон зуурын сэтгэл ханамжаа гүйцэлдүүлэхэд нөлөөлдөг. Харин хууль сахидаг иргэн хэн нэгнийг хохироох, эсвэл өөрөө гэмт зан үйлийн золиос болох, түүндээ хөтлөгдөх явдлаас ангид байж чаддаг. Учир нь тэд өөрийнхөө зан үйлийг хянаж чаддаг бөгөөд нийгэмд харш үйлдэлд бусдыг уруу татдаггүй. Тиймээс өөрийгөө хянах чадвар сул байх нь нийгэмших үйл явц нь гажуудалтай байдгаас улбаатай бөгөөд бага насандаа нийгэмшлийн эерэг үр нөлөөг мэдрээгүй хүүхэд ихэвчлэн нийгэмд харш зан үйлтэй болдог.

Хиршин үзсэнээр, нийгэмшлийн болон хүмүүс хоорондын нийцлийг сайжруулдаг нийгмийн хяналтын дараах 4 өөр хоорондоо харилцан уялдаатай холбоо хамаарал байдаг ажээ. Үүнд:

1. Дотно холбоо;
2. Үнэнч байдал;
3. Оролцоо;
4. Итгэл үнэмшил зэрэг багтана.

Хирши “...эдгээр хүмүүс хоорондоо нягт холбоотой байх тусам нийгэмд харш зан үйл төдий хэмжээгээр бага байдаг” гэжээ. Мөн түүний үзсэнээр, эдгээр чухал холбоо нь өсвөр насны хүмүүсийг эерэгээр нийгэмших, өсөж хүмүүжихэд дэм болдог. Энэ нь эцэг, эх, гэр бүл, найз нөхөд болон сургууль, хамт олон зэрэг тухайн хүүхэдтэй хамгийн ойр буй нийгмийн бүтэц хоорондын дотно холбооноос хамааралтай юм. Эцэг, эхчүүд хүүхэдтэйгээ ойр дотно байж, хамтдаа цагийг таатай өнгөрүүлэх, бие биенийгээ мэдрэх, илэн далангүй байх зэрэг эерэг харилцаа нь дотно харилцаа холбооны чухал хүчин зүйл болдог. Мөн тэрээр “...хүүхэд хичээл сурлагадаа тааруу байх нь сөрөг зан үйл бий болоход шууд бусаар нөлөөлдөг”⁴¹ гэж үзсэн. Оюун ухаан, танин мэдэхүй, хичээл сургалттай холбоотой асуудал нь тухайн хүүхдийн сурлагын үзүүлэлтэд нөлөөлж, үүнээс хамаарч хичээлдээ дур сонирхолгүй болох, улмаар багш нар, сургуулийн захиргаа нь үл хүндэтгэж эхэлдэг. Тиймээс эцэг, эх, сургууль хоёрын хоорондын сул харилцаанаас болж нийгэмшлийн эерэг процесс, өөрийгөө хянах байдал алдагдаж, ойворгон занг нэмэгдүүлж, сөрөг зан үйл болон гэмт хандлагыг төрүүлдэг байна.

Хамгийн сүүлийн холбоо нь нийгмийн үнэт зүйл, тогтсон хэм хэмжээнд итгэх, хууль дүрмийг хүндлэх ухамсар, зан байдлаар тодорхойлогдоно. Харин энэхүү итгэл үнэмшил суларсан, дутагдсан тохиолдолд хүмүүс нийгэмд харш, хууль бус үйлдэл хийх магадлал өсдөг. Хиршин ахлах ангийн сурагчид, залуусын дунд хийсэн судалгаагаар, хэрэв нийгмийн хууль дүрэм, шударга ёсонд итгэх залуусын итгэл алдарвал нийгмийн холбоо харилцаа суларч, улмаар нийгэмд харш, хууль бус үйлдэл хийх магадлал өсдөг болох нь харагдсан. Тэрээр дээрх 4 холбоо нь өсвөр насны хүмүүс нийгэмд харш, гэмт зан үйлээс урьдчилан сэргийлдэг болохыг нотолсон.

Энэхүү онолоор нийгмийн хөгжилд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам үндсэн 2 эерэг үр дагаврыг бий болгодог гэж үздэг. Нэгдүгээрт, гэмт хэрэг, зөрчилд холбогдох эрсдэлтэй өсвөр насны хүмүүсийг тэдний эцэг, эх, гэр бүл, сургуультай нь дотно холбоотой байлгахад анхаарах. Хоёрдугаарт, ойворгон занг өдөөдөг тэрхүү өдөөгч хүчин зүйлийг хянах чадварыг тэдэнд олгох замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлдэг идэвх, санаачилгатай үйл ажиллагаа юм.

Нийгмийн хөгжилд суурилсан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад архаг гэмт хэрэгтнүүд өөрийгөө хянах чадвар сул,

⁴⁰ Hirschi Travis and Gottfredson, *General Theory of Crime*, Stanford: Stanford University Press, 1990.

⁴¹ Barbara J. Costello and John H. Laub, *Social Control Theory: The Legacy of Travis Hirschi's Causes of Delinquency*, *Annual Review of Criminology*. 2020. 3:21–41 <https://prohic.nl/wp-content/uploads/2021/01/150-14jan2021-SocialControlTheoryOverview.pdf>.

ойворгон зантай, асуудал шийдвэрлэх чадваргүй, аливаа үйлдлийг бодолгүйгээр хийх явдал нь гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан болсон байна.

Нийгмийн хөгжилд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замын үндсэн интервенцүүд нь өөрийгөө хянах чадвар доогуур байгаа нь ойворгон занг дэвэргэгч хүчин зүйлсийг багасгах, бүтээлчээр эргэцүүлэн бодох чадварыг бий болгох, асуудлыг шийдвэрлэх, даван туулах чадвар эзэмшүүлэх, хувь хүний хариуцлагыг ухамсарлуулах, өөрийн үйлдлийн үр дагаврыг ойлгож, урьдчилан харах чадварыг эзэмшүүлэхэд чиглэгддэг.

Дүгнэлт

Хүүхдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд нөлөөлдөг хувь хүний, гэр бүлийн, сургуулийн, гэмт хэргийн гаралт ихтэй орон нутаг буюу амьдарч буй орчны эрсдэлт хүчин зүйлсийг сайн танин мэдэж, түүнийг бууруулах, арилгахад чиглэсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаагаар дамжуулан, нийгмийн хөгжилд суурилсан аргачлалын тусламжтай урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай болох нь харагдаж байна. Ингэхдээ гэмт хэргийн эрсдэлийн хүчин зүйл тус бүр нь хүн бүрд ялгаатай нөлөөлдөг болохыг анхаарах хэрэгтэй.

Мөн гэмт хэрэг, зөрчил үйлдэж байгаа болон огт гэмт хэрэг үйлддэггүй хүмүүсийн хоорондох онцлог, ялгаатай байдал, ямар зан чанартай хүмүүс гэмт хэрэг үйлдэх хэв шинжийг агуулдаг болох, хүүхэд хэвлийд бүрэлдэхээс эхлэн өсвөр нас хүртэлх хугацаанд эрсдэлт хүчин зүйл ямар ялгаатай нөлөөлж буйг судлах хэрэгцээ, шаардлага урган гарч байна. Тухайлбал, хүүхдийн насны үечлэл бүрд өмнө дурдсан эрсдэлт хүчин зүйлс хэрхэн харилцан адилгүй нөлөөлж, цаашид гэмт хэрэгтэн бие хүн болж төлөвшихөд ямар эрсдэл учруулж болохыг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай юм.

Гэмт хэргийн шалтгааны эрсдэлт хүчин зүйлсийн үүднээс тайлбарлахад, эцэг, эхийн хараа хяналт сул хүүхдүүд нийгэмд харш, гэмт зан үйлтэй үе тэнгийнхэнтэйгээ нийлэх зэрэг сөрөг үр дагаврыг үүсгэдэг болох нь дээрх үзэл баримтлалууд, судалгаагаар тогтоогдож байна⁴².

Санал

Дээрх харьцуулан судалсан, эш татсан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онол, арга зүйд үндэслэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, цагдаа, боловсролын, хүүхэд хамгаалалын болон төрийн бус байгууллагуудтай хамтран хүүхдийн насны үечлэлд тохирсон хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Эрсдэлт гэр бүлд чиглэсэн үйл ажиллагааг эрүүл мэнд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжих байгууллага, цэцэрлэг, сургууль, цагдаа, орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллагын дэмжлэг, оролцоотой хөтөлбөр (гэрээр зочлох, ментор хийх, зөвлөгөө өгөх г.м) хэрэгжүүлэх;
- Эрсдэл бүхий өсвөр насныханд чиглэсэн цагдаагийн байгууллагын идэвх, санаачлагатай урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, уламжлалт хэв маяг, ажлын арга барилаа өөрчлөх. Тухайлбал, гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй өсвөр насны хөвгүүдэд чиглэсэн боловсрол, эрүүл мэнд, хувь хүний хөгжил, спортын сургалтуудыг боловсролын байгууллага, спортын холбоо, клубуудтэй хамтран зохион байгуулах;

⁴² Судлаачийн зүгээс өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэж 4-10 удаа хорих ял шийтгүүлсэн давтан (рецидив) гэмт хэрэгтнүүдээс ганцаарчилсан ярилцлагын аргаар судадгаа авахад судалгаанд оролцогчдын 80% нь эцэг эхийн хараа хяналт сул, эсвэл сурах сонирхолгүй сургууль завсардсан, түүнээс шалтгаалан нийгэмд харш зан үйлийн төлөвшилтэй үеийн хүүхдүүдтэй нийлж гэмт хэрэг зөрчилд холбогдож байв.

- Сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хорооны цагдаа, хүүхдийн байцаагч, багш нарт тогтмол сургалт явуулах ажлыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, их, дээд сургууль, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагатай хамтран, төвлөрсөн болон бүсчилсэн хэлбэрээр тогтмол зохион байгуулж хэвшин, уг ажилд иргэд олон нийт, эцэг, эхчүүдийг татан оролцуулах;
- Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн тэргүүлэх чиглэл болгон, онцгой анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Ашигласан материал

- Оюунболд, Г. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. Улаанбаатар, 2017.
- Зүмбэрэллхам, Д. Криминологийн онол. Улаанбаатар. 2022.
Гадаад эх сурвалж
- Bandura, A. Social Learning Theory, General Learning Press, New York, 1977.
http://www.asecib.ase.ro/mps/Bandura_SocialLearningTheory.pdf.
- Barbara J. Costello and John H. Laub, Social Control Theory: The Legacy of Travis Hirschi's Causes of Delinquency, Annual Review of Criminology. 2020. 3:21–41
<https://prohic.nl/wp-content/uploads/2021/01/150-14jan2021-SocialControlTheoryOverview.pdf>.
- Goldstein, A.P., Glick, B., Gibbs. J.C., Aggression Replacement Training: A Comprehensive Intervention for Aggressive Youth, Research Press, Champaign, IL, 1998.
- Farrington, D.P., Childhood risk factors and risk-focused prevention, in The Oxford Handbook of Criminology, 4th edn., Maguire, M., Morgan, R., and Reiner, R., Eds., Oxford University Press, Oxford, U.K., 2007.
- Farrington, D.P. and Loeber, R., Transatlantic replicability of risk factors in the development of delinquency, in Historical and Geographical Influences on Psychopathology, Cohen, P., Slomkowski, C., and Robins, L.N., Eds., Lawrence Erlbaum, Mahwah, NJ, 1999.
- Hirschi Travis and Gottfredson, General Theory of Crime, Stanford: Stanford University Press, 1990.
- Merton. R, Social Structure and Anomie, American Sociology Review, 3, 672-682, 1938.
- Ross L Matsueda. The current State of Differential Association Theory
<https://faculty.washington.edu/matsueda/Papers/Current>.
- Schneider, S., Crime Prevention: Theory and Practice, CRS Press Tylor & Francis Group. 2010.
- Wilburn, E., Police-Led Boys' Clubs in England and Wales. 1918-1951. PhD thesis, The Open University. 2020.
Цахим эх сурвалж
- <https://www.britannica.com/topic/anomie>.

**ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС ХҮНИЙ АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДЭД
УЧРАХ ХОХИРЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН
АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

ANALYSIS OF MEASURES TO REDUCE HUMAN
INJURIES FROM TRAFFIC ACCIDENTS

О.Болорцэцэг

ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч

Bolortsetseg O.

Graduate student of the University of Internal Affairs, Police Senior Lieutenant

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол Улсын хэмжээний зам тээврийн осол, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, түүний улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан арга, хэлбэр, шалтгаан, хүчин зүйлийг судалж, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга замын талаар санал-зөвлөмж боловсруулсан.

Abstract: In this report, how the life and health of sheep were damaged by road traffic accidents throughout Mongolia, and the influencing factors study and analyze and prevent accidents and incidents. some ways to reduce are briefly discussed.

Түлхүүр үгс: Автомашин, амь нас, байгууламж, бэртэл, гэмтэл, зам, замын хөдөлгөөний аюулгүй байдал, хохирол, хүн, эрүүл мэнд.

Keywords: Car, Life, facility, injuries, damage, Road, Traffic Safety, damage, person, health.

Үндсэн хэсэг

Зам, тээврийн ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирох явдал дэлхий нийтийн анхаарал татах гол асуудал хэвээр байна. Манай улсын хувьд ч ялгаагүй зам, тээврийн ослоос үүдэлтэйгээр иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирох үзэгдэл түгээмэл ажиглагдаж байна.

Криминологийн шинжлэх ухааны нэг чухал зорилт бол хүн амыг гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх болон гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдлын асуудлын талаарх шинжилгээ, судалгааны ажил хийж, үр дүнтэй санал, зөвлөмжийг бодит амьдралд хэрэгжүүлэх явдал мөн. Зам, тээврийн ослын улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрах асуудал нь мөн адил криминологийн шинжлэх ухааны анхаарах ёстой сэдвийн нэг билээ. Энд тээврийн хэрэгслийг жолоодож буй хүний буруутай үйлдлээс улбаатай үүсдэг хохирол, хор уршгийн асуудал түлхүү яригдах боловч хохирогчийн буруутай үйлдлийн улмаас гарах сөрөг үр дагаврын асуудал ч тодорхой байр суурь эзэлж байдаг онцлогтой юм. Хохирогчийн зан үйл нь гэмт санаа үүсч, хэрэгжихэд нөлөөлсөн тохиолдолд сая нэг хохирогчийн гэм буруутай тухай ярих нөхцөл бүрдэнэ⁴³.

Үүнтэй холбоотойгоор хохирогч судлал буюу виктимологийн тухай асуудал яригдах учиртай. Уг нэр томъёо нь “Victima /хохирогч/ гэсэн латин үг, “Logos” /сургааль/ гэсэн грек үгнээс гаралтай бөгөөд хохирогчийн тухай сургууль буюу хохирогч судлал” гэсэн утгийн илэрхийлнэ. Виктимологи нь хохирогч, түүний мөн чанар, нийгмийн сөрөг үр дагавар бүхий тохироонд хохирогчийн гүйцэтгэх үүргийн тухай сургаал мөн⁴⁴.

Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн виктимологи, түүний объект нь зам тээврийн осолд өртөж, хохирсон жолооч, тээврийн хэрэгслээр зорчигч, явган зорчигч, онцгой тохиолдолд аж ахуйн нэгж байгууллага байна. Монгол Улсад бүртгэгдсэн анхны зам тээврийн ослын хохирогч нь явган зорчигч байсан ба түүнээс

⁴³ Болдбаатар, Ж. Нямдаваа, О. Криминологи. 1 дэвтэр. Улаанбаатар. 2010. 112 дахь тал.

⁴⁴ Нямсүрэн, Ч. Гэмт хэргийн виктимологи. Улаанбаатар. 2005. 36 дахь тал.

хойш автомашин үзэгдэх болж, улмаар зам тээврийн осол ч нэлээд бүртгэгдэж эхэлсэн талаар бүтээлүүдэд дурьдагдсан байна. Тухайлбал, 1925 онд Хятад далайн пүүсийн жолооч Ты Юань Күй Маймаа нь хотын зүүн өмнө гудамжид машинтай давхиж явахдаа хашааны гадна тоглож байсан П.Долгорсүрэн гэгч охиныг дайрч амь насыг нь хохироож байсан, И.М. Майскийн тэмдэглэн үлдээснээр XIX зууны сүүлчээр нийслэл хот, өргөөний гудамжид Монгол эмэгтэйг Оросын консулын сүйх тэрэг дайрсан⁴⁵, XVII зууны сүүлчээр Франц улсад “Морин тэрэгний хөдөлгөөн зохицуулах заавар” нэртэй анхны хөдөлгөөн зохицуулах баримт бичиг гарсан нь одоогийн замын хөдөлгөөний дүрмийн эхлэл байсан гэж үздэг. Өнөөдөр дэлхийд нэг сар тутамд 4800 хүн зам тээврийн ослоор нас барж байна. Энэ нь дэлхийн хамгийн том онгоцнуудын нэгд тооцогддог “Бойнг” гэх 960 хүний суудалтай онгоц сард 5 удаа унаж, осолдож байгаа явдалтай хохирлын хувьд тэнцэж байгаа юм. Дэлхийн улс орны зарим судлаачид “дэлхийн 3 дугаар дайн зам дээр болж байна” гэж дүгнэсэн байдаг.

“Зам тээврийн ослоор хохирогсдод хүндэтгэл үзүүлэх дэлхий нийтийн өдөр”-ийг жил бүрийн 11 дүгээр сарын 3 дахь 7 хоногт дэлхий нийтээрээ тэмдэглэн өнгөрүүлж, хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай. Уг өдрийг анх 1993 онд Английн Вант улсад тэмдэглэсэн ба үүнээс хойш улс орнууд уг арга хэмжээг авто ослоор амь үрэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх, сэтгэл санааны болон бусад хохирол амсаж суугаа тэдний ар гэр, ойр дотныхонд гашуудал илэрхийлэх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх өдөр болгон тэмдэглэж байхаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейгаас шийдвэрлэсэн байна⁴⁶.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.6-д “Зам тээврийн осол” гэж “зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг ойлгоно”⁴⁷ гэж заасан байдаг. Зам тээврийн ослыг хохирлоор ангилаад, зам тээврийн гэмт хэрэг, зам тээврийн зөрчил гэж ялгаж болох юм. Зам тээврийн гэмт хэрэгт Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 “Автотээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ”⁴⁸ буюу түүнээс дээш хохирол учирсан зам тээврийн ослыг хамааруулан ойлгоно. “Зам тээврийн зөрчил” гэдэгт ослын улмаас учирсан хохирол нь эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээргүй, Зөрчлийн тухай хуулийн 14.7.51 дэх хэсэгт зааснаар арга хэмжээ тооцогдох байдлыг хамааруулан ойлгоно.

Хүснэгт №1. 2017-2021 оны хооронд бүртгэгдсэн зам тээврийн ослын тоо

⁴⁵ Энхболд, А. Замын хөдөлгөөний аюулгүй байдал. Улаанбаатар. 2007. 15 дахь тал.

⁴⁶ <https://www.trends.mn/n/7382>.

⁴⁷ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. //Төрийн мэдээлэл. Улаанбаатар. 2015. №28.

⁴⁸ Монгол Улсын Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. Улаанбаатар. 2016. №7.

№	Он	Зам тээврийн осол																							
		Осолд өртсөн нийт хүн			Үүнээс Явган зорчигч			Нийт осолд өртсөн хүнд явган зорчигчийн эзлэх хувь			Амь насаа алдсан хүн			Үүнээс Явган зорчиг			Гэмтсэн хүн			Үүнээс Явган зорчигч			Явган зорчигчийн бүрүүтэй үйлдлээс гарсан осол		
		У/лс	Хот	О/н	У/лс	Хот	О/н	У/лс	Хот	О/н	У/лс	Хот	О/н	У/лс	Хот	О/н	У/лс	Хот	О/н	У/лс	Хот	О/н	У/лс	Хот	О/н
1	2017	5104	3736	1168	4823	3706	1117	94.5	99.2	81.7	392	74	318	111	44	67	4712	3662	1050	2359	2141	218	868	768	100
2	2018	5323	3901	1423	2933	2394	239	49.5	61.4	16.8	562	140	422	132	82	50	4761	3761	1000	2501	2312	189	632	549	83
3	2019	4351	2836	1515	2089	1704	385	48	60	25.4	561	131	430	140	88	52	3790	2705	1085	1949	1616	333	530	451	79
4	2020	3178	1833	1315	1393	1070	323	43.8	58.4	24.6	460	111	319	163	82	81	2718	1722	996	1230	988	242	532	417	115
5	2021	2858	1617	1241	1224	947	277	42.8	58.6	22.3	383	116	267	129	72	57	24	75	1501	974	1095	875	220	442	63

Улсын хэмжээнд 22482 зам тээврийн осолд өртсөн 2858 хүний 383 буюу 13,4 нь амь насаа алдаж, 2475 буюу 86,6 хувь нь гэмтэл, бэртэл авч эрүүл мэндээрээ хохирсон үзүүлэлт гарсан байна.

Монгол Улсын хэмжээнд бүх төрлийн 25429 гэмт хэргийн улмаас 683 хүн нас барсан /амь насаа алдсан/ нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 1.9 хувиар өссөн. Гэмт хэргийн улмаас нас барсан 683 хүний 34.8 хувь нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алджээ. Улсын хэмжээнд хүний амь нас хохирсон гэмт хэргийн 354 тохиолдол бүртгэгдэж, түүнээс 157 гэмт хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтаар хэрэгсэхгүй болгосон, мөн эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шалгасан байх тул статистик мэдээнд нас барсан 284 гэж тусгагдсан байна.

Амь насаа алдсан хүний тоон үзүүлэлтийг доорх байдлаар ангилдаг. Үүнд:

- Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүн;
- Гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хүн.

Зам тээврийн ослын улмаас газар дээрээ болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нас барсан буюу бодит нас баралтын тоон үзүүлэлтийг авч үздэг байна.

“Гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хүн” гэж Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангаас боловсруулан гаргасан үзүүлэлт буюу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтаар хэрэгсэхгүй болгосон хэрэг болон хохирлыг хасаж тооцсон тоон үзүүлэлтийг хэлдэг бол “гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн” гэж зам тээврийн ослын улмаас биед авсан гэмтлийн зэрэг нь шүүх эмнэлгийн магадлагаагаар хүндэвтэр, хүнд зэрэг тогтоогдон, эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан хэргийн улмаас гэмтсэн хүний тоон үзүүлэлтийг ойлгохоор заажээ.


Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 2475 хүн гэмтсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 8.9 хувь, хүнд, хүндэвтэр гэмтсэн хүн 1.3 хувиар тус тус буурсан байна⁴⁹.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд 238 хүн амь насаа алдаж, 774 хүн гэмтсэн үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад, амь насаа алдсан хүний тоо 9.8 хувиар, гэмтсэн хүн 1.3 хувиар тус тус буурсан байна. Гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хүний 164 буюу 68.9 хувь нь орон нутагт, 74 буюу 31.1 хувь нь нийслэлд

⁴⁹ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт. Эмхэтгэл. Улаанбаатар. 2021.


байна⁵⁰. Нийт гэмтсэн 2475 хүний 774 буюу 31.3 хувь нь хүнд болон хүндэвтэр гэмтэл авсан байна.

График №1. Зам тээврийн ослын улмаас хохирсон хүмүүсийн насны байдал



Зам тээврийн ослын улмаас 254 эрэгтэй хүн амь насаа алджээ. Хохирсон хүмүүсийн хүйсийн харьцааг авч үзвэл, амь насаа алдсан хүний 66.3 хувийг эмэгтэй, 54.7 хувийг эрэгтэй хүмүүс эзэлжээ. Тэгэхээр 18-35 насны эрэгтэй, хөдөлмөрийн насны хүмүүс замын хөдөлгөөнд зөв оролцоогүй, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн хэн нэгэн буруутай этгээдээс хамаарч амь нас, эрүүл мэндээрээ хохирсоор байна.


Гарфик №2. Зам тээврийн ослын улмаас хохирсон хүмүүсийн хүйсийн харьцаа



Зам тээврийн ослын хамгийн хүнд үр дагавар бол хүний эрүүл мэнд, амь нас хохирох явдал байдаг. Зам тээврийн осолд өртөж, хохирсон хүн, гэмтлийн зэрэг, гэмтсэн эрхтэн, ямар хүчин зүйлийн улмаас гэмтэл учирч байгаа болон амиа алдаж байгаа зэрэг зүйлсийг тодорхойлох нь түүнээс урьдчилан сэргийлэх, хор уршгийг багасгах, эмнэлгийн тусламжийг шуурхай, оновчтой үзүүлэх гэх мэтийн арга хэмжээг төлөвлөх, боловсронгуй болгоход нэн чухал ач холбогдолтой.

График №3. Зам тээврийн ослын улмаас хүний биед үүссэн гэмтлийн тоон үзүүлэлт


⁵⁰ Тээврийн цагдаагийн алба. Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт. Улаанбаатар. 2021. 31 дэх тал.



Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүний 71.7 хувь нь зөөлөн эдийн гэмтэл, бэртэл, шалбарсан, зулгарсан гэх мэт амь насанд аюул багатай гэмтэл авсан байна. Цагдаагийн байгууллагын бүртгэлд зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан 383 хүний 89.3 хувь нь ослын газар дээрээ болон эмнэлгийн тусламж авч амжаагүй амь насаа алдсан бол хүнд зэргийн гэмтэл авсан 46 хүн эмчлэгдэж байгаад 30 хоногт амь насаа алдсан тоон мэдээ байна. Зам тээврийн ослын үед амь нас, эрүүл мэндээрээ хохирогчид нь толгой, цээж, хөл, гар, тулгуур эрхтний, гэмтэл, бэртэл ихээхэн авдаг байна⁵¹. Зам тээврийн осолд өртөж амь насаа алдсан 383 хүний 15.4 хувь нь осолд өртсөн даруйд эмнэлгийн анхны тусламж авсан, 84.6 хувь нь анхны тусламж авч чадаагүй гэсэн мэдээлэл байна. Зам тээврийн ослоор нас барсан хүмүүсийн 355 буюу 92.7 хувь нь ослын газар дээрээ болон 24 цагийн дотор амь насаа алдсан бол 28 буюу 7.3 хувь нь осолд өртөж, эмнэлгийн тусламж авсны дараа 30 хоногт амь насаа алдсан тоон судалгаа гарсан байна. Амь насаа алдсан хүмүүсийн 45.4 хувь нь толгойдоо, 8.6 хувь нь цээжиндээ хүнд гэмтэл авсан байхад 149 хохирогч толгой, тархи, тулгуур эрхтний хавсарсан гэмтэл авч амь насаа алдсан байна.

Хүснэгт №2. Зам тээврийн ослын улмаас 2021 оны байдлаар биеийн аль хэсэгт гэмтэл авсан талаар

⁵¹ Тээврийн цагдаагийн алба. Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт. Улаанбаатар. 2021. 34 дэх тал.



Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг боловсруулахад зам тээврийн осол гарах шалтгаан, нөхцөл, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг сайтар судлах нь зүйтэй. Замын хөдөлгөөний хүрээнд үүссэн гэмт хэрэг нь хүн амын дотор өөрийн аюулгүй байдлын талаар аймшиг төрүүлэх итгэлгүй мэдрэмж бий болгож, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулдаг. Энэ төрлийн гэмт хэргийн өсөж буй хэмжээ нь түүнийг хянаж, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн, зохион байгуулалт, санхүү, материал техникийн болон бусад зардлыг улсаас шаардаж байна. Тэгэхээр зам тээврийн осол нь криминологийн шинжлэх ухааны бие даан судалбал зохих асуудал болж байна. Зам тээврийн осол нь объектив хүчин зүйлээс үүдэлтэй хэдий ч, осол гарахад хүний субъектив хүчин зүйлийн нөлөө онцгой үүрэг гүйцэтгэдэг болохыг статистик тоо баримтаас харж болно⁵².

Судлаач Х.Доржпалам зам тээврийн хэрэг, ослын шалтгааныг “Тээврийн хэрэгслийн жолооч замын хөдөлгөөний журам зөрчсөн үйлдэл, хөдөлгөөнд оролцогч бусад зорчигчдын буруутай үйлдэл, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг хүчин зүйлүүдийн нөлөөлөл /зам засварын ажлыг гэрэлтүүлэггүй буюу хангалтгүй хийх/, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зөрчих гэмт хэргийн хохирлыг ихэсгэхэд нөлөөлөх хүчин зүйлүүд /хохирогчид эмнэлгийн тусламж үзүүлээгүй буюу буруу эмчлэх/, техникийн боловсронгуй бусаас аюулын эх сурвалжийг ихэсгэх /тахир бол хугарах, хурдны таяг мултрах зэрэг/ байдлуудын үр дүн”⁵³ гэж ангилан үзжээ. Харин судлаач Д.Нямдорж уг хэргийн шалтгааныг судалж үзээд, “жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөнөөс, явган хүний буруугаас, замын нөхцөлөөс шалтгаалан гарч байна”⁵⁴ гэж дүгнэсэн байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас (Цаашид – ДЭМБ гэх) улс орнуудын замын хөдөлгөөний аюулгүй байдлын түвшинг тогтооход харгалзах гол үзүүлэлт нь 100.000 хүн амд ногдох нас баралтын түвшин байдаг. Монгол Улсын хувьд энэ үзүүлэлт нь 2020 оны байдлаар 13 байгаа нь өмнөх оны үеэс буурсан байна.

ДЭМБ-аас гаргасан “Дэлхийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын тайлан 2018”-д⁵⁵ дурдсанаар дэлхийн дундаж 18.2, манай улс бүсчлэлд нь хамаарч байгаа ази-номхон далайн бүсийн дундаж 16.9 байна.

⁵² Нямдорж, Д. (2009), Монголын зам тээврийн гэмт хэргийн криминологийн товч үнэлэмж. //Гэмт явдал.

⁵³ Нямдорж, Д. (2009). Криминологическая характеристика и предупреждение преступлений, связанных с нарушениями правил безопасности движения и эксплуатации автомобильного транспорта в монголии. Хууль зүйн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Москва.

⁵⁴ Мөн тэнд.

⁵⁵ <https://www.who.int/publications-detail/global-status-report-on-road-safety-2018>.

Дэлхийн улс орнууд зам тээврийн ослын шалтгаан, нөхцөлийг тогтооход системийн шинжилгээний аргуудыг өргөнөөр ашиглах болсон бөгөөд “Хүн-Зам /орчин/-Тээврийн хэрэгсэл” гэсэн гурван хүчин зүйлсийн нөлөөллийг харгалзахыг зөвлөж байна. Германы эрдэмтдийн судалж тогтоосноор зам тээврийн ослын нэг сөрөг хүчин зүйл болоод байгаа замын нөлөөлөл 31 хувь буюу түүнээс дээш, Оросын эрдэмтэн А.П.Матросов⁵⁶ зам тээврийн ослын шалтгаан, нөхцөлийг нарийвчлан тогтоох зорилгоор 1971 онд хийсэн судалгаагаар “замын нөхцөл нь гарсан ослын 70 хувьд нь ямар нэг байдлаар сөрөг нөлөө үзүүлсэн” гэж үзсэн бол Шведийн судлаач Хелена Стигсон нар⁵⁷ энэ нөлөөллийг ойролцоогоор “63 хувь” гэж дүгнэжээ. Эдгээр эрдэмтэн, судлаачдын дүгнэлт болон ДЭМБ-ийн арга зүйгээс үзэхэд, зам тээврийн ослын шалтгаан нь жолооч, явган зорчигч, замын нөхцөл байдал зэргээс үүдэл буюу харилцан хамааралтай болох нь тогтоогдож байна.

Зам тээврийн ослын шалтгааныг доорх байдлаар ангилан үзэх явдал түгээмэл байна. Үүнд:

- Явган зорчигчийн өөрийн буруутай үйлдлээс гарсан;
- Жолоочийн буруутай үйлдлээс гарсан;
- Зам орчин-замын нөхцөлөөс гарсан;
- Техникийн бүрэн бус байдлаас гарсан осол.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 21482 зам тээврийн ослын 17682 буюу 97.5 хувь нь жолоочийн буруугаас, 424 буюу 2.6 хувь нь явган зорчигчийн буруугаас, 25 буюу 0.2 хувь нь замын нөхцөл, техникийн байдлаас үүдэлтэй байна.

График №4. Зам тээврийн ослын шалтгааныг харуулсан хүснэгт



Улсын хэмжээнд зам тээврийн осолд өртөж, амь нас нь хохирсон 2858 хүний 1224 буюу 42.8 хувь нь явганаар замын хөдөлгөөнд оролцож байсан бол 1032 буюу 36.1 хувь нь тээврийн хэрэгслээр зорчигч, 511 буюу 17.9 хувь нь жолооч, 91 буюу 3.2 хувь нь дугуйгаар зорчигч байна.

Зам тээврийн осол нь олон нийтэд ил үйлдэгддэг, иргэдэд орчны аюулгүй байдалдаа санаа зовох мэдрэмж, эргэлзээ төрүүлж, нийтийн амгалан, тайван байдалд маш их сөрөг нөлөө үзүүлж байдаг нийгмийн үзэгдэл боловч осол гарахад нөлөөлдөг хүчин зүйл нь тодорхой, хүнээс шалтгаалах асуудал тул түүнээс урьдчилан сэргийлэх боломжтой гэж олон улсад үздэг.

⁵⁶ Зам тээвэр, хөгжлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном. (2018). Улаанбаатар. 2019. 66-67 дахь тал.

⁵⁷ Helena Stigson, Maria Krafft & Claes Tingvall. Use of Fatal Real-Life Crashes to Analyze a Safe Road Transport System Model, Including the Road User, the Vehicle, and the Road. Traffic Injury Prevention, 9:5, 2008. page 463- 471, DOI: 10.1080/15389580802335240.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэйгээр ажилладаг Тээврийн цагдаагийн алба нь зам тээврийн осол, түүнээс үүдэн гарч буй хохирол, хор уршгийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр, зам тээврийн осол гарч байгаа шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар цогцолбор арга хэмжээ авч, энэ чиглэлийн асуудалд зонхилох үүрэг гүйцэтгэж байна. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг төр, олон нийтийн байгууллага хамтран гүйцэтгэх шаардлагатай боловч, өнөөдрийн байдлаар цагдаагийн байгууллага дангаараа үүрэг гүйцэтгэж байна.

Тээврийн цагдаагийн албаны 2022 оны 1 дүгээр улиралд “Хар цэг” хэсэгчилсэн арга хэмжээг зохион хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд 21 аймгийн нутаг дэвсгэрт сүүлийн 5 жилийн хугацаанд зам тээврийн осол, хэрэг тогтмол бүртгэгддэг 231 байршлын судалгааг аймаг тус бүрээр гаргасан байна⁵⁸.

Хүснэгт №3. Зам тээврийн осол, хэрэг гардаг цэгүүдийн (аймаг тус бүрээр) судалгаа

№	Зам тээврийн осол, хэрэг гардаг цэгүүдийн тоо	Аймаг
1	27	Архангай
2	4	Баян-Өлгий
3	4	Баянхонгор
4	6	Булган
5	14	Говь-Алтай
6	2	Говьсүмбэр
7	3	Дархан-Уул
8	5	Дорноговь
9	5	Дорнод
10	5	Дундговь
11	12	Орхон
12	5	Өмнөговь
13	30	Өвөрхангай
14	27	Сэлэнгэ
15	10	Увс
16	3	Завхан
17	2	Сүхбаатар
18	27	Төв
19	10	Ховд
20	6	Хөвсгөл
21	16	Хэнтий

Зам тээврийн хяналтын хэлтсээс дээрх цэгүүдэд хөдөлгөөн зохион байгуулалтыг өөрчлөх, шаардлагатай тэмдэг, тэмдэглэлийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх нэн тэргүүний шаардлагатай байна. Уг ажлыг хэрэгжүүлснээр зам тээврийн ослыг багасгах боломж үүснэ.

Монгол Улсад зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн зохион байгуулалтын бүтэц 1949 оноос бий болж, өнөөг хүртэл үйл ажиллагаа нь тогтмол хэрэгжсээр байна. Гэхдээ зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх хэлтсийн үйл ажиллагаа нь соён гэгээрүүлэх, аян, хэсэгчилсэн арга хэмжээ хэрэгжүүлэх, судалгаа, шинжилгээ хийх, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээс бус замын дэд бүтцийг судалж, замын нөхцөл байдлаас үүдэлтэй шалтгаан, нөхцөлийг буурахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлдэггүй болох нь ажиглагдаж байна.

⁵⁸ Тээврийн цагдаагийн алба. Зам тээврийн хяналтын хэлтсийн тайлан. Улаанбаатар. 2022.

Гэтэл зөвхөн замын эвдрэл, гэмтэл л гэхэд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж, зам тээврийн осол, хэрэг гарах шалтгаан, нөхцлүүдийн нэг болдог байна. Өнөөг хүртэл замын эвдрэл, гэмтэл, онгорхой нүх, овоолсон шороо, зузаан мөстсөн замын хэсэг, замын бусад хангалтгүй нөхцөлийг тойрох гэсэн автомашины жолооч хөдөлгөөний чиглэлээ гэнэт өөрчлөх, тойрч эсрэг урсгалд орсноос гарсан тохиолдлыг осол гарсан актад тусгахгүй, ихэнх тохиолдолд бурууг жолооч, бусад хөдөлгөөнд оролцогчдод хариуцуулж байна. Манай орны зам тийм сайн биш байхад замын нөхцөл гэсэн хүснэгтэд байгаа тоон үзүүлэлт маш бага байгаа нь үүнтэй холбоотой юм.

Зам тээврийн ослоор иргэнд эд хөрөнгийн болон эрүүл мэнд, амь насны хохирол учирсан тохиолдолд гадаад орнуудад хэрхэн шийдвэрлэдэг талаар Япон Улсын жишгийг авч үзье. Япон Улсын хуулиар зам тээврийн ослын хохирлыг шүүхээр тус тусад нь авч үздэг. Японд иргэний хэрэг нь “Иргэд, аж ахуйн нэгж зэрэг хувийн хэвшлийн байгууллагуудын хоорондын эрх, эрх зүйн харилцаатай холбоотой маргааныг шийдвэрлэх журам” гэгддэг ба нөгөө талаар эрүүгийн хэрэг нь “Эрүүгийн хууль, бусад хууль тогтоомжид зааснаар хэрэг хийсэн хүнийг төр шийтгэх журам, өөрөөр хэлбэл, иргэн, хувийн хэвшлийн байгууллага төрийн харилцааны тухай журам” байдаг ажээ.

Авто замын ослоор хүн нас барсан тохиолдолд хохирогч болон хохирогчийн ар гэрийнхэн нь эмчилгээний зардал болон сэтгэл санааны төлбөр зэрэг хохирлын нэхэмжлэлийг гаргахын (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар) зэрэгцээ Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журамд “Албан үүрэгтээ хайнга хандсанаас болж хүний амь насанд хүрсэн”, “Аюултай байдлаар машин барьсан” гэсэн ял, шийтгэлийг эрүүгийн хуулийн заалтын дагуу оногдуулдаг байна. Зам тээврийн ослын улмаас бэртсэн тохиолдолд төлөгдөх нөхөн төлбөр болгож доорх зардлыг гаргуулдаг байна. Үүнд:

- Эмчилгээний зардал болон бусад зардал, хажууд нь харж, асрах хүний зардал (шаардлагатай гэж тогтоогдсон бол), эмнэлэг орох замын зардал зэрэг нь жолоочид бичиг болон зардлын тайлан болон ирдэг байна;

- Ажилдаа яваагүйгээс үүдэн гарах хохирол, өдрийн дундаж цалин, өдрийн орлого зэргийг байгууллагын албан бичгээр шүүхэд илгээдэг бөгөөд шүүх харин жолоочийн өмгөөлөгч эсвэл гэрт нь албадан хүргэнэ;

- Бэртлийн нөхөн төлбөр (сэтгэл санаа, бие бялдрын хувьд амссан хохирол). Мэргэжлийн сэтгэл зүйч бие бялдрын гэмтэл авсан хохирогчтой долоо хоногийн турш ажиглалт хийсний үндсэн дээр сэтгэл санааны нөхөн олговрын хэмжээг шүүхийн байгууллага руу илгээдэг байна.

- Бэртлийн улмаас (хууч өвчтэй болсон тохиолдолд) ирээдүйд ямар нэгэн нөлөөлөл үлдсэн, жишээ нь: хөлөө тайруулах, сохрох зэрэг гэмтлийн агуулгаас шалтгаалж 1-14 группд ангилан, тухайн ангилалд тохирсон нөхөн төлбөрийг тогтооно. Жишээ нь: “Нэг талын чих нь 40 сантиметрээс дээш зайны энгийн яриа, дуу чимээг сонсохгүй болсон бол” 11 дүгээр групп буюу 3.300.000 иений нөхөн төлбөр оногдуулна. Хоёр гараа, тохойгоо хүртэл алдсан бол “1 дүгээр групп” гэж үзэн, 30.000.000 иений нөхөн төлбөр оногдуулна. Ирээдүйд гарч болох нөлөөллийн хувьд урьдчилан зохих хэмжээгээр тодорхой болсон зүйлийг нийлүүлэн тооцож, нэхэмжилнэ. Тооцоолоогүй хууч өвчин гарч, энэ нь осолтой холбоотой болох нь тогтоогдвол, дараа нь дахин хянан шийдвэрлүүлж, тухайн хэсгийг нэхэмжилж болно. Түүнчлэн эмчийн оношоор “өвчин архагшсан” гэж тогтоогдсон буюу одоогийнхоос сайжрахгүй, муудахгүй гэсэн үеэс нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг бүрдүүлж, жолоочид төлбөрийн бичиг илгээдэг байна.

Зам тээврийн ослын улмаас хүний эрүүл мэндэд гэмтэл, хохирол учирсан тохиол бүрийг нарийн тусгаж, төлбөрийн нэхэмжлэл гаргасан явдал нь нийгмийн харилцааны хүрээнд иргэдийн хооронд үүсэх энэ чиглэлийн харилцааг тодорхой зохицуулсан байна. Тэгвэл зам тээврийн ослын улмаас хүний амь нас хохирсон тохиолдолд дараах төрлийн зохицуулалттай байна. Үүнд:

- Эмчилгээний зардал гарсан бол тухайн зардлыг осол гаргасан жолооч хохирогчид 100 хувь нөхөн олгох;

- Оршуулгын зардал. Жолоочийн алдаанаас болж иргэн амь насаа алдвал жолооч сэтгэл санаа болон оршуулгын зардал, насанд хүрээгүй хүүхэдтэй байсан бол хүүхдийг 18 нас хүртэл нь төлбөрийг нь 100 хувь төлөх болон байрны зардал зэргийг хариуцна.

- Олох байсан орлого (амьд мэнд ажиллаж байсан бол олох байсан орлого). Уг аргыг шүүхийн шийдвэрийн эмнэлэг гаргадаг ба ажиллаж байсан байгууллагаас хамаарч хоёр сарын турш тандалт явуулсны үр дүнд тооцдог байна. Хариуцлага алдсан жолооч хамгийн багадаа 10-15 жилийн турш амьд мэнд байхдаа олдог мөнгийг нь гэр бүлд нь нөхөн олгодог байна.

Дүгнэлт

Зам тээврийн ослоор хүний амь нас, эрүүл мэнд хохирсон асуудал нь урьдчилан сэргийлэх боломжтой, ихээхэн судлагдаж, нөлөөлдөг үндсэн эрсдэлт хүчин зүйл нь тодорхой болсон асуудал юм. Иймээс энэхүү тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор зам тээврийн осол, гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөнд оролцогсдын мэдлэг, хандлагыг өөрчлөн, зохистой зан үйлийг төлөвшүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах замаар зам тээврийн осол, гэмтлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Сүүлийн 20 жилийн хугацаанд хөгжингүй орнуудад замын хөдөлгөөний аюулгүй байдалд системийн хандлагыг хэрэглэж, зам тээврийн ослыг бууруулж чадсан байна. Системийн хандлага нь дан ганц замын хөдөлгөөнд оролцогсдын зан үйлийг өөрчлөх замаар бус замын орчин, тээврийн хэрэгсэл, замын хөдөлгөөнд оролцогсдод чиглэсэн арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлэх арга юм.

Замын хөдөлгөөний осол зөрчлийн ангиллыг хянаж, осол, зөрчлийн буруутай эзнийг тогтооход голлон анхаарах бус, шалтгаан, нөхцөл, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийг тогтооход түлхүү анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй байна. Судалгаанаас үзэхэд, Дорнод аймгийн хувьд өнөөгийн гаргасан шийдвэр, хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдээ дахин үнэлэх, өнөөгийн шаардлагад нийцүүлж сайжруулах, шинэчлэх шаардлагатай харагдаж байна.

Санал

Дээрх дүгнэлтийг үндэслэн зам тээврийн ослыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг боловсронгуй болгохын зэрэгцээ, авто замын сүлжээ өндөр хөгжсөн орнуудын стандартыг өөрийн орны зохицуулалтад нэвтрүүлэн тусгаж, нарийвчилсан хэм хэмжээ тогтоож өгдөг заавал мөрдөх шаардлага бүхий техникийн зохицуулалтуудыг шинээр бий болгох;

2. Зам тээврийн ослоор амь насаа алдагсдын 70 хувь нь эмнэлгийн анхны тусламж авч чадаагүй буюу энэ тусламжийг буруу үзүүлснээс, 20 хувь нь эмнэлгийн тусламж хоцорч очсоноос, 10 хувь нь аврах боломжгүй гэмтэл байдаг гэсэн олон улсын судалгааны дүнд үндэслэн, эмнэлгийн анхны тусламжийг цаг алдалгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, тусламж үзүүлэх чадвар бүхий иргэдийн хүрээг нэмэгдүүлэх;

3. Зам тээврийн ослын газрын үзлэг хийх, зам тээврийн ослын шалтгаан, нөхцөлийг иж бүрэн тодорхойлох, өндөр хөгжилтэй улсуудад ашиглаж байгаа программ хангамжийг нэвтрүүлэх;

4. “Шар дарцаг”, “Яараад яахав дээ”, “Аажуу явбал аяндаа хүрнэ”, Дураараа биш дүрмээрээ, Хамгаалах бүс, “School police” гэх мэт олон нийтийг уриалсан шинэ, шинэлэг хөдөлгөөнүүдийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр дамжуулан идэвхтэй өрнүүлж, үр дүнг тооцон ажиллаж, тус үйл ажиллагаануудад суурилж, цаашид авах арга хэмжээг төгөлдөржүүлэх;

5. Жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөр, арга, механизм, шалгалт авч буй тогтолцоо, аргыг цогцоор нь шинэчлэн, ур чадвар, сэтгэл зүй, ухамсрын төвшинд төлөвшсөн жолооч бэлтгэх тогтолцоог бүрдүүлэн, жолоочоос шалтгаалсан ослыг бууруулахад чиглэсэн бусад дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэх;

6. Иргэд, байгууллагад замын хөдөлгөөний нөхцөл байдлыг танилцуулж, замын хөдөлгөөний тухай хууль, тогтоомжуудыг судлуулж мөрдүүлснээр, зам тээврийн ослоор хүний амь нас, эрүүл мэнд хохирох асуудлаас урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалт, хөтөлбөр, товхимлыг замын хөдөлгөөнд оролцогчийн нас болон хууль дүрмийн хүрээнд хүлээх үүрэг хариуцлагаар нь ангилан, шинэчлэн боловсруулж, иргэдийн ихээр үйлчлүүлдэг автобус, автобусны буудал, дэлгүүр зэрэг газарт байршуулах-зэрэг болно.

Ашигласан материал

1. Болдбаатар, Ж. Нямдаваа, О. Криминологи. 1 дэвтэр. Улаанбаатар. 2010. 112 дахь тал.

2. Зам тээвэр, хөгжлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном. (2018). Улаанбаатар. 2019. 66-67 дахь тал.

3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. //Төрийн мэдээлэл. Улаанбаатар. 2015. №28.

4. Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт. Эмхэтгэл. Улаанбаатар. 2021.

5. Монгол Улсын Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. Улаанбаатар. 2016. №7.

6. Нямдорж, Д. (2009), Монголын зам тээврийн гэмт хэргийн криминологийн товч үнэлэмж. //Гэмт явдал.

7. Нямдорж, Д. (2009). Криминологическая характеристика и предупреждение преступлений, связанных с нарушениями правил безопасности движения и эксплуатации автомобильного транспорта в монголии. Хууль зүйн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Москва.

8. Нямсүрэн, Ч. Гэмт хэргийн виктимологи. Улаанбаатар. 2005. 36 дахь тал.

9. Тээврийн цагдаагийн алба. Зам тээврийн хяналтын хэлтсийн тайлан. Улаанбаатар. 2022.

10.Тээврийн цагдаагийн алба. Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт. Улаанбаатар. 2021. 31 дэх тал.

11.Тээврийн цагдаагийн алба. Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт. Улаанбаатар. 2021. 34 дэх тал.

12.Энхболд, А. Замын хөдөлгөөний аюулгүй байдал. Улаанбаатар. 2007. 15 дахь тал.

Гадаад эх сурвалж

1. Helena Stigson, Maria Krafft & Claes Tingvall. Use of Fatal Real-Life Crashes to Analyze a Safe Road Transport System Model, Including the Road User, the Vehicle, and the Road. Traffic Injury Prevention, 9:5, 2008. page 463- 471, DOI: 10.1080/15389580802335240.

Интернет эх сурвалж

1. <https://www.trends.mn/n/7382>.

2. <https://www.who.int/publications-detail/global-status-report-on-road-safety-2018>.

ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ХҮҮХДИЙГ ХАМГААЛЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АНХААРАХ АСУУДАЛ

PROTECTION OF CHILD VICTIMS OF VIOLENT CRIME CURRENT SITUATION

С.Гүндэгмаа

ДХИС-ийн магистрант, цагдаагийн дэслэгч

Gundegmaa S.

Graduate student of the University of Internal Affairs, Police lieutenant

Хураангуй: Энэхүү өгүүлэлд хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалж буй өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, сайжруулах арга замын талаар санал боловсруулахыг зорилгоо.

Abstract: This article presents the current situation of child rape victim protection and suggested ways to improve it.

Түлхүүр үг: Хохирогч, хүүхэд, хүчиндэх гэмт хэрэг, хохирогч хамгаалал.

Keywords: Victim, violent crime, protection, child, current situation.

Нэг. Монгол Улс дахь өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцид нэгдэн орсноор үндэсний хууль тогтоомжид хохирогч хүүхдийг хамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 19.1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” 38.2.7 дахь хэсэгт “Засгийн газар дараах үндсэн, бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх⁵⁹” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтууд нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөний нийтлэг байдлыг илэрхийлж байгаа төдийгүй, тусгайлсан эрх бий болгоход чиглэгдсэн. Өөрөөр хэлбэл, нийгмийн тодорхой харилцааны онцлогтой холбоотойгоор иргэний эдлэх эрхийн үндэс болох юм.


Монгол Улсад гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээд, мэдээлэл өгсөн иргэний аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн зохицуулалт, төрийн тогтолцоог бий болгох хэрэгцээ, шаардлагын улмаас 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай⁶⁰” хуулийг баталж, 2014 онд гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг буюу Тахарын ерөнхий газрыг байгуулж, 2 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулж байсныг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор татан буулгаж, зарим чиг үүргийг цагдаагийн байгууллагад шилжүүлэн, улмаар Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 444 дүгээр тушаалаар Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс байгуулагдсан.

Улсын хэмжээнд 2019 онд 144 хамгаалтын арга хэмжээгээр 134 иргэн, 2020 онд 104 хамгаалалтын арга хэмжээгээр 101 иргэн, 2021 онд 191 хамгаалалтын арга хэмжээгээр 202 иргэний аюулгүй байдлыг ханган ажилласан мэдээтэй байна.

⁵⁹ Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992. 38 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэг.

⁶⁰ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль. УБ. 2013.

График №1.



Сүүлийн 3 жилийн байдлаар гэмт хэргийн улмаас хамгаалалтад авагдсан эмэгтэй гэрч, хохирогч, хамаарал бүхий этгээдийг авч үзвэл, 2019 онд насанд хүрсэн эмэгтэй гэрч 5, насанд хүрсэн эмэгтэй хохирогч 68, насанд хүрээгүй эмэгтэй хохирогч 11, 2020 онд насанд хүрсэн эмэгтэй гэрч 4, насанд хүрсэн эмэгтэй хохирогч 55, насанд хүрээгүй эмэгтэй хохирогч 6, 2021 онд насанд хүрсэн эмэгтэй гэрч 5, насанд хүрээгүй эмэгтэй гэрч 1, насанд хүрсэн эмэгтэй хохирогч 86, насанд хүрээгүй эмэгтэй хохирогч 37 тус тус хамгаалалтад авагдсан байна⁶¹. Үүнээс үзвэл, эмэгтэй гэрч, хохирогчийн тоо жил бүр өсөх хандлагатай байгаа нь ажиглагдаж байна. Үүнд:

График №2.



Хамгаалалтад авагдсан эмэгтэй хамгаалуулагч иргэнийг гэмт хэргийн төрлөөр авч үзвэл, 2019 онд гэр бүлийн хүчирхийлэл 45, бэлгийн хүчирхийлэл 12, хүн худалдаалах гэмт хэргийн 1, 2020 онд гэр бүлийн хүчирхийлэл 36, бэлгийн хүчирхийлэл 13, 2021 онд гэр бүлийн хүчирхийлэл 50, бэлгийн хүчирхийлэл 47, хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг 6 иргэн⁶² тус тус хамгаалалтад авагдсан байна.

⁶¹ Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн тоон мэдээ. УБ. 2022. 4 дэх тал.

⁶² Мөн тэнд. 5 дахь тал.

График №3.



Хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл зүйн хувьд маш их гэмтэлтэй байдаг. Тэр ч утгаараа, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд ихээхэн зардал, мөнгө шаарддаг. Аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад хохирогчийг эмнэлэгт хэвтүүлэх, ахуйн хэрэглээний зүйлс, хичээл, сургуулийн хэрэглэл гэх мэт маш их зардал гардаг. Энэхүү зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр хуульчилсан боловч одоогийн байдлаар улсаас шийдвэрлээгүй байна.

Дээрх судалгаанаас дүгнэхэд, гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулахад чиглэсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг бүрэн хангахад гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль чухал байр суурь эзлэх төдийгүй хохирогч хүүхдийг хамгаалалтад авсан. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд хамгаалалтад авагдсан гэрч, хохирогч, түүний хамаарал бүхий этгээд, бусад шаардлагаар хамгаалалтад авагдсан этгээдийн амь нас, эрүүл мэндэд заналхийлэх тохиолдол нэлээдгүй гарч эдгээр нь ихэвчлэн дээрх төрлийн хэрэгт холбогдон шалгагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч байна.

Хоёр.Хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах ажлыг сайжруулах талаар

2013 онд УИХ-аас Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг баталж, улмаар эрх зүйн орчин бүрдэж, хохирогч хүүхдийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэх байгууллага, бүтцийн нэгжийг байгуулан бодлогын шинж чанартай ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, олон улсын туршлагыг нэвтрүүлэх, төрийн болон бусад байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, төсвийг нэмэгдүүлэх, энэ чиглэлийн мэргэшсэн алба хаагчийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

1.Хохирогч хүүхдийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл болох аюулын эрсдэлийн түвшин тогтоох аргачлалыг шинэчлэн боловсруулж, мөрдөх.

2."Гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах стандарт"-ыг боловсруулж, батлуулах.

3.Хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагатай мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

4.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд “Биечилсэн хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн харуул хамгаалалтын бүсэд хэрэгжүүлж болно” гэж заасан боловч Зэвсэгт хүчний тухай хууль болон бусад хууль тогтоомжид энэ талаар тусгаагүй тул хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна.

Дээрхээс үндэслэн хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, эрх зүйн хийдэл, зөрчлийг арилгах, боловсронгуй болгох шаардлагатай байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн үйл ажиллагааны урсгал зардал болон насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээний зардал нь одоогийн батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулахад хүрэлцэхгүй байна.

Тус хэлтэст техник, тоног төхөөрөмж худалдаж авах, алба хаагчдыг мэргэжлийн чиглэлийн гадаад, дотоод сургалтад хамруулах, хамгаалалтын арга хэмжээг эрсдэлгүй зохион байгуулах чиглэлээр дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1.Нийслэлд хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхэд болон бусад хүмүүсийг хамгаалах хүний нөөц, хүч хэрэгсэл хүрэлцэхгүй байгаа учраас ахлагч бүрэлдэхүүнийг ажиллуулах.

2.Орон нутагт хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхэд болон бусад хүмүүсийг хамгаалах ажиллагааг явуулах байгууллага байхгүй байгаа учир нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэст гэрч, хохирогчийг хамгаалах нэгжийг байгуулах.

3.Хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах ажиллагаа, зардлыг нэмэгдүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах, алба хаагчдийг сургаж дадлагажуулах, мэргэшүүлэх зэрэг болно.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд хамгаалалтад авч байгаа этгээдийн ахуйн хэрэглээний зардлыг хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулаагүйн улмаас зарим төрлийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл учирч байна. Тухайлбал, аюулгүй газарт байрлуулсан хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалж, харилцааг хязгаарласан тохиолдолд ахуйн хэрэглээний (хоол, хүнс, хувцас, эрүүл ахуйн зэрэг) зардлыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны болон тусгай зардлаас гаргаж болохгүй тул хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн хэрэглээний зардлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байна.

Ашигласан материал

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн конвенц. 1989.
2. Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992.
3. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль. УБ. 2013.
4. Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн тоон мэдээ. УБ. 2022.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ БОЛОХ НЬ

DOMESTIC VIOLENCE IS A VIOLATION OF HUMAN RIGHTS

У.Уранцэцэг

ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч

Urantsetseg U.

Graduate student of the University of Internal Affairs, senior police lieutenant

Хураангуй: Хүчирхийлэл гэх ойлголтод хүний эрхийн зөрчлийн асуудал, эрүүл мэндийн асуудал, хувь хүний ёс суртахууны асуудал зэрэг багтдаг. Хүчирхийлэл бол гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь эрх мэдлээ тогтоох зорилгоор янз бүрийн хэлбэрээр дарамтлах, эрхшээлдээ оруулахыг ойлгож болно. Үүнээс гадна хүчирхийлэл нь бие махбодын хүчийг ашиглаж гэмтээх, зүй бус харьцах, хохироох, устгаж сүйрүүлэхийг хэлдэг. Эндээс хүчирхийлэл нь бусдын эрх ашигт шууд халдсан, хор хөнөөл ихтэй зүйл болох нь ойлгогдож байх тул түүнийг судлахыг зорилоо.

Abstract: The concept of violence includes human rights violations, health problems, and personal moral problems. Violence is when one of the family members perceives harassment in various forms for the purpose of establishing authority. In addition, violence refers to the use of physical force to injure, ill-treat, harm, destroy and ruin. The aim of this study is to understand that violence is a direct attack on the interests of others and that it is harmful.

Түлхүүр үгс: Бэлгийн хүчирхийлэл, бие махбод, сэтгэл зүй, хохирол, хүний эрх, хүчирхийлэл, эдийн засаг.

Keywords: Sexual violence, physical, psychological, damage, human rights, violence, economic.

Дэлхий дахинд сая сая эмэгтэйчүүд, хүүхдүүд гэр бүлийн хүчирхийллийн улмаас тарчлан зовж байна. Гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн ноцтой зөрчил бөгөөд нас, хүйс, царай зүс, хөрөнгө чинээ, нийгэмд эзлэх байр суурь, боловсрол зэргээс төдийлөн үл хамаарч төрөл бүрийн хэлбэрээр үйлдэгддэг. Үр дагавар нь хүний өөртөө итгэх итгэл, амьдралын баяр баясгаланг үгүй хийж сэтгэл санаа, бие махбод, амь нас, аюулгүй байдалд ноцтой хор хохирол учруулж, хамгийн эмгэнэлт төгсгөлд ч хүргэж болдог. Энэ аюулт үзэгдэл “Гэр бүлийн хүчирхийлэл”, “Эр эмийн хоорондын маргаан”, “Гэр бүлийн дотоод асуудал” эсвэл “Амьдралд байдаг л асуудал” гэдэг хүрээнд яригдаж ойлгогдох нь түгээмэл хэвээр байсаар байна. Энд бас хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөөр л байна.

Хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн амьд явах, ялгаварлан гадуурхалт, айдас, дарамт, хүчирхийлэл, эрүүдэн шүүлтээс ангид, эрх чөлөөтэй амьдрах эрхийг зөрчдөг. Дээр дурьдсан эрх, эрх чөлөө нь олон улсын хэм хэмжээгээр хамгаалагдсан ч⁶³ гэр бүлийн хүчирхийлэл нь дэлхий нийтэд тулгамдсан, түгээмэл асуудал болсоор л байна. Эмэгтэйчүүдийн 70 хувь нь амьдралынхаа явцад ямар нэг төрлийн хүчирхийлэлд өртөж байгааг НҮБ-ын судалгаагаар тогтоожээ⁶⁴

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй, гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”, 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уг эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй” гэж

⁶³ Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенци, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенци.

⁶⁴ Нэгдсэн Үндэстний Байгууллага, “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл. мэдээллийн хуудас. 2011.

тус тус заасан. Энэхүү үндсэн эрхийг баталгаажуулж 2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль баталсан бөгөөд тус хуулийг 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр шинэчлэн найруулж баталсан. Үүний дараа 2015 оны шинэ Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар гэр бүлийн хүчирхийллийг бие даасан гэмт хэрэг, зөрчил хэмээн тодорхойлж, зарим гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон оруулсан.

“Гэр бүл” гэж иргэний эрх зүйн бүрэн чадамжтай буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар бий болсон эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй тэгш эрхийн үндсэн дээр эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг ойлгоно. Гэр бүлийн гишүүн гэдэгт эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг хамааруулдаг. Гэр бүлийн гишүүд нь тэгш эрх эдлэхээс гадна бие биедээ үнэнч байх, халамжлах, хүндэтгэх зэрэг ёс суртахууны үүрэг хүлээхээс гадна тэжээн тэтгэх, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх зэрэг хуульд заасан үүрэг хүлээдэг. Хэрэв ямар нэгэн хүчирхийлэл үйлдвэл Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээдэг. Энэ нь төр иргэнийхээ үндсэн эрхийг хамгаалж, гэр бүлийн ашиг сонирхлыг хамгаалах үүргээ биелүүлж байгаа хэрэг юм. Гэтэл 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулинд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх асуудлыг ялган зааглаж, зөв томъёолж чадаагүйгээс болж мердегч, прокурор, шүүх хуулийн агуулгыг янз бүрээр тайлбарлаж шийдвэр гаргахад хүргэсэн. өөрөөр хэлбэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн зүйлчлэлд тодорхойгүй байдал үүсэн хуулийн хийдэлд орсон. Тухайлбал, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулинд гэмт хэрэг, зөрчлийн бүрэлдэхүүний шинж ялгамжгүй болсон, мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд заасан гипотез, диспозицийг зөрчлийн тухай болон Эрүүгийн хуулинд өөрөөр тусгасан зэрэг асуудлууд байсаар байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2019 онд-985, 2020 онд-1138, 2021 онд-1531 болсон нь жилд дунджаар 15 хувиар өсч байна.

Гэмт хэрэг, зөрчилд нөлөөлөх хүчин зүйлсийг ёс суртахууны онолын чиг хандлагуудаас харахад, ёс суртахуунгүй газар хууль ёс,амаа хамжих хандлага байгаа нь эртний үеэс хүний хүмүүжил, төлөвшил, ёс зүйн хөгжил төлөвшилд нь анхаардаг байсан нь аль ч улсын хувьд үл алдаж болох зүйл гэдгийг өнөө үед ч олон жишээ харуулж байна. Япон улсад гэмт хэргийн гаралт хамгийн бага байдаг шалтгаан нь “Таван хөдөлшгүй”⁶⁵-г нийгмийн ёс суртахууны үндэс болгон хүмүүжил олгодог байсантай холбон судлаачид дүгнэсэн⁶⁶ байна. Чезаре Беккариа “Гэмт хэрэг ба ял шийтгэл” бүтээлдээ “Чөлөөт хүсэл зоригийн онол”-ын дэвшүүлж хүн гэмт хэрэг үйлдэхдээ сайн ба муугийн үр дагаврыг тооцсоны үндсэн дээр өөрийн ухамсартай сонголтыг хэн нэгнээс хамааралгүй чөлөөт хүсэл зоригоор хийдэг, шийтгэхээс илүү гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, ял шийтгэлийн харьцаа зохистой байх, гэмт хэргийн цорын ганц үнэн зөв хэмжүүр бол нийтэд учирсан хохирол байх, ял шийтгэлийн зорилго нь тамлан тарчлаахдаа бус гэмт хэрэгтэн дахиад гэм хор учруулахгүй байх, бусдыг тийм үйлдэл хийхээс татгалзуулахад оршино, ял шийтгэл үр нөлөөтэй байх ёстой⁶⁷. Гэмт хэрэгтэн үйлдлээ давтах, татгалзахгүй байх, хохирол нөхөн төлөгдөхгүй байх асуудал түгээмэл байгаа нь зөрчил, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдсэний дараа бус үйлдэхээс нь өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэхэд илүү анхаарах шаардалагатайг илтгэнэ.

⁶⁵ Конфуцийн таван хөдөлшгүйд захирагдагч нь захирагчдаа, эхнэр нь нөхөртөө, хүү нь эцэгтээ дүү нь ахдаа, залуу нь ахмаддаа ёсчлон захирагдах нь гэр бүлийн, нийгмийн ёс суртахууны үндэс гэж үздэг байжээ. Монголчууд бид үүний нэгэн адил эрт үеэс хүн ахтай, дээл захтай, ахаа алд хүндэл, эгчээ дэлэм хүндэл, цэр нь цээжиндээ, бөөр нь бөгсөндөө, төр түвшин бол түмэн олон амар амгалан гэх мэт ёс суртахуун, эмх цэгцтэй байх хэм хэмжээг дагаж мөрдөхийг уламжилсаар ирсэн.

⁶⁶ Зүмбэрэллхам, Д. Криминологийн онол. 2022. 29 дэх тал.

⁶⁷ Beccaria, C. “On crimes and punishment”. New Brunswick, NJ Transaction Publishers 1764/2009.

Хүний эрх зөрчигдөх, зохих хамгаалалтгүй болох гэмт буруутай этгээдэд хариуцлага тооцохгүй байх явдал нь дэлхийн ихэнх улсад нийгэм эдийн засаг, улс төрийн шилжилтийн үед илүү ажиглагддаг байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд "Хүн бүр халдашгүй дархан байх эрхтэй" хэмээн жам ёсны эрхийг бататган хэнийг ч зовоон тарчилгах, харгис хэрцгий, хүний ёсноос гадуур харьцах, шийтгэхийг хориглосон байдаг. Бусдыг зовоон тарчилгах, харгис хэрцгий хандах явдал нь дөрвөн гол элементийг агуулж байдаг. Үүнд:

1. Хүчтэй өвдөлт, шаналалыг үүсгэдэг.
2. Төлөвлөгдсөн үйлдлээр явагддаг.
3. Зорилго агуулдаг.
4. Үйлдэл болон эс үйлдлээр илэрдэг. Эдгээр элементүүд нь гэр бүлийн хүчирхийлэлд илэрч байдаг. Тухайлбал

Нэгд: Гэр бүлийн хүчирхийлэл нь биеийн болон сэтгэл санааны асар их дарамтыг учруулж, бие хүнийг хөнөөж байдаг.

Хоёрт: Төлөвлөгдсөн ухамсарт үйлдлээр илэрдэг бөгөөд ойр дотны хүмүүсээ хүчирхийлж байгаа энэ зан үйлээ бусдад гаргадаггүй нь хүчирхийлэл үйлдэгч өөртөө хяналт тавих чадвартайг харуулж байна.

Гуравт: Тодорхой зорилгод хүрэх үүднээс хүчирхийлэл үйлдэгч айлган сүрдүүлэх, шийтгэх, хохирогчийг өөрөөсөө хамааралтай гэдэгт итгүүлэн үнэмшүүлэх тактик хэрэглэдэг.

Иймд гэр бүлийн хүчирхийлэл нь Хэн нэгэн хүний ганц нэгэн удаагийн, санамсаргүй, тохиолдлын зан үйл биш. Тодорхой зорилгод хүрэх үүднээс төлөвлөгдсөн ухамсарт үйлдэл төдийгүй бусдыг зовоон тарчилгах нэг хэлбэр. Гэр бүлийн хүчирхийлэл нь санаатай үйлдэгддэг, байнгын тогтвортой үргэлжилдэг тэгш бус харилцаа. Гэр бүлийн хүчирхийлэл хүний хувийн амьдрал, хувийн нууцтай холбоотой эмзэг асуудал. Гэр бүлийн хүчирхийлэл нь дахин давтагдаж, даамжирч, далд үйлдэгддэг хэрэг юм.

Нийгмийг хамгаалах онолыг боловсруулсан Адолф Принсийн үзэд баримтлалаар гэмт хэрэг, зөрчлийг бууруулахын тулд ял шийтгэлийн тогтолцоог хөгжүүлэх бус харин ажилгүйдэл, ядуурал, зовлонд нэрвэгдсэн хүмүүсийг нийгмийн зүгээс анхааран халамжлах нь чухал, амьдрах гэр оронгүй, тогтсон гэр бүлгүй эрхэлсэн ажилгүй, орлогогүй хүмүүс биеэ авч явах талаар тогтсон уламжлал болон хуульт ёсонд захирагддаггүй гэсэн дүгнэлтийг хийсэн нь гэмт хэрэг, зөрчил үйлдэж буй хүмүүсийн ихэнх нь эрхэлсэн ажилгүй, боловсролын түвшин доогуур, огтсон гэр бүлгүй ямар нэг амьдралд нь асуудал байгаатай холбоотой гэж ойлгож болохоор байна⁶⁸.

Хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг шалтгааныг “Хүүхэд насанд хүрэгчдээс сул дорой, өөрийгөө тэжээн тэтгэх чадваргүй, тухайн орчноос зугатаах боломжгүй байдаг” нь хүчирхийлэгчээс хараат байх нөхцөлийг бүрдүүлдэг⁶⁹. Хүчирхийлэлд өртөж байгаагаа, хохирлоо барагдуулах, нөхөн сэргээх асуудлаа мэдэхгүй, мэдсэн ч барагдуулахгүй өнгөрч байгаа нь зөрчил, гэмт хэрэг үйлдэгчийг үйлдлээ давтах шалтгааны нэг болж байна. Ажилгүй, орлогогүйгээс гэр бүл ядууралд өртөж хамгийн том хохирогч нь хүүхэд болж байгаа тул зөвхөн ял шийтгэлээр хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэх боломжгүй.

Мөн хүчирхийллийн өөр нэг хэлбэрийн хувьд:

- Өөрийн эсрэг;
- Хүмүүс хоорондын;
- Хамтын гэж хувааж үздэг байна.

Өөртөө хүчирхийлэл үйлдэх ба өөрийн эсрэг хүчирхийлэл

⁶⁸ Зүмбэрэллхам, Д. Криминологийн онол. 2022. 105-109 дэх тал.

⁶⁹ Finkelhor, D., Dzuiba-Leatherman, J. Victimization of children. Am Psychologist. 1994;49:173-183.

Өөртөө чиглэсэн хүчирхийлэл болон өөрийгөө гэмтээх бусад хэлбэрүүд нь хүүхэд залуучууд, гэр бүлд нөлөөлдөг ноцтой асуудал юм. Өөртөө чиглэсэн хүчирхийллийг хүний санаатайгаар хийдэг аливаа үйлдэл гэж тодорхойлдог.

Өөрийн эсрэг хүчирхийллийг амиа хорлох, өөрийгөө гэмтээх гэж хоёр хувааж үздэг. “Амиа хорлох” ангилалд амиа хорлох бодол, оролдлого, үйлдлийг багтааж байгаа бол “өөрийгөө гэмтээх” гэсэн ангилалд өөрийн бие махбодыг санаатайгаар гэмтээх зэрэг үйлдэл багтана.

Өөртөө чиглэсэн хүчирхийлэлд:

- Толгойгоо цохих, өөрийгөө хазах, өөрийгөө маажих;
- Өөрийгөө зүсэх;
- Архи, мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэх;
- Бусдын амиа хорлох зан үйлд өртөх;
- Амиа хорлохоор бодох, төлөвлөх, оролдлого хийх;
- Амиа бүр мөсөн өгүүтгэх зэрэг ангилсан байдаг.

Хүмүүс хоорондын хүчирхийлэл

Хэн нэгэн этгээд өөрийн эрх мэдлээ тогтоож, зорилгодоо хүрэхийн тулд биенийхээ эсрэг албадлага, хүч хэрэглэх аргыг хэлнэ.

Энэ төрлийн хүчирхийлэл нь гэр бүлийн, бэлгийн хамтрагчийн эсрэг хүчирхийлэл, хүүхэдтэй зүй бус харьцах, ахмад настны эсрэг хүчирхийлэл багтдаг байна. Танил хүмүүс хоорондын хүчирхийлэлд танхайрах бие махбодид халдах, бэлгийн, сэтгэл санааны ба үл хайхрах мөн чанартай байдаг.

Хүмүүс хоорондын хүчирхийлэлд:

- Хүүхэдтэй зүй бус харьцах хүчирхийлэл;
- Залуучуудын эсрэг хүчирхийлэл;
- Бэлгийн хамтрагчийн эсрэг хүчирхийлэл;
- Бэлгийн хүчирхийлэл;
- Ахмад настуудтай зүй бус харьцах хүчирхийлэл;
- Тусгай хэрэгцээт иргэний эсрэг хүчирхийлэл;
- Өдөр тутмын хүчирхийлэл гэх мэт ангилж болно.

Хүчирхийллийн хэлбэрийг бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, үл хайхрах, гачигдуулах⁷⁰ гэж ангилсан бол Монгол Улсад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн хүчирхийллийн хэлбэрийг⁸ ихэвчлэн хуульчилсан байна. “Үл хайхрах” хүчирхийлэл гэж сэтгэцийн болон бие бялдарын чадваргүй байдал эсвэл бие даах чадваргүй хоол, байр, хувцас эмнэлэгийн үйлчилгээ эрүүл мэндийн болон бусад үйлчилгээ авах хэрэгцээг өөрөө хөнгөж чадахгүй тохиолдолд асран хамгаалагч нь үзүүлэхгүй байхыг ойлгодог⁸. Үл хайхрах, гачигдуулах хүчирхийлэлд илүүтэй бусдын асран хамгаалалтад байдаг хүүхэд, өндөр настан, хөдөлмөрийн чадвараа алдсан буюу хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүн илүүтэй өртөх эрсдэлтэй байдаг. Үл хайхрах, гачигдуулах хүчирхийлэл дээрх бүх хүчирхийллийн төрөлд байдаг ба хөгшин залуу, эрэгтэй, эмэгтэй, нас, хүйс ялгаагүй энэ төрлийн хүчирхийллээс ангид байх эрхтэй. Үл хайхрах хүчирхийлэл дангаараа болон бусад хүчирхийллийн хэлбэрүүдтэй хамт илэрдэг. Хамгийн хүнд илрэх хэлбэр нь хүүхдийг үл хайхарснаар хүүхэд хэнд ч хэрэггүй гэж өөрийгөө хорлох, өгүүтгэх гэж оролдох үйлдэл гаргадаг нь өсвөр насны дунд нэмэгдэх хандлагатай байгаа нь харамсалтай юм⁷¹.

Зөрчлийн тухай хуульд хүүхдийн эрхийг зөрчих 15 зөрчлийг хуульчилснаас ихэнх нь хүүхдийн махбодод халдсан, үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архидан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн зөрчил нэлээдгүй байна. Үл хайхрах хүчирхийлэл нь дангаараа олон бусад хүчирхийллийн хэлбэртэй хамт үйлдэгддэг тул

⁷⁰ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. /2016/ 6 дугаар зүйл 6.1.

⁷¹ Монгол Улсын хувьд бие даасан хүчирхийллийн төрөлд хамааруулаагүй боловч хууль тогтоомжуудад үл хайхрах гачигдуулах хүчирхийллийн үйлдэл хэлбэрийг тусгасан байдаг.

хамгийн түгээмэл байх боловч илрүүлэлт хангалтгүй, хариуцлагын үр нөлөөтэй байдалд анхаарах шаардлага зайлшгүй байна.

Гэр бүлийн хүрээнд архидалт, ядуурал, ажилгүйдэл их байгаа нь хүүхдээ үл хайхрах, зөрчлөө давтан үйлдэх, үйлдлээ ухамсарлахгүй байх шалтгааны нэг хэсэг болж байна. Иймд үл хайхрах хүчирхийллийг үйлдэж буй этгээдэд хүлээлгэж буй хариуцлагын хэмжээ, үр нөлөөтэй байдал, хүүхдэд учирсан хохирол, үр дагаврыг арилгах талаар авч үзэх нь ач холбогдолтой юм

Монгол Улсын Үндсэн хуульд “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”⁷² гэж заасны дагуу Улсын Их Хурлаас гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуулийг тус тус баталсан. Гэр бүлийн хүчирхийлэл, түүнд хариуцлага хүлээлгэх асуудлыг Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар зохицуулж байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Эх нялхас онцгой асрамж, туслалцаа авах эрхтэй. Баталгаатай гэр бүлээс гарсан буюу бутач гэдгээс үл хамааран бүх хүүхэд нийгмээс адилхан хамгаалалт эдлэх ёстой”⁷³ Хүүхдийн эрхийн тухай хуульд “Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй”⁷⁴ гэж заасан байдаг. Үл хайхрах байдал гэдгийг “Хэн нэгэн этгээд хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, эруул мэнд, хөгжил боловсрол, аюулгүй байдал, хайр халамжаар хангах зэрэг суурь хэрэгцээг гачигдуулсны улмаас ххдэд гэм хор учруулсан болон учруулахыг завдсан, энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй байдлыг хэлнэ” хэмээн тодорхойлжээ. Хүүхдийн эрхийн тухай конвенцод “гэмтэл, бэртэл учруулах, зүй бусаар харьцах, анхаарч халамжлахгүй байх, үл хайхрах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх, мөлжих зэрэг бие махбод, сэтгэл санааны хүчирхийллийн бүх хэлбэр” хэмээн тодорхойлсон байна.

Хүүхэд хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиудад заасан өндөр настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг гэр бүлийн хамаарал бүхий этгээд нь хүчирхийлэл үйлдэх, тодорхой эс үйлдэл хийх нь зөрчил болон гэмт хэрэг хэмээн үзэж хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан. Дээрх хуулиудад хүчирхийллийн зарим үйлдэл, эс үйлдлийг нэг бүрчлэн нэрлэн дурдаж, хууль бус гэж үзэж хориглосон байх ба хариуцлагыг Зөрчлийн болон Эрүүгийн хуулиар хүлээлгэхээр заасан. Гэтэл Зөрчлийн болон Эрүүгийн хуульд тухайн үйлдэлд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт хангалтгүй, зарим тохиолдолд зохицуулалт дутмаг байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2 дахь заалт гэр бүлийн гишүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах, нуух түүнийг нийгмийн харилцаанд оролцохыг аливаа хэлбэрээр хязгаарлах, хөгжүүлэх чадваржуулах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийх, мөн хуулийн; 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэгт энэ хуулийг зөрчсөн этгээдийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ гэж заасан боловч зөрчлийн хувьд тухайлсан зохицуулалт байхгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт “хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг Хүүхдийн эрхийн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар, хүүхдийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах ял, албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуулиар тус тус тодорхойлно заасан бөгөөд зарим зохицуулалт нь хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэгт, зарим нь гэр бүлийн

⁷² Монгол Улсын Үндсэн хууль. 16.11 дүгээр зүйл. 1992.

⁷³ Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 25 дугаар зүйл 25.2. 1946.

⁷⁴ Хүүхдийн эрхийн тухай хууль. 7 дугаар зүйл. 2016.

хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт хамаарахаар зохицуулжээ. Энэ нь субъектийн хувьд гэр бүлийн хамааралтай болон хамааралгүй субъектээс хүчирхийлэл үйлдэх гэсэн агуулга бүхий боловч зарим зохицуулалт нь тодорхой бус, зарим нь давхцалыг бий болгохоор байна. Эдгээрээс дүгнэхэд материаллаг хуулиудын уялдаа холбоо дутмаг, эрх зүйн зохицуулалт хийдэлтэй, давхардалтай байгаа нь хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хүндрэл гарах, тухайн эрх зүйн харилцаанд оролцогчдын хууль ёсны эрх, ашиг сонирхол хөндөгдөх, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, хууль хэрэглээний алдаа гарах эрсдэлийг бий болгож байна.

Зөрчлийн тухай хуульд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хуулиар асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн, хуулийн этгээд хуухдийг хувцас, хоол хүнс, орон байраар зориуд гачигдуулсан, хүүхдэд эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй хоол хүнсний зүйлийг хэрэглүүлсэн, хүүхдийг дархлаажуулалтад хамруулах үүргээ биелүүлээгүй, хуулиар хүлээсэн асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.⁷⁵ Мөн хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архи дан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэсэн нь бусад асран хамгаалалт шаардлагатай, хүчирхийлэлд өртөх магадлал өндөр хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настантай харьцуулахад үл хайхрах хэлбэрт хариуцлага хүлээлгэхээр заасан нь сайшаалтай байна.

Зөрчлийн тухай хуульд хүүхдийн эрхийг зөрчих 15 зөрчлийг хуульчилсан байдаг. Судалгаанаас харахад зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан "Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архи дан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн" зөрчил нийт зөрчлийн дийлэнх хувийг эзэлж байна. Тухайлбал, 2020 онд бүртгэгдсэн 3215 зөрчлийн 80.7 хувь нь, 2021 оны нэгдүгээр улиралд бүртгэгдсэн 1162 зөрчлийн 96.7 хувийг дээрх төрлийн зөрчлийн хэрэг эзэл байна. Мөн шүүхийн шийтгэвэрт хийсэн дүн шинжилгээгээр 1207 тохиолдлын 14.3 хувь нь Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан "Шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг 3 сараас дээр хугацаанд төлөөгүй зөрчил эзэлж, 1034 буюу 85.6 хувь нь "Хүүхдийн дэргэд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн зөрчил эзэлж байгаа нь гэр бүлийн хүчирхийллийн дам хохирогч нь хүүхэд болж байгааг харуулж байна. Мөн шүүхээс хүүхдэд тэтгэлэг тогтоосон хэдий ч тэтгэлгийг төлөхгүй байгаа нь хүүхдээ үл хайхарч байгаа жишээний нэг юм.

Гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийн ихэнх нь зөрчлийн хуулиар шийдвэрлэгдэж хүчирхийлэл үйлдсэн этгээдэд баривчлах, албадан сургалтад хамрагдах хариуцлага хүлээлгэж байна. Баривчлагдах хугацаанд хүчирхийлэл үйлдэгчийг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж маргааныг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх, уур бухимдал, сэтгэл зүйгээ удирдах зэрэг зөв амьдралын дадал хэвшлийг суулгахад анхаарч сургалтыг зохион байгуулж байгаа хэдий ч хүчирхийлэл үйлдэгч үйлдлээ давтах, засарч сайжрахгүй байгаа нь цөөнгүй байна. Тиймээс Зөрчлийн тухай хуулиар хүлээлгэх хариуцлагын нэг төрөл болох зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг нэг мөр хэрэгжүүлэхэд анхаарах, тэр дундаа хууль зүйн болон сэтгэл зүйн шинжлэх ухааныг хослуулан хөгжүүлэх хэрэгцээ гэр бүлийн харилцааны хүрээнд илүү шаардлагатай байна.

Гэр бүлийн хүчирхийлэл нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хэм хэмжээгээр⁷⁶ зохицуулагддаг. Гэтэл дээрх хууль тогтоомжуудад дараах хэм хэмжээний зөрчилдөөн үүссэн үүнд:

⁷⁵ Зөрчлийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. 6 дугаар зүйл 6.20. 2017.

⁷⁶ Гэр бүлийн тухай хууль, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль.

Нэр томъёоны асуудал

“Гэр бүлийн хүчирхийлэл” гэдгийг ойлгохын тулд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиас гадна гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн нэр томъёо зайлшгүй чухал юм. Гэтэл дээрх хууль тус бүрт дараах нэр томъёог өөр өөр утгаар тайлбарласан. Үүнд:

1) Объектив шинж - Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэдгийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд “энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодид халдсан үйлдэл, эс үйлдэхүй”⁷⁷ гэж, Эрүүгийн хууль болон зөрчлийн тухай хуульд “гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хунийг зодсон, харгис хэрцгий харьцсан. догшин авирласан, тарчлаасан, эд хөрөнгө захиран зарцуулах эрхэд халдсан үйлдэл, эс үйлдэхүй”⁷⁸-г ойлгоно гэж тус тус заасан. Дээрхээс харахад, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн болон бие махбодийн хүчирхийллийн объектив шинжийг Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд бүрэн хуульчилж чадсан эсэх нь эргэлзээтэй. Тухайлбал, үл хайхрах, мөрдөн мөшгих, заналхийлэх, гутаан доромжлох зэрэг сэтгэл санааны хүчирхийлэл, орлого олох боломжийг хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх зэрэг эдийн засгийн хүчирхийлэл дээрх хуульд байхгүй. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд үйлдлийн арга бүрийг тоочин заасан нь хуулийн хийдэл үүсгэсэн.

2) Хохирогч Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн” байна гэж тодорхойлсон. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн гэдгийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд ойлгомжгүй тодорхойлсон⁷⁹. Мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.4 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт өөр байдлаар тайлбарласан.” Гэтэл Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд гэр бүл, гэр бүлийн гишүүн, төрлийн болон садангийн хүн гэсэн нэр томъёо байхаас биш гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, гэр бүлийн харилцаатай хүн. бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн гэх ойлголт байхгүй байна. Өөрөөр хэлбэл аль хуулийн нэр томъёог үндэслэж хохирогчийг тодорхойлох нь эргэлзээтэй болсон.

Хэргийн зүйлчлэлийн асуудал

1. Эрүүгийн хуулийн тусгай анги /Цаашид – ЭХТА гэх/-н 11.7 дугаар зүйл /Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/-ийн 1 дэх хэсэгт гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив шинж болон Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйл /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих/-ийн 4 дэх хэсэгт зөрчлийн хэргийн бүрэлдэхүүний объектив шинжийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

Хүснэгт №1. Хуулийн харьцуулалт

№	Эрүүгийн хууль	Зөрчлийн тухай хууль	Тайлбар
	Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг		Ижил
	Байнга	-	Өөр
1.	Зодсон	Зодсон	Ижил
2.	Харгис хэрцгий харьцсан, догшин авирласан,	Хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан	Ойролцоо

⁷⁷ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсэг.

⁷⁸ Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг.

⁷⁹ Эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд; тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү; гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд.

	тарчлаасан	Бусадтай харилцахыг хязгаарласан	
3.	Хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан	Хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан	Ижил
	Хууль зүйн хариуцлага		Тайлбар
1.	Албадлагын арга хэмжээ	Албадлагын арга хэмжээ	Ижил
2.	6 сараас 1 жил хүртэл хорих ял	7-оос 30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл	Өөр

Дээрхээс үзвэл, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол гэмт хэрэг, эсхүл зөрчил гэж үзэхэд хүндрэл үүсгэсэн. Ганцхан зааглаж буй томъёолол нь “байнга” гэх шинж юм. Академич С.Нарангэрэл “янз бүрийн объектив болон субъектив нөхцөл байдалд цаг хугацааны нэлээд завсарлагатайгаар нэг гэмт хэргийг хоёроос дээш удаа үйлдэх нь гэм буруутай этгээдийн үйлдлийг байнга гэж үзэх үндэс болохгүй. Байнга гэдэг бол гэмт хэрэг үйлдэх явдал үе үе давтагдаж, тэдгээрийн хоорондын зай их бишийг харуулан гэм буруутай этгээдийн зан үйлийн тодорхой чиглэл илэрсэн, гэмт хэрэг давтан үйлдэх явдал юм. Гурав буюу түүнээс дээш гэмт хэрэг үйлдэх нь байнга гэсэн ухагдахууны зайлшгүй тоон үзүүлэлт мөн” гэжээ.

Доктор С.Жанцан “нэг этгээд нэлээн үргэлжилсэн хугацаанд нэг гэмт хэргийг дөрөв ба түүнээс дээш удаа үйлдэж, тэдгээрийн алинд нь шийтгэгдээгүй бөгөөд энэ нь түүний гэмт зан төлөвийн тогтсон хандлагыг илэрхийлсэн байхыг гэмт хэргийг байнга үйлдэх гэнэ” гэж тодорхойлсон байна.

Дээрхээс дүгнэхэд, “байнга гэмт хэрэг үйлдэх” гэх ойлголт нь дараах байдлаар илэрч болохоор байна. Үүнд:

- Нэг гэмт хэргийг тодорхой хугацааны завсарлагатайгаар гурав ба түүнээс дээш удаа үйлдсэн байх;

- Тэдгээрийн алинд ч ял шийтгүүлээгүй байх;

- Гэмт хэрэг үйлдсэн хүний гэмт зан төлөвийн илрэл бөгөөд энэ нь амьдралд хэвшиж тогтсон дадал зуршил гэсэн шинжийг агуулж байна⁸⁰.

Гэтэл Эрүүгийн болон зөрчлийн тухай хуулийн дээрх хэм хэмжээний ялгамжгүй байдлаас үүдэж гэмт хэрэг, зөрчлийн бүрэлдэхүүний шинжийг мөрдөгч, прокурор, шүүх тодорхойлох боломжгүй болсон. Өөрөөр хэлбэл гэр бүлийн хамаарал бүхий харилцаа хунийг 1 юм уу 2 удаа зодсон, эсхүл 3 удаа зодсон байлаа ч 1 удаагийн үйлдэлд нь Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулсан бол гэмт хэрэг биш гэж шийдвэрлэсээр байна. Учир нь Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулсан үйлдэлд Эрүүгийн хуулийн дагуу ял оногдуулах нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан “нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэсэн шударга ёсны зарчимтай харшлах юм гэж үзсэн байна.¹⁵

Дээрхээс үзэхэд, хохирогч 3 болон түүнээс дээш гэр бүлийн хүчирхийлэлд өртсөний дараа гомдол, мэдээлэл гаргасан тохиолдолд гэмт хэрэг, тухай бүр гомдол, мэдээлэл гаргасан тохиолдолд эерчил гэж шийдвэрлэгдэх нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндсэн зорилгод нийцэхгүй гэж дүгнэхээр байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогчийн биед гэмтэл учирсан нь шүүх эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд гэр бүлийн хүчирхийлэл байнга үйлдсэн байсан ч Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлгийн 11.1 дэх хэсэг (Хүний эрүүл

⁸⁰ <https://mglbar.mn/news/330>.

мэндэд хүнд хохирол санаатай учруулах), 11.4 дэх хэсэг (Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах), 11.6 дахь хэсэг (Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах) г.м зүйлүүдийн хүндрүүлэх нөхцөлд хамааруулан зүйлчилж шийдвэрлэдэг практик байна. Гэмтэл учруулахгүйгээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн бол 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хоригдох бол гэмтэл учруулж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх хөнгөн шийтгэл ногдуулахаар заасан нь хөнгөнөөс хүндрүүлэх зарчим алдагдаж ял завших боломжийг хууль тогтоогчийн зүгээс олгосон гэж үзэхээр байгаа тул эргэн харах нь зүйтэй юм.

Хүчирхийлэл нь хүний амьд явах эрх, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх, эрх тэгш бөгөөд ялгаварлан гадуурхалтаас ангид байх зэрэг эрхүүдийг тодорхой байдлаар зөрчиж эсвэл хязгаарлаж байдаг учир хүний эрхийн зөрчил гэж тооцогдох бөгөөд хүчирхийлэлтэй холбоотой НҮБ-ын болон Европын Холбооны конвенцууд зэрэг Олон Улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зохицуулалтууд дэлхийн улс орнуудад үйлчилж байна. НҮБ-аас баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйлд "Хүн бүр амьд явах, эрх, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй"⁸¹ зэргээр суурь харилцааны үндсийг тодорхойлсон байна.

Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын актын 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй" гэж, мөн пактын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй", 26 дугаар зүйлд "Хүн бүр хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчлах явдлыг хуулиар хориглох бөгөөд хууль нь арьс, өнгө, нас, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал буюу бусад байдлаар алагчлахаас бүх хүнийг адил тэгш үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой" гэж тус тус заасан байна.

Харин эрх тэгш бөгөөд ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "оролцогч улсууд арьс өнгө, нас хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн болон бусад нөхцөл байдлаар алагчлахгүйгээр энэхүү Пактад тунхагласан эрхийг хэрэгжүүлэх баталгааг бий болгох үүрэгтэй" гэж, мөн Пактын 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "...оролцогч улсууд хүн бүрийн бие бялдрын болон сэтгэцийн эрүүл мэндэд дээд төвшинд хүрсэн байх эрхийг хүлээн зөвшөөрнө" гэж заасан.

Хүчирхийлэлтэй тэмцэх нь дэлхий нийтийн хурцадмал сэдэв болсны учир НҮБ болон олон улсын бусад байгууллагаас энэ чиглэлээр цөөнгүй тооны тогтоол, зөвлөмжийг гаргаж, улс орнуудыг гэр бүлийн хүчирхийллийг устгахад уриалсан байдаг.

- Хүүхдийн эрхийн тухай 1924 оны Женевын тунхаглал
- Еренхий Ассамблейгаас 1959 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр батласан Хүүхдийн эрхийн тунхаглал

- Эмэгтэйчүүдийг алагчлах бух хэлбэрийг устгах тухай конвенц -(2017) НҮБ-ын Еренхий Ассамблей 1979 оны 12 дугаар сарын 18-ны 34/180 тоот тогтоолоор баталсан тус конвенц нь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр гарсан эрх зүйн гол баримт бичиг бөгөөд энэ асуудлаар гарсан хожмын тогтоол, зөвлөмжүүдийн тулгуур баримт бичиг болсон юм. Энэхүү конвенцийг хэрэгжүүлэх

⁸¹ Хүний эрхийн олон улсын билл. Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхтгэл 2018. 16 дахь тал.

зоригоор Конвенцийн хорооноос 1989, 1992 онуудад зөвлөмж, тогтоолууд гаргасан байдаг⁸².

- Истанбулын конвенц-(2011) Европын зөвлөлийн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай 2011 оны конвенц (Истанбулын конвенц) нь олон улсын болон бус нутгийн түвшинд хамгийн өргөн хүрээг хамарсан урт хугацааны арга хэрэгсэл, стандарт болсон бөгөөд энэ чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны олон асуудлыг хамарсан, нарийвчилсан төлөвлөгөө болдог. Уг конвенцийн дагуу эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь хуний эрхийн зарчил, ялгаварлан хэлбэр болохыг тогтоож эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хүрээнд зайлшгүй байдлын стандартыг нэгтгэн тогтоохын зэрэгцээ бие махбодын бэлгийн, сэтгэл санааны хүчирхийлэл, мөрдөн мөшгөх, бэлгийн дарамт үзүүлэх, эм бэлэг эрхтнийг зэрэмдэглэх, албадан хүчээр гэрлүүлэх, хүчээр ур хундуулэх, албадан ургуй болгох зэрэг болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн төрөл бүрийн хэлбэрүүдийг гэмт хэрэгт тооцохыг оролцогч улсуудад даалгасан байна.

- Венийн тунхаг бичиг-(1993) Австрийн Вена хотод 1993 оны 6 дугаар сарын 25 ны дөр болсон хуний эрхийн Дэлхийн бага хурлаас эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь хү бичиг болох "Венийн тунхаглал"-д нийгмийн болон гэр бүлийн харилцаанд эмэгтэйчүүдийг хүчирхийлэх бүх хэлбэрийг устгахын чухлыг онцлоод, улс гүрнүүдэд бэлгийн дарамт, мөлжлөг, жендэрийн тэгш бус байдлыг халахад чиглэсэн арга хэмжээ авахыг уриалсан байна.

Энэхүү тунхаг бичгийн уриалгын дагуу Монгол улс олон арга хэмжээг хэрэгжүүлсэн нь НҮБ-ын тогтолцооны хүрээнд батлагдан гарсан хүний эрхийн гэрээ, конвенц, нэмэлт протоколуудад нэгдэн орох чухал хөшүүрэг болсон.

- Эмэгтэйчүүдийг хүчирхийлэхийн эсрэг тунхаглал-(1993) НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1993 онд Эмэгтэйчүүдийг хүчирхийлэхийн эсрэг 6 зүйл бүхий тунхаглал гаргасан. Уг тунхаглалд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэж жендэрт суурилсан хүчирхийллийн аливаа үйлдлийг, түүний дотор үйлдэхээр заналхийлэх, эрх чөлөөг хасах буюу хасахаар заналхийлэх үйлдлийг хамруулсан ба хүчирхийлэл үйлдэгч нь аль хүйсийн хүн, гэр бүлийн гишүүн, тэр ч байтугай төр байж болохыг заасан. Уг тунхаг бичгийн 4 дүгээр зүйлд эмэгтэйчүүдийг хүчирхийлэхийн эсрэг үндэсний хэмжээнд төлөвлөгөө гарган, холбогдох санхүүжилтийг шийдвэрлэн санаачлагатай ажиллахыг уриалсан байдаг.

- Бээжингийн тунхаглал-(1995) Бээжин хотноо 1995 онд зохион байгуулагдсан Эмэгтэйчүүдийн асуудлаарх Дэлхийн IV чуулга уулзалтаас баталсан "Бээжингийн тунхаглал"-д эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хуний эрхийн ноцтой зөрчил мөн хэмээн онцлон тэмдэглэж, түүнийг устгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр улс орнууд хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхийг уриалж, үйл ажиллагааны хөтөлбөр гаргасан;

- Хүүхдийг бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийллээс хамгаалах тухай Европын зөвлөлийн конвенц⁸³ гэр бүл доторх хүүхдийн бэлгийн хүчирхийллийг шийдвэрлэхтэй холбогдсон анхны олон улсын гэрээ эрхийн зөрчил болохыг тэмдэглэж, улмаар төгсгөлийн баримт.

-

Дүгнэлт

Хүний эрхийн зөрчил нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, нэгдэн орсон олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийн хэрэгжилтээр тодорхойлогдох боловч эрүү, иргэн, захиргааны эрх зүй гэх мэт салбар эрх зүйгээр зохицуулах харилцаанаас үүдэн гарсан зөрчил нь хүний эрхийн зөрчилд хамаарахгүй. Харин хүний эрхийн онол талаас сонгодог утгаар нь авч үзвэл төр, төрийн байгууллага, албан тушаалтнаас

⁸² Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага IDLO гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлэх. УБ. 2021. 2 дугаар хэвлэл. 86 дахь тал.

⁸³ Council of Europe Convention on the Protection of Children against Sexual Exploitation and Sexual Abuse.

хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үүргээ биелүүлж чадахгүй байгаагаас үүдэн гарч буй зөрчлийг хүний эрхийн зөрчил хэмээн нийтлэг утгаар ойлгодог.

Хүчирхийллийн талаарх эрх зүйн зохицуулалт хэрэгжих механизм нь учир дутагдалтай байгаа нь хууль тогтоох үүргээ төр зохих ёсоор хэрэгжүүлээгүйгээс эрх зүйн зохицуулалтгүй орхигдож хүний эрхийн зөрчил үүсэх гарцийг нээж байна гэж дүгнэж болохоор байна.

Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хууль, хеделмерийн тухай хууль, Жендерийн тухай зэрэг хуулиудад тухайн субъектийн эсрэг чиглэсэн хүчирхийллийн талаарх ойлголтыг тус бүр тусгасаж Эрүүгийн болон зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэхээр заасан хэдийн зөрчлийн ба эрүүгийн хуульд энэ төрлийн хүчирхийлэлд хүлээлгэх холбогдох хариуцлагыг орхигдуулсан байна. Энэ нь хэрэгжих механизмгүй хүний эрх шүдгүй арслантай адил гэж нэг мэргэн хүний үгийг өөрийн эрхгүй санагдуулахад хурч байна. Тиймээс тухайн хучирхийлэлд хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан тусгаж өгөх шаардлагатай гэж дүгнэлээ.

Залуучуудын хүчирхийлэл, нехен үржихуйн хүчирхийллийн зэрэг хүчирхийллийн хэлбэрүүд хуулийн огт зохицуулалтгүй байгаа нь энэ төрлийн хүчирхийлэл нь хүний эрхийн зөрчил гарах үндэслэл болж байна.

Мөн зарим субъектийн хувьд хуульчлигдаж хамгаалагдсан үл хайхрах хүчирхийллийг зөвхөн хүүхдийн хурээнд авч үзсэн боловч ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл хайхрах асуудлууд хуулийн хамгаалалтгүй орхигдсон байна.

Хүүхдийг үл хайхрах хүчирхийллээс хамгаалахын тулд эрх зүйн орчныг бий болгох нь хангалтгүй юм. Хангалтгүй учраас ч өнөөгийн нийгэмд хүүхдийн эсрэг хүчирхийлэл чимээгүй, хариуцлагаас ангид хаалттай хаалганы цаана байсаар байна.

Үл хайхрах хүчирхийлэлд хүүхэд гэлтгүй гэр бүлийн бүхий л гишүүд өртөх боломжтой юм. Ялангуяа асрамж, хамгаалалт шаардлагатай өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй гишүүн, хүүхэд илүүтэй өртөж байдаг. Одоогийн эрх зүйн зохицуулалтад энэ төрлийн хүчирхийллээс дээрх субъектүүдийг хэрхэн хамгаалах эрх зүйн зохицуулалт дутмаг, энэ төрлийн зөрчил нь ямар үйлдлүүдээр илрэх нь ойлгомжтой бус, гэр бүлийн хүчирхийллийн төрөл эсэх нь ч тодорхой бус зохицуулалттай байна. Эрүүгийн болон зөрчлийн хуульд дээрх үл хайхрах, гачигдуулсан үйлдлийг санаатайгаар хүүхэд, ендер настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн бол зөрчил болон улмаар гэмт хэрэгт тооцох, цаашлаад одоо байгаа зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Зүмбэрэллхам, Д. Криминологийн онол. 2022.
2. Нэгдсэн Үндэстний Байгууллага. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл. мэдээллийн хуудас. 2011.
3. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага IDLO гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлэх. УБ. 2021. 2 дугаар хэвлэл.
4. Хүний эрхийн олон улсын билл. Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл 2018.

Гадаад эх сурвалж

5. Beccaria, C. "On crimes and punishment". New Brunswick, NJ Transaction Publishers 1764/2009.
6. Council of Europe Convention on the Protection of Children against Sexual Exploitation and Sexual Abuse.
7. Finkelhor, D., Dzuiba-Leatherman, J. Victimization of children. Am Psychologist. 1994.

Интернет эх сурвалж

8. <https://mglbar.mn/news/330>.

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛ БА ЯЛЫН БОДЛОГО

CIVIL SERVICE REFORM AND CRIMINAL JUSTICE LEGAL PENALTY POLICY

Ж.Нямдулам

ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Nyamdulam J.

Associate professor, Department of public law, School of law and social sciences, University of internal affairs, doctor (Ph.D), associate professor, Lieutenant Colonel of the police

Хураангуй: Төрийн албаны болон Эрүүгийн хуулийн шинэтгэл нь зэрэгцээ яригдаж, 2017 онд хуулиуд батлагдсан. 2017 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого алдагдаж, хохирлын хэмжээгээр ялыг ялгамжтай оногдуулахаар тогтоож өгөөгүй зэрэг олон алдаа, дутагдал бий. Өгүүллийн хүрээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэг, тэр дундаа 22.4 дүгээр зүйлд заасан хахууль авах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж болон 2018 онд шүүхээс шийдвэрлэсэн хэргийн тоон мэдээнд дүн шинжилгээ хийж, харьцуулан судалсан болно.

Abstract: The Public service reform and Criminal law reform were clearly spelled out and reflected in 2017. The current version of the provisions of the Criminal code of 2017 limits a number of arguments that clearly define the law as a reality, and also do not clearly define the punishment for damage and imposing punishment on it. As part of this study, we analyzed and compared the special Chapter 22 of the Criminal code of the special class of criminal law, including article 22.4, criminal law, as well as the criminal prosecution of crimes serving in 2018.

Түлхүүр үгс: Авлигын гэмт хэрэг, коррупци, төрийн албаны шинэтгэл, хахууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хуулийн загвар, ялын бодлого.

Keywords: Official crime, corruptions, civil service reform, bribery, criminal law, criminal law model, indictment policy.

2002 оны Эрүүгийн хуулийн хэрэгжилт, үр нөлөөг судалсны үндсэн дээр үндэсний онцлогийг харгалзан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгохоор Монгол Улсын Их Хурал 2015 онд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, 2017 онд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг тус тус баталсан.

Монгол Улсын Засгийн газар эдгээр хуулийн төслийг боловсруулахдаа бодлогын болон академик 6 судалгаа, дэлхийн 20 гаруй улсын Эрүүгийн хууль болон олон улсын эрдэмтэд хамтран боловсруулсан “Эрүүгийн загвар хууль” зэргийг ашиглажээ.

2007 онд АНУ-д “Model Codes for Post-Conflict Criminal Justice” буюу “Мөргөлдөөний дараах Эрүүгийн шүүн таслах ажиллагааны төрөлжсөн хуулийн загвар”-ыг хоёр боть болгон хэвлүүлжээ. Нэгдүгээр боть нь Model Criminal Code буюу Эрүүгийн төрөлжсөн хуулийн загвар, хоёрдугаар боть нь Model Code of Criminal Procedure буюу Эрүүгийн байцаан шийтгэх төрөлжсөн хуулийн загвар юм. Үүнийг 2015 оны хууль санаачлан боловсруулагчид “Дэлхийн эрүүгийн загвар хууль” хэмээн хөрвүүлсэн байна. Гэтэл энэ бол хэсэг эрдэмтдийн боловсруулсан Эрүүгийн хуулийн

загвар юм. Энэ загварыг хууль болгон батлаагүй, харин Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны нэг загвар юм.⁸⁴ Нөгөөтээгүүр, “post- conflict state” гэсэн нь “Мөргөлдөөний дараах улс” гэсэн санааг илэрхийлнэ. Үүнийг “шилжилтийн болон зөрчилдөөний дараах үе” гэж орчуулжээ.

Дэлхий дахинаа мөргөлдөөний дараах үеийн улс гэсэн хэллэг буй болоод багагүй хугацаа өнгөрчээ. Ийм улсад Афганистан, Ангол, Либер, Судан, Камбож, Косово зэрэг улс ордог.

Манай улсын хувьд эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны баялаг уламжлалтай бөгөөд 1926, 1929, 1934 оны Шүүх цаазын бичиг, 1942, 1961, 1986, 2002 оны Эрүүгийн хуульд авлига, албан тушаалын гэмт хэргийг хуульчилж ирсэн.

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, 2017 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн онцлог нь хорих ял биечлэн эдлүүлэх явдлыг багасгах, хохирол нөхөн төлүүлэх чиглэлд анхаарч, зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ялыг тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах ялыг хөнгөрүүлэх, чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх, өсвөр насны хүнд болон хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх институтийг тусгасанд оршино.

1961 оны Эрүүгийн хуулиас хойш “Албан тушаалын гэмт хэрэг” гэж нэрлэж байсныг 2015 оны Эрүүгийн хуулиар “Авлигын гэмт хэрэг” гэж хуульчилсан.

Коррупци гэх ойлголтод хахууль авах, албан тушаалаа урвуулан ашиглах аль аль нь хамаардаг. Төрийн хүчин чадлыг сулруулж, нөгөө талаар төрийн албан хаагчдыг эх орон, ард түмний язгуур эрх ашгийн төлөө нэг үзүүрт сэтгэлээр зүтгэх явдлыг саармагжуулж, албан тушаалын хувьд олгогдсон эрх мэдэл, мөнгө өгөх, баяжих, хөгжих, албан тушаалын байдлаа худалдах хэрэглүүр болдогт авлигын гэмт хэргийн нийгмийн хор аюул оршино. Иймээс монгол төрийн албаны шинэтгэл бол авлигын гэмт хэрэгтэй тэмцэх явдлаас эхлэх ёстой.

Авлига-(англ. corruption; ор. коррупция, получение взятки)

Авлига-Засаг төрийн төлөөлөгчийн чиг үүргийг гүйцэтгэж буй этгээд, түүнчлэн төрийн алба хаагч аливаа хэлбэрээр эдийн ба эдийн бус баялаг, давуу талыг хууль бусаар олж авхын тулд өөрийн албан тушаалын байдлыг санаатайгаар хортой урвуулан ашигласан, эдгээр этгээд албан тушаалаа худалдсан байдлаар илэрдэг улс төр буюу төрийн удирдлагын салбар дахь нийгэмд нэн аюултай сөрөг үзэгдэл.⁸⁵

Хахууль-(англ. bribe; subornation; амер. graft; ор. взяточничество)

Хахууль-Хахууль өгөх ба хахууль авах гэмт хэргийн халдлагын зүйл бөгөөд мөнгө, үнэт цаас, бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн шинжтэй ашгийн байдалтай материаллаг урамшууллын бүхий л төрлийг багтаасан ерөнхий ойлголт.⁸⁶

Corruption-Коррупци гэдэгт хахууль, албан тушаалаа урвуулах зэрэг бусад гэмт үйлдлүүд хамаараад байгаа юм.

“Эрүүгийн хуулийн загвар” (Model Criminal Code)-ийн тусгай ангид “Corruption Offences” буюу (Коррупцын гэмт хэрэг) гэснээс хагас дутуу хуулбарласан байна.⁸⁷ Эрүүгийн хуулийн загвар (Model Criminal Code)-ын тусгай ангид “Corruption Offences” буюу “Коррупцын гэмт хэрэг” гэсэн бүлэг:

- “Corruption Involving a Public Official (Article 138)⁸⁸, (Төрийн албан хаагчийн үйлдсэн коррупц);

⁸⁴ Нарангэрэл, С., Эрдэнэбулган, Ж. нар “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургаж” нэг сэдэвт бүтээл. УБ. 2019. 44 дэх тал.

⁸⁵ Нарангэрэл, С. “Монголын эрх зүйн толь бичиг” (англи, орос, латин хадмал). Дөрөв дэх хэвлэл. УБ. 2015. 5-6 дахь тал.

⁸⁶ Мөн тэнд. 501 дэх тал.

⁸⁷ Нарангэрэл, С., Эрдэнэбулган, Ж. нар “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургаж” нэг сэдэвт бүтээл. УБ. 2019. 204 дэх тал.

⁸⁸ Model Codes for Post- Conflict Criminal Justice. P.307.

- “Corruption Involving a Foreign Public Official or an Official a Public International Organization (Article 139)⁸⁹ (Гадаадын төрийн албан хаагч буюу Олон Улсын төрийн байгууллагын албан тушаалтны үйлдсэн коррупци);

- “Corruption in the Private Sector (Article 140)⁹⁰, (Хувийн секторын коррупц) эдгээр гэмт хэргийг заасан нь хахууль авсан гэмт хэрэг ажээ. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн загвар (Model Criminal Code)-т “Коррупцын гэмт хэрэг” болон “Коррупцтай хамааралтай бусад гэмт хэрэг буюу Төрийн албан тушаалтнаас үйлдсэн бусад гэмт хэрэг” (Corruption- Related Offences and Other Offences Involving a Public Official) гэсэн бүлэг тусад нь байгааг авч үзэлгүй орхигдуулсан байна. Энэ бүлэгт: Албаны нөлөөгөө худалдах (Trading in Influence) гэх мэт.

Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт 11 төрлийн авлига, албан тушаалын гэмт хэргийг хуульчилсан бөгөөд статистикийг эдгээр төрлөөр авч үзэхэд 22.1 дүгээр зүйлд заасан “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг”, 22.4, 22.5 дугаар зүйлд заасан “Хахууль авах”, “Хахууль өгөх” гэмт хэрэг авлигын гэмт хэргийн ихэнх хувийг эзэлж байна.

Авлигын гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 2017 онд 658, 2018 онд 858, 2019 онд 894, 2020 онд 1020, 2021 онд 1144, шалгасан эрүүгийн хэрэг 2017 онд 427, 2018 онд 1138, 2019 онд 1300, 2020 онд 1331, 2021 онд 1307, шүүхээр шийдвэрлэсэн хэрэг 2017 онд 44, 2018 онд 84, 2019 онд 68, 2020 онд 114, 2021 онд 160 байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо, шүүхээс таслан шийдвэрлэж байгаа хэрэг бүгд өссөн байгааг харуулж байна.

Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүн нь адил хэмжээний ял хариуцлага оногдуулахаар заасан байгааг ялгамжтай байхаар өөрчлөх, энэ бүлгийн зарим төрлийн гэмт хэргийн шинжийг тодорхой болгох, зарим гэмт хэргийг шинээр нэмж хуульчлах, хахууль авах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн субъектыг зөвхөн нийтийн албан тушаалтнаар хязгаарлахгүй нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хамаарахаар өргөжүүлэх, оногдуулах ялын бодлогыг чангатгах зэрэг нэмэлт, өөрчлөлт хийж, авлигатай тэмцэх төрийн бодлогыг чангатгах шаардлагатай байна.

Иймд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүний ял хариуцлага адил хэмжээтэй оногдуулахаар заасан давхардал, зөрчлийг арилгаж ялгамжтай байхаар өөрчлөх, хахууль авах гэмт хэргийг нийтийн албан тушаалтан хахууль авах, нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хахууль авах гэмт хэрэг болгон хуульчилж, ялын бодлогыг ялгамжтай тодорхойлох, энэ бүлгийн гэмт хэрэгт оногдуулах торгох ялыг нэмэгдүүлэх, хүндрүүлэх бүрэлдэхүүнээс торгох ялыг хасах, хорих ялын хэмжээг нэмэгдүүлэх, нийтийн албанд ажиллах эрх хасах ялыг зарим тохиолдолд бүх насаар хасах зэрэг нэмэлт, өөрчлөлтийг Эрүүгийн хуульд 2023 онд оруулсан байна.

Мөн төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учруулсан бол үндсэн бүрэлдэхүүнд хамаарахаар, 22.8 дугаар зүйл, 22.9 дүгээр зүйлд заасан төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэргийг өөрийн хамаарал бүхий харилцаатай хуулийн этгээдэд давуу байдал олгож үйлдсэн бол хүндрүүлэх нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн Эрүүгийн хуулийн нэг жилийн дараах хэрэгжилт, үр нөлөө, тэр дундаа 22 дугаар бүлэгт заасан авлигын гэмт хэрэгт ял шийтгэгдсэн байдлыг авч үзье.

⁸⁹ Мөн тэнд. Р.309.

⁹⁰ Мөн тэнд. Р.311.

График №1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэгт заасан авлигын зарим гэмт хэрэгт шүүхээс ял шийтгэсэн байдал



Эндээс үзэхэд, Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл буюу хахууль авах гэмт хэрэгт нийт 22 хүн ял шийтгүүлсэн нь нийт 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргээр ял шийтгүүлэгчдийн 46.8 хувийг эзэлж байна.

График №2. Ял шийтгүүлэгчдийн насны байдал



Ял шийтгүүлэгчдийн насны байдлаас үзэхэд, 35-аас дээш насныхан дийлэнхи хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь төрийн албанд ажиллах насны шалгуураас хамааралтай боловч нөгөө талаас төрийн албанд удаан тогтвортой ажиллаж, төрийн хүний ноён нуруу, буйр суугаагүй насны хүмүүс гэж хэлж болохоор байна.

Авлигын гэмт хэрэгт дээд боловсролтой, бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй хүмүүс ял шийтгүүлсэн байна. Нөгөөтээгүүр, эрхэлж буй албан тушаалд тавигдах боловсролын шаардлага болон бусад үзүүлэлтэй шууд хамааралтай нь тодорхой юм.

График №3. Авлигын гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийн боловсролын байдал





График №4. Авлигын гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийн боловсролын байдал



Авлигын гэмт хэргийн онцлог нь энэ төрлийн гэмт хэргийг “цагаан захтан” ихэвчлэн үйлдэх бөгөөд боловсролгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй хүн үйлддэггүй.

График №5. Ял эдэлж байгаа хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн байдал

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 22 ДУГААР БҮЛЭГТ ЗААСАН ГЭМТ ХЭРЭГТ ЯЛ ШИЙТГЭГДЧИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ



Дээрх статистикаас харахад, авлигын гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн 35.4 хувийг төрийн үйлчилгээний болон төрийн тусгай алба хаагч, 22.5 хувийг төрийн улс төрийн албан тушаалтан эзэлж байна. Энэ нь төрийн өндөр албан тушаалтнаас үйлдсэн авлигын гэмт хэргийг нотлох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд улс төрийн нөлөөлөл ихээхэн байгааг харуулж байна гэж үзэж болохоор байна.

Авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй нэг арга хэрэглүүр нь ялын бодлого юм. Энэ нь нэг талаасаа авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нөгөө талаар авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хуульд заасан ял оногдуулж, нийгэмд шударга ёсыг тогтооход чиглэгдэж байна.

Авлигын гэмт хэрэгт ялын бодлогыг зөв хэрэгжүүлэхэд дараах хүчин зүйл шууд нөлөөлнө.

1. Авлигын гэмт хэргийг төрийн албан хаагчдад оногдуулах, сахилгын хариуцлагаас зааглах. Энэ асуудлын хувьд ердийн хэвшсэн ойлголтоор бэлэг гэдгийг хахуулиас ялгах явдал онцгой чухал. (Зөрчлийн тухай хууль, Төрийн алба хаагчийн ёс зүйн дүрэм)

2. Авлигын гэмт хэргийг зөв зүйлчлэх.

Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан” гэж тодорхойлжээ. Үүнээс үзэхэд, хууль тогтоогч хахууль авах гэмт хэргийн халдлагын зүйл юу болох, ямар хэмжээний зүйл хахуульд авсныг тодорхойлоогүй буюу хуульчлаагүй. Хахуулийн зүйл болох мөнгө, үнэт цаас, бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн шинжтэй ашиг нь хахуулийг талархлаа илэрхийлсэн ердийн бэлгээс зааглан ялгах боломжтой болгоно.

Хууль тогтоогч хахууль авах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талд “хахууль өгөхийг шаардсан” гэсэн шинжийг нэмсэн нь практикт нэг мөр ойлгож хэрэглэхэд бэрхшээлтэй байдал үүсэж болохоор, учир нь энэ үйлдлийг нотлоход бэрхшээлтэй бөгөөд, нөгөө талаар, шударга албан тушаалтныг хэлмэгдүүлэхэд ашиглаж болох талтай.

Нөгөөтэйгүүр, хахууль авах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний бүтцэд их хэмжээний хахууль авахыг заагаагүй. Өөрөөр хэлбэл, ялыг ялгамжтай оногдуулахад хахуулийн хэмжээг зааглан тогтоох нь яалт ч үгүй чухал юм.

Иймд Эрүүгийн хуулийн хэм хэмжээг боловсронгуй болгох зорилготой дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Авлигын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах, ялангуяа, энэ төрлийн гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээдийн үйлдсэн бол нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж, 8-20 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар хуульчлах.

2. Нийтийн албан тушаалтан албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хахууль авах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг үйлдэж олсон авлигын хэмжээнээс шууд хамааралтай байдлаар, ялыг ялгамжтайгаар хуульчлах.

Ашигласан материал

1. Нарангэрэл, С., Эрдэнэбулган, Ж. нар “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж” нэг сэдэвт бүтээл. УБ. 2019.

2. Нарангэрэл, С. “Монголын эрх зүйн толь бичиг” (англи, орос, латин хадмал). Дөрөв дэх хэвлэл. УБ. 2015.

3. Нарангэрэл, С. “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй тусгай анги”. УБ. 1999

Гадаад эх сурвалж

4. Model Codes for Post- Conflict Criminal Justice.

АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

CHALLENGING PROBLEMS OF LEGAL REGULATION OF OFFICIAL CRIMES

Б.Мөнх-Эрдэнэ

Шихихутуг их сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч

Munkh-Erdene B.

Head of Public law department, Shihihutug university

Хураангуй: Авлигын гэмт хэрэг нь дэлхий дахины хэмжээнд тогтмол давтагддаг нийгмийн сөрөг үзэгдэл юм. Улс үндэстэн бүр авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох бүхий л арга хэмжээг авахыг хичээхийн зэрэгцээ хууль тогтоомжоо боловсронгуй болгож, хэрэгжүүлэх тал дээр түлхүү анхаарч байна. Монгол Улсын хувьд албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэхэд Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргүүдийн шинж, ялын бодлого зэргийг эргэн харах шаардлагатай байна.

Түлхүүр үгс: Авлигын гэмт хэрэг, дураараа аашлах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, хахууль авах, хахууль өгөх, эрх мэдлээ урвуулан ашиглах.

*Авлига бол нийгмийн хорт хавдар бөгөөд иргэдийн ардчилалд
итгэх итгэлийг үгүй хийж, шинэ санаа, бүтээлч сэтгэлгээг бууруулдаг.
Жо Байден*

Авлигын гэмт хэргийн ойлголт нь өмчийг нийтийн болон хувийн гэдэг ангилалд хуваах болсон үеэс л төсвийн хөрөнгийг хувьдаа ашиг унагах зорилгоор буруугаар ашиглах, үрэх, албан тушаалын байдлаа урвуулах байдлаар бусдаас авлига авах гэдэг ойлголт бий болсон. Хахууль өгдөг, авдаг харилцааны дээрх арга хэлбэрүүд нийгмийн харилцаанд тодорхой үүрэг гүйцэтгэсээр эцэстээ ёс зүйн болон хуулийн зохицуулалт үгүй болгох хэмжээнд эмх замбараагүй аномн байдал үүсэх эрсдэл дагуулж далд хууль, нууц дүрмүүд үйлчлэх хэмжээнд хүргэжээ. Төрийн үйлчилгээг авахын тулд албан бус үнэ тариф тогтоох, иргэдээс шан харамж харах, шаардах, хэн хүчтэй, хэн мөнгөтэй нь асуудлаа өөртөө ашигтайгаар шийдүүлэх, төрийн эрх мэдлийг ашиглан их хэмжээний төсвийн хөрөнгийг шамшигдуулах зэрэг олон сөрөг үр дагавар нийгэмд бухимдал, айдас, үзэн ядалт, үл ойлголцол бий болгоод байна.

Гэмт хэрэг бол бүх улс орны хувьд хамгийн хэцүү, тулгамдсан асуудлуудын нэг хэвээр байгаа дэлхий дахины асуудал гэдэг нь эргэлзээгүй. Тэр дундаа авлигын гэмт хэрэг нь тодорхой бус байдлыг бий болгож, амьдралын чанарыг доройтуулдаг төдийгүй хүмүүсийг эрсдэлд оруулдаг, бизнес эрхлэх үйл ажиллагааг удаашруулж нийгмийг туйлдуулдаг гэдгээрээ үр дагавар нь тооцоолох аргагүй аюултай нөхцөл байдлыг бий болгодог. Монгол улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан 11 төрлийн гэмт хэргийг Авлигатай тэмцэх газар харьяалан шалгадаг. Хэдийгээр Авлигатай тэмцэх газар дээрх гэмт хэргүүдийн хүрээнд авлигын эсрэг гэмт хэргүүдтэй тэмцэж хэргийг хянан шийдвэрлэж байгаа хэдий ч хууль эрх зүйн хийдлээс үүдэлтэйгээр авлигатай тэмцэхэд хүндрэл бэрхшээл үүсэж байна. Учир нь албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн хүмүүст оногдуулах ялын бодлого үр дүнтэй биш буюу зарим тохиолдолд хэтэрхий бага, гэмт хэргийн шинжийг тогтоох явцад олон талт байдлаар хуулийг тайлбарлах болоод зайлшгүй байх шаардлагатай гэмт хэргийг хуулиар хүчингүй болгосон нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд, түүнийг таслан зогсооход саад учруулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэсэн тулгуур зарчмыг хэрэгжүүлэхэд авлигыг бууруулж түүнтэй үр дүнтэй тэмцэх нь чухал бөгөөд хууль эрх зүйн сайн зохицуулалт

шаардлагатай. Авлигын томоохон хэргүүдэд ял шийтгэлгүй өнгөрөх, авлигын гэмт хэргээр ял авсан ч хариуцлага нь бага байх зэрэг нь авлигын эсрэг тэмцэлд иргэдийн итгэлийг сулрахад хүргэсэн. Цаашид хуулийг нэг мөр цэгцлэн улс төрчдийн нөлөөлөл, дарамт шахалтаас ангид байлгах, хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, халдашгүй бүрэн эрхээр халхавчлан хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээдэггүй, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх, шударга ёсны зарчмыг гажуудуулдаг байдлыг халах, авлигын эсрэг гэмт хэргийн зохицуулалтыг боловсронгуй болгох буюу хуулийн хийдлийг нэг мөр арилгах байдлаар урьдчилан сэргийлэх, таслан зогсоох нь чухал байна.

Албан тушаалын гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, онцлог

Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар авлигын гэмт хэргүүдийг тусад нь 22 дугаар бүлэгт хуульчилж өгсөн билээ⁹¹. Энэхүү шинэ хуулиар төрийн албан хаагч нь “албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлээгүйгээс өөртөө эсхүл бусдад давуу байдал бий болгосон” бол хохирол шаардахгүйгээр хэлбэрийн гэмт хэрэгт тооцож, ял оногдуулахаар хуульчилсан нь шинэлэг бөгөөд авлигатай тэмцэхэд томоохон түлхэц болохуйц заалт болж чадсан юм. Мөн “төрийн албан хаагч өөртөө, эсхүл өөрийн хамаарал бүхий этгээдэд давуу байдал олгуулах зорилгоор өөрөө эсхүл өөрийн удирдлагад ажилладаг албан тушаалтнаар дамжуулан албаны эрх нөлөөг урвуулан ашиглаж давуу байдал олж авсан, эсхүл олгосноос бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол гэх объектив шинжээр гэмт хэрэгт тооцож ял оногдуулахаар заасан байсныг 2017 оны Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хүчингүй болгосон нь авлигын төрлийн гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдийг хүлээн зөвшөөрөх үндэслэл болсон.

Түүнчлэн Гадаад улсын албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтан эрхмэдлээ урвуулан ашиглавал Монгол улсын хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр болсон төдийгүй Хээл хахууль авах гэмт хэргийн субъект нь нийтийн албан тушаалтнаас гадна хууль, захиргааны хэм хэмжээний акт, хэлцэлээр үүрэг хүлээсэн хүн байж болохыг тодорхой болгож, хууль тогтоомж, дүрэм журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчснөөс гадна дээрх албан үүргээ зохих журмын дагуу хэрэгжүүлсний төлөө бусдаас мөнгө, эсхүл давуу байдал олж авсан бол хахууль авах гэмт хэрэгт тооцогдохоор болгосон билээ. Шинэ хуулиар хахууль авах, өгөхөөс гадна өгөхийг шаардсан, хахууль өгөх саналыг хүлээн зөвшөөрсөн, эсхүл хахууль өгөхийг чанал болгосон, амласан зэрэг үйлдэл хийснээр гэмт хэрэг төгссөн тооцохоор болгож чадсан. Нийтийн албан хаагчийн хууль ёсны дагуу албан үүргээ гүйцэтгэж, үзүүлэх байсан төрийн үйлчилгээг хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд хахууль өгч авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж, ял шийтгэлээс чөлөөлөх, харин хахууль авагчийг хууль бус үйлдэл хийлгэхээр хахууль өгсөн хүнийг ялаас

⁹¹ 22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах

22.2 дугаар зүйл. Албаны эрх нөлөөг урвуулан ашиглах

22.3 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах

22.4 дүгээр зүйл. Хахууль авах

22.5 дугаар зүйл. Хахууль өгөх

22.6 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах

22.7 дугаар зүйл. Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх

22.8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах

22.9 дүгээр зүйл. Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах

22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих

22.11 дүгээр зүйл. Дураараа аашлах

22.12 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах зэрэг нийт 12 төрлийн гэмт хэргийг хуульчилсан бөгөөд 2017 оны нэмэлт өөрчлөлтөөр 22.2 дугаар зүйл. Албаны эрх нөлөөг урвуулан ашиглах гэмт хэргийг хүчингүй болгосон.

чөлөөлөхгүй, харин хахууль өгсөн хүнд эрх бүхий байгууллагад сайн дураараа хэргээ илчлэн ирсэн бол ял шийтгэлийг хөнгөрүүлэх хуулийн боломж олгохоор зохицуулалт хийгдсэн билээ. 2015 оны Эрүүгийн хуульд авилга, албан тушаалын гэмт хэргийн НҮБ-аас баталсан Авилгын эсрэг Конвенцийн шаардлагад нийцүүлсэн гэдгээрээ өмнөх хуулиудаас ялгаатай бас давуу талыг эрх зүйн зохицуулалтын хүрээнд гаргаж чадсан гэж үзэх үндэстэй. Гэсэн хэдий ч Монгол Улс авлигын индексийн дүнгээр 2015 онд 72 дугаар байр, 2016 онд 87 дугаар байр, 2017 онд 103 дугаар байр, 2018 онд 93 дугаар байр, 2019 онд 106 дугаар байр, 2020 онд 111 дүгээр байр, 2021 онд 110 дугаар байрт эрэмблэгдсэн үзүүлэлттэй байна⁹². Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт 11 төрлийн авлига, албан тушаалын гэмт хэргийг хуульчилсан бөгөөд статистикийг эдгээр төрлөөр авч үзэхэд 22.1 дүгээр зүйлд заасан Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг, 22.4, 22.5 дугаар зүйлд заасан Хахууль авах, өгөх гэмт хэрэг нийт авлигын хэргийн ихэнх хувийг эзэлж байна. Авлигын гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 2017 онд 658, 2018 онд 858, 2019 онд 894, 2020 онд 1020, 2021 онд 1144, шалгасан эрүүгийн хэрэг 2017 онд 427, 2018 онд 1138, 2019 онд 1300, 2020 онд 1331, 2021 онд 1307, шүүхээр шийдвэрлэсэн хэрэг 2017 онд 44, 2018 онд 84, 2019 онд 68, 2020 онд 114, 2021 онд 160 байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоо, шүүхээр шийдвэрлэж байгаа хэрэг бүгд өсөж байгааг харуулж байна.⁹³ Тиймээс энэ төрлийн эрүүгийн бодлого болоод эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага зүй ёсоор үүсээд байна. Тухайлбал авлига, албан тушаалын гэмт хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхгүй байх асуудлыг нэг мөр шийдэхгүйгээр ял наймаалцах нөхцөлийг хязгаарлах, авлигын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох арга хэмжээг үр дүнтэй болгох боломжгүй юм. Бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгт шалгуулалгүйгээр явдаг халдашгүй эрхтэй албан тушаалууд байдаг. Энэ тохиолдолд тухайн хэргийг ял шийтгэл гарцаагүй байвал хөөн хэлэлцэх хугацааг уртасгах тухай Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд яригдаж эхэлсэн нь нэг талаараа шийдэл мөн хэдий ч авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нийтэд нь тусгайлан заах шаардлагатай.

Албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой тулгамдаж буй асуудал:

Монгол Улсын шүүхийн 2021 оны шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээллээр Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 12068 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн ихэнх төрлийн гэмт хэрэг буурсан үзүүлэлттэй гарсан бол хүчиндэх болон залилах гэмт хэрэг, авлигын гэмт хэрэг өссөн дүнтэй гарчээ. Энэ дотроо Авлигын гэмт хэрэг бүхэлдээ өссөн дүнтэй гарсан. Тайлант хугацаанд нийт 235 хэргийг хүлээн авснаас 33 хэргийг прокурорт буцааж дөрвөн хэргийг түдгэлзүүлж, нэг хэргийг харьяаллын дагуу шилжүүлж 155 хэргийг хянан шийдвэрлэжээ. Энэ бүлэгт хамаарах 235 хэргийн 14.2 хувь нь прокурорт буцаж, 1.8 хувийг түдгэлзүүлж, 0.4 хувь нь харьяаллын дагуу шилжиж 65.9 хувь нь шийдвэрлэгдэж, 15.9 хувь нь тайлангийн эцсийн үлдэгдэл гэсэн дүгнэлттэй гарсан байна. Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн 12068 хэргийн 1.3 хувьд нь авилгын хэргийг хянан шийдвэрлэжээ. Хянан шийдвэрлэсэн авлигын гэмт хэргийн 49 хувь нь буюу хоёр хэрэг тутмын нэг нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг байсан бол 34.2 хувь хахууль авах гэмт хэрэг, 9.7 хувь нь хахууль өгөх гэмт хэрэг байна. Харин Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст 2022 оны эхний улиралд авлигын 124 хэрэг бүртгэгджээ. Энэ нь өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 35-аар буюу 39.3% өссөн дүн юм. Авлигын гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс өсөхөд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 28-аар буюу 39.4% өссөн нь голлон нөлөөлснийг Үндэсний статистикийн

⁹² Хууль зүйн үндэсний хүрээлэн. Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. УБ., 2022 он. 26 дахь тал.

⁹³ Мөн тэнд.

хорооны мэдээлэл гарсан. Бүртгэгдсэн авлигын 124 хавтаст хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зүйлээр ангилахад:

- 99 (75.6%) нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах;
- 17 (13.0%) нь хахууль авах гэмт хэрэг;
- 7 (5.3%) нь хахууль өгөх гэмт хэрэг;
- 4 (3.0%) нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг;
- 1 (0.8%) нь дураараа аашлах гэмт хэрэг;
- 2 (1.5%) нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг;
- 1 (0.8%) нь хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэрэг

байна⁹⁴.

Авлига, мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд оролцдог байгууллагуудын нэг нэгэндээ итгэх итгэлийг сайжруулах, тэдгээр байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах асуудал өнөөдөр яригдаж байна. Цаашид энэ талаарх асуудлыг шийдвэрлэхгүйгээр ажлын уялдаа холбоо хангагдах боломж хязгаарлагдмал юм. Авлигад өртөх нь бага байх онолын ойлголт бол хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн 3 эрх мэдэл нэгэндээ хяналт тавьж буй эсэх асуудал⁹⁵ билээ.

Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 ба 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд нэг ижил хариуцлага хүлээлгэхээр заасныг нэн даруй өөрчлөх шаардлагатай байна. Энэ нь улсад их хэмжээний бодит хохирол учруулсан этгээд нь хохирол учруулаагүй этгээдтэй ижил ял шийтгэгдэхээр байгаа нь шударга ёсны зарчимд нийцэхгүйгээс гадна энэ төрлийн гэмт хэргийг өөгшүүлсээр байгаа хэрэг мөн. Иймд Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгаж торгуулийн ялгүй болгож ялгамжтай байдлаар бусад ялыг тогтоох шаардлагатай. Мөн 22.1 дүгээр зүйлийн 1-т хохирлын шинж тогтоож өгөөгүйн улмаас зөрчлийн хэрэг болон гэмт хэрэг хоёрын зааг ялгааг гаргах асуудал яригдаж эхлэсэн бөгөөд шүүхийн практикт тус зүйл ангитай холбоотойгоор ямар нэгэн хохирол, хохирогч байхгүй хэрэгт хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрсдэл үүссэн байгааг анхаарах шаардлагатай байна.

Мөн Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн дахь хэсгийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол нийтийн албанд томилогдох эрхийг 10-аас дээш бүх насаар нь хасаж торгох ялгүй болгон хорих ялын доод хэмжээ болон дээд хэмжээг нэмэгдүүлэх нь чухал. Учир нь авлигын гэмт хэргийн хамгийн их үйлдэгдэж буй нь 22.1 дүгээр зүйл буюу Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг байгаагийн цаад шалтгаан нь хариуцлагын арга хэмжээ сул байгаатай шууд холбоотой.

Эрүүгийн хуулийн 22.2 буюу Албаны эрх нөлөөг урвуулан ашиглах гэмт хэрэг нь 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон. Энэхүү заалт нь дахин Эрүүгийн хуулиар зохицуулагдах боломжтой. Учир нь энэ заалт нь авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилготой чухал агуулга бүхий гэмт хэрэг гэж үзэн Авлигын эсрэг Олон Улсын байгууллагуудаас заавал Эрүүгийн хууль тогтоомждоо оруулахыг зөвлөдөг болно. Мөн нийтийн албан тушаалтанд давуу байдал бий болгосон, хууль бусаар давуу байдал олж авсан нийтийн албан тушаалтан биш этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт өнөөдөр үгүйлэгдэж байна.

Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл буюу Хахууль авах гэмт хэргийн хүндрүүлэх шинжүүд болох 22.4 дүгээр зүйлийн 4 болон 5 дахь хэсгүүдийг торгуулийн ялгүй болгох шаардлагатай. Олон нийтийн болоод хууль хяналтын байгууллагуудын авлигатай тэмцэх тэмцэлд үр дүн гаргахад ялын төрөл, хэмжээ чухал нөлөөлөл үзүүлэхийн дээр хариуцлага нь сул байх хэрээр урьдчилан сэргийлэх, таслан зогсоох боломж хязгаарлагдаж байна.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг албан тушаалтан хээл хахууль авах, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах зэрэг үндсэн гэмт хэрэгт

⁹⁴ Ikon.mn. 2022 он 4 сар.

⁹⁵ Alt, James. "Political And Judicial Checks on Corruption: Evidence From American State Governments".

заавал давхар зүйлчлэн мөрдөн шалгадаг. Практик дээр үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг дангаар шийдвэрлэсэн тохиолдол гараагүй, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байсан нь ийм төрлийн гэмт хэргийг дахин үйлдэхэд нөлөөлдөг байж болзошгүй байна. Иймд энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд Үндсэн хуулийн суурь зарчимд харшлахгүй байдлаар холбогдох хуульд зохих өөрчлөлтийг оруулах нь чухал юм.

Авлигатай тэмцэх газар Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэрэг болон мөрдөн шалгах ажиллагааны явцад өөрсдийн илрүүлсэн Мөнгө угаах гэмт хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг. Авлига, албан тушаалын гэмт хэрэг нь бусад төрлийн гэмт хэргүүдээс үйлдлийн арга, үйлдэгдсэн нөхцөл байдал, субъектын хувьд өөрийн онцлогтой, ээдрээ түвэгтэй, өргөн цар хүрээнд шалгалтыг хийдэг тул мөрдөн шалгахад нэлээд цаг хугацаа шаарддаг бөгөөд Мөнгө угаах, Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн хувьд одоогийн үйлчилж буй хуулиар тогтоосон хөөн хэлэлцэх хугацаа 3 жил байгаа нь практик дээр гэмт хэргийг илрүүлэн эцэслэн шалгаж шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж байдаг. Иймд эдгээр гэмт хэргийн хувьд ялын бодлогыг чангатгах, хөөн хэлэлцэх хугацааг уртасгах талаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгтэй байна.

Цаашид авлигын гэмт хэрэгтэй шийдвэртэй тэмцэхэд хорих эсхүл торгох ял шийтгэлийг сонгох үндэслэл, нөхцөлийг тухайн гэмт хэргийн шинж, хүнд хөнгөний байдлаас хамаарч шатлалтайгаар тогтоодог зохицуулалтыг бий болгох хэрэгтэй. Түүнчлэн авлигын хэрэгт тэнсэх албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй байх өөрчлөлтийг Эрүүгийн хуульд оруулах эсвэл тэнсэх арга хэмжээг хэрэглэх үндэслэл, нөхцөлийг тухайн гэмт хэргийн онцлог, хэргийн хүнд хөнгөн байдалд уялдуулан ялгамжтай хэрэглэх хэрэгтэй. Авлига, албан тушаалын гэмт хэрэгт нэмэгдэл ялыг өгөхдөө нийтийн албан тушаалд ажиллах эрхийг 10-аас жилээр эсвэл бүх насаар нь хасаж авлигын хэргээр ял авсан хүн өршөөлийн хуульд хамрагдахгүй байх нь чухал юм.

Албан тушаалтан л үйлдэх боломжтой нийт 20 гэмт хэргийн нэгээс бусад бүх хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа таван жил байхаар заасан байна. Гэтэл 5-15 жилийн хорих ял оноохоор Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдвэл 12 жил өнгөрөхөд хөөн хэлэлцэх хугацаа дуусч хэрэгсэхгүй болгоно. Тэгэхээр зарим гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцох хуулийн үндэслэл эргэлзээтэй байгааг өөрчилж засах шаардлагатай. Эрүүгийн хуульд нэг хүртэлх жилийн хорих ялтай, эсхүл хорихоос өөр төрлийн ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрвөл, 1-5 жилийн хорих ялтай хэрэг дээрээ таван жил, 5-8 жилийн ялтай хэрэг дээр нийман жил, 8-15 жилийн ялтай хэрэг дээрээ 15 жил өнгөрвөл гэх мэтээр хөөн хэлэлцэх хугацаагаа тавих нь чухал юм. Япон болон барууны орнуудад ч ийм л зарчим үйлчилдэг. Учир нь тухайн зүйл заалтын ялын дээд хэмжээнээсээ хөөн хэлэлцэх хугацаа нь бага байж болдоггүй.

Дэлхий нийтийн албан тушаалын гэмт хэргийн эсрэг бодлого, шийдвэрлэх арга зам:

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (Цаашид – ХБНГУ гэх)-ын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 30 дугаар хэсгийн 331-358 дугаар зүйлүүдэд албан тушаалын гэмт хэргийн талаар заагдсан байна. Германы хуулиар хээл хахууль өгөх ба авах хэрэгт эрүүгийн хариуцлага ноогдуулахдаа тухайн албан тушаалтан өөрийн албан үүрэгт хамрагдах хууль ёсны үйлдэл хийгээд авсан уу, эсвэл албан үүрэгт нь хамаарахгүй хууль бус үйлдэл хийгээд авсан уу гэдгээр нь ангилан ханддаг⁹⁶ байна. Түүнчлэн Германы Эрүүгийн хуулийн 331 дүгээр зүйлд ёсоор албан тушаалтан ямар нэг үйлдэлийг тухайн хугацаанд хийх юмуу ирээдүйд хийхийн тулд бусдаас эд хөрөнгийн болон өөр ашиг нэхсэн, эсвэл авсан, эсвэл авахаар амлуулсан бол торгох

⁹⁶ Монгол Улсын Их хурлын тамгын газар. Судалгааны төв. Б. Буяндэлгэр, Р. Хатанбаатар, П. Амаржаргал, К. Пүрэвсүрэн, Б. Цолмонбаяр. Судалгааны эмхтгэл, XII боть. УБ. 2012. 20 дахь тал.

юмуу хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэгдэнэ. Хэрэв дээрх хэргийг шүүгч үйлдсэн бол торгох юмуу гурав жил хүртэл хорих ялаар шийтгэгдэнэ гэж зохицуулалт оруулсан байдаг. Гэхдээ энэ зүйлд албан тушаалтан этгээд нэхсэн ашигаа бодитоор авах юмуу амлалт авахдаа урьдчилан зохих эрх мэдэлтэнд мэдэгдэж зөвшөөрөл авсан, эсвэл авмагцаа уг хахуулийг өгсөн, авсан тухай мэдэгдвэл шийтгэл оноохгүй гэж заасан⁹⁷ байгаа нь өвөрмөц зохицуулалт гэлтэй. Шүүгчийн авлигын хэргийг хүндрүүлэх нь шүүхийн бие даасан хараат бус байдлыг баталгаажуулах гэсэн нэгэн онцлог зохицуулалт юм. Монгол улсын хувьд ч энэхүү Герман улсын эрүүгийн зохицуулалтуудаас өөрсдийн авлигын гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд санаа авч хууль тогтоомждоо тусгах хэрэгцээ байгааг үгүйсгэхгүй.

Түүнчлэн, Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 30 дугаар хэсгийн 332 дугаар зүйлээр 331 дүгээр зүйлд дурдсан хэргийг үйлдэхдээ албан тушаалтан өөрийн албан үүргээ зөрчин хийсэн бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял онооно, хөнгөн тохиолдолд торгох юмуу гурав жил хүртэл хорих ял онооно гэж заажээ. Хэрэв энэ хэргийг шүүгч үйлдсэн бол нэг жилээс арван жил хүртэл хугацаагаар, хөнгөн тохиолдолд зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял оноодог⁹⁸ байна. Эрүүгийн хуулийн 333 дугаар зүйлд дээрх хоёр зүйлд заасан хээл хахуулийн хэргийн хахууль өгөгч этгээдэд оноох ял нь хахууль авагчийнхтай адил байхаар зохицуулжээ. Харин 334 дүгээр зүйлээр хахууль өгөгч этгээд хахууль өгөх юмуу амлахдаа албан тушаалтан өөрийн үүргээ зөрчин хийхээр тохиолдолд түлхсэн бол хахууль авсан этгээдтэй адилаар 332 дугаар зүйлд заасантай адил ялаар шийтгэгдэхээр зохицуулжээ⁹⁹. Энэхүү ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн зохицуулалтууд нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход анхаарч харьцуулан үзэх боломжтой нарийвчилсан заалтууд гэж үзэж байна.

Улс төрийн үйл ажиллагаанд оролцох, ямарваа улс төрийн албан тушаал эзлэхийн төлөө сонгууль явагдах үеэр нэр дэвшигч, улс төрийн намыг дэмжиж, эсвэл эсэргүүцэж үг хэлсний төлөө, ерөнхий болон тусгай сонгуулийн үеэр хэн нэгэнд ажилд оруулж өгөх болон бусад ашиг амласан этгээд нь авлигын хэргээр хариуцлага хүлээнэ¹⁰⁰ боломжтойгоор зохицуулалт зарим улсад хийгдсэн байгаагаас харахад авлигыг өргөн хүрээнд хуульчилж арга хэмжээ авах нөхцөлийг хуулиар бүрдүүлжээ.

Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Авлигын эсрэг конвенцид нийцүүлэн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусад бүлгийн гэмт хэргээс аль болох уртаар буюу 5-аас доошгүй жилээр тогтоож өгөхгүй бол авлигын гэмт хэрэгтэй тэмцэх ажил үр дүнд хүрэхэд саад болно. Япон улсад Эрүүгийн хэрэг хянан шийтгэх тухай хуулийн 254 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хэргийн оролцогчийн аль нэгийг нь яллах дүгнэлт үйлдүүлэх замаар хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх үйл ажиллагаа нь бусад хамтран гүйцэтгэгч нараас хамаардаг. Өөрөөр хэлбэл хэн нэгэн хамтран оролцогч этгээдийн асуудлыг ярихын тулд бусдынх нь хөөн хэлэлцэх хугацааг зогсоодог. Хэрэгт холбогдсон хамтран оролцогч нэг этгээд нь шүүхээр хэргээ эцэслэх хүртэл бусад хамсаатны хөөн хэлэлцэх хугацаа зогсоно¹⁰¹. Дээрх заалт нь манайд хэрэгжих боломжтой төдийгүй ялангуяа авлигын хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дээр анхаарах асуудал мөн. Түүнчлэн Япон улсын Эрүүгийн хэрэг хянан шийтгэх тухай хуулийн 255 дугаар зүйлд сэжигтэн, яллагдагч гадаадад гарсан, гадаад улсад нуугдаж байгаа бол яллах дүгнэлт үйлдэх, яллах дүгнэлт үйлдэх

⁹⁷ Мөн тэнд. 20 дахь тал.

⁹⁸ Мөн тэнд.

⁹⁹ Мөн тэнд.

¹⁰⁰ Ашигласан материал: <http://www.law.cornell.edu/uscode/>, Cornell University Cornell Law School, Legal Information Institute.

¹⁰¹ 刑事訴訟法第254条2項. (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 254 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг).

боломжгүй бол энэ хугацаанд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлнэ¹⁰² гэж заасан байдаг.

Өөрөөр хэлбэл, дээрх заалт нь гадаадад гарч зугтаж байгаа л бол хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх явдал юм. Үүний нэг жишээ бол Япон улсын Йодо группын Такахиро Кониши, Кимихиро Уомото, Мориаки Вакабаяши, Широ Акаги нарын залилан, авлигын хэрэг юм. 2009 оны 10-р сарын 20-ны өдөр Японы Дээд шүүх үл хөдлөх хөрөнгийн зуучлагчаас нийт 33 сая орчим иен залилан мэхэлсэн, авлигад өгсөн хэргээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байх үед дээрх этгээдүүд гадаадад 56 удаа аялж, нийт 324 хоног гадаадад байсан нь тогтоогдсон бөгөөд дээрх хугацааг хөөн хэлэлцэх хугацаанд оруулж тооцоогүй байдаг. Дээрх Японы Эрүүгийн хэрэг хянан шийтгэх тухай хуулийн 255 дугаар зүйлд гэмт хэрэгтэн гадаадад гарсан, гадаад улсад нуугдаж байхад яллах дүгнэлт үйлдэх боломжгүй бол энэ хугацаанд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлнэ гэж заасан заалттай ижил төстэй байдлаар хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх үндэслэлүүдийг гаргаж хуульчлах хэрэгцээ манай улсад байна.

Түүнчлэн, яллах дүгнэлтийг хүргүүлээгүй тохиолдолд, яллах дүгнэлт үйлдэж ирүүлээгүй тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх эсэх асуудал яригддаг. Хуульд заасан хугацаанд прокурор яллах бодолтой байгаагаа илэрхийлсэн л бол ял хөнгөрүүлэх, нотлох баримтыг сарниулахаас урьдчилан сэргийлж хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлснийг хүлээн зөвшөөрсөн тохиолдол бий¹⁰³. Тиймээс 1995 онд Гунма мужийн Такасаки хотын эрүүл мэндийн хүнсний борлуулалтын компанийн ерөнхийлөгчийн татвараас зайлсхийсэн хэрэгт түүнийг хаана байгааг нь тогтоохгүйгээр хэрэг үүсгэж байсан. 1999 оны 3 дугаар сараас эхлэн яллах дүгнэлт үйлдээгүй, шүүхээс яллах бүрэлдэхүүнийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргахад өмнөх ерөнхийлөгчийг цагдан хорих хүртэл нийт 42 удаа яллах дүгнэлт үйлдэж прокурорын тогтоолыг 5 жил зогсоож 2007 оны 3 дугаар сард шийдсэн тохиолдлууд байдаг¹⁰⁴. Мөн Кагава мужийн Такамацу хотод тусгай асрамжийн газар барихтай холбоотой авлигын хэргээр баривчлагдсан хотын зөвлөлийн дарга асан Казүто Миямотогоос 2005 онд Кагава мужийн цагдаагийн газраас байцаалт авсны дараа үргэлжлүүлэн зугтсан тул Такамацу дүүргийн прокурорын газар хөөн хэлэлцэх хугацааг дуусгахаас урьдчилан сэргийлэхийн тулд хоёр удаа хээл хахуулийн хэрэг үүсгэсэн түүхтэй. Тиймээс авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд дээрх агуулгуудыг Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацаанд оруулж өгөх шаардлагатай гэж үзэж байна. Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх бодлого барьж буй л бол хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульд тусгайлан зааж өгөх боломжтой. Тухайлбал, Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөд татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг онцгойлон таван жил байна гэж заасантай адил шууд 8 эсвэл 10 жил байхаар авлигын хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хуульчлах боломжтой. Зарим улсад хөөн хэлэлцэх хугацааг авлигын хэрэгт тоолдоггүй тохиолдол ч бий.

Мөнгө угаах, үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн хувьд одоогийн үйлчилж буй хуулиар тогтоосон хөөн хэлэлцэх хугацаа нь нэг жил буюу 12 сар байгаа нь практик дээр гэмт хэргийг эцэслэн шалгаж шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж байна. Иймд эдгээр гэмт хэргийн хувьд хүлээлгэх хариуцлагыг хүндрүүлэх талаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай. Ялангуяа авлигын гэмт хэргийн улмаас олсон мөнгөтэй холбоотой давхар мөнгө угаах гэмт хэргийн асуудал яригдах үед дээрх асуудал чухлаар хөндөгдөх ёстой. Дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчмын дагуу хориглоогүй бол Монгол улс авлигын болон бусад гэмт хэрэгт оролцсон, хамтран зохион байгуулсан, үйлдэхийг завдсан, дэмжлэг үзүүлсэн, нөхцөл бололцоогоор хангаж өгсөн, захиалсан, зөвлөгөө мэдээллээр хангасан үйлдлүүдийг

¹⁰² 刑事訴訟法第255条1項.

¹⁰³ 最高裁決定昭和55年5月12日". 裁判所. 2015年8月22日閲覧.

¹⁰⁴ 脱税で43回起訴 元社長に有罪判決 前橋地裁 = 群馬 読売新聞 2007年7月12日

гэмт хэрэгт тооцох шаардлагатай гэх ФАТФ-ын зөвлөмж гуравт орсон агуулгыг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн тусгаж шийдвэрлэх хэрэгтэй. Түүнчлэн өөр нэгэн авлигын эсрэг үр дүнтэй эрх зүйн зохицуулалт бол АНУ-д үйлчилж байгаа “Албан тушаалтан хууль ёсны орлогоос нь их хэмжээгээр илүү гарсан хөрөнгийг хэрхэн олж авсан талаар үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй бол” гэсэн үйл явцтай холбоотой нийтлэг зохицуулалт бол 1. Илүү гарсан хөрөнгийг төрд хураан авах 2. Ажлаас халах, дахиж төрийн албанд ажиллахгүй байх 3. Хорих¹⁰⁵ гэсэн зохицуулалт юм.

Дүгнэлт

Олон улс орнуудын авилгын, Эрүүгийн болон Авлигын эсрэг тухай хуулиудыг авч үзэхэд, төрийн албан хаагчид мөнгөн болон үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас олж авахад хяналт тавьдаг, бүртгэдэг, хариуцлага хүлээлгэдэг тогтолцоо бүгдэд нь байгаа боловч тусгайлан гадаад улс, гадаадын банк, гадаадын компанийн тухай заалт цөөн орны хуульд заагдсан байна. Харин төрийн албан хаагч мөрийтэй тоглоомын газраар үйлчлүүлэх тохиолдлыг авлигын мөнгийг угаах аль нэг хэлбэр байж болзошгүй гэж үзэж шалгах тухай заалт хэд хэдэн орны Эрүүгийн хуульд тусгагджээ. Мөн сонгууль ба улс төрийн үйл ажиллагаатай холбоотой авлигын гэмт хэргийн зохицуулалтууд нь манай улсаас өвөрмөц онцлогтой байгаа нь анзаарагдсан. Тухайлбал сонгуульт албан тушаалд нэр дэвшигч өөрийг нь дэмжсэний төлөө хэн нэгэнд нийтийн буюу хувийн секторын албан тушаалд томилуулах эсвэл хөлсний ажилд оруулахаар амласан бол энэ нь авлигын хэргээр хариуцлага хүлээлгэдэг асуудлыг анхаарч үзэх шаардлагатай.

Түүнчлэн, АНУ-ын хуулийн Кодын 18 дугаар хэсгийн 41 дүгээр бүлэгт дарамтлах тухай заасан байна. “АНУ-ын аль нэг департамент эсвэл төлөөлөгчийн газрын албан хаагч, албан тушаалтан ямарваа зүйлийг олж авахаар дарамтласан, дарамтлахаар оролдсон бол 5000 хүртэл доллараар торгуулах эсвэл 3 хүртэл жил хорих ялаар шийтгэгдэнэ” гэжээ. Сенатын гишүүд, Төлөөлөгчдийн танхимын гишүүд, АНУ-ын албан хаагчид болон АНУ-ын төрийн сангаас цалин, шагнал авдаг этгээдийн зүгээс шууд болон шууд бусаар улс төрийн хувьд хамтран ажиллахыг шахах, хандив нэхэх, хандив авах зэрэг нь авлигын гэмт хэргийн төрөлд багтдаг ойлголт манайд ч байгаа хэдий ч илүү тодорхой хуульчлах хэрэгцээ байна гэж дүгнэсэн болно.

Санал

1. Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 ба 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд нэг ижил хариуцлага хүлээлгэхээр заасныг нэн даруй өөрчлөх шаардлагатай байна. Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан (материаллаг бүрэлдэхүүнтэй) гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, ялгамжтай байдлаар тогтоох. Мөн 22.1 дүгээр зүйлийн 1-т хохирлын шинж тогтоож өгөөгүйн улмаас зөрчлийн хэрэг болон гэмт хэрэг хоёрын зааг ялгааг гаргах асуудал яригдаж эхлэсэн бөгөөд шүүхийн практикт тус зүйл ангитай холбоотойгоор ямар нэгэн хохирол, хохирогч байхгүй хэрэгт хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрсдэл үүссэн байгааг анхаарах.

2. Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан объектив шинжид урвуулан ашиглаж, зориуд хэрэгжүүлээгүй байж, өөртөө, бусдад давуу байдал бий болгосон гэж заасныг нэг мөр ойлгоход төвөгтэй нөхцөл байдал үүссэн. Тиймээс дээрх шинжүүдийг нэгдсэн нэг ойлголттой болгож тайлбарлах, дахин нягтлан зарим агуулгыг нарийвчлан гаргах хэрэгцээ байна.

3. Эрүүгийн хуулийн 22.2 буюу Албаны эрх нөлөөг урвуулан ашиглах гэмт хэрэг нь 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон. Энэхүү заалт нь дахин Эрүүгийн хуулиар зохицуулагдах боломжтой. Учир нь энэхүү заалт нь авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилготой чухал

¹⁰⁵ Монгол Улсын Их хурлын тамгын газар. Судалгааны төв. Б. Буяндэлгэр, Р. Хатанбаатар, П. Амаржаргал, К. Пүрэвсүрэн, Б. Цолмонбаяр. Судалгааны эмхтгэл, XII боть. УБ. 2012. 22 дахь тал.

агуулга бүхий гэмт хэрэг гэж үзэн Олон Улсын байгууллагаас заавал Эрүүгийн хууль тогтоомждоо оруулахыг зөвлөдөг болно

4. Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл буюу Хахууль авах гэмт хэргийн хүндрүүлэх шинжүүд болох 22.4 дүгээр зүйлийн 4 болон 5 дахь хэсгүүдийг торгуулийн ялгүй болгох шаардлагатай. Олон нийтийн болоод хууль хяналтын байгууллагуудын авлигатай тэмцэх тэмцэлд үр дүн гаргахад ялын төрөл, хэмжээ чухал нөлөөлөл үзүүлэхийн дээр хариуцлага нь сул байх хэрээр урьдчилан сэргийлэх, таслан зогсоох боломж хязгаарлагдаж байна

5. Одоо мөрдөж буй Эрүүгийн хуулийн заалтыг нийтийн албан тушаалтныг өөрийнхөө гэм бурууг нотлохыг үүрэгжүүлсэн буюу Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчимд харшлах зохицуулалт болсон гэж үзэх үндэслэлтэй байгаа тиймээс цаашид энэхүү агуулгыг залруулах. Түүнчлэн Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг албан тушаалтан хээл хахууль авах, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах зэрэг үндсэн гэмт хэрэгт заавал давхар зүйлчлэх асуудал яригддаг. Практик дээр үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг дангаар шийдвэрлэсэн тохиолдол гараагүй, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байсан нь ийм төрлийн гэмт хэргийг дахин үйлдэхэд нөлөөлдөг байж болзошгүй. Тиймд энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд Үндсэн хуулийн суурь зарчимд харшлахгүй байдлаар холбогдох хуульд зохих өөрчлөлтийг оруулах

6. Цаашид авлигын гэмт хэрэгтэй шийдвэртэй тэмцэхэд хорих эсхүл торгох ял шийтгэлийг сонгох үндэслэл, нөхцөлийг тухайн гэмт хэргийн шинж, хүнд хөнгөний байдлаас хамаарч шатлалтайгаар тогтоохын зэрэгцээ хүндрүүлэх шинжүүд дээр торгох ялгүй байхаар өөрчлөлт оруулах. Түүнчлэн авлигын хэрэгт тэнсэх албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй байх

7. Хахууль авах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн субъектыг зөвхөн нийтийн албан тушаалтнаар хязгаарлахгүй нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хамаарахаар өргөжүүлэх, энэ бүлгийн гэмт хэрэгт оногдуулах санкцын торгох ялыг нэмэгдүүлэх, хүндрүүлэх бүрэлдэхүүнээс торгох ялыг хасах, хорих ялыг нэмэгдүүлэх

8. Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Авлигын эсрэг конвенцид нийцүүлэн эрүүгийн хуулийн тусгай ангид засан бусад бүлгийн гэмт хэргээс аль болох уртаар буюу 5-аас доошгүй жилээр тогтоох

9. Япон Улсад Эрүүгийн хэрэг хянан шийтгэх тухай хуулийн 254 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хэргийн оролцогчийн аль нэгийг нь яллах дүгнэлт үйлдүүлэх замаар хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх үйл ажиллагаа нь бусад хамтран гүйцэтгэгч нараас хамаардаг. Өрөөр хэлбэл авлигын хэрэгт хэн нэгэн хамтран оролцогт этгээдийн асуудлыг ярихын тулд бусдынх нь хөөн хэлэлцэх хугацааг зогсоодог жишгийг нэвтрүүлэх

10. Япон Улсын Эрүүгийн хэрэг хянан шийтгэх тухай хуулийн 255 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт сэжигтэн, яллагдагч гадаадад гарсан, гадаад улсад нуугдаж байгаа бол яллах дүгнэлт үйлдэх, яллах дүгнэлт үйлдэх боломжгүй бол энэ хугацаанд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх, зогсоодог жишгийг нэвтрүүлэх

11. Эрүүгийн хуульд нэг хүртэлх жилийн хорих ялтай, эсхүл хорихоос өөр төрлийн ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрвөл, 1-5 жилийн хорих ялтай хэрэг дээрээ таван жил, 5-8 жилийн ялтай хэрэг дээр найман жил, 8-15 жилийн ялтай хэрэг дээрээ 15 жил өнгөрвөл гэх мэтээр хөөн хэлэлцэх хугацаагаа тавих нь чухал юм. Япон болон барууны орнуудад ч ийм л зарчим үйлчилдэг. Учир нь тухайн зүйл заалтын ялын дээд хэмжээнээсээ хөөн хэлэлцэх хугацаа нь бага байхгүй байх бодлого баримталдаг.

12. Улс төрийн үйл ажиллагаанд оролцох, ямарваа улс төрийн албан тушаал эзлэхийн төлөө сонгууль явагдах үеэр нэр дэвшигч, улс төрийн намыг дэмжиж, эсвэл эсэргүүцэж үг хэлсний төлөө, ерөнхий болон тусгай сонгуулийн үеэр хэн нэгэнд ажилд оруулж өгөх болон бусад ашиг амласан этгээд нь авлигын хэргээр хариуцлага хүлээдэг болгох

13. Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлээр зүйлчлэгдсэн хэргүүд дунд авлигын хэрэг гэхээс илүүтэй ахуйн хэрэг болох хулгай болон дээрмийн гэмт хэргийн улмаас олсон мөнгөө бусдад худалдаалан ашиг олсон гэх хэргүүд байна. Энэ нь практикт хэр үр дүнтэй байгаа эсэхийг харгалзан эрх зүйн зохицуулалтыг нарийн гаргаж өгөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл авлигын болон эдийн засгийн мөнгө угаасан хэргүүд мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлэгдэхгүй орхигдох нөхцөл үүсээд байна. Иймд энэ төрлийг хэргийг шийдэхдээ шүүхийн албан бус жишиг бий болгох эсхүл Улсын Дээд Шүүхээс тайлбар гаргаж асуудлыг нэг мөр шийдэх хэрэгтэй.

14. Авлигын эсрэг гэмт хэргүүдийг Өршөөл үзүүлэх тухай хуульд хамруулахгүй байх жишиг тогтоох, эсвэл хуульчлах.

Ашигласан материал

Нэг. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
2. Эрүүгийн хууль. 2015.

Хоёр. Ном сурах бичиг, нэг сэдэвт бүтээл, эмхэтгэл

3. Монгол Улсын Их хурлын тамгын газар. Судалгааны төв. Б. Буяндэлгэр, Р. Хатанбаатар, П. Амаржаргал, К. Пүрэвсүрэн, Б. Цолмонбаяр. Судалгааны эмхэтгэл, XII боть. УБ. 2012.

4. Нарангэрэл, С., Эрдэнэбулган, Ж нар. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж. УБ. 2019.

5. Улсын Дээд Шүүх. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ. 2013.

6. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. УБ. 2022.

Гадаад эх сурвалж

7. 刑事訴訟法第255条1項.
8. 最高裁決定昭和55年5月12日”. 裁判所. 2015年8月22日閲覧.
9. 脱税で43回起訴 元社長に有罪判決 前橋地裁＝群馬 読売新聞 2007年7月12日.
10. Alt, James. “Political And Judicial Checks on Corruption: Evidence From American State Governments”.
11. <http://www.law.cornell.edu/uscode/>, Cornell University Cornell Law School, Legal Information Institute.

АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

STATUTE OF LIMITATIONS IN CORRUPTION CRIMES AND THE INTERNATIONAL PRACTICE

Б.Ганхуяг

ДХИС-ийн докторант

Gankhuyag B.

Researcher doctoral candidate of University of Internal Affairs

Хураангуй: Авлигын гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангилалд үндэслэн ялгавартай тогтоох, авлигын гэмт хэргийн хамрах хүрээ, нийгмийн хор аюулаас шалтгаалж, хөөн хэлэлцэх хугацааг тооцож байгаа олон улсын туршлагыг судалж, энэ чиглэлийн харилцаатай холбоотой маргаантай, онолын үзэл баримтлал багатай эрх зүйн зохицуулалтын талаар судалж, санал дэвшүүлэхийг зорилоо.

Abstract: The aim is to define the statute of limitations for corruption based on the classification of crimes, to study the international experience of calculating the statute of limitations due to the scope of the crime of corruption, social harm and danger, to study the controversial and low-theoretical legal regulations related to this relationship, and to make effective proposals.

Түлхүүр үгс: Авлигын гэмт хэрэг, олон улсын туршлага, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа.

Keywords: Statute of limitation in corruption crimes, international practice.

Төрийн өндөр албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээдийн үйлдсэн авлигын гэмт хэргийн онцлогоос үүдэн, уг хэргийн хөөн хэлэлцэх хугацааг илүү нарийвчлан, тодорхой хуульчлах нь гэмт этгээд ял завших боломжийг хумих, шүүхийн шийдвэр гаргах процесст хүндрэл гаргахгүй байх, мөрдөгч, прокурор, шүүгч эргэлзээгүй ойлгож, хэрэглэхэд бэрхшээлтэй хуулийн зүйл, хэсэгт тайлбар шаардах, ижил төстэй хэргүүдэд өөрөөр хэрэглэгдэхгүй байх боломжийг бүрдүүлнэ.

Өнөөдөр авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх явцад гэмт хэргийн ангилал тодорхой бус байгаагаас шалтгаалан, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг янз бүрээр тоолж байгаа нь нийгэмд бухимдал, маргаан дагуулж байна. Ийм асуудал зөвхөн манай улсад төдийгүй, бусад оронд түгээмэл тохиолддог явдал бөгөөд авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны туршлага, сургамжийг судлах нь судлаач эрдэмтдийн сонирхол татсан сэдэв болж байна.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь манай улсын хууль, эрх зүйн орчин болон практикт шинэ ойлголт биш юм. Хөөн хэлэлцэх хугацааг анхлан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 1926, 1929 оны “Шүүх, цаазын бичиг”-т “Ялыг үл хэлэлцэх”, 1934 оны “Шүүх, цаазын бичиг”-т “Шүүх, цаазын ёсоор хөөн байцааж үл болох шалтгаан”, 1942 оны Эрүүгийн хуульд “Хуулийн ёсоор хөөн шийтгэж үл болох шалтгаан” гэж тус тус хуульчлан томъёолж ирсэн байна. “Хөөн хэлэлцэх хугацаа” гэх томъёоллыг 1961 оны Эрүүгийн хуульд тусгаснаас хойш манай улсын Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд энэ байдлаар нэрлэж хэвшсэн¹⁰⁶.

2002 оны Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 72 дугаар зүйлд заасан “Эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх” үндэслэлээр хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой харилцааг зохицуулахаар тусгасан байсан бол Олон Улсын хэмжээнд мөрдөгддөг нийтлэг ойлголт, эрх зүйн хөгжлийн

¹⁰⁶ Б.Батзориг. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай. Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн Тогтоол. 2021.06.11. Дугаар №1.

шинэ хандлагыг багтаах зорилгоор Улсын Их Хурлаас (Цаашид – УИХ гэх) 2015 онд батлан, хэрэгжүүлсэн шинэ Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлд “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн томьёолол оруулсан. Уг хуульд заасны дагуу хөөн хэлэлцэх хугацааг тоолохдоо хэзээнээс эхлэн аль үе хүртэл тооцох нь хамгийн гол асуулт бөгөөд энэ нь үндсэндээ мөрдөн байцаах ажиллагаанаас ял оноох шатны процессын ямар хэсэг хүртэл явахыг тодорхойлох явдал юм. 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулиар хөөн хэлэлцэх хугацаанд өмнөх буюу 2002 оны Эрүүгийн хуультай харьцуулахад зарчмын том өөрчлөлт хийсэн байна. Шинэ хууль нь өмнөх хуулийн зарчмаас илүү шинэлэг хэлбэрийг тусгасан боловч авлигын гэмт хэрэгт мөрдөх хөөн хэлэлцэх хугацаа нь ойлгомжгүй зүйлсийг өөртөө агуулж байна.

2015 онд баталсан Эрүүгийн хуульд нийт 20¹⁰⁷ удаагийн нэмэлт, өөрчлөлт орсноос, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: “2. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн, анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно. Яллагдагч, шүүгдэгч оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс зогсоож, уг этгээд баригдсан, эсхүл хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно”, мөн хуулийн 1.10 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсгийг: “5. Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш таван жил байна. 6. Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно” гэж тус тус өөрчилсөн.

Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны талаар судлаач Г.Халиунаа, Б.Ариунжаргал нар “Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацааны тухай томьёолол нь олон тооны зөрчилтэй асуудлууд үүсгэж байгаа явдлын нэг тод жишээ нь хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно гэж зааснаас үүдээд, прокурор гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусахаас өмнө шүүхэд яллах дүгнэлт үйлдэн, хэргийг шилжүүлсэн боловч, анхан шатны шүүх хуралдаан болохоос өмнө гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул шүүх хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэх үндэслэл болж байна”¹⁰⁸ гэж дүгнэжээ.

Дээрх өөрчлөлтийн талаар судлаач Г.Ганбаатар “Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалттай эсрэгцэх, гэхдээ зарчмын ба фундаменталь биш, зөвхөн хэлбэрийн төдий “зөрчилдөөний шинж” хийгээд хууль зүйн алдаатай байдал үүсгэжээ. Тухайн тохиолдолд нэг харилцаанд үйлчлэх эсрэгцэх 2 хэм хэмжээ нэгэн цагт, нэгэн зэрэг, шууд үйлчлэхгүй буюу үнэний шинжийг агуулахгүй, нэг нь үнэн, нөгөө нь худал, гурав дахь утга байхгүй тухай логикийн хуулиудын үндэслэгээ, мөрдлөгөөг баримтлан, хууль зүйн зөв, оновчтой үндэслэгээ хийх зайлшгүй шаардлагатай”¹⁰⁹ гэжээ.

Хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосноор гэмт этгээд ял завших явдал түгээмэл гарч байгаа талаар эрдэмтэн, судлаачид шүүмжлэлтэй хандах явдал ихсэж байна. Энэ талаар доктор (Ph.D), Д.Зүмбэрэлхам “...шинэчлэн найруулсан буюу одоогийн Эрүүгийн хуульд 1.10 дугаар зүйлд “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа” гэж нэрлэн томьёолоод дор нь “1. Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй” гэж заасан. Энд эрүүгийн хариуцлагын хөөн хэлэлцэх хугацаа гэдэг өмнөх

¹⁰⁷ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. legalinfo.mn. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11634&type=2> цахим хуудаснаас үзэв.

¹⁰⁸ Б.Ариунжаргал, Г.Халиунаа нар. “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хүний эрхийн үүднээс авч үзэх нь”. Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэц. <https://www.conscourt.gov.mn/?p=5221>.

¹⁰⁹ Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны тулгуур зохицуулалт ба хууль хэрэглээний арга зүй, анхаарах зарим асуудал. Шүүхийн Ерөнхий Зөвлөл. 2022.04.26. https://www.judcouncil.mn/site/news_full/12067.

ойлголтыг нь өөрчилж, уг хөөн хэлэлцэх хугацаанд гэмт хэргийг бүхэлд нь хамааруулаад зогсоогүй, гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдийн гэм бурууг нь ч тогтоох боломж олгохгүйгээр зөвхөн хугацааг тоолоод л хэрэгсэхгүй болгох нөхцөлийг бүрдүүлжээ. Түүнээс гадна өмнөх хуульд гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж маш тодорхой ангилаад, тэр болгонд тохирсон хөөн хэлэлцэх хугацааг тогтоон хэрэглэж ирсэн. Үүнээс үүдсэн ял завших боломж гарч байсангүй. Гэтэл одоогийн хуулиар маш чухал ач холбогдол бүхий энэхүү ангиллыг байхгүй болгосноос, ялын хүнд ба хөнгөний хэмжээг ялгавартай тогтоох цэгцэрсэн бодлого алдагдсан бөгөөд түүнтэй холбоотойгоор хөөн хэлэлцэх хугацаа тооцох арга ихээхэн ойлгомжгүй, онолын үзэл баримтлал гэж барих юмгүй болжээ. Энэ нь чухамдаа хуулиар халхавчлан ял завшуулах ёс бус явдлын эх сурвалж болсон байна”¹¹⁰ гэжээ.

Хөөн хэлэлцэх хугацааны талаар судлаачид болон хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд байр сууриа ихээр илэрхийлж байна. Жишээлбэл, Ийгл (Eagle) телевизээр “Эрүүгийн хуулийг нийтдээ 7 удаа өөрчилсөн боловч албан тушаалтнуудад ял завших бололцоо олгосон сансгаас огт татгалзаагүй”¹¹¹, Gerege.mn сайтад “...энэ мэт хууль, хяналтын байгууллага нааш, цааш толхилцож, хугацаа хожсоноор, тус хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаж, гэмт этгээд эрүүгийн хариуцлагаас мултарсан баримт жишээ олныг өгүүлж болно”¹¹² гэх мэдээ, нийтлэлүүд гаргасан бол хуульч Д.Отгонбат “Нийгэмд болон хуульчдын дунд дахин Эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны асуудлаар байр суурь зөрөх, практикт хэрхэн нэг мөр ойлгож, хэрэглэх талаар ойлгомжгүй байдал үүсээд байгаа юм”¹¹³ гэх зэргээр шүүмжилсээр байна.

Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зүйл, заалтуудыг нэг мөр хэрэглэх тал дээр үүсээд байгаа ойлгомжгүй байдлууд нь зөвхөн хэвлэл, мэдээллийн орчинд бус хууль хэрэгжүүлэгч, тэр дундаа шүүхийн байгууллагад ч гарч байна. Тухайлбал, Монгол Улсын Дээд Шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны албан ёсны тайлбарт “...зарим шүүх 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан өөрчлөлтийн дагуу хянан хэлэлцэгдэж байгаа хэрэгт хөөн хэлэлцэх хугацааны дотор ял сонсгож, яллагдагчаар татсан бол уг хугацааг цаашид тоолохгүй, зогссонд тооцно” гэж үзсэн бол хэд хэдэн шүүх “...тухайн өөрчлөлт нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан” гэж дүгнэн, уг заалтын өмнөх агуулгыг буюу “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолж, хэргийг шийдвэрлэж иржээ” гэж дурджээ. Хөөн хэлэлцэх хугацааны ийм зөрүүтэй ойлголтууд, зөрчлийг цэгцлэх, хуулийн орчинд хэрэглэх, мөн практикт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн мөрдүүлэх талаарх асуудлыг нэг мөр болгох үүднээс Монгол Улсын Дээд Шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаас “Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар”-ыг 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 11 тоот тогтоолоор гаргасан байна. Уг тайлбарт “Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт өөрчлөлт оруулсан, 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт болон шүүхийн шатанд хянагдаж буй хэрэгт гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолох зохицуулалтыг хэрэглэнэ” гэжээ.

Хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх судалгааг Улсын Дээд Шүүхийн Практик судлалын хэлтсээс 2019 онд хийсэн “Хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр

¹¹⁰ Д.Зүмбэрэлхам. <http://itoim.mn/article/iLAEP/17846-aac> үзэв.

¹¹¹ Хөөн хэлэлцэх хугацаа буюу хуулийн хулгай. 2022.04.14. Eagle news: <http://eagle.mn/r/100601-aac> үзэв.

¹¹² Gerege.mn. 2022.02.05. <https://gerege.mn/news/41965-aac> үзэв.

¹¹³ Д.Отгонбат. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Улсын Дээд Шүүхийн тайлбар хоёрын алийг нь хэрэглэх вэ? 2022.03.11. Shuurhai.mn: <https://shuurhai.mn/p/19415> аас үзэв.

хэрэгсэхгүй болгосон талаарх”¹¹⁴ судалгаанаас үзэхэд, 2016-2018 онуудад гарсан эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашигласан нийт 92 гэмт хэргийн 150 холбогдогчоос 2 хүнийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэргийг нь хэрэгсэхгүй болгожээ. Харин 2018 онд 4 хэрэг, 2019 онд 9 хэргийг дээрх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон байна¹¹⁵. Албан ёсны тоо баримт ийм байгаа хэдий ч, зарим төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас болж, эрүүгийн хариуцлагаас зайлсхийх явдал ихээр гарч байгаа болохыг тодотгосон УИХ-ын гишүүн Б.Пүрэвдоржийн (хөөн хэлэлцэх хугацааг өөрчлөх тухай” хэлэлцүүлгийн үеэр “400 гаруй хэрэг хөөн хэлэлцэх хугацаагаар хаагдсан. Малын хулгай, орон байрны хулгайгаас эхлээд санхүүгийн луйврын хэргүүд хаагдсан)¹¹⁶ тайлбараас харж болох юм.

Дээрх дүгнэлтүүд, тайлбар, статистикаас үзэхэд, хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий ойлголт нь одоогоор нэг мөр болж тогтоогүй, хууль сахиулах (прокурор, шүүхийн) байгууллагын зүгээс нэгдсэн шийдвэрт хүрээгүй, өөрсдийн үзэл баримтлал, ойлголтын хүрээнд хэрэглэж байна гэж дүгнэх үндэстэй байна. Энэ нь нэг талаар бүх төрлийн гэмт хэрэгт (татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргээс бусад) хөөн хэлэлцэх хугацааг нийтлэг хэлбэрээр хэрэглэх тухай одоогийн зохицуулалт, арга нь тухайн гэмт хэрэг, үйлдэл болгоны өөрийн онцлог, сэдэл, үйлдэгдсэн байдал, хамрах хүрээ, хохирогч бүхий бодит байдалд нийцэхгүй байгааг харуулж байх талтай юм.

Хөөн хэлэлцэх хугацааны талаарх заалтыг практикт хэрэгжүүлэх асуудал тун ээдрээтэй, үр ашиг муутай байгаа явдал нь энэ чиглэлээр олон зуун жилийн туршлагатай, дэвшилттэй аргыг хэрэгжүүлж ирсэн, гадаадын улсуудын туршлагыг судлах, өөрийн орны нөхцөл байдалтай холбон авч үзэх зайлшгүй шаардлага үүсгэж байна.

Дэлхийн олон улс орнууд хөөн хэлэлцэх хугацааг хууль, эрх зүйн нэг томоохон бие даасан зохицуулалт болгон ашигладаг. Сүүлийн 20 орчим жилийн туршид улс орнууд авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг бусад гэмт хэрэгт хэрэглэдэг байдлаар ижил төвшинд хэрэглэсээр ирсэн байна. Гэвч улс төрийн системийн өөрчлөлт гарч дэлхийн даяаршил газар авч, улс хоорондын харилцаа хөгжихийн хэрээр, авлигын нөхцөл байдал хүндэрч, улс төрчид, албан тушаалтнуудын оролцоо, нөлөөлөл ихтэй, үндэстэн дамжин үйлдэгдсэн авлигын гэмт хэргүүд нэмэгдэх хандлагатай байгаа учир хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг улс орнууд эргэн харах болсон байна.

Франц Улс авлигын эсрэг гэмт хэрэгт тоолдог хөөн хэлэлцэх хугацаа нь хуучин хуулиар 3 жил байсан боловч, хуулийн шинэчлэлийн (2017 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацаа өөрчлөгдсөн) дараа авлигын болон зарим гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 6 жил болгон нэмэгдүүлсэн¹¹⁷. Авлигын гэмт хэрэг олон улсыг хамарч, дамжин үйлдэгдэх болсон онцлогыг дагаад мөрдөн шалгах ажиллагаа явуулах хугацаа сунжирдаг байдлаас шалтгаалан, хөөн хэлэлцэх хугацааг сунгасан байна.

Тэгвэл 2019 оны 01 дүгээр сард Итали улс “Төрийн захиргааны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, хөөн хэлэлцэх хугацаа, улс төрийн нам, хөдөлгөөний ил тод байдлын асуудлаар авах арга хэмжээний тухай” хуульдаа өөрчлөлт оруулж, хөөн хэлэлцэх хугацааг анхан шатны шүүхийн шийдвэрээс (ял, цагаатгагдсан эсэхээс үл хамааран) эцсийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл түдгэлзүүлэхээр өөрчилсөн

¹¹⁴ Хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон хэргийг судалжээ. Мэдээ мэдээлэл. 2019.06.06. Улсын Дээд Шүүхийн цахим хуудас: <http://old.supremecourt.mn/news/459-aac> үзэв.

¹¹⁵ Хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан авлигын гэмт хэргүүдийг сэргээн шалгах хууль баталлаа. Улс төр. 2020.01.11. Gogo.mn: <https://gogo.mn/r/249585?i=-aac> үзэв.

¹¹⁶ А.Төгөлдөр. Хөөн хэлэлцэх хугацааг өөрчлөхөөр болов. ikon.mn. 2019.10.05. <https://ikon.mn/n/1ovu-aac> үзэв.

¹¹⁷ <https://www.mondaq.com/france/criminal-law/861120/anti-corruption-bribery-comparative-guide>.

байна¹¹⁸. Энэ нь мөн л авлигын гэмт хэргүүд олон тооны нөлөө бүхий оролцогчдыг хамарч, үндэстэн дамнах байдлаар үйлдэгдсэнтэй шууд холбоотой ажээ.

Чили Улс Эрүүгийн байцаан шийтгэх тогтолцоогоо 1999 оноос эхлэн шинэчилж, авлига болон мөнгө угаах гэм хэргүүдийг мөрдөн шалгах, яллах үүрэг бүхий “Public Prosecutor’s Office” гэх нэртэй, бие даасан үйл ажиллагаа явуулдаг Улсын прокурорын газрыг байгуулсан. Уг газар нь нийт 6 хэсгээс бүрддэгийн нэг хэсгийг Авлигатай тэмцэх мэргэшсэн хэсэг бүрдүүлж, дотроо хуулийн, нягтлан бодох, санхүүгийн шинжилгээ хийдэг, мэргэшсэн багуудыг агуулдаг байна. Чили улсын хуулиар, яллагдагч мөрдөн байцаалтын явцад хамтран ажилласан, эсвэл хөөн хэлэлцэх хугацаа дууссаны талаас илүү хугацаа өнгөрсний дараа хэрэг эхэлсэн тохиолдолд, ялыг бууруулах замаар хориг арга хэмжээний үр нөлөөг хязгаарладаг. Мөрдөн байцаалтын ажиллагааг албажуулахаас өмнө прокурор урьдчилсан мөрдөн байцаалт явуулж болох боловч, хөөн хэлэлцэх хугацааг тасалдуулахгүй. Мөрдөн байцаалтын ажиллагаа албан ёсоор явагдсаны дараа хөөн хэлэлцэх хугацааг тооцож эхэлдэг. Иймд прокурор мөрдөн байцаалтыг албажуулахаас өмнө аль болох амжиж урьдчилсан мөрдөн байцаалт явуулах нь чухал болдог байна¹¹⁹. Энэ зохицуулалт нь хөөн хэлэлцэх хугацааг мөрдөн шалгах ажилд илүү давуу байдал олгох чиглэлд ашиглаж байгаа хэлбэр юм.

Хөөн хэлэлцэх хугацааг авлигын гэмт хэрэгт зөвхөн нэмэлт мэдээллийг гадаад улс орнуудаас олох шаардлагатай үед ашигладаг тохиолдол ч бий. Америкийн Нэгдсэн Улсын “Гадны авлигын гэмт хэргийн тухай хууль”-д зааснаар, тус улсын засгийн газрын төлөөлөгч тухайн гадаад улс руу нэмэлт материалын хүсэлт явуулсан өдрөөс эхлэн уг хэрэг дээрх хөөн хэлэлцэх хугацаа тооцогдож эхэлдэг бөгөөд, гадаад улсаас хүссэн нэмэлт баримт ирснээр дуусгавар болдог. Хөөн хэлэлцэх хугацаа нийт 3 жил үргэлжилдэг¹²⁰.

Сальвадор Улсын парламент 2021 оны 09 дүгээр сард Эрүүгийн хуульдаа авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг мөрдөхгүй байхаар өөрчлөлт оруулсан байна. Авлигын гэмт хэрэгт шамшигдуулах, хахууль авах, далд тохироо хийх, хууль бусаар хөрөнгөжих, нөлөөлөх зэрэг үйлдлүүдийг оруулдаг. Тус улсын хууль тогтоогчид “авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаагүй болсноор энэ төрлийн гэмт хэрэгт шийтгэл онооход ямар нэгэн цаг хугацааны хүндрэл үүсэхгүй байх давуу талтай” гэж үзсэн байна. Мөн уг өөрчлөлтөөр ирээдүйд илрэх авлигын гэмт хэргүүд хэдий үед үйлдэгдсэн байх нь хамаарахгүйгээр хөөн хэлэлцэх хугацааг мөрдөхгүй байхаар заажээ¹²¹. Болив улс үүнтэй төстэй өөрчлөлтийг “Авлигын эсрэг хууль”-даа оруулж, “...тухайн авлигын гэмт хэрэг нь улс оронд ихээхэн хэмжээний эдийн засгийн хохирол учруулсан бол хөөн хэлэлцэх хугацааг мөрдөхгүй”¹²² гэж заажээ.

Австри Улс Эрүүгийн хуульдаа авлига болон шамшигдуулалтын гэмт хэргүүдийг “төрийн болон хувийн салбарын” гэж хуваах байдлаар илүү нарийвчлан авч үзэж, хамгийн хөнгөн хэргүүдэд 1-5, хүнд хэргүүдэд 5-10 жилийн хөөн хэлэлцэх хугацаа тогтоосон байна¹²³. Хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэрэг гарснаас эхлэн мөрдөн байцаалт хийгдсэн хугацааны хооронд хамаарахаар зохицуулж, авлигын хэргүүдийг нарийвчлан зүйлчилж, төрийн болон хувийн салбар тус бүрд нь хуваажээ. Тухайлбал, төрийн албан хаагч авлигын идэвхтэй (active) болон идэвхгүй (passive)

¹¹⁸ Global compliance news, Italy’s new anticorruption law, <https://www.globalcompliancencews.com/2019/03/15/italys-new-anti-corruption-law-20190228/>.

¹¹⁹ Anti corruption authorities, Overview of criminal prosecution of corruption in Chile, <https://www.acauthorities.org/successstory/corruption-prosecution-chile>.

¹²⁰ A Resource Guide to the U.S. Foreign Corrupt Practices Act. Second Edition.

¹²¹ BH compliance, Global news, September 10, 2021, <https://bh-compliance.com/el-salvadors-congress-approves-that-corruption-offenses-will-not-be-subject-to-statute-of-limitations/>.

¹²² HSE University, Anti-corruption portal, October 09, 2021, https://anticor.hse.ru/en/main/news_page/bolivia_amends_its_anticorruption_legislation.

¹²³ Countdown to Impunity-Corruption related Statutes of Limitation in the EU, Transparency International-Austrian Chapter, National Report.

гэмт хэрэг үйлдэх зорилгоор бэлдсэн гэж үзвэл, гэмт хэрэгт тооцох бөгөөд 5 жилийн хөөн хэлэлцэх хугацаа тогтоодог.

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш 20 жилийн хугацаа өнгөрсөн тохиолдолд уг хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөнд тооцдог. Харин цагаан захтны гэмт хэрэг буюу авлигын гэмт хэргийг шүүх гэмт хэрэг мөн эсэхийг нь тогтоосны дараа хөөн хэлэлцэх хугацаанд хамааруулдаг байна¹²⁴. Энэ нь хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай тогтоодог практикийн нэг хэлбэр юм. Харин 2011 онд Грек улс авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгасан бөгөөд, сайд нар болон засгийн газрын гишүүдэд тусгайлан заасан хөөн хэлэлцэх хугацааны давуутай нөхцөлийг хүчингүй болгосон. Транспэрэнси Интернэшнл¹²⁵ байгууллагын үзсэнээр, Грек улсад 2009 онд үүссэн эдийн засгийн хямралын гол шалтгаануудын нэг нь авлига байсан бөгөөд, Грекийн улс төрчдийн нэрийдсэнээр татвараас зугтах явдал “үндэсний спорт”-ийн хэмжээнд хүрч байжээ. Хөөн хэлэлцэх хугацааг ялгавартай тогтоосон нь улс төрийн төлөөллүүдийн авлигын хэргийг бууруулах зорилгоор хийсэн зохицуулалт гэж үзэж болно.

Бразил Улс 2021 онд төрийн албан хаагчдын ёс зүйн хуульдаа хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаанаас эхлэн тооцож, 8 жилээр тогтоосон байна¹²⁶. Мөн төрийн албан хаагчид авлигын гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд, төрд алба хаах болон улс төрийн эрх эдлэх явдлыг 8-14 жилээр хасах, авлигаар олсон хөрөнгийг царцаах явдлыг түргэтгэх заалтуудыг тус тус оруулсан байна.

Олон улсын хэмжээний хамтын ажиллагааны болон судалгааны байгууллагууд болох Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Транспэрэнси Интернэшнл зэрэг байгууллагууд нь улс орнуудын авлигын гэмт хэрэгт мөрдөж байгаа хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтуудын тал дээр нэлээд далайцтай судалж байна. OECD¹²⁷-с 2007 онд гаргасан авлигын тайлбар тольд “Хөөн хэлэлцэх хугацаа хангалттай урт байгаа эсэхийг тодорхойлох нэг чухал хүчин зүйл нь тодорхой хугацаанд уг хугацааг түдгэлзүүлж болох эсэх нөхцөл байдал юм. Жишээлбэл, хөөн хэлэлцэх хугацаанд тухайн гэмт хэрэгтэн оргон зайлсан тохиолдолд түдгэлзүүлэх хэрэгтэй, эс бөгөөс гэмт этгээд ял завшина. Мөн тухайн хэрэг дээр гадаадын орнуудаас нэмэлт нотолгоо, баримт цуглуулахад их хугацаа ордог учраас энэ хугацаанд мөн түдгэлзүүлэх нь зүйтэй¹²⁸” гэж онцолсон. Энэ нь хөөн хэлэлцэх хугацааг авлигын гэмт хэрэг дээр бусад хэргээс ялгамжтай байдлаар мөрдүүлэх, зохицуулалт нь мөрдөн шалгах болон баримт материал бүрдүүлэх зэрэг хугацаа шаардсан үйл ажиллагааг зайлшгүй тооцон үзэх шаардлагатай болохыг харуулж байна.

Транспэрэнси Интернэшнл байгууллагаас 2010 онд хөөн хэлэлцэх хугацааны талаарх судалгааг Европын Холбооны (Цаашид – ЕХ гэх) 27 улсыг хамруулан хийж, дараах нийтлэг хандлагыг тодорхойлсон байна. Үүнд:

- Богино хугацаатай хөөн хэлэлцэх хугацаа нь авлигын гэмт хэрэг үйлдэгчид ял завших бололцоо олгодог нь нийтлэг үзэгдэл. Судалгаанд хамрагдсан Грек, Итали, Португал зэрэг орнуудад сэжигтнийг авлигын гэмт хэрэг үйлдсэнийг нь тогтоосон ч гэсэн хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар шийтгэл хүлээлгэх боломж үгүйсгэгддэг байсан;

- Хөөн хэлэлцэх хугацаа хэт богино орнуудын хувьд гэмт этгээд ял завших, шүүхээр орохгүй байдал түгээмэл;

¹²⁴ Herbert Smith Freehills, Africa notes, South Africa: White collar crime- law and practice, November 19, 2021, <https://hsfnotes.com/africa/2019/11/21/south-africa-white-collar-crime-law-and-practice/>.

¹²⁵ Corruption in Greece, Wikipedia, https://en.wikipedia.org/wiki/Corruption_in_Greece.

¹²⁶ Anti-bribery and anti-corruption review, 10th edition, editor Mark F. Mendelson, 2021 Law Business Research Ltd.

¹²⁷ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага.

¹²⁸ Corruption. A Glossary of International Criminal Standards. 2007.

- ЕХ-ны ихэнх орнуудын хувьд хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь олон тооны дутагдал, цоорхойтой байна. Үүний нэг жишээ нь, гэрч болон шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн хамгаалалт сул байгаа явдал;

- Улс төрчид болон эрх мэдэлтнүүдийн оролцоо бүхий нарийн зохион байгуулалттай, ээдрээтэй авлигын хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт чухал нөлөөтэй;

- ЕХ-ны орнууд хөөн хэлэлцэх хугацааг сунгах, түр зогсоох, тасалдуулах зэргээр зохицуулалтыг нь сайжруулах арга хэмжээ авч байна.

Дээрх судалгааны үр дүнд үндэслэн, Транспэрэнси Интернэшнл байгууллагаас дараах зөвлөмжийг гаргажээ. Үүнд:

- Авлигын гэмт хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацаан дээр бусад хэргээс ялгамжтай тогтоох (Франц улсын хувьд авлигын гэмт хэргийг тусгайлан гэмт хэрэг гэж үздэггүй байснаар энэ төрлийн хэргүүд бусад хэргийн адил 3 жилийн хөөн хэлэлцэх хугацаагаар ял шийтгэлгүй өнгөрдөг байсан);

- Хөөн хэлэлцэх хугацааг 10 буюу түүнээс дээш жилээр тогтоох;

- Хөөн хэлэлцэх хугацааг тухайн авлигын хэргийн онцлог, нөхцөлтэй уялдуулж тогтоох;

- Авлигын гэмт хэргийг илрүүлэх явцад олон улс дамжсан мөрдөн шалгах ажиллагаа, улс орнууд хамтарч явуулсан шалгалтын ажиллагаанд зарцуулсан хугацааг хөөн хэлэлцэх хугацаанд хамруулахгүй байхаар ЕХ-ны улсуудын хоорондоо зохицуулах;

- Улс төрчид болон төрийн албан хаагчдыг авлигын хэрэгт холбогдсон тохиолдолд сонгуульт ажил, албан тушаал эрхэлж буй үед нь хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоох (энэ зохицуулалт нь авлигын хэрэгт холбогдсон этгээдийг сонгуульт ажил, албан тушаалаа өгсний дараагаар мөрдөн шалгах, байцаах бололцоо олгоно);

- Авлигын гэмт хэрэгт холбогдсон нь эхний удаад тогтоогдсоноос хойш ямар нэгэн хэлбэрээр хөөн хэлэлцэх хугацааг дахин ашиглахгүй (энэ зохицуулалт нь авлигын гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон этгээд хөөн хэлэлцэх хугацаанд хамаарч ял шийтгэлгүй үлдэх боломжийг багасгана);

- Хөөн хэлэлцэх хугацааны нөлөөллөөс үүдэн ял шийтгэл аваагүй, эсвэл хаагдсан хэргүүдийн талаар мэдээллийн бааз бүрдүүлэх (ийм дата нь хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг цаашид илүү боловсронгуй болгоход хэрэглэгдэнэ).

Дүгнэлт

Улс орнууд өөрсдийн онцлог нөхцөлүүдэд тохируулан, авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хуульдаа хэрэглэж байна. Хөөн хэлэлцэх хугацаа нь тухайн улсын авлигын гэмт хэргийн нөхцөл байдал, олон нийтийн хандлага, улс төрийн нөлөөлөл зэргээс хамаарч байнга өөрчлөгдсөөр ирсэн байна. Олон улсын хэмжээнд авлигын эсрэг хууль болон эрүүгийн практикт хөөн хэлэлцэх хугацааны талаар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хувилбар, зохицуулалт гэж байхгүй бөгөөд, энэ нь нэг талаас улс орнуудын хууль, эрх зүй харилцан адилгүй хөгжсөн, мөн улс төрийн нөлөөлөл, олон нийтийн хандлага, соёлын ялгаа зэрэгтэй холбоотой байх талтай юм.

Авлигын гэмт хэргийн зохион байгуулалт, хамрах хүрээ, улс төрийн нөлөөлөл хамгаалалт зэрэг нь байнга өөрчлөгдөж байдагтай холбоотойгоор, улс орнууд хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, тооцож эхлэх хугацааг сунгах, түр зогсоох, ялгамжтай тогтоох зэрэг олон тооны зохицуулалт хэрэглэдэг байна. Авлигын гэмт хэрэг дээр хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг бусад хэргүүдтэй ижил төвшинд үздэг байсан өмнөх практикаас улс орнууд татгалзаж, зарим орнууд авлигын гэмт хэргийг онцгойлон үзэж, хөөн хэлэлцэх хугацааг тухайлан тогтоох, эсвэл энэ төрлийн гэмт хэрэгт мөрдөхгүй байхаар хуульчилж байна. Олон улсад хэрэглэгдэж байгаа аргуудын нэг нь авлигын гэмт хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт хийгдэх, баримт материал бүрдүүлэх зэрэгт хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоодог бөгөөд энэ нь гэмт этгээд хөөн хэлэлцэх хугацаагаар ял завших явдлыг хаах давуу талтай байна.

Монголын өнөөгийн хууль, эрх зүйн зохицуулалтууд нь авлигын гэмт хэргийн орчин, мөрдөн байцаах болон гэмт үйлдлийг шалган тогтоох үйл ажиллагаа, прокурор, шүүхийн шийдвэр гаргах процесс зэрэгтэй уялдаа муутай, завсар гардгаас үүдэн, гэмт этгээдүүд хөөн хэлэлцэх хугацааг ял завших, хэргээ хэрэгсэхгүй болгох зэрэгт ашиглаж, томоохон эрх зүйн зөрчил, зохицуулалтын хийдэл үүсгэж байна.

Авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг илүү оновчтой мөрдөх, хэрэглэх, олон улсын харилцаа өргөжих, бизнесийн салбар, төрөл хөгжих, нийт эдийн засаг дахь мөнгөний болон хөрөнгийн урсгал нэмэгдэхийн хэрээр Монгол Улсын хувьд авлигын гэмт хэрэг илүү нарийн зохион байгуулалттай, олон улсыг хамарсан хэлбэртэй өрнөж болзошгүй тул хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтуудыг тухай бүр шинэчлэн өөрчлөх шаардлагатай болж байна.

Хөөн хэлэлцэх хугацааг авлигын бүх хэрэгт мөрдөхгүй зөвхөн тухайн авлигын гэмт хэргийн хэлбэр, хамрах хүрээ, учруулсан хохирол, улс оронд үзүүлэх сөрөг нөлөө зэргээс хамаарч, уг хэргийг хөөн хэлэлцэх хугацаанд хамруулах эсэхийг анхлан тодорхойлдог байх нь зүйтэй байна.

Хөөн хэлэлцэх хугацаа нь зөвхөн авлигын хэрэг үйлдсэн гэмт этгээдэд хамаарах зохицуулалт биш, энэ нь мөрдөн байцаахаас шүүхээр хэлэлцэх шийдвэрлэх хүртэлх бүх явц, дамжлага дээр хоёр талтай зохицуулалтын хэрэгсэл гэж ойлгох нь зүйтэй юм. Тухайн авлигын хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэлх аль ч шатанд гарч буй шийдвэрээс хамааран хөөн хэлэлцэх хугацаанд (нэмэгдэх, түр зогсох) өөрчлөлт ордог байх нь хэрэг хэрэгсэхгүй болох эрсдэл буурахаас гадна гэмт этгээд санаатайгаар хөөн хэлэлцэх хугацааг дуусгах зорилгоор ашиглах явдал багасаж, түүнийг мөрдөн шалгаж хэргийг тогтоох, хуулийн дагуу ял шийтгэл оноох дамжлагуудын хариуцлага нэмэгддэг байна.

Мөн эх орноосоо урвасан, олон улс дахь Монгол Улсын нэр хүнд, байр суурьд сөргөөр нөлөөлсөн, улсын газар нутгаас зарсан, гадаадын этгээдэд дамжуулсан, түүх соёлын үнэт зүйлсийг эвдэн сүйтгэсэн, улс орон, хувь хүмүүс, хуулийн этгээдэд их хэмжээний мөнгөн болон биет хохирол учруулсан, байгаль орчинд нөхөшгүй эвдрэл, сүйрэл үүсгэсэн гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй байхаар хуульчлах нь зүйд нийцэх юм.

Санал

Авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг анхлан тоолохдоо, уг хэргийг “албан ёсоор илэрсэн” гэж үзсэн тохиолдолд тооцож эхлэх нь “өнөөгийн нөхцөлд тохирох хувилбар юм” гэж үзээд дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Гэмт хэрэг илэрсэн үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацаа тооцох;
- Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг урт хугацаагаар тогтоох;
- Гэмт хэрэгт холбогдогч этгээд мөрдөн шалгах ажиллагаанаас зайлсхийх идэвхтэй үйлдлийн улмаас өнгөрсөн хугацааг хөөн хэлэлцэх хугацаанд дээр буцаан нэмж тооцох;
- Шүүгч ямар нэгэн байдлаар хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоодог байх;
- Гэмт этгээд хугацаа хожих зорилгоор элдэв арга хэрэглэж, төөрөгдүүлэхэд гарсан хугацааг нэмж тооцох;
- Авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг ашигласан тохиолдлуудыг (хэрэгсэхгүй болсон, гэмт этгээд ял шийтгэл аваагүй, эсвэл шийтгүүлсэн, хөөн хэлэлцэх хугацааг зогсоосон, нэмсэн зэрэг тохиолдол бүрт) нарийвчлан бүртгэж, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг болно.

Ашигласан материал

1. Батзориг, Б. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай. Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн Тогтоол. 2021.06.11. Дугаар №1.

Гадаад эх сурвалж

2. A Resource Guide to the U.S. Foreign Corrupt Practices Act. Second Edition.
3. Anti-bribery and anti-corruption review, 10th edition, editor Mark F. Mendelson, 2021 Law Business Research Ltd.
4. Corruption. A Glossary of International Criminal Standards. 2007.
5. Countdown to Impunity-Corruption related Statutes of Limitation in the EU, Transparency International- Austrian Chapter, National Report.

Интернет эх сурвалж

6. Anti corruption authorities, Overview of criminal prosecution of corruption in Chile, <https://www.acauthorities.org/successstory/corruption-prosecution-chile>.
7. BH compliance, Global news, September 10, 2021, <https://bh-compliance.com/el-salvadors-congress-approves-that-corruption-offenses-will-not-be-subject-to-statute-of-limitations/>.
8. Corruption in Greece, Wikipedia, https://en.wikipedia.org/wiki/Corruption_in_Greece.
9. Gerege.mn. 2022.02.05. <https://gerege.mn/news/41965>.
10. Global compliance news, Italy's new anticorruption law, <https://www.globalcompliancencews.com/2019/03/15/italys-new-anti-corruption-law-20190228/>.
11. Herbert Smith Freehills, Africa notes, South Africa: White collar crime- law and practice, November 19, 2021, <https://hsfnotes.com/africa/2019/11/21/south-africa-white-collar-crime-law-and-practice/>.
12. HSE University, Anti-corruption portal, October 09, 2021, https://anticor.hse.ru/en/main/news_page/bolivia_amends_its_anticorruption_legislation.
13. <https://www.mondaq.com/france/criminal-law/861120/anti-corruption-bribery-comparative-guide>.
14. Ариунжаргал, Б., Халиунаа Г. нар. “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хүний эрхийн үүднээс авч үзэх нь”. Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэц. <https://www.conscourt.gov.mn/?p=5221>.
15. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны тулгуур зохицуулалт ба хууль хэрэглээний арга зүй, анхаарах зарим асуудал. Шүүхийн Ерөнхий Зөвлөл. 2022.04.26. https://www.judcouncil.mn/site/news_full/12067.
16. Зүмбэрэллхам, Д. <http://itoim.mn/article/iLAEP/17846>.
17. Отгонбат, Д. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Улсын Дээд Шүүхийн тайлбар хоёрын алийг нь хэрэглэх вэ? 2022.03.11. Shuurhai.mn: <https://shuurhai.mn/p/19415> аас үзэв.
18. Төгөлдөр, А. Хөөн хэлэлцэх хугацааг өөрчлөхөөр болов. ikon.mn. 2019.10.05. <https://ikon.mn/n/1ovv>.
19. Хөөн хэлэлцэх хугацаа буюу хуулийн хулгай. 2022.04.14. Eagle news: <http://eagle.mn/r/100601>.
20. Хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон хэргийг судалжээ. Мэдээ мэдээлэл. 2019.06.06. Улсын Дээд Шүүхийн цахим хуудас: <http://old.supremecourt.mn/news/459>.
21. Хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан авлигын гэмт хэргүүдийг сэргээн шалгах хууль баталлаа. Улс төр. 2020.01.11. Gogo.mn: <https://gogo.mn/r/249585?i=>.
22. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. legalinfo.mn. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11634&type=>.

ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛЫН АСУУДАЛ

THEORETICAL ASPECTS OF INTERNATIONAL CRIMINAL LAW

Б.Досжан

Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, Бүгд Найрамдах Турк Улсын Кожаяли их сургуулийн докторант

Dosjan B.

Lecturer, School of law, Otgontenger University, Post-graduate student of Kocaeli University of the Republic of Turkey

Хураангуй: Хүн төрөлхтний сэтгэлийг түгшээсэн аюул, заналхийлэл учруулахуйц олон улсын гэмт хэргийг тодорхойлсон, ОУЭЭЗ-н хэм хэмжээний ойлголт бүрэн гүйцэт хэлбэржин тогтсон үйл явцыг тодорхойлж, улмаар олон улсын эрх зүйн тогтолцоон дахь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний эзлэх байр суурь, бусад олон улсын салбар эрх зүйн уялдаа холбоо, харилцан хамаарлын талаарх зарим үзэл санааг дэвшүүлэн судлахыг зорилоо.

Abstract: the IUCN aims to define a fully formed process that defines international crimes that pose a disturbing threat to humanity, and thus to explore the position of criminal legal standards in the international legal system and some ideas about the relevance and interdependence of other international legal disciplines.

Түлхүүр үгс: Олон улсын гэмт хэрэг, ОУЭЭЗ, эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ.

Keywords: International crime, international criminal law, criminal law norms.

Удиртгал

Олон Улсын эрүүгийн гэмт хэрэгт Олон Улсын эрүүгийн эрх зүй (Цаашид – ОУЭЭЗ гэх)-ээр олон улсын шинжтэй гэмт хэрэгт хил дамнасан буюу Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна үйлчлэх эрүүгийн эрх зүйгээр хариуцлага хүлээлгэх асуудал зэрэг нь ялгаатай боловч ижил байдлаар ОУЭЭЗ-н судлагдахуун болдог.

Улс орон бүр өөрийн нутаг дэвсгэрт тухайн газар зүйн онцлог ард иргэдийн ёс, зан заншилд нийцэхүйц нийтийн хэв журмыг тогтоох нийгмийг гэмт хэрэг, гэмт халдлагаас хамгаалах эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тогтоодог бол үүний нэгэн адил олон улсын хүрээнд олон улсын байгууллага болон хэд хэдэн улсын хооронд байгуулагдсан гэрээгээр нийт хүн төрөлхтнийг олон улсын шинжтэй гэмт хэрэг халдлагаас хамгаалах ОУЭЭЗ-н хэм хэмжээг тогтоодог.

Дотоодын эрх зүйн тогтолцоонд тухайн нийгмийн гишүүдийн эрх ашгийг хамгаалах нь эрүүгийн эрх зүйн онолын болон практикийн ач холбогдолтой бол олон улсын түвшинд тодорхой төрлийн эрх ашгийг хамгаалах нь ОУЭЭЗ-н ач холбогдол бүхий ойлголт юм. Олон улсын түвшинд олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдах эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд аливаа улс гүрний зүгээс эрх ашгаа хамгаалахаар авч болохуйц эцсийн арга хэмжээ (ultima ratio) нь ОУЭЭЗ-н зохицуулалт учир энэхүү ойлголт нь сүүлийн жилүүдэд олон улсын хүрээнд чухал судлагдахуун болж байна.

Олон улсын, дэлхийн нийт хүн амд аюул учруулж болзошгүй зарим үйлдлийг өргөн хүрээнд олон улсын гэмт хэрэг гэх байдлаар тодорхойлох боломжтой. ОУЭЭЗ нь олон улсын хүрээнд нийт хүн амын эрх ашиг, дэлхий нийтийн энх тайван, аюулгүй байдал, сайн сайхныг хамгаалах хэм хэмжээний нийлбэр цогц юм. Тус өгүүлээр олон улсын эрүүгийн гэмт хэргийн тухай ойлголт, ОУЭЭЗ нь олон улсын эрх зүйн зарим хэм хэмжээтэй хэрхэн холбогдож байгааг тодорхойлохыг зорилоо.

Үндсэн хэсэг

ОУЭЭЗ хэмээх нэр томъёо, ойлголтыг дотоодын болон олон улсын эрх зүйн тогтолцоонд дараах 3 хэлбэрээр тайлбарладаг.

1. Гадаад нөхцөл байдал агуулсан үйлдэл, эс үйлдэхүйд дотоодын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх. Энэ нь “Эрүүгийн хууль үйлчлэх хэмжээ хязгаар буюу нутаг дэвсгэрийн зарчим”-д нийцэх бөгөөд гол төлөв Ром-Германы эрх зүйн бүлийн орнуудад тухайн улсын нутаг дэвсгэрт олон улсын шинжтэй гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд анхдагч байдлаар дотоодын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх шаардлагатай гэх агуулгаар илэрхийлэгддэг¹²⁹.

2. Олон улсын шинжтэй гэмт хэрэг, олон улсын эрүүгийн гэмт хэрэг эсхүл хилийн чанадад үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх уг гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд хянан шийдвэрлэх ажиллагааг эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ үүн дотор шүүхийн даалгавар гүйцэтгэх хэм хэмжээгээр зохицуулах тухай асуудал ордог. Олон улсын эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх нь олон улсын хамтын ажиллагааны үр дүнд бий болсон олон улсын гэрээ хэлцэл зэргээр харьцангуй тогтвортой зохицуулагддаг¹³⁰.

3. Энэхүү хэлбэр нь төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг зэрэг шууд хэлбэрээр олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх шаардлага бүхий зохицуулалттай мөн олон улсын шүүхээр хянан шийдвэрлэх гэмт хэрэгтэй холбоотой ойлголт юм¹³¹. Олон Улсын Эрүүгийн эрх зүй нь энэхүү гуравдах ойлголтоор ихэвчлэн тайлбарлагддаг¹³².

Улс орнуудад эрүүгийн хууль тогтоомж гэх байдлаар тодорхойлогддог тэрхүү эрх зүйн хэм хэмжээ нь ихэнхдээ үндэсний болон хүн төрөлхтний эрх ашиг сонирхлыг гэмт халдлагаас сэргийлэх зорилготой байдаг учир эрдэмтэд зарим тохиолдолд ОУЭЭЗ-г дотоодын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний нэг хэсэг мөн гэж адилтган үзэх явдал бий.

Франц, Итали, Герман, Испани, Турк, Монгол Улс эхний дээр дурдсан хоёр дахь хэлбэрийг дотоодын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний нэг төрөл хэмээн үздэг. Иймд гуравдахь хэлбэрийг ОУЭЭЗ-г тодорхойлох албан ёсны хэлбэр гэж үзэх боломжтой¹³³. Гурав дахь хэлбэр олон улсын эрх зүйн хэм хэмжээний гэмт хэрэг түүнтэй холбогдох асуудлыг авч үздэг бол эхний хоёр хэлбэр дотоодын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээгээр олон улсын шинж чанартай гэмт хэрэг түүнтэй холбогдох асуудлыг судлах байдлаар тодорхойлогдож болно.

Хэд хэдэн улсын нутаг дэвсгэр дамнан үйлдэгдэх гэмт хэрэг, үйлдэлд ОУЭЭЗ-ээр хариуцлага хүлээлгэх явдал нь аливаа улс орнуудын бүрэн эрхт байдал эрүүгийн хууль үйлчлэх хэмжээ хязгаар, нутаг дэвсгэрийн зарчимтай зөрчилдөх асуудал урган гарч байдаг. Иймд энэхүү асуудлыг шийдвэрлэх үүднээс олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон баримтлах тодорхой төрлийн зарчмуудыг олон улсын гэрээ хэлцлүүдээр тодотгон зохицуулж өгсөн. Уг зохицуулалт Европын холбоо түүний бүтэц дэх байгууллагууд, бүс нутгийн шинжтэй үйл ажиллагаа явуулах олон улсын байгууллагуудын үйл ажиллагаа болон Эрүүгийн шүүхийн олон улсын хүчин төгөлдөр байдлын тухай Европын конвенц зэрэг хэм хэмжээгээр илрэн гарна¹³⁴. ОУЭЭЗ-н хөгжил нь эрх зүйн салбарын чухал ухагдахуун¹³⁵ болохыг олон улсын болон бүс нутгийн шинжтэй байгууллагуудын үйл ажиллагаанаас харж болох бөгөөд энэхүү эрх

¹²⁹ Satzger, 2022, p.34.

¹³⁰ Мөн тэнд, p.36.

¹³¹ Tezcan, Erdem & Önok, 2009, p.31.

¹³² Гол төлөв Англо-Саксоны эрх зүйн бүлийн орнуудад ОУЭЭЗ гэх нэр томъёо (International Criminal Law)-ыг дээрх байдлаар тодорхойлдог.

¹³³ Feridun, 1988, p.5.

ОУЭЭЗ-г томъёолсон ойлголтыг хэд хэдэн ОУЭЭЗ судлаачид ном бүтээлүүддээ мөн дээрх байдлаар тодорхойлсон байдаг.

¹³⁴ Европын холбооны үйл ажиллагааны хүрээнд бэлтгэгдэн хүчин төгөлдөр болсон European Convention on the International Validity of Criminal Judgements, 2022.

¹³⁵ Профессор Хенри Доннедию Де Вабрес (Prof. Henri Donnedieu De Vabres) 1922 онд гаргасан “ОУЭЭЗ-н ерөнхий ойлголт” хэмээх бүтээлдээ “магадгүй хэзээ нэгэн цагт дэлхий дээр гэмт үйлдэлд хариуцлага хүлээлгэх хариуцлагын ойлголт нэг мөр хэрэгжиж эхлэх үед ОУЭЭЗ-н салбар судлагдахуунд хандах судлаачдын хандлага өөрчлөгдөх юм” гэх байдлаар тусгасан.

зүйн ойлголт нь дотоодын эрх зүйн нэг хэсэг гэх ойлголтоос илүү өргөн агуулгатай байна.

ОУЭЭЗ нь олон улсын эрх зүйн бусад салбартай холбогдох нөхцөл нь олон улсын бусад салбар эрх зүйн хэм хэмжээг ноцтой зөрчих тохиолдолд ОУЭЭЗ-н хэм хэмжээгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх байдлаар илрэн гарна. Иймд ОУЭЭЗ гэх нэр томъёотой уялдаа холбоо бүхий хүмүүнлэгийн эрх зүй болон хүний эрхийн талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээнүүдийг зөрчсөн ямар үйлдлийг олон улсын эрүүгийн гэмт хэрэг гэж тооцох эсэхийг тодорхойлох нь эрх зүйн ач холбогдолтой.

Хүмүүнлэгийн (humanitarian law)¹³⁶ эрх зүй нь дайны үеэр дайнд оролцохоос татгалзаж буй этгээдүүдийг хамгаалах, дайн бүхий нөхцөл байдлыг хууль ёсны дагуу үргэлжлүүлэх эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц юм. Нөгөө талаас хүмүүнлэгийн эрх зүй нь “дайн болон зэвсэгт мөргөлдөөний үр нөлөөг тодорхой түвшинд хязгаарлах зорилготойгоор хүмүүст олгогдох наад захын эрх болон тусламж үзүүлэх хэм хэмжээг өөрт агуулж” буй салбар эрх зүй¹³⁷, “олон улсын болон олон улсын бус зэвсэгт мөргөлдөөнөөс үүдэх хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх гэрээ, дүрэм, журмын нийлбэр цогц”¹³⁸ гэж тус тус тодорхойлжээ.

Хүмүүнлэгийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжих гол шалтгаан нөхцөл нь тодорхой төрлийн зэвсэгт мөргөлдөөн (armed conflict) үүссэнээс үүдэлтэй¹³⁹. Хүмүүнлэгийн эрх зүйн зохицуулалтын зорилго нь дайн болон зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэгдэх зэвсэг хэрэгсэл болон дайны хөнөөлт байдлын энгийн ард иргэдэд нөлөөлөх үр дагаврыг багасгах, энэ нь нэг талаас улсууд нөгөө талаас зэвсэгт мөргөлдөөнд оролцсон хувь хүмүүсийн зан үйлд шууд нөлөөлөхүйц хэм хэмжээ болохыг тодорхойлох юм.

Хүмүүнлэгийн эрх зүйн гол эх сурвалжууд нь зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай 1954 оны Гагийн конвенц, Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан болон өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай 1949 оны Женевийн (i) конвенц, 1977 оны нэмэлт протоколууд зэрэг болно. Хүмүүнлэгийн эрх зүй болон ОУЭЭЗ нь зорилго болон үйлчлэх хэмжээ хязгаараараа ялгаатай мэт боловч хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээг зөрчих тохиолдол нь дайны гэмт хэрэг үйлдэгдэх анхдагч нөхцөл гэх байдлаар томъёологддог учир ОУЭЭЗ-н судлагдахуун болж байдаг¹⁴⁰.

ОУЭЭЗ-тэй уялдаа холбоо бүхий өөр нэгэн олон улсын эрх зүйн ойлголт бол олон улсын хүний эрхийн тухай гэрээ, конвенцууд юм. Энэхүү гэрээ, конвенцууд дайны бус энхийн цагт хүний эрх чөлөөг хангах хамгаалах чиглэлээр хэрэгжих хэм хэмжээний нийлбэр цогц бөгөөд хүний эрхийг хангах, хамгаалах чиг үүрэгтэй олон улсын эрх зүйн хэм хэмжээ нь дайн байлдааны явцад хэрэгжих боломжгүй боловч зэвсэгт мөргөлдөөнөөс бусад үед хүний эрхтэй холбогдон хэрэгжүүлэх үйл ажиллагааг бүхэлд нь зохицуулна.

Дээрх ойлголт хүний эрхийг хангах хамгаалах чиг үүрэг бүхий олон улсын эрх зүйн хэм хэмжээ бөгөөд дайны үйл явцыг бүхэлд нь зохицуулдаггүй, зэвсэгт мөргөлдөөн дайны ажиллагаанаас бусад үед хэрэгжих зохицуулалт хэмээн тодорхойлж дайны үед хүмүүнлэгийн эрх зүй нь “Lex specials” буюу хэрэглэгдэх голлох эх сурвалж болж тус харилцааг зохицуулах юм¹⁴¹.

¹³⁶ Олон улсын хүрээнд (“law of war”), дайны эрх зүй, зэвсэгт мөргөлдөөний эрх зүй (“law of armed conflict”), хүмүүнлэгийн эрх зүй (“humanitarian law”) зэрэг нэр томъёонууд ижил байдлаар хэрэглэгддэг гэж зарим судлаачид тэмдэглэх боловч эсрэг үзэл баримтлал бүхий судлаачдын зүгээс дайны эрх зүй нь зэвсэгт мөргөлдөөний эрх зүйгээс өргөн утга агууллагатай, ямар нөхцөл байдалд дайныг хууль ёсоор явагдсан эсэхийг агуулж буй харилцаа гэж үздэг.

¹³⁷ Ayşe Nur, 2006, p.1.

¹³⁸ Yamaner, Melike, 2007, p.379.

¹³⁹ Мөн тэнд, p.380.

¹⁴⁰ Than, Shorts, 2003, p.12.

¹⁴¹ Yamaner, Melike, 2007, p.381.

Хүний эрхийг хангах хамгаалах олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон ОУЭЭЗ-н хэм хэмжээ хүний эрхийн үндсэн үнэт зүйлсийг хамгаалдаг, бусад олон улсын эрх зүйн хэм хэмжээнүүдийн нэгэн адил асуудалд ерөнхий зохицуулалт хийх бус шийдвэрлэх асуудал нь үргэлж тодорхой хувь хүмүүст чиглэж байдаг, олон улсын эрүүгийн шүүхээр хэрэг хянан шийдвэрлэхэд шүүгдэгч шударга шүүлгэх тухай асуудал нь хүний эрхийг хамгаалах эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагддаг зэрэг хэд хэдэн адил ухагдахуунд огтлолцож байдаг¹⁴².

ОУЭЭЗ, олон улсын эрх зүйн бусад салбар эрх зүй тэдгээрийн хоорондын уялдаа холбоо мөн судлагдах хэрэгцээ шаардлагыг тодотгон гаргах байдлаар ямар эрх зүйн хэм хэмжээг зөрчих тохиолдолд, ямар үйлдэл нь олон улсын гэмт хэрэг болохыг тодорхойлох шаардлагатай юм. ОУЭЭЗ-д олон улсын гэмт хэргийг олон улсын нийт хүн ам буюу тодорхой бүс нутаг, улс оронд аюул учруулж болзошгүй, аюул учруулсан тохиолдолд хохирол нь нийт хүн амд нөлөөлөхүйц үйлдэл, эс үйлдэхүй юм¹⁴³ хэмээн тодорхойлдог. Олон улсын гэмт хэрэг гэх ойлголт нь дотоодын эрүүгийн хуульд заасан бусад гэмт хэргээс үйлдэл болон хүлээлгэх хариуцлагаар өргөн цар хүрээтэй бөгөөд хохирол, хор уршиг нь нийт хүн амд аюул учруулж болзошгүй байдаг. Энэ нь тухайн үйлдэл, эс үйлдэхүй хийгдэх үед зөвхөн бие хүнд бус хэд хэдэн улсын хоорондох эв найрамдал ба аюулгүй байдалд хохирол учруулж байдагтай холбогдоно¹⁴⁴.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хуулийн хороо олон улсын гэмт хэргийг арьс өнгөөр ялгаварлах (apartheid), төрлөөр устгах (genocide), боолчлох зэрэг хүн төрөлхтний аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэгтэй олон улсын хэм хэмжээнүүдийг хүнд хэлбэрээр болон өргөн хүрээнд зөрчих явдал¹⁴⁵ гэж тодорхойлсон.

Олон улсын гэмт хэрэг нь субъектийн хувьд тодорхой төр улс эсхүл төрийн байгууллага болон бие хүн байх боломжтой. Мөн олон улсын гэмт хэрэг үйлдэгдэх газар хилийн чанд эсхүл өөр улсын нутаг дэвсгэр байх шаардлагагүй. Жишээ нь: тодорхой нэг улсын нутаг дэвсгэрт эхэлсэн дотоодын эмх замбараагүй байдал зэвсэгт мөргөлдөөний явцад үйлдэгдэж буй үйлдэл дайны гэмт хэрэг¹⁴⁶ болох магадлалтай. Тодорхой улсын дотоодод болж буй зэвсэгт мөргөлдөөн, бослого зэрэг нь хэдийгээр тус улсын дотоодын асуудал боловч хөрш зэргэлдээ улсуудын аюулгүй байдалд аюул заналхийлэл бий болгодог учир дээрх нөхцөл байдлыг тухайн улсын дотоод асуудал гэж үзэх бус тухайн улсад олон улсын шинжтэй гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэлтэй байна гэж дүгнэнэ.

Олон Улсын эрүүгийн гэмт хэргийн талаар хуульч, судлаач Антонио Кассесе (Antonio Cassese)¹⁴⁷ онолын үзэл баримтлалаа дэвшүүлсэн, түүний хувьд аливаа үйлдэл, олон улсын гэмт хэрэг нь дараах элементүүдийг агуулсан байх ёстой үүнд:

- Олон улсын гэрээ болон олон улсын зан заншлын хэм хэмжээнүүдийг зөрчсөн байх;

- Олон улсын гэмт хэрэг үйлдэхийг хориглосон эрх зүйн актууд дэлхийн бүх улс түмний чухалчлан үздэг үнэт зүйлийг хамгаалах чиг үүрэгтэй учир уг гэмт хэрэг нь дэлхийн бүх улс түмний нийт хүн амд нөлөөлөхүйц байх;

- Олон улсын гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шийтгэл оногдуулах асуудал олон улсын хэм хэмжээний хүрээнд тодорхой улсын шүүх байгууллагаар дамжин хэрэгжиж болохуйц байх;

- Олон улсын гэмт хэрэг үйлдсэн этгээд тодорхой нэг улсыг төлөөлж уг гэмт хэргийг үйлдсэн бол шүүн таслах ажиллагаанаас “аливаа улс өөр нэгэн гадаад улсын шүүх байгууллагад дуудагдах ёсгүй” гэх үндэслэлээр шүүн таслах ажиллагаанаас зайлсхийхгүй байх.

¹⁴² Than, Shorts, 2003, p.15.

¹⁴³ Başak, 2003, p.2.

¹⁴⁴ Devrim, 2002, p.137.

¹⁴⁵ Мөн тэнд.

¹⁴⁶ Than, Shorts, 2003, p.18.

¹⁴⁷ Antonio Cassese, 2022.

Дээр дурдсан элементүүдийг өөрт агуулсан олон улсын гэмт хэргийг тодорхойлохын тулд цаг хугацааны явцад уг гэмт хэргийн субъектүүдийг шийтгэх зорилгоор байгуулагдсан олон улсын шүүхүүдийн эрх зүйн эх сурвалж болсон гэрээ, актуудыг харах нь зүйтэй. Тухайлбал:

- Нюрнбергийн олон улсын цэргийн эрүүгийн шүүх (1945.08.08-ний Лондонгийн олон улсын гэрээ);

- Токиогийн олон улсын цэргийн эрүүгийн шүүх (1946.01.19-ний Цэргийн генаралын шийдвэр¹⁴⁸);

- Руандагийн олон улсын эрүүгийн шүүх, Хуучин Югославын олон улсын эрүүгийн шүүх (1994, 1993 онуудад Нэгдсэн Үндэстний Байгууллагаас байгуулагдсан ad hoc шүүхүүд);

- Олон улсын эрүүгийн шүүх (1998 оны олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм);

- 2002 оны Сьерра Леонийн тусгай шүүх.

Тодорхой цаг хугацаанд үйл ажиллагаа явуулж байсан олон улсын эрүүгийн шүүхүүд (Ad hoc шүүхүүд¹⁴⁹) ямар төрлийн үйлдлийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэх, тухайн үйлдэлд хариуцлага хүлээлгэх үед баримтлах эрх зүйн хэм хэмжээ зэргээрээ харилцан адилгүй байсан боловч ихэнх гэрээ конвенцод ерөнхийд нь ижил байдлаар тусгалаа олсон суурь хэд хэдэн гэмт хэрэг нь төрлөөр устгах, түрэмгийлэл, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг байна.

Дүгнэлт

XIX зуун, түүнээс өмнөх цаг хугацаанд хамаарах ОУЭЭЗ-н хэм хэмжээг тогтоох явдал олон улсын гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн асуудлыг хянан хэлэлцэх шүүх байгуулах замаар хэрэгжиж байсан. Хэдийгээр ОУЭЭЗ-н хэм хэмжээг тухайн үед шинээр байгуулж байсан шүүхийн дүрэм зэргээр тодорхойлох гэж оролдож байсан ч энэ нь хангалттай зохицуулалт болох мөн гэмт хэрэг үйлдсэн хүнд ялыг шударгаар оногдуулж, олон улсын төвшинд гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөлийг бүрэн арилгаж чадаагүй.

Улс орнуудад дэлхийн II дайнаас хойш одоог хүртэл хүн төрөлхтний аюулгүй байдалд аюул заналхийлэл учруулахуйц олон улсын гэмт хэргүүд үйлдэгдсээр байна. Цаг хугацааны хувьд дэлхийн II дайны дараагаар байгуулагдсан түр хугацааны Олон Улсын Эрүүгийн шүүхийн дүрэм, уг дүрмийг баримталж гаргасан шийдвэр зэрэг нь ОУЭЭЗ судлаачдын шүүмжлэлд өртөж байсан бөгөөд энэ нь дараа дараагийн шинээр байгуулагдах Олон Улсын Эрүүгийн шүүх болон ОУЭЭЗ-н хэм хэмжээг алдаа, дутагдал, хийдэл багатай болгоход шууд нөлөөлсөн.

ОУЭЭЗ-н хөгжил нь 2002 оны 07 дугаар сарын 01-ний өдөр байгуулагдсан Олон Улсын Эрүүгийн шүүх, Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрмээр тодорхойлогдоно. Энэхүү дүрэмд нэгдэн орж өөрийн улс орныг Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд заасан олон улсын эрүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго агуулсан улсууд байгаа бол нөгөө талаас тус гэрээнд нэгдэн оролгүйгээр гэрээний гишүүн улсын газар нутагт олон улсын эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн өөрийн улсын иргэнийг олон улсын эрүүгийн шүүхэд хүлээлгэж өгөх бус улсдаа хүлээн авах агуулга бүхий хоёр талт гэрээ байгуулсан улсууд мөн байдаг. Иймд цаашид ОУЭЭЗ-н хэм хэмжээг дээрх нөхцөл байдлыг гаргуулахгүй байх чиглэлээр шинэчлэх сайжруулах хэрэгцээ шаардлага бий болно.

Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд нэгдэж орохоос зайлсхийсэн улсууд нь эдийн засаг нийгэм соёлын байдлаар дэлхийд тэргүүлэхүйц улсууд бөгөөд гэрээнд нэгдэн орсон тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн иргэдээ дотоодын шүүхээр шударгаар шүүх эсхүл олон улсын эрүүгийн шүүхэд хүлээлгэн өгөх, ОУЭЭЗ-н хэм хэмжээг дагаж мөрдөх үүрэг хүлээх юм. Тус гэрээнд нэгдэж ороогүй улсууд нь олон

¹⁴⁸ Douglas MacArthur, 2022.

¹⁴⁹ Ad hoc, 2022.

улсын гэмт хэргийг бусад улсын нутаг дэвсгэрт дотоодын эмх замбараагүй байдлыг арилгах, энхийг сахиулах, зэрэг нэрийдлээр нэвтрэн орж үйлдэж байна гэх таамаглал дэвшүүлж болох юм.

Ашигласан материал

1. Ad hoc Judge. (2019). Oxford international public law web. 01.11.2022, <https://opil.ouplaw.com/view/10.1093/law-mpeipro/e1170.013.1170/law-mpeipro-e1170>.
2. Antonio Cassese. (2022). Wikipedia. 01.03.2022, https://en.wikipedia.org/wiki/Antonio_Cassese.
3. Ayşe Nur, T. İnsancıl Hukuka Giriş (2006). İstanbul: Beta basım yayın.
4. Başak, C. Uluslararası Ceza Mahkemeleri ve Uluslararası Suçlar (2003). Ankara: Turhan kitabevi yayınları.
5. Claire de Than, Edwin, S. International Criminal law and Human Rights (2003). London: Sweet & Maxwell.
6. Devrim, A. Uluslararası Ceza Hukukunun Gelişimi (2002). Ankara: Ankara Üniversitesi Hukuk fakültesi yayınları.
7. Douglas MacArthur. (2022). Wikipedia. 01.03.2022, https://en.wikipedia.org/wiki/Douglas_MacArthur.
8. European Convention on the International Validity of Criminal Judgements. (1970). Council of Europe web. 27.01.2022, https://rm.coe.int/1680072d3b?fbclid=IwAR1UA6P5fRrYoB-z_eQgKWX0jTN0mm-t2kanbQhzGECpVxD8Zlt4wjsfWnA.
9. Feridun, Y. Milletlerarası Ceza Hukuku, Ceza Yargılarının Değeri ve Mevzuatı (1998). İstanbul: Beta basım yayın.
10. Satzger, Internationales und Europaisches Strafrecht, (2022).
11. Tezcan, D., Erdem, M.R., & Önok, M., Uluslararası Ceza Hukuku (2009). Ankara: Seçkin.
12. Yamaner, B.M. Uluslararası İnsan Hakları Hukuku ve Uluslararası İnsancıl Hukuk ilişkisi, Erdoğan Teziç'e Armağan. İstanbul. Turkey.

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧ ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ДУУДЛАГА, МЭДЭЭЛЛИЙН ДАГУУ АВАХ АРГА ХЭМЖЭЭ

MEASURES AND LEGAL REGULATIONS FOR POLICE OFFICERS IN RESPONSE TO CALLS AND INFORMATION RELATED TO EXPLOSIVES

Б.Баянмөнх

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа

Bayanmunkh B.

Head of police law, University of Internal Affairs, doctor of law (Ph. D), police lieutenant colonel

Хураангуй: Үйлдвэрийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглаж, тэсэлгээний ажил, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын буруутай үйл ажиллагаа, байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан, том хэмжээний аюул, осол үүсэх эрсдэлтэй байдаг. Тэсэрч, дэлбэрэх бодис бол хүн ам, аж ахуйн нэгж, байгууллага ихээр төвлөрсөн газарт илэрвэл түүний учруулах хор уршиг ямар их болохыг жирийн иргэд төдийлөн сайн мэддэггүй нь анхаарвал зохих асуудлын нэг гэж үзэж байна.

Энэхүү өгүүллийн эхний хэсэгт тэсэрч дэлбэрэх бодисын тухай Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн тусгасан болон тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой дуудлага, мэдээллийн дагуу цагдаагийн алба хаагчаас хийж, гүйцэтгэх ажил, арга хэмжээ, түүний дарааллын талаар, дараагийн хэсэгт Цагдаагийн албаны тухай хууль болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасан тодорхой ажиллагааны журмуудад тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой харилцаа үүссэн үед баримтлах арга зүйн заавар, түүний эрх зүйн зохицуулалт, түүнд зайлшгүй нэмбэл зохих ажил, арга хэмжээний талаар судлахыг зорилоо.

Abstract: there is a risk of large-scale hazards and accidents caused by the use of industrial explosives and blasting equipment, wrong actions of companies and organizations engaged in blasting operations and services, force majeure and force majeure. It is considered to be a matter of concern that the general public is not aware of the potential impact of explosives on the population, businesses and organizations in highly concentrated areas.

In the first part of this article, we aim to study the procedure and procedure to be carried out by the police officer in accordance with the Mongolian legislation on explosives and the call and information related to explosives, and in the next part to study the methodological instructions for dealing with explosives in certain operating procedures specified in the law on police services and the regulation on police operations, as well as the necessary measures to be added to it.

Түлхүүр үгс: аюултай бүс, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой осол, хамгаалалтын бүс, цагдаагийн алба хаагч.

Keywords: hazardous area, explosives, explosives-related incidents, security zone, police officer.

Үндсэн хэсэг

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ.” гээд тус зүйлийн 1 дэх хэсгийн 2-т

“эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй.” гэж, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж, мөн зүйлийн 2-т “Хүний эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй”¹⁵⁰ гэж тус тус заасан байдаг.

Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжиж, төрийн өмчийн үйлдвэрүүдийн бүтэц задарч, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд бий болж, эдийн засаг нийгмийн хөгжлийн түлхэц болсон уул уурхайн салбар хурдацтай хөгжиж, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлт нэмэгдсэнээр хэрэглээ эмх замбараагүй болж зөрчил, гэмт хэргийн гаралт нэмэгдэх болов. Ийнхүү уг харилцаанд хяналт тавих эрх зүйн орчинг шинээр бүрдүүлэх цаг үеийн хэрэгцээ, шаардлагаар Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийг анх 2004 онд баталсан.

Уул уурхайн салбар улам эрчимтэй хөгжиж ашигт малтмалын томоохон ордууд эдийн засгийн эргэлтэд орсноор тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, хэрэгцээ, импорт эрс нэмэгдсэн. Үүнтэй уялдуулан аж ахуйн зарим үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг зохицуулах, онцгой аюултай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлд тавих төрийн хяналтыг сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийг 2013 онд дахин шинэчлэн баталжээ¹⁵¹.

Өнөөдрийн байдлаар Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд 4 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна. Тус хуульд “Тэсэрч дэлбэрэх бодис” гэж тэсэлгээний хэрэгсэл, гадны үйлчлэлийн нөлөөгөөр агшин зуурын хугацаанд химийн урвалд орж, өндөр даралт үүсгэн дулаан ялгаруулах химийн нэгдэл буюу механик хольцыг”, “Тэсэлгээний хэрэгсэл” гэж тэсэрч дэлбэрэх бодисын тэсрэлтийг үүсгэх зориулалттай цэнэг агуулсан өдөөгч хэрэгслийг”, “Пиротехникийн хэрэгсэл” гэж хурц гэрэл гэгээ цацруулдаг буюу чанга дуу чимээ үүсгэдэг баяр ёслол, үзвэр, цэнгээний зориулалтаар ашиглагдах хэрэгслийг, “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлт” гэж тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах, тэсэлгээний ажил явуулах үйл ажиллагааг”¹⁵² хэмээн тодорхойлжээ.

Ашигт малтмал, газрын тосны газраас 2020 онд гаргасан мэдээллээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр 300 гаруй ил, далд уурхай ажиллаж байгаа ба “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн дагуу эдгээр уурхайд тэсэлгээний ажил үйлчилгээ хийх “Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх тусгай зөвшөөрөл”-тэй 85 компани, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна¹⁵³.

Тэсрэх бодисын техникийн шаардлагыг тогтоосон MNS 4223:1994 стандарт¹⁵⁴ /Ангилалтын код: 13.230/-ыг Стандарт, хэмжил зүйн газар батлан гаргасан байдаг. Энэ стандарт уул уурхайн болон барилгын материалын үйлдвэрт хэрэглэх энгийн тэсрэх бодисын аюулгүй байдал, техникийн шаардлага, үйлдвэрлэх, хэрэглэх, турших, шалгаж хүлээн авах, савлах, хаяглах, тээвэрлэх, хадгалах, хамгаалах журмыг тогтоодог байна. Энэхүү стандартыг цагдаагийн алба хаагчид мэддэггүй, энэ

¹⁵⁰ Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. 1992. №1.

¹⁵¹ https://nli.gov.mn/pdf/1_Teserch-delbereh-bodis-Last-version-3.pdf.

¹⁵² Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2013. №8.

¹⁵³ <https://nema.gov.mn/n/116716>.

¹⁵⁴ <https://estandard.gov.mn/standard/v/2129>.

талын мэдээ, мэдээлэл дутмаг байдаг нь тэсэрч дэлбэрэх бодистой харьцах, анхан шатны байдлаар шалгахад хүндрэл учрах магадлалыг нэмэгдүүлж байна.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой харилцааг зохицуулсан цөөнгүй заалтууд байна. Үүнд:

- 11 дүгээр зүйл /Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэхэд тавих шаардлага/-ийн 11.1.6. цагдаа, тагнуулын болон онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг авсан байх;

- 12 дугаар зүйл /Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлоход тавих шаардлага/-ийн 12.1.2. цагдаагийн болон тагнуулын төв байгууллага, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг авсан байх;

- 12.3.4. цагдаагийн болон тагнуулын төв байгууллага, Зэвсэгт хүчний жанжин штабын санал авсан байх ба санал өгөх хугацааг ажлын 20 өдрийн дотор шийдвэрлэж байх;

- 14 дүгээр зүйл /Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтэд тавих шаардлага/-ийн 14.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зөвшөөрөгдсөн чиглэлийн дагуу тээврийн болон аюултай ачааны стандартыг баримтлан тусгай тоногдсон тээврийн хэрэгслээр аюулгүй байдлыг хангаж, харуул хамгаалалттай тээвэрлэх бөгөөд тээврийн хэрэгслийн зөвшөөрөл, тээвэрлэлтийн маршрутыг цагдаагийн байгууллага олгож, харуул хамгаалалтыг дотоодын цэрэг гүйцэтгэж, аюулгүй байдалд хяналт тавина;

- 14.7. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны журмыг цагдаагийн төв байгууллага геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална;

- 15 дугаар зүйл /Тэсэлгээний ажил явуулахад тавих шаардлага/-ийн 15.2.2. цагдаагийн болон тагнуулын төв байгууллагын саналыг авсан байх;

- 17 дугаар зүйл /Пиротехникийн хэрэгсэл/-ийн 17.4.3. цагдаа, тагнуулын болон онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг авсан байх;

- 18 дугаар зүйл /Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах, хамгаалахад тавих шаардлага/-ийн 18.4. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл алдагдсан, үрэгдсэн тохиолдолд цагдаагийн болон тагнуулын байгууллагад даруй мэдэгдэх бөгөөд эрэн сурвалжлах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд түүнийг эзэмшигч хуулийн этгээд бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй;

- 22 дугаар зүйл /Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сан/-ийн 22.4. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сантай холбогдолтой мэдээллийг батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, цагдаагийн болон тагнуулын байгууллага авч ашиглана¹⁵⁵;

- 23 дугаар зүйл /Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд тавих хяналт/-ийн 23.1.3. пиротехникийн хэрэгслийн худалдаа, үзвэрийн зориулалтаар ашиглах үеийн аюулгүй байдалд цагдаа, онцгой байдлын болон хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага¹⁵⁶ зэргээр цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг тусгажээ.

Харин Цагдаагийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйл /Захиргааны хяналт тавих/-ийн 13.1.1. хүн ам, экологийн аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй

¹⁵⁵ Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2013. №8.

¹⁵⁶ Энэ заалтад "мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны" гэснийг "хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий" гэж 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хүчтэй хордуулах, мансууруулах бодис болон галт зэвсэг, сум хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх, хадгалж хамгаалах, ашиглах талаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах¹⁵⁷ гэсэн захиргааны чиг үүргийн хүрээнд цагдаагийн алба хаагч тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой харилцаанд оролцдог байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн доорхи зүйл, заалтыг үндэслэн цагдаагийн алба хаагчид тэсэрч дэлбэрэх бодистой тодорхой харилцаанд ордог. Тухайлбал:

- 35 дугаар зүйл /Зорчих хөдөлгөөнийг хязгаарлах/-ийн 35.1.5. террор ажиллагаа болон тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон аюултай бодистой холбоотой мэдээллийг шалгах;

- 38 дугаар зүйл /Эрэн сурвалжлах ажиллагаа/-ийн 38.1.8. алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, тээврийн хэрэгсэл, мал, амьтан, түүх соёлын дурсгалт, үнэт болон бусад эд зүйл;

- 40 дүгээр зүйл. Нийтийн эмх замбараагүй байдлын үед авах арга хэмжээ 40.2.4. ангийн зориулалттай буу, сум хэрэгсэл болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн худалдаа, аюултай ачаа тээвэрлэлтийг түр хориглох;

- 54 дүгээр зүйл /Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх/-ийн 54.6.1. хордсон хүн, амьтан, тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон аюултай бодис алдагдах, гал түймэр гарах эх үүсвэр байгаа эсэхийг шалгаж, аюулгүй болгох зэрэг болно.

Цагдаагийн алба хаагч нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасан дараах журмуудын холбогдох зүйл заалтуудыг удирдлага болгон ажил үүргээ хэрэгжүүлнэ. Тухайлбал:

Тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой дараах мэдээллийг Ноцтой гэмт хэргийн талаар мэдээлэх журам /код 201/-ын 201.2.1-д зааснаар цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын алба нь мэдээлэл хүлээн авмагц байгууллагын даргад, дарга нь цагдаагийн төв байгууллагын дарга, удирдлагад даруй мэдээлдэг байна. Тухайлбал:

а/хүн худалдах, барьцаалсан, агаарын хөлгийг авч зугтаасан, зэвсэглэсэн этгээд оргосон, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүнийг алсан, харгис, хэрцгий аргаар үйлдэгдсэн болон тэсэрч дэлбэрэх бодис ашигласан, хорлон сүйтгэсэн;

д/галт зэвсэг, сум, тэсэрч дэлбэрэх бодис, машин, тусгай хэрэгсэл алдагдсан тухай;

е/галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон химийн хорт бодис үйлдвэр, тэдгээрийн агуулах савнаас алдагдсан тухай мэдээлдэг байна.

Дээрхи мэдээлэл дотор тэсэрч дэлбэрэх бодис олдсон, илрүүлсэн тохиолдолд мэдээлэл хэрхэн дамжуулах талаар чиглэл байхгүй байгаа нь анхаарал татаж байна.

Гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах журам /код 205/¹⁵⁸-ын 205.6.4-д “Тэсэрч дэлбэрэх бодис, занга тавьсан байж болзошгүйг анхаарч, сэжигтэй зүйл илэрвэл түүнд хүрэхгүй, орчны хүмүүсийг даруй холдуулж, нөхцөл байдлын талаар шуурхай удирдлагын албанд яаралтай мэдэгдэнэ”¹⁵⁹ хэмээн заасан байдаг.

Энэхүү журамд зааснаар тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой сэжигтэй зүйл илэрсэн тохиолдолд шуурхай удирдлагын албанд мэдэгдэх, иргэдийг уг газраас холдуулах, түүнд хүрэхгүй байх талаар заасан байна.

Цагдаагийн эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид “Тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодисын талаарх мэдээлэл хүлээн авч ажиллах журам” /код 211/¹⁶⁰-ыг баримтлан ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Уг журамд “Тэсэрч дэлбэрэх бодис” - тэсрэлтийн хүчийг ашиглах зориулалттай гадны хүчний үйлчлэлээр агшин зуурын хугацаанд химийн урвалд орж, хүний амь

¹⁵⁷ Цагдаагийн албаны тухай хууль //Төрийн мэдээлэл. 2017. №8.

¹⁵⁸ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/262 дугаар тушаалаар батлагдсан.

¹⁵⁹ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ. 2018. 343 дахь тал.

¹⁶⁰ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/262 дугаар тушаалаар батлагдсан.

нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хор хөнөөл учруулах аюултай химийн нэгдэл буюу механик хольцыг хэмээн тодорхойлжээ. Энэхүү тодорхойлолтыг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд заасан тодорхойлолтоос агуулгын хувьд ялгаагүй мэт боловч арай дэлгэрэнгүй байдлаар тодорхойлжээ.

Цагдаагийн байгууллагад тэсэрч дэлбэрэх зүйл, химийн хорт болон цацраг идэвхт бодис илэрсэн талаар мэдээлэл ирвэл уг журмын 211.3.1-д зааснаар шуурхай удирдлагын штаб нь дараахь ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

а) дуудлагыг хүлээн авч байршил, дуудлага мэдээлэл өгсөн иргэний талаар тодорхой бүртгэнэ;

б) тэсэрч дэлбэрэх зүйл, химийн хорт болон цацраг идэвхт бодисын дуудлага, мэдээллийн талаар шууд удирдах дарга, Шуурхай удирдлагын штаб, Онцгой байдал, Мэргэжлийн хяналтын болон Зэвсэгт хүчний мэргэжлийн албад, Эмнэлгийн яаралтай тусламжийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ;

в) тухайн нутаг дэвсгэрт хамгийн ойр байгаа эргүүлийг нөхцөл байдалд тохирсон зааварчилга, мэргэжлийн удирдлагаар хангаж, хамгаалалтыг зохион байгуулна¹⁶¹.

Харин тэсэрч дэлбэрэх зүйл, химийн хорт болон цацраг идэвхт бодис ашиглан гэмт хэрэг үйлдэх гэж байгаа талаар мэдээлэл ирвэл дараахь ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

а) мэдээллийг хүлээн авч, гэмт хэрэг үйлдэх гэж байгаа газар орон, мэдээлэл өгсөн иргэний талаар тодорхой бүртгэнэ;

б) илрүүлэх, таслан зогсоох хойшлуулшгүй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Харин бидний гол хөндөх асуудал бол тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой мэдээлэл хүлээн авч тухайн газарт анхлан очсон алба хаагчийн хийж гүйцэтгэх ажиллагаатай холбоотой асуудлыг билээ. Тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодисын талаарх мэдээлэл хүлээн авч ажиллах журам /код 211/¹⁶²-ын 211.4.1-д зааснаар мэдээлэл хүлээн авч тухайн газарт эхлэн очсон алба хаагч дор дурьдсан ажлыг хийж гүйцэтгэхээр журамласан байна. Үүнд:

а) тэсэрч дэлбэрэх зүйл, химийн бодис болон цацраг идэвхт байж болзошгүй зүйлд өөрөө болон бусдыг хүргэхгүй байх;

б) дэлбэрэлтийн бүсийн эргэн тойронд 200 метр, химийн осол болон цацраг идэвхт бодисын хөнөөлийн үед 300-500 метрээс доошгүй зайд хамгаалалтын бүс тогтоож, иргэдийг бүсээс гаргаж, бүслэн хамгаалах;

в) тухайн зүйлийн байршил, орчин, хэмжээ, хэлбэр, төрөл, өнгө, үнэр зэрэг гадаад шинж тэмдэг, учирсан болон болзошгүй хор уршиг, аюулын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Шуурхай удирдлагын штабт мэдэгдэх;

г) тухайн газраас 300 алхмын дотор радио долгионы хэрэгсэл ашиглахгүй байх;

д) ойролцоо газар, тухайн нутаг дэвсгэрт тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодис байгаа эсэхийг шалгах¹⁶³ зэргийг гүйцэтгэхээр тусгасан байна.

Харин тэсэрч дэлбэрэх бодисоос үүдэлтэй осол болон аюултай бүс, аюулгүй бүс тогтоох гэж юу болох талаар тайлбар тодорхойлолт байхгүй байгаа нь журмын ач холбогдлыг бууруулах нэг үндэслэл болж байна. Тиймээс дараах нэр томъёоны тодорхойлолтуудыг журамд оруулбал цагдаагийн алба хаагчийн хийж гүйцэтгэх ажил, арга хэмжээний үр дүн нэмэгдэх боломжтой гэж үзэж байна. Тухайлбал:

“Тэсэрч, дэлбэрэх бодисоос үүдэлтэй осол” гэж тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах, тэсэлгээний ажил явуулах үйл ажиллагааны горим зөрчигдөх, технологийн явцад эвдрэл гарах зэргээс шалтгаалан хүн, барилга байгууламж, зам талбай,

¹⁶¹ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ. 2018. 373 дахь тал.

¹⁶² Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/262 дугаар тушаалаар батлагдсан.

¹⁶³ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ. 2018. 343 дахь тал.

хүрээлэн буй орчинд аюул учруулах тохиолдлыг; “Аюултай бүс” гэж тэсрэлтийн үйлчлэл (тэсрэлтийн улмаас шидэгдэх эд материал, шороо чулуулаг, цохих долгион) хүн, техник тоног төхөөрөмж, барилга байгууламжид нөлөөлж, аюул учруулж болзошгүй зай; “Аюулгүйн бүс тогтоох” гэж Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дагуу мэргэжилтнүүдийн зүгээс тэсрэлтийн үйлчлэл (тэсрэлтийн улмаас шидэгдэх эд материал, шороо чулуулаг, цохих долгион) хүн, техник тоног төхөөрөмж, барилга байгууламжид нөлөөлөхгүй байх аюулгүй бүс тогтоох ажиллагаа гэсэн тодорхойлолтуудыг оруулах шаардлагатай байна.

Аюултай бүсийг цагдаагийн алба хаагч нь журамд заасан “дэлбэрэлтийн бүсийн эргэн тойронд 200 метр” гэж заасан боловч орон сууцны хороолол дунд бол уг зааврыг хэрхэн хэрэгжүүлэх талаар арга зүйн мэдлэг дутагдах магадлалтай болж байгаа нь тулгамдсан асуудал болж байна. Түүнчлэн мэдээлэл хүлээн авч тухайн газарт эхлэн очсон алба хаагчийн хийж гүйцэтгэх ажил, арга хэмжээндээ дараах ажлуудыг давхар хийж гүйцэтгэхээр тусгаж өгмөөр байна. Тухайлбал:

- Тухайн газарт эхлэн очсон алба хаагчтай хамтран үүрэг гүйцэтгэх алба хаагчдын аюулгүй байдлыг хангах;

- Гарч болзошгүй ослын хор уршгаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй аргыг тодорхойлох;

- Ослын голомт дээр шаардлагатай онцгой байдлын албаны хүч хэрэгслийг татан төвлөрүүлэх, харилцан ажиллагааг зохион байгуулах, хуваарилан ажиллуулахад дэмжлэг үзүүлэх;

- Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангах, иргэдийг төөрөгдүүлэхгүй байх ажлыг зохион байгуулах зэргийг нэмж тусгах шаардлагатай байна.

Ялангуяа гудамж талбай, олон нийтийн газарт эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой мэдлэг, хэрхэн харьцах арга зүйн мэдлэг, чадварын түвшинг бодлогын түвшинд судалж үзэх шаардлагатай байна. Түүнчлэн уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бүс нутагт үүрэг гүйцэтгэж байгаа хэсгийн төлөөлөгч нарт мөн адил хамаатай юм.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой асуудал үүсвэл зохицуулах заалтууд цөөнгүй байна. Тухайлбал:

- Замын хөдөлгөөний урсгал, чиглэлийг түр өөрчлөх, хаах журам /код 224/-ын 224.4.1.Цагдаагийн байгууллага, алба хаагч нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8.2.2-д заасан эрхийн хүрээнд дараахь тохиолдолд замын хөдөлгөөнийг зохион байгуулах, урсгал, чиглэлийг түр өөрчлөх, хязгаарлах, хаах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: г/нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон, тэсэрч дэлбэрэх аюул, террорист халдлага, тухайн орчинд хорт бодис, хий тархсан үед иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учрах аюулыг таслан зогсоох¹⁶⁴;

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх журам /код 227/-ын 227.2. Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр энэ журмын 227.6-д заасан нийтлэг үүргээс гадна дараахь үүргийг хэрэгжүүлнэ: д/Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, нэгж: 8/тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хүчтэй хордуулах, мансууруулах бодис болон галт зэвсэг, сум хэрэгслийг хадгалж хамгаалах, ашиглах талаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах¹⁶⁵;

- 229.Эрэн сурвалжлах журам /код 229/-ын 229.6.3. Эрэн сурвалжлах хүн, мал, эд зүйлс, цогцосны мэдээллийг “ASAP” санд дор дурдсан өнгөний ангилалаар бүртгэж зарлан мэдээлнэ: д/“ногоон” - түүх соёлын дурсгалт болон үнэт зүйл, галт

¹⁶⁴ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ. 2018. 404 дэх тал.

¹⁶⁵ Мөн тэнд. 417 дахь тал.

зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах, химийн хорт бодисын талаар /маягт 5421, 5422, 5424/¹⁶⁶;

229.11.2.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга: и/эрэн сурвалжилж байгаа галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодисын талаарх мэдээллийг Зэвсэгт хүчний жанжин штаб, Онцгой байдлын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газарт мэдэгдэн, мэргэжлийн туслалцаа авч хамтран ажиллах;

- Гүйцэтгэх ажил явуулах журам /код 307/-ын 307.4.1. Цагдаагийн байгууллага нь хуулиар харьяалуулсан нууц далд аргаар үйлдэгдсэн, эсхүл тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, таслан зогсоох, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох, түүнчлэн сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон прокурор, шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох зорилгоор гүйцэтгэх ажил явуулна.¹⁶⁷

- Эд мөрийн баримтыг хадгалах, хамгаалах журам /код 329/-ын 329.4.4.Хүний амь нас, эрүүл мэнд, байгал орчинд шууд хор хөнөөл, аюул учруулахуйц, эсхүл түргэн муудах, шинж чанараа алдах эд зүйл /тэсэрч дэлбэрэх, шатамхай химийн хорт бодис, хүнсний бүтээгдэхүүн гэх мэт/ байвал мэргэжлийн байгууллагуудтай хамтарч, аюулгүй байдлыг хангаж ажиллан зориулалтын агуулах байранд хадгалуулахаар хүлээлгэж өгнө.¹⁶⁸

- Жагсаал, цуглааны үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам /код 502/-ын 502.4 /жагсаал, цуглаанд оролцогчдыг хамгаалах/-ын г/халуун, хүйтэн зэвсэг, хорт болон тэсэрч дэлбэрэх бодис, орчин тойрондоо болон хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болохуйц аливаа зүйл, амьтан авч явж болохгүйг жагсаал, цуглаанд оролцогчдод урьдчилан анхааруулж, тийм тохиолдол илэрвэл холбогдох байгууллагад даруй мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авахуулах;

- Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам /код 504/-ын 504.4 /гүйцэтгэх үүрэг/-ын 504.4.1 г/ангийн зориулалттай буу, сум хэрэгсэл болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн худалдаа, аюултай ачаа тээвэрлэлтийг түр хориглох;

- Онц байдал зарласан үед нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам /код 505/-ын 505.3 /цагдаагийн байгууллагаас гүйцэтгэх үүрэг/-ын т/иргэдийн эзэмшилд байгаа галт болон хүйтэн зэвсэг, галт хэрэгсэл, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн технологид хэрэглэдэг тэсэрч дэлбэрэх, хүчтэй үйлчлэх химийн хорт болон цацраг идэвхт бодис, сургалтын зориулалттай байлдааны зэвсэг, техник хэрэгслийн ашиглалтад хяналт тогтоох, шаардлагатай гэж үзвэл ашиглалтыг зогсоох буюу тэдгээрийг түр хураан авах;¹⁶⁹

Дээрхи бүх журмуудын холбогдох зүйл, заалтуудыг эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчид мэдэж, тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой дуудлага мэдээлэл хүлээн авсан даруй дагаж мөрдөх ёстой юм. түүнчлэн тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой гэмт хэргийн мэдээлэл дутмаг байгаа ч Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүхээр шийдвэрлэгдсэн нэг гэмт хэргийн талаар авч үзвэл:

Шүүгдэгч Д.Намсрай нь 2014 оны 01 дүгээр сарын үед Улаанбаатар хотын Налайх дүүргээс тэсэрч дэлбэрэх бодис болох ПТ-П300 загварын завсрын тэсрүүлэгч 8 ширхэг, ЭД-1-8 загварын цахилгаан тэслүүр 11 ширхэг, ДШ-А загварын 52.93 метр урттай цохир дамжуулагч шижим зэргийг хууль бусаар авч яваад Улаангом суманд 5

¹⁶⁶ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/262 дугаар тушаалаар батлагдсан.

¹⁶⁷ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ. 2018. 507 дахь тал.

¹⁶⁸ Мөн тэнд. 567 дахь тал.

¹⁶⁹ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/265 дугаар тушаалаар батлагдсан.

дугаар багийн 11-09 тоотод оршин суух иргэн Л.Сүхбаатарын амбаарт хадгалсан бөгөөд уг тэсэрч дэлбэрэх бодис болон бусад эд зүйлийг 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр тус аймгийн Давст сумруу авч явж өөрийн амбаартаа хадгалсан гэх гэмт хэрэгт холбогджээ.¹⁷⁰

Үүнээс харвал, иргэд тэсэрч дэлбэрэх бодистой гэмт хэрэг, зөрчил болон уг бодисын хор хөнөөлийн талаар мэдлэг тун хомс байгаа нь харагдаж байгаа бөгөөд иргэд, олон нийтийн дунд тэсэрч дэлбэрэх бодисын хор хөнөөл, учирч болох хор уршгийн талаар урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ хангалтгүй явагдаж байгаатай холбон үзэж болохоор байна. Нөгөө талаараа тэсэрч дэлбэрэх бодисын хор хөнөөлийн талаар төдийлөн ач холбогдол өгөхгүй, мэдээлэл дутмаг байгаа нь өнөөгийн нийгмийн тогтворгүй байгаа цаг үед зайлшгүй анхаарвал зохих асуудал болж байна.

Дүгнэлт

Тэсэрч дэлбэрэх бодисын талаарх ойлголт, ангилал, төрөл, хэлбэр болон гадаад хэлбэр дүрс гэх мэт мэдээ, мэдээлэл, түүний учруулж болох хор уршгийн талаар цагдаагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид тун бага мэдлэгтэй байх магадлал өндөр байгаа нь асуудал гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой дуудлага, мэдээллийн дагуу цагдаагийн алба хаагчийн хийж гүйцэтгэх ажлын талаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасан үйл ажиллагаануудад зарим зохицуулалт орхигдсон байгаа нь анхаарвал зохих асуудал болоод байна.

Мөн цагдаагийн алба хаагчаас тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой дуудлага, мэдээллийн дагуу хийх ажил, арга хэмжээг зохицуулсан журамд зайлшгүй байх ёстой зарим нэг нэр томъёоны тодорхойлолт дутмаг байгааг анхаарч нэмэлт өөрчлөлт оруулах замаар журмын үр нөлөөг дээшлүүлэх явдал чухал байна гэж үзлээ.

Санал

Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодисын талаарх мэдээлэл хүлээн авч ажиллах журам /код 211/-д дараах нэр томъёоны тодорхойлолтыг нэмж оруулах

- “Тэсэрч, дэлбэрэх бодисоос үүдэлтэй осол” гэж тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах, тэсэлгээний ажил явуулах үйл ажиллагааны горим зөрчигдөх, технологийн явцад эвдрэл гарах зэргээс шалтгаалан хүн, барилга байгууламж, зам талбай, хүрээлэн буй орчинд аюул учруулах тохиолдлыг;

- “Аюултай бүс” гэж тэсрэлтийн үйлчлэл (тэсрэлтийн улмаас шидэгдэх эд материал, шороо чулуулаг, цохих долгион) хүн, техник тоног төхөөрөмж, барилга байгууламжид нөлөөлж, аюул учруулж болзошгүй зай;

- “Аюулгүйн бүс тогтоох” гэж тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дагуу мэргэжилтнүүдийн зүгээс тэсрэлтийн үйлчлэл (тэсрэлтийн улмаас шидэгдэх эд материал, шороо чулуулаг, цохих долгион) хүн, техник тоног төхөөрөмж, барилга байгууламжид нөлөөлөхгүй байх аюулгүй бүс тогтоох ажиллагаа;

2. Тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодисын талаарх мэдээлэл хүлээн авч ажиллах журам /код 211/-ын 211.4.1-д заасан мэдээлэл хүлээн авч тухайн газарт эхлэн очсон алба хаагчийн хийж гүйцэтгэх ажилд дараах ажлуудыг нэмж тусгамаар байна. Үүнд:

- Тухайн дуудлага мэдээллийн газарт эхлэн очсон алба хаагч хамтран үүрэг гүйцэтгэх алба хаагчийнхаа аюулгүй байдлыг хангах;

¹⁷⁰ https://shuukh.mn/single_case/6569?start_date=&end_date=&id=1&court_cat=2&bb=1.

- Гарч болзошгүй ослын хор уршгаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй аргыг тодорхойлох;

- Ослын голомт дээр шаардлагатай онцгой байдлын албаны хүч хэрэгслийг татан төвлөрүүлэх, харилцан ажиллагааг зохион байгуулах, хуваарилан ажиллуулахад дэмжлэг үзүүлэх;

- Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангах, иргэдийг төөрөгдүүлэхгүй байх ажлыг зохион байгуулах.

3. Орон сууцны хороолол дунд тэсэрч дэлбэрэх бодис илэрсэн тохиолдолд аюултай бүсийг цагдаагийн алба хаагч хэрхэн тогтоож, аюулгүй бүсийг байгуулах талаар тусгайлсан зааварчилгаа боловсруулах зэрэг болно.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. 1992. №1.
2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2013. №8.
3. Цагдаагийн албаны тухай хууль //Төрийн мэдээлэл. 2017. №8.
4. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ. 2018. 343 дахь тал.
5. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/262 дугаар тушаал.

Интернет эх сурвалж

6. <https://estandard.gov.mn/standard/v/2129>.
7. <https://nema.gov.mn/n/116716>.
8. https://nli.gov.mn/pdf/1_Teserch-delberek-bodis-Last-version-3.pdf.
9. https://shuukh.mn/single_case/6569?start_date=&end_date=&id=1&court_cat=2&bb=1.

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ БИЧГИЙН ЗОХИОГЧИЙГ МАГАДЛАХ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

THE CURRENT STATE OF FORENSIC AUTHOR EXAMINATION IN MONGOLIA

М.Эрдэнэжаргал

ДХИС-ийн докторант, цагдаагийн ахмад

Erdenejargal M.

Researcher doctoral candidate of University of Internal Affairs, police captain

Хураангуй: Бичгийн зохиогчийг магадлах хэрэгцээ, шаардлагыг судалж, бичгийн зохиогчийг магадлах шинжилгээний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийн, монгол хүний бичсэн бичгийн зохиогчийг магадлах шинжилгээ хийхэд тулгамдаж буй хүчин зүйлсийг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг тогтоох зорилгоор судалгаа хийж, үр дүнг нэгтгэлээ.

Abstract: In order to identify issues coming up in author examination of writings that are written by Mongolians, a study was conducted and concluded by analyzing the needs and requirements of author examination and the current state of forensic author examination.

Түлхүүр үгс: Адилтгал, бичгийн зохиогчийг магадлах шинжилгээ, бичгийн хэл, оношилгоо.

Keywords: Identification, forensic author examination, written speech, diagnostic.

Удиртгал

1930 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Дотоодыг хамгаалах газраас Донров, Судар бичгийн хүрээлэнгээс Д.Нацагдорж, Я.Цэвэл нар томилогдон бичиг судлалын шинжилгээ хийн хянан тогтоосон актыг үйлдэж, “экспертийн комисс” хэмээн гарын үсэг зурсан баримтаас харахад шинжилгээ хийж үр дүнг нь баталгаажуулах хүрээнд ЗХУ-д бий болоод байсан шинжилгээ томилох түүнийг хийхтэй холбоотой эрх зүйн соёл тухайн цаг үед Монгол Улсад нэвтэрч эхэлжээ. Үүнээс хойш өнөөдрийг хүртэл бичиг судлалын шинжилгээ хийгдэж, тус мэдлэгийн салбар хөгжлийн тодорхой түвшинд хүрсэн. Гэсэн хэдий ч эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн төрлийн шинжилгээгээр хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг бүрэн тогтоож чадахгүй, зөвхөн уламжлалт аргаар шинжилгээ хийж байгаа нь учир дутагдалтай байна.

Түүнчлэн, шинжээчийн дүгнэлтийн үнэлэмжийг сайжруулах зорилгоор монгол хүний бичгийн хэв, хэлний онцлогыг судалж, энэ төрлийн шинжилгээгээр тогтоож буй асуудлын хүрээг өргөжүүлэх, дэвшилтэт техник хэрэгсэл болон олон улсад ашиглагдаж буй шинжилгээний арга зүйг нэвтрүүлэх нь шинжлэх магадлах ухааны онол, шүүхийн шинжилгээний практик судлалын анхаарал татсан асуудлуудын нэгд зүй ёсоор багтаж байна.

Мөн нийгмийн хөгжлийн явцад бий болж буй шинэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэргийн нөхцөл байдлыг бүрэн тогтооход шинжээчээс гарган өгч буй шинжлэх ухааны үндэслэлтэй нотлох баримтын хэрэгцээ шаардлага улам ихэссээр байна.

Иймээс дээрх хэрэгцээ, шаардлага болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Салбарын үйл ажиллагаанд шинжлэх ухааны өндөр түвшний технологийг нэвтрүүлэх бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй

болгож, судалгаа, шинжилгээний баазыг бэхжүүлсэн байна”, Шүүхийн шинжилгээний байгууллагын техник, тоног төхөөрөмж болон хүний нөөцийн чадамж дээшилсэн байна” гэж заасныг тус тус үндэслэн “Монгол Улс дахь бичгийн зохиогчийг магадлах шинжилгээний өнөөгийн байдал” сэдвээр судалгаа, шинжилгээ хийсэн.

Энэ төрлийн шинжилгээ хийгдэхгүй байгаа манай орны хувьд бичгийн зохиогчийг магадлах онолын болон практик хэрэгцээ, шаардлагыг гүйцэтгэгч(шинжээч) болон нотлох баримтыг хэрэглэгч(шүүх, прокурор, мөрдөгч) талаас нь дэлгэрэнгүй судалж, бичгийн зохиогчийг магадлах шинжилгээний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийн, монгол хүний бичсэн бичгийн зохиогчийг магадлах шинжилгээ хийхэд тулгамдаж буй шинжлэх ухаан, хууль зүй, техник, хүний хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор судалгаа хийж, дүгнэлт, санал дэвшүүлж байгаа нь уг судалгааны ажлын шинэлэг тал юм.

Уг судалгааны ажлын хүрээнд SmartPLS 3.0, PLS-SEM програмыг ашиглан чанарын судалгаа хийснээс гадна цагдаа, шүүх, авилгатай тэмцэх газрын нийт 203 шинжилгээ томилох эрх бүхий этгээдээс асуулгын аргаар судалгаа авч, үр дүнг нэгтгэлээ.

Үндсэн хэсэг

Бичиг судлалын шинжилгээ хийхэд шинжээчийн тусгай мэдлэгээс гадна олон ур чадварыг шаарддаг бөгөөд мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн туршлага, техник тоног төхөөрөмжийн хэрэглээ, оролцоо, зан төлөв, сэтгэл ханамж зэрэг нь бичиг судлалын шинжээчийн ажлын гүйцэтгэлд хамгийн ихээр нөлөөлдөг гэсэн таамаглалыг бичиг баримтын шинжилгээний лабораторид ажилласан 10 жилийн туршлага болон шинжээчдийн дунд хийсэн ярилцлагын үр дүнд дэвшүүлэн дээрх таамаглалыг батлах зорилгоор чанарын судалгаа хийсэн.

Судалгааны үр дүнгээс харахад, мэргэжлийн ур чадвар, оролцоо нь бичиг судлалын шинжээчийн ажлын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлж, дэвшүүлсэн таамаглал батлагдсан.

Мэргэжлийн ур чадварын хувьд бичиг судлалын шинжээчийн ажлын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлдөг нь батлагдсан хэдий ч “Шинжилгээний арга зүйн ашиглалт”, “Дүгнэлт бичих”, “Техник хэрэгсэл ашиглалт”, “Нарийвчлан ажиглах байдал”, “Шүүмжлэлт сэтгэлгээ”, “Мэргэжлийн туршлага” гэсэн далд хувьсагчид 0.7-оос доош гарсан. Үүний шалтгаан нь бичиг судлалын шинжилгээний онцлогоос хамааран тухайн шинжилгээг хийж буй шинжээч сэтгэлгээний ур чадвар сайтай, шинжилгээний арга зүйг бүрэн эзэмшиж, ашигладаг байхаас гадна шинжилгээний дүгнэлтэд хүрэх үндэслэлээ оновчтой тодорхойлж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах боломжтой боловч өнөөгийн практикт ажиллаж буй шинжээчдийн мэргэжлийн эдгээр ур чадвар дутмаг байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Судалгааны таамаглалаас хүчин зүйлийн шууд хамаарлыг шинжлэхэд бичиг судлалын шинжээчийн зан төлөв, техник, тоног төхөөрөмж, сургалт, хөгжлийн ихэнх далд хувьсагч 0.7-оос дээш гарч үр дүн сайтай байсан ч ажлын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлж чадахгүй байгаа нь батлагдсан. Тухайлбал, техник, тоног төхөөрөмжийн далд хувьсагчуудын ихэнх нь 0.7-оос дээш гарч техник, тоног төхөөрөмж ажлын гүйцэтгэлд тодорхой эерэг нөлөө үзүүлж байна гэж үзэж болох ч “Техник, тоног төхөөрөмжийн ашиглалт”, “Техник, тоног төхөөрөмжийн стандартчлал” гэсэн далд хувьсагчид 0.7-оос доош гарсан нь ажлын гүйцэтгэлд эерэг нөлөө бий болгож чадахгүй байгаа нь батлагдсан бөгөөд бичиг судлалын шинжилгээг зөвхөн уламжлалт аргаар бус шинээр техникт суурилсан шинжилгээний арга зүйг нэвтрүүлэх, олон улсын стандартад нийцсэн техник, тоног төхөөрөмжийг ашиглах шаардлага үүсэж байна¹⁷¹.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад бичиг судлалын шинжилгээний арга зүйг боловсронгуй болгох, сайжруулах хэрэгцээ байгаа бөгөөд тус мэдлэгийн салбарт

¹⁷¹ Эрдэнэжаргал, М., Баясгалан, Ц., Пүрэвсүрэн, Ж. Бичиг судлалын шинжээчийн ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл. УБ. 2022. 3 дугаар улирал.

бичгийн хэв, бичгийн хэл гэсэн 2 үндсэн ухагдахуун байдаг. Монгол Улсын хувьд бичгийн гүйцэтгэгчийг магадлах шинжилгээний арга зүй боловсруулагдаж, хөгжлийнхээ тодорхой түвшинд хүрсэн байна. Харин бичгийн хэлний шинж тэмдгийг ашиглаж, шинжлэн магадлаж, хэрэгт ач холбогдолтой нотлох баримт гаргаж өгдөг бичгийн зохиогчийг магадлах шинжилгээний онолын үндэс, шинжилгээний арга зүй манай улсад хараахан төлөвшиж бий болоогүй байна. Тиймээс шинжлэн магадлах ухааны нэг судлагдахуун болох бичгийн зохиогчийг магадлах асуудлыг судлах онолын шаардлага бий болсон.

Мөн нэгэнт Оросын Холбооны Улс (Цаашид – ОХУ гэх) зэрэг орнуудад хөгжиж байгаа бичгийн зохиогчийг магадлах шинжилгээний онолын үндсийг судалсны үндсэн дээр арга зүйг боловсруулах шаардлагатай. Учир нь гадаад орнуудад энэ төрлийн шинжилгээний арга зүй байгаа боловч монгол хэлээс өгүүлбэрийн бүтэц, утга зүйн хувьд өөр, манай орны шинжилгээний практикт шууд ашиглах боломжгүй бөгөөд монгол хэл болон монгол хүний сэтгэлгээг судалсны үндсэн дээр бичгээр илэрхийлж буй санаа нь ямар дадлын түвшинд илэрч байгааг судалж, адилтгах нь зүй юм. Жишээлбэл англи болон орос хэлний энгийн өгүүлбэрийн бүтэц нь “Эзэн бие+үйл үг+тусгагдахуун” гэсэн байрлалтай бол монгол хэлний хувьд “эзэн бие+тусгагдахуун+үйл үг” гэсэн байрлалтай байдаг.

Иймээс бичгийн хэлний ойлголт, хэрэглээ, бичгийн хэл бүрэлдэх, төлөвших, өөрчлөгдөх зүй тогтол, түүний физиологийн үндэс, бичгийн зохиогчийг магадлах онцлогыг судалж, шинж тэмдэгт судалгаа хийсний үндсэн дээр шинжилгээний нийтлэг арга зүйг боловсруулах нь шинжлэн магадлах ухааны онолд томоохон хувь нэмэр болох юм.

Мөн чанарын судалгаагаар бичиг судлалын шинжээчийн ажлын гүйцэтгэлд зөвхөн шинжээч бус шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд, шинжилгээний байгууллагын удирдлага болон бүртгэлийн ажилтан зэрэг оролцогчдын оролцоо эерэг нөлөө үзүүлнэ хэмээн таамагласан ч “Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн оролцоо” гэсэн далд хувьсагч 0.7-оос доош гарсан нь шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн мэдлэг, ур чадвар, шуурхай ажиллагаанд анхаарах шаардлагатай байгааг харуулж байна¹⁷².

Үүний зэрэгцээ шинжээчийн дүгнэлтийг нотлох баримтаар ашиглаж, үнэлдэг хэрэглэгчийн хувьд шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд бичиг баримтын шинжилгээ томилоход тулгарч буй асуудал, ямар хэрэгцээ байгааг судлах зорилгоор 203 мөрдөгч, шүүгчээс асуулгын аргаар судалгаа авахад нийт оролцогчдын 31.5 хувьд бичиг баримтын шинжилгээ томилох хэрэгцээ байсан ч шийдвэрлүүлж чадаагүй тохиолдол гарсан бөгөөд дээрх тохиолдлын 39.8 хувийг бичгийн зохиогчийг тогтоолгох асуудал дангаараа эзэлж байна.

Түүнчлэн цаашид бичгийн зохиогчийг магадлах шинжилгээний чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх шаардлагатай гэж асуулганд оролцогчдын 60 хувь нь хариулсан төдийгүй 83.7 хувь нь шинэ төрлийн шинжилгээний ач холбогдлийг өндрөөр болон хэрэгт тодорхой ач холбогдолтой гэж үзсэн байна.

Дээрх чанарын болон асуулгын судалгааны үр дүнгээс эрх бүхий этгээдүүдэд бичгийн зохиогчийг магадлах шинжилгээ хийлгэх практик шаардлага үүсдэг боловч шинжилгээний онол, арга зүй нь байхгүйн улмаас шийдвэрлүүлж чадахгүй, бичиг судлалын шинжээчдийн адил энэ төрлийн шинжилгээний талаарх мэдлэг тааруу байгаа нь харагдаж байна.

Дэлхийн улс орнууд даяаршлалын нөлөөгөөр цэцэглэн хөгжиж буй гэмт явдлыг хянах боломж хязгаарлагдмал байна. Сүүлийн жилүүдэд нийгмийн стресс бухимдал ихэсч байгаа, хувь хүний сэтгэл зүй болон харилцаа зэрэг олон шалтгаантай холбоотойгоор амиа хорлох явдал (2017 онд 332, 2018 онд 312, 2019 онд 293, 2020 онд 275¹⁷³) ихэссэний зэрэгцээ нийгмийн бүхий л орчинд(гэр бүл, шорон г.м) амиа

¹⁷² Мөн тэнд.

¹⁷³ <https://apps.who.int/gho/data/view.main.MHSUICIDEASDRV?lang=en>.

егүүтгэсэн мэт харагдах боловч гэмт хэргийн шинжтэй хүний амь нас хохироосон хэргүүд гарсаар байгаа нь криминологийн нуугдмал гэмт хэргийн судалгаанаас харагддаг. Амиа хорлолт голчлон өөрийгөө боомилох, судсаа ханах, өндрөөс унах хэлбэрээр үйлдэгдсэн байх бөгөөд ихэнх тохиолдол гэрээслэл, захиа, зурвас, олон нийтийн харилцааны цахим харилцааны хэрэгслүүд ашиглан сэтгэл санааны байдал, сэтгэгдэл, захих захиа, амиа хорлосон нь үнэн тухайгаа эсхүл хэн нэгнийг буруутгаж буйгаа бусдад илэрхийлж үлдээсэн байдаг. Дээрх бичгийн хэлбэрээр үлдсэн нотлох баримтууд нь тухайн хүнийг амиа егүүтгэсэн гэдгийг нотолж өгдөг боловч зөвхөн тухайн хүний бичигтэй харьцуулан бичгийн хэвийн шинжилгээ хийх, амиа хорлогчийн цахим эрхээр нэвтэрсэн байгаагаар шууд хэргийг амиа хорлолт хэмээн тогтоож, хааж байгаа нь санамсаргүйгээр нуугдмал гэмт хэргийг хөхүүлэн дэмжиж буй явдал юм. Тиймээс бичгийн хэвийн адилтгалын шинжилгээгээр гэрээслэл, захидлыг нас барахаас өмнөх бичгийн хэвтэй нь харьцуулахаас гадна бичгийн зохиогчийг магадлах шинжилгээгээр тухайн хүн өөрөө зохиосон эсэхийг давхар нотлох, боловсрол, нас, хүйс, сэтгэлзүй, сэтгэцийн байдлыг тогтоох практик шаардлага бий болж байна.

Санаагаа бичгээр илэрхийлж, хол газар үг хэлээ дамжуулах болсон нь хүн төрөлхтний оюун ухааны асар том ололт юм. Эрт цагт санаа бодлоо илэрхийлэх эрмэлзлийн анхных нь дээс зангидах, модонд хэрчлээс гаргах, сүг дүрс зурах тэргүүтэн болзмол тэмдэг байжээ. Хэл гэдэг орон зай хийгээд цаг хугацаа давхцаж байх үед, харьцангуй хязгаарлагдмал нөхцөлд харилцааны хэрэглүүр болох үүргээ биелүүлж чаддаг байсан бөгөөд хөгжлийн явцад энэхүү орон зайн хамаарал, цаг хугацааны эрхшээлээс гэтлэн мэдээлэл дамжуулах зайлшгүй шаардлага тулгарсан бөгөөд үүний шийдэл нь бичиг үсэг юм.

Бичгийн хэл гэдэг нь бичгийн агуулга түүнийг илэрхийлэх найруулга зүй бичиг мэдэх түвшин, үгийн бүрэлдэхүүн зэрэг хэлний хэрэгсэл юм. Агуулга зүй нь бичгийн хэлний шинжээр илэрдэг.

Бичгийн хэл нь дараах зүй тогтолтой: Бичгийн хэл бүрэлдэх, төлөвших, өөрчлөгдөх.

Бүрэлдэх зүй тогтол: Хэрэгцээ нь бие махбодыг гадаад орчинтой холбох болон бие махбодын өөрөө оршин тогтнох хөгжиж байх үндэс нь болсон зайлшгүй чухал өвөрмөц зүйл юм¹⁷⁴. Биологийн, оюуны, нийгмийн гэсэн хэрэгцээнүүд байдаг.

Бичиг үсэг нь анх мэдээллийг хадгалж авч үлдээх, мөн түүнийг дамжуулах зорилготойгоор үүсч бий болсон бөгөөд хөгжлийнхөө явцад хүний оюуны болон нийгмийн хэрэгцээг хангах чухал хэрэглүүр болжээ. Бичээсийн гол зорилго нь яриаг мэдэгдэхүйц зайнаас дамжуулж, цаг хугацаанд нь нэгтгэж үлдээх явдал юм. Эдгээр зорилгыг гүйцэлдүүлэхийн тулд тусгай зураасан тэмдэг эсвэл дүрсийг ашиглаж үг, үсэг, дуу авиаг дамжуулдаг.

Бичгийн хэл нь бичгийн хэв бүрэлдэж, төлөвшиж эхлэх үед, бичиж байгаа зүйлийнхээ хэлбэрт бус агуулгад хандуулж эхэлснээр бүрэлдэж эхэлдэг. Ингэснээр хүн өөрийн бичиж буй зүйлийнхээ агуулга, утга, дэс дараалал санааг хэрхэн тусгах тухай бодож бичигтээ тусгаж эхэлдэг.

Төлөвших зүй тогтол: Олон удаагийн давтамж, удаан хугацааны дадал болсны үр дүнд бичгийн процесс нь автоматжисны улмаас хүний бичих ур чадвар тогтвортой болж, агуулгаа өөрчлөх санаатай оролдлого ч эерэг үр дүнд хүргэхгүй.

Бичгийн хэлний дадал төлөвшихөд тухайн хүний нас, боловсрол, мэргэжил, эрхэлж буй ажил, оюуны чадвар, бүтээлч сэтгэлгээ ихээхэн нөлөө үзүүлдэг бөгөөд 16-25 насанд бүрэн төлөвшдөг.

Өөрчлөгдөх зүй тогтол: Хүний бичгийн хэлний болон хэвийн шинж тэмдэг маш аажимдаа сайжирч, муудаж өөрчлөгддөг ба энэ хугацаанд боловсрол, ажил мэргэжил, өвчин эмгэг гэх мэт олон төрлийн шалтгаанууд нөлөөлдөг.

Орчин үеийн шинжлэх магадлах ухааны онол, шүүхийн шинжилгээний практик янз бүрийн шинжлэх ухааны (хэл шинжлэл, сэтгэц судлал, сэтгэл судлал, социологи

¹⁷⁴ <https://www.slideshare.net/otgonubuns/3-deed-medrel-chuhual>.

болон бусад) мэдлэгээс авч ашигласан зохиогчийг магадлах шинжилгээний шинжлэх ухааны үндэс болж чадахуйц, шүүхэд нотлох баримт болох баримтыг баттай тогтооход гарцаагүй шаардлагатай нэгдмэл онол бүрэлдүүлэхийг шургуу шаардаж байгаа хэдий ч энэ талаар бичиж туурвисан бүтээл ховор, онолын нэгдсэн үзэл баримтлал байхгүй байна.

Бичгийн болон ярианы хэл шинжлэх, бичиг баримт болон мэдээлэл-эрх зүйн маргаан, нэргүй захидал, маргаантай болон зохиомол бичигтэй холбоотой шүүхийн процессыг мэргэжлийн түвшинд хөтлөн явуулах амин чухал шаардлагыг ч дурдалгүй өнгөрч болохгүй. Шинжилгээний практикт ийм хэргийн тоо өсөж байгаа нь шүүхийн системийн ардчилал, шүүхийн процессын маргаант шинж өсөн нэмэгдэж байгаа, хэл шинжлэлийн мэдлэг улам тэлсээр байгаа, мэдээллийн суваг өргөжин тэлж байгаа, хэрэглэгчдийн тоо, нийгмийн хүрээ мөн өсөн нэмэгдэж байгаа зэрэгтэй холбоотой.

Манай орны хувьд бичгийн хэл буюу бичгийн зохиогчийг магадлах талаар хууль зүйн докторын зэрэг хамгаалсан С.Бадарчи¹⁷⁵ Ж.Хурцгэрэл¹⁷⁶, Бө.Бат-Эрдэнэ¹⁷⁷, Б.Лхагвасүрэн¹⁷⁸ нарын нэг сэдэвт бүтээлүүдэд дурдагдсан байна.

ОХУ-д ярианы хэлний шинжээр зохиогчийг магадлах анхны шүүх шинжилгээ хийсэн тохиолдол 1886 онд бүртгэгдсэн бөгөөд зохиогчийн бичгийн хэлний шинж тэмдгүүдийн адилтгалын ба оношилгооны ач холбогдол, бодит үнэт зүйл, бие даасан ач холбогдлыг гарган боловсруулахаар олон эрдэмтэн удаан хугацааны туршид хөдөлмөрлөсөн бөгөөд үүнд В.Н. Белов, В.К. Войнов, С.М. Вул¹⁷⁹, Е.И. Галыгина, Т.В. Гомон¹⁸⁰, Е.И. Горошко¹⁸¹, А.Ю. Комиссаров¹⁸² нарын бүтээл зүй ёсоор тооцогддог.

ОХУ-д бичгийн зохиогчийг магадлах шинжилгээг олон субъект оролцсон, олон үе шатаас бүрдсэн, бичгийн хэлтэй ажиллах ажиллагаа гэж ойлгодог ба эрүүгийн, иргэний, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бичиг баримт, эсвэл эд мөрийн баримт гэж тооцогдож нилээд ач холбогдол агуулдаг.

Бичгийн зохиогчийг магадлах шинжилгээний арга зүйн үндэс нь хэл шинжлэлтэй хавсардаг бөгөөд шинжилгээ хийж буй шинжээчийн ажил криминалистик, шинжлэн магадлах ухаан, шүүх зохиогч судлал, хэл шинжлэлийн статистик, хэл шинжлэл, сэтгэц судлал-хэл шинжлэл, сэтгэл судлал зэрэг салбарын онолын үзэл баримтлал ба туршилтын судалгааны үр дүн, түүнчлэн шүүх шинжилгээний практикийн судалгаа, хэрэглээнд үндэслэсэн баримт материалуудад суурилдаг.

Бичгийн зохиогчийг магадлах орчин үеийн шинжилгээний үндэс болж буй онолын үндсэн үзэл баримтлал нь дараах зүйлд оршиж байна. Үүнд:

-бичиг зохиох үйл ажиллагаа нь зохиогчид яриа-сэтгэхүйн дадал бүрэлдэхэд болон түүнийг хэрэгжүүлэх механизмд оюуны ажил үүргийн тусгай цогцолбор үүсэхэд нөлөөлдөг;

-бичгийн зохиогчийг магадлах шинжилгээний зорилтыг шийдвэрлэх чухал мөн чанаруудын илэрхийлэгч болдог (тухайлбал: адилтгалын ба оношилгооны шинж тэмдгүүдийн нэр томъёонд тусгагдан илэрсэн байж болох давтагдашгүй шинж, харьцангуй тогтвортой, хувилбартай шинж);

¹⁷⁵ Бадарчи, С. Криминалистикийн бичиг судлал. УБ. 1998.

¹⁷⁶ Хурцгэрэл, Ж. Криминалистик-1. УБ. 2002.

¹⁷⁷ Бат-Эрдэнэ, Б. Криминалистик. УБ. 2003.

¹⁷⁸ Лхагвасүрэн, Б. "Криминалистикийн шинжилгээ судлал". УБ. 2010.

¹⁷⁹ Вул С.М. Теоретические и методические вопросы криминалистического исследования письменной речи. — М., 1977.

¹⁸⁰ Гомон Т.В. Судебно-автороведческая экспертиза текстов документов, составленных с намеренным искажением письменной речи. Автореф. дисс. канд. юрид. наук. - М., 1992. С.77.

¹⁸¹ Вул С. М., Горошко Е. И. Судебно - автороведческая классификационная диагностика: установление половой принадлежности автора документа // Современные достижения науки и техники в борьбе с преступностью. Материалы научно-практической конференции. Минск. 1992. С.156.

¹⁸² Комиссаров А.Ю. Криминалистическое исследование письменной речи. — М.: ЭКЦ МВД России, 2000.

-Бичгийн зохиогчийг магадлах шинжилгээний хүрээнд адилтгалын ба оношилгооны төрөл бүрийн асуулт тогтоодог;

-Бичгийн зохиогчийг магадлах шинжилгээнд дараах бичвэрүүд янз бүрийн хэлбэрээр орж ирэн объект нь болдог. Үүнд:

1. гар бичмэл;
2. бичгийн машинаар гүйцэтгэсэн;
3. полиграф аргаар ба олшруулах техник ашиглан үйлдсэн;
4. Интернет сайтад байрласан электрон баримтууд.

Дээр дурдсан төрөл бүрийн бичгийн зохиогчийг магадлах үед адилтгалын хийгээд оношилгооны шинжилгээ хийхэд тулгамдаж буй онолын болон арга зүйн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай байна.

Дүгнэлт

Бичиг судлалын шинжилгээний арга зүйг боловсронгуй болгох, сайжруулах хэрэгцээ байгаа бөгөөд Монгол Улсын хувьд бичгийн гүйцэтгэгчийг магадлах шинжилгээний арга зүй боловсруулагдаж, хөгжлийнхээ тодорхой түвшинд хүрсэн байна. Харин бичгийн хэлний шинж тэмдгийг ашиглаж, шинжлэн магадлаж, хэрэгт ач холбогдолтой нотлох баримт гаргаж өгдөг бичгийн зохиогчийг магадлах шинжилгээний онолын үндэс, шинжилгээний арга зүй манай улсад хараахан төлөвшиж бий болоогүй байна.

Мөн шинжилгээ томилох эрх бүхий этгээдүүдэд бичгийн зохиогчийг магадлах шинжилгээ хийлгэх практик шаардлага үүсдэг боловч шинжилгээний онол, арга зүй нь байхгүйн улмаас шийдвэрлүүлж чадахгүй, энэ төрлийн шинжилгээний талаарх мэдлэг тааруу байна.

Бичгийн хэвийн адилтгалын шинжилгээгээр гэрээслэл, захидлыг нас барахаас өмнөх бичгийн хэвтэй нь харьцуулахаас гадна бичгийн зохиогчийг магадлах шинжилгээгээр тухайн хүн өөрөө зохиосон эсэхийг давхар нотлох, боловсрол, нас, хүйс, сэтгэлзүй, сэтгэцийн байдлыг тогтоох шаардлагатай байна.

Орчин үеийн шинжлэх магадлах ухааны онол, шүүхийн шинжилгээний практик янз бүрийн шинжлэх ухааны (хэл шинжлэл, сэтгэц судлал, сэтгэл судлал, социологи болон бусад) мэдлэгээс авч ашигласан зохиогчийг магадлах шинжилгээний шинжлэх ухааны үндэс болж чадахуйц, шүүхэд нотлох баримт болох баримтыг баттай тогтооход гарцаагүй шаардлагатай нэгдмэл онол бүрэлдүүлэхийг шургуу шаардаж байгаа хэдий ч энэ талаар бичиж туурвисан бүтээл ховор, онолын нэгдсэн үзэл баримтлал байхгүй байна.

Санал

Олон Улс болон Монгол Улсын хувьд бичгийн хэвэнд хийх шинжилгээний арга зүй боловсруулагдаж, хөгжлийнхээ тодорхой түвшинд хүрсэн байна. Харин бичгийн хэлний шинж тэмдгийг ашиглаж, шинжлэн магадлаж, хэрэгт ач холбогдолтой нотлох баримт гаргаж өгдөг зохиогч судлалын онолын үндэс, шинжилгээний арга зүй манай улсад хараахан төлөвшиж бий болоогүй байна. Тиймээс бичгийн зохиогчийг магадлах шинжилгээний онол, арга зүйн асуудлыг судлах санал дэвшүүлж байна.

Ашигласан материал

1. Бадарчи, С. Криминалистикийн бичиг судлал. УБ. 1998.
2. Бат-Эрдэнэ, Б. Криминалистик. УБ. 2003.
3. Лхагвасүрэн, Б. “Криминалистикийн шинжилгээ судлал”. УБ. 2010.
4. Хурцгэрэл, Ж. Криминалистик-1. УБ. 2002.
5. Эрдэнэжаргал, М., Баясгалан, Ц., Пүрэвсүрэн, Ж. Бичиг судлалын шинжээчийн ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл. УБ. 2022. 3 дугаар улирал.

Гадаад эх сурвалж

6. Вул С.М. Теоретические и методические вопросы криминалистического исследования письменной речи. — М., 1977.

7. Гомон Т.В. Судебно-автороведческая экспертиза текстов документов, составленных с намеренным искажением письменной речи. Автореф. дисс. канд. юрид. наук. - М., 1992. С.77.

8. Вул С. М., Горошко Е. И. Судебно - автороведческая классификационная диагностика: установление половой принадлежности автора документа // Современные достижения науки и техники в борьбе с преступностью. Материалы научно-практической конференции. Минск. 1992. С.156.

9. Комиссаров А.Ю. Криминалистическое исследование письменной речи. — М.: ЭКЦ МВД России, 2000.

Интернет эх сурвалж

10. <https://apps.who.int/gho/data/view.main.MHSUICIDEASDRv?lang=en>.

11. <https://www.slideshare.net/otgonubuns/3-deed-medrel-chuhual>.

ЭРДЭМТЭН, СУДЛААЧДЫН ҮЗЭЛ БОДОЛ

ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ХУУЛЬ ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН ЭРХ ЗҮЙН ҮР ДАГАВАР

LEGAL CONSEQUENCES OF LEGAL RESPONSIBILITY ON CIVIL SERVICE

Н.Мөнхзул

ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Munkhzul N.

University of Internal Affairs of Mongolia, Law and Social sciences school, Dean of Public law department, Doctor (Ph.D)

Хураангуй: Төрийн албан дахь хууль зүйн хариуцлагын төрөл, тэдгээрээс үүсэх эрх зүйн үр дагаврыг хууль зүйн хариуцлагын мөн чанарт уялдуулан зохицуулсан байдлыг судалж, харьцуулан шинжилгээ хийж, Төрийн албаны хууль дахь “сахилгын шийтгэлтэй” байдлын зохицуулалт нь төрийн тусгай албаны зарим салбарын дүрэм, журмаар сөрөг үр дагавар үүсгэж байгааг тогтоож, энэ нь хүний эрхийг зөрчиж, хууль зүйн хариуцлагын зарчимд нийцэхгүй байх тул өөрчлөх санал дэвшүүлээ.

Abstract: This paper briefly compared and analyzed the types of legal responsibility of the civil service and the legal consequences in accordance with the essence of legal liability and proposed to change the regulation “with disciplinary liability” is causing adverse consequences and human rights incompatible with the principles of legal liability.

Түлхүүр үгс: Захиргааны хариуцлага, сахилгын хариуцлага, сахилгын шийтгэл, сахилгын шийтгэлтэй байдал, хохирол нөхөн төлөх хариуцлага, хууль зүйн хариуцлага, шударга ёсны зарчим, эд хөрөнгийн хариуцлага, эрүүгийн хариуцлага, ялтай байдал.

Keywords: The concept of administrative responsibility, disciplinary responsibility, disciplinary sanctions, liability for compensation of damages, legal responsibility, principles of Justice, property responsibility, criminal responsibility and conviction.

Хууль зүйн хариуцлагын ойлголт, мөн чанар: Хууль зүйн хариуцлагыг үүргийн ухамсар, үүргийн мэдрэмж, хууль зүйн дагуу үйл ажиллагаа явуулах үүрэг болон тухайн үүргийн хэрэгжилт гэсэн хууль зүйн сөрөг үр дагавар үүсгэхгүй байх хариуцлага; санкцийн хэрэгжилт, төрийн албадлагын арга хэмжээ, ял (шийтгэл), эрх зүйн зөрчилд нийгмээс үзүүлэх хариу үйлдэл, эрх зүйн зөрчлөөс урган гарсан хууль зүйн үүрэг, албадлагын нөлөөллийн арга хэмжээг хүлээх чадвар, нийгэмд аюултай үзэгдэлд өгөх үнэлэмж болон түүнийг үйлдсэн этгээдийг буруутгах хэлбэр буюу эрх зүй зөрчсөний үр дагавар гэсэн өргөн агуулгын хүрээнд авч үзэх нь зүйтэй байдаг¹⁸³.

Хууль зүйн хариуцлагыг ийнхүү өргөн агуулгаар тодорхойлох шаардлага нь түүний мөн чанараас урган гарч байгаа бөгөөд энэ нь түүний шинж, зорилго, зарчмаар илэрхийлэгддэг. Эрх зүйн онол ёсоор хууль зүйн хариуцлагын шинжийг: а) төрийн албадлагатай нягт холбоотой байх. Төрийн албадлага нь хууль зүйн хариуцлагын агуулгыг илэрхийлэх бөгөөд төрийн нэрийн өмнөөс хэрэгждэг. Ийм учраас энэ нь нэг талаас төрийн албадлага, нөгөө талаас эрх зүйн шинжийг илэрхийлнэ. б) хууль зүйн хариуцлага нь нэг талаас цээрлүүлэх, нөгөө талаас зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх гэсэн хоёр зорилгыг агуулах. в) хууль зүйн

¹⁸³ Мөнхзул, Н. Төрийн тусгай албан хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага. УБ. 2019. 16 дахь тал.

хариуцлагыг зөвхөн эрх зүйн зөрчил гаргасан нөхцөлд хэрэглэх¹⁸⁴ гэж тодорхойлсноос үзвэл, зөвхөн негатив хандлагаар авч үзсэнийг харуулж байна.

Тиймээс ч хууль зүйн хариуцлага нь эрх зүйн хамгаалах чиг үүргийн хүрээнд хэрэгжих ба эрх зүйн зөрчил гарсан тухай хууль зүйн фактад түшиглэн хууль буюу эрх зүйн хэм хэмжээг зөрчсөний төлөө гэм буруутай этгээдэд эрхийг нь хязгаарлах буюу цээрлэл үзүүлэх замаар оногдуулж байгаа төрийн албадлага, нөлөөллийн арга хэмжээний цогц¹⁸⁵ хэмээн тодорхойлсон байна.

Хууль зүйн хариуцлага нь эрх зүйн салбарын онцлогийг үл харгалзан эрх зүйн дэг журмыг хамгаалах, хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх, цээрлүүлэх зэрэг зорилгыг агуулах бөгөөд энэ нь тухайн нийгмийн хөгжил, үзэл суртал, эрх зүйн үнэт зүйлийн баримжааллаас хамаарч түүхэн цаг үеүдэд өөрчлөгдөн хувьсаж ирсэн нь хууль зүйн хариуцлагын мөн чанарыг өөр өөрөөр илэрхийлэх үндэс болж ирсэн байдаг¹⁸⁶.

Хууль зүйн хариуцлагын мөн чанарыг илэрхийлэгч дараагийн нэг шалгуур нь түүний зарчим байна. Хууль зүйн хариуцлагын зарчим нь:

- Зөвхөн эрх зүй зөрчсөн зан үйлд хариуцлага хүлээлгэх зарчим. Энэ зарчим нь хуульд заагаагүй бол эрх зүйн зөрчил болон ял, шийтгэл гэж байхгүй, нөгөө талаар хүний юу санаж бодож байгаад нь биш зөвхөн бодит үйлдэл, эс үйлдэлд л хариуцлага хүлээлгэх гэсэн агуулгаар тодорхойлогдоно¹⁸⁷.

- Гэм буруугүйд тооцох зарчим. Энэ зарчим нь “гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно”¹⁸⁸сгэсэн агуулгаар тодорхойлогдоно.

- Шударга ёсны зарчим. Энэ зарчмын агуулга нь гэмт хэргийн бус зөрчилд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх, ял шийтгэл нь хүний нэр алдрыг гутаах, бие махбодийг тарчлаан зовоохгүй байх, хариуцлага нь зөрчлийн хүнд, хөнгөнд тохирсон байх, ял шийтгэх болсон буюу хариуцлага хүндэрсэн хуулийг буцаан хэрэглэхгүйбайх, учирсан гэм хор сэргээгдэх шинжтэй бол түүнийг заавал арилгах зэрэг шаардлагуудаар илэрхийлэгдэнэ. Түүнчлэн эрх зүйг зөрчсөн нэг зөрчлийн төлөө хоёр удаа хариуцлага хүлээлгэж болохгүй бөгөөд нэг зөрчилд нэг л удаа хариуцлага хүлээлгэх, зөрчил гаргагчдад авах нөлөөллийн арга хэмжээ нь хууль зүйн хариуцлагын зорилгод нийцсэн байх ёстой гэсэн шаардлагаар илэрхийлэгдэнэ.

- Хууль дээдлэх зарчим. Энэ зарчмын агуулга нь хариуцлагыг зөвхөн хуульд заагдсан гэм бурууд хүлээлгэх, хариуцлага хүлээлгэх үйл явц нь байцаан шийтгэх ажиллагааны хууль зүйн шаардлагыг хангасан байх, эрх зүйг зөрчсөн факт бүрэн дүүрэн нотлогдсон байх, хууль зүйн хариуцлага тогтоож байгаа хууль нь Үндсэн хуулийн шаардлагад нийцсэн байх зэргээр тодорхойлогдоно.

- Ялгавартай хандах зарчим. Энэ зарчим ньэрх зүй зөрчсөн этгээдийнзөрчлийн ба хувийн байдлыг харгалзан хариуцлага хүлээлгэх, ял зэмлэлийг зөвхөн өөрөө хүлээх, гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглох, хууль зүйн хариуцлагын зорилго өөр арга замаар хангагдсан тохиолдолд хариуцлагаас чөлөөлөх, эсвэл хөнгөрүүлэх зэрэг шаардлагуудаар хангагдана.

- Хууль зүйн хариуцлага эргэлт буцалтгүй байх зарчим. Төрийн хараанаас эрх зүйн нэг ч зөрчил мултрах ёсгүй. Хариуцлагын арга хэмжээ цаг үеэ олсон шуурхай байх, хууль хамгаалах байгууллагын ажилтнуудын мэргэшлийн ур чадвар өндөр түвшинд байх, хууль зүйн хариуцлагын арга хэмжээ үр нөлөөтэй байх гэсэн

¹⁸⁴ Нямсүрэн, Ч. Эрх зүйн ерөнхий онол: үндсэн ойлголт, тулгамдсан асуудал. УБ. 2010. 395 дахь тал.

¹⁸⁵ Мөн тэнд.

¹⁸⁶ Тухайлбал, Монгол улсын хууль тогтоомжийн түүхэн хөгжлөөс харвал цээрлүүлэх буюу хүмүүжүүлэх зорилгыг хангахад чиглэгдэж ирсэн бол нэн шинэ үеийн эрх зүйн эх сурвалжуудад эрх зүйн дэг журмыг хамгаалах буюу нөлөөлөл үзүүлэх зорилгыг хангахад чиглэгдэж байна. Н.Мөнхзул. Төрийн тусгай албан хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага. УБ. 2019. 29-54 дэх тал.

¹⁸⁷ Энэ хоёр зарчим нь анх Францын иргэний ба хүний эрхийн Тунхаглалын 7, 8 дугаар зүйлд тусгалаа олжээ.

¹⁸⁸ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. УБ. 1992. №1.

шаардлагаар уг зарчим нь хангагдана. Хариуцлага хүнд, хөнгөндөө биш харин зайлшгүй хүлээлгэдэг байхыг хэлнэ. Гэхдээ тухайн нөхцөл байдлыг харгалзан хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэх явдлыг үгүйсгэж болохгүй юм.

Төрийн албан дахь хууль зүйн хариуцлагын төрөл, хууль зүйн хариуцлагын үр дагавар

Үүрэг зөрчсөний төлөө хүлээх хариуцлага буюу негатив утгаар нь авч үзвэл хууль зүйн хариуцлагын тогтолцоотой¹⁸⁹ нягт уялдах бөгөөд түүний дагуу төрийн албан дахь хууль зүйн хариуцлага нь эрүүгийн хариуцлага; захиргааны хариуцлага; хохирол нөхөн төлөх хариуцлага; эд хөрөнгийн хариуцлага; сахилгын хариуцлага гэсэн төрөлтэй байна.

Эрүүгийн хариуцлага. Монгол Улсын Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулиар зохицуулах бөгөөд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар¹⁹⁰ нийт зуу гаруй гэмт хэргийн сУБъектээр төрийн албан хаагч байхаар хуульчилж өгсөн байна. Түүнд оногдуулах ялын тухайд зорчих эрхийг хязгаарлах, хорих, торгох зэрэг үндсэн, эрх хасах¹⁹¹ нэмэгдэл шийтгэлийг оногдуулахаар заасан.

Хүснэгт №1. Эрүүгийн хариуцлагын зорилгын талаарх 2002, 2015 оны Эрүүгийн хуулиудын харьцуулалт

Эрүүгийн хариуцлагын зорилго ¹⁹² (2002 оны Эрүүгийн хуулийн үзэл баримтлал)	Эрүүгийн хариуцлагын зорилго ¹⁹³ (2015 оны Эрүүгийн хуулийн үзэл баримтлал)
- <u>Иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах,</u> - Гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, - Гэмт хэрэг үйлдсэн <u>этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх,</u> - Гэмт хэрэг <u>үйлдэхээс урьдчилан сэргийлэх.</u>	- Гэмт хэрэг үйлдсэн <u>хүн, хуулийн этгээдийг</u> цээрлүүлэх, - гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, - <u>хохирлыг нөхөн төлүүлэх,</u> - гэмт хэргээс <u>урьдчилан сэргийлэх,</u> гэмт хэрэг үйлдсэн хүнийг <u>нийгэмшүүлэх.</u>

Эрүүгийн хариуцлагын зорилготой уялдуулан эрүүгийн хариуцлагын хэмжээ хязгаар гэсэн ойлголтын хүрээнд эрүүгийн хариуцлага нь сУБъектүүд эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлсэн ялтан ялаа эдэлж, ялгүй болсноор дуусгавар болно¹⁹⁴ гэснээс үзвэл эрүүгийн хариуцлагын үр дагавар нь “ялтай байдал”¹⁹⁵ хэмээх ойлголт юм. Ялтан ялаа эдэлж дууссаны дараа тодорхой хугацаанд зарим эрхийн хязгаарлалт, тааламжгүй үр дагаврыг амсах, эдлэх шаардлагатай болдог ба энэ нь 2002 оны Эрүүгийн хуульд зааснаар ял хүндрүүлэх нөхцөл байдал¹⁹⁶ болохоос гадна хугацаанаас өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэх боломжийг хязгаарлах¹⁹⁷, хорих ял

¹⁸⁹ Нямсүрэн, Ч. Эрх зүйн ерөнхий онол: Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал. УБ. 2010. 397 дахь тал.

¹⁹⁰ Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга). Төрийн мэдээлэл. УБ. 2016. №7.

¹⁹¹ Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-ийн 5.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хориглохыг эрх хасах ял гэнэ”, 2 дахь хэсэгт “Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ялыг оногдуулж болно” гэж заасан байна. Төрийн мэдээлэл. УБ., 2016. №7.

¹⁹² Жанцан, С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (ерөнхий ба тусгай анги). УБ., 2012. 32 дахь тал.

¹⁹³ Гантөмөр, Г. нар. Эрүүгийн эрх зүй: ерөнхий анги. УБ., 2020. 359 дэх тал.

¹⁹⁴ Жанцан, С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (ерөнхий ба тусгай анги). УБ., 2012. 33 дахь тал.

¹⁹⁵ 2002 оны Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 78.1. Ялтан шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн түүнийг ялгүйд тооцох буюу ялгүй болох хүртэл хугацаанд ялтайд тооцогдоно.

¹⁹⁶ 2002 оны Эрүүгийн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.12 дахь хэсэгт “..., эсхүл ялтай байхдаа гэмт хэрэг дахин үйлдсэн” бол ял хүндрүүлэхээр заасан байна. Мөн 451.2.3

¹⁹⁷ 2002 оны Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэгт тэнсэх журмыг ялтай байгаа этгээдэд хэрэглэхгүй гэж заасан.

эдлэх байгууллагын дэглэм тодорхойлоход нөлөөлөх¹⁹⁸, ял оногдуулахад харгалзах шүүгдэгчийн хувийн байдалд хамаарах¹⁹⁹ зэрэг хууль зүйн үр дагаврыг тодорхойлж өгсөн байсан.

Тухайн этгээд тэнсэж хянан харгалзсан, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй; хөнгөн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд ялаа эдэлж дууссанаас хойш нэг жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй; хүндэвтэр гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд үндсэн ба нэмэгдэл ялаа эдэлж дууссанаас хойш таван жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй; хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд үндсэн ба нэмэгдэл ялаа эдэлж дууссанаас хойш найман жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй; онц хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд буюу онц аюултай гэмт хэрэгтэн үндсэн ба нэмэгдэл ялаа эдэлж дууссанаас хойш арван жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй бол ялгүй болох зохицуулалттай байсан. Харин ял шийтгүүлсэн этгээд үндсэн ба нэмэгдэл ялаа эдэлж дууссаны дараа зан байдал, засрал хүмүүжлээрээ үлгэр жишээч байвал шүүх хугацаанаас нь өмнө ялгүйд тооцож болох зохицуулалттай байжээ.

Харин одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2015 оны Эрүүгийн хуулиар “ялтай байдал”, “онц аюултай гэмт хэрэгтэн”, “давтан” гэх мэт хууль зүйн үр дагавар үүсгэж, гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулсан, зохицуулалтыг хүчингүй болгосон нь хүний эрхийн зарчим, хууль зүйн хариуцлагын мөн чанарт (хууль ёсны зарчим, шударга ёсны зарчим, ялгавартай хандах зарчим) тохирсон дэвшилтэт зохицуулалт болсон.

Энэ агуулгаар Төрийн албаны тухай хуулийн²⁰⁰ төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах нийтлэг шаардлагад “22.1.3.Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх;” гэж зааснаас харвал төрийн жинхэнэ албанд бусад төрлийн гэмт хэргээр ял шийтгүүлсэн этгээд орох боломжтойг илэрхийлж байна, нөгөө талаас хууль зүйн хариуцлагын нэг зөрчилд нэг л шийтгүүлэх шударга ёсны зарчмыг хангах зохицуулалт болжээ.

Хүснэгт №2. Төрийн албаны тухай хуулиудын харьцуулалт

1994 оны Төрийн албаны тухай хууль	2002 оны Төрийн албаны тухай хууль	2017 оны Төрийн албаны тухай хууль
16 дугаар зүйл. Төрийн захиргааны албан тушаал эрхлэх болзол	16 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол	22 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг шаардлага
2.Төрийн захиргааны албан тушаалд дараахь тохиолдолд авч ажиллуулахыг хориглоно: 1/Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн, эсхүл бусад төрлийн гэмт хэрэг үйлдэж	16.2.Төрийн жинхэнэ албан тушаалд дараахь тохиолдолд авч ажиллуулахыг хориглоно: 16.2.1.хуульд өөрөөр заагаагүй бол Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн, эсхүл бусад	22.1.3.Эрүүгийн хуульд заасан <u>авлига, албан тушаалын гэмт хэрэг</u> үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх;

¹⁹⁸ 2002 оны Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэг “Хүнд гэмт хэрэг үйлдсэн, эсхүл урьд нь хорих ял эдэлж байсан, анх удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтны хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ”.

¹⁹⁹ 2002 оны Эрүүгийн хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсэгт “Шүүх ял оногдуулахдаа гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хор уршгийн шинж чанар, хохирлын хэр хэмжээ, хариуцлагыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзнэ”.

²⁰⁰ Төрийн захиргааны алба, төрийн тусгай албыг төрийн жинхэнэ алба гэнэ. Төрийн албаны тухай хуулийн 6.2. 2017. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=13025>.

шүүхээр ял шийтгүүлээд <u>ял шийтгэлгүйд тооцогдох хугацаа нь дуусаагүй бол;</u> <u>2/төрийн захиргааны албан тушаалаас сахилгын шийтгэлээр халагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрөөгүй бол;</u>	төрлийн гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлээд <u>ялгүйд тооцох буюу ялгүй болох хугацаа нь дуусаагүй;</u> <u>16.2.2.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалаас сахилгын шийтгэлээр халагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрөөгүй;</u>	23 дугаар зүйл. Төрийн албан тушаалд тавих тусгай шаардлага 23.1.Төрийн улс төрийн болон тусгай албан тушаалд тавих тусгай шаардлагыг холбогдох хуулиар тогтооно. 23.2.Хуульд өөрөөр заагаагүй бол доор дурдсан төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 22.1-д заасан нийтлэг шаардлагаас гадна дараахь тусгай шаардлагыг хангасан иргэнийг томилно:
--	--	---

Нөгөө талаар Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Төрийн улс төрийн болон тусгай албан тушаалд тавих тусгай шаардлагыг холбогдох хуулиар тогтооно” гэж заасны дагуу төрийн тусгай албаны “гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх” тусгай шаардлагыг харьцуулан үзвэл:

Хүснэгт №3. Эрх зүйн баримт бичгүүдийн харьцуулалт

Эрх зүйн акт	Холбогдох заалт
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай ²⁰¹	4 дүгээр зүйл.Цэцийн гишүүн 1.Цэцийн гишүүн хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, эрүүгийн ял шийтгэлгүй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэн байх ба Цэцийн гишүүд эрх тэгш байна.
Шүүхийн тухай ²⁰²	31 дүгээр зүйл.Шүүгчид тавих болзол, шаардлага 31.1.1.эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй;
Прокурорын тухай ²⁰³	45 дугаар зүйл.Прокурор 45.1.... гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдож байгаагүй, ... Монгол Улсын иргэнийг прокуророор томилно.
Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай ²⁰⁴	6 дугаар зүйл. Зөвлөлийн зохион байгуулалтын бүтэц 6.2.Зөвлөлийн нарийн бичгийн даргыг Монгол Улсын Ерөнхийлөгч томилно. Хуульд тусгайлан шаардлага тавиагүй.
Төв банк /монгол банк/-ны тухай ²⁰⁵	26 дугаар зүйл. Монгол банкны удирдлага 3. Монгол банкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг томилохдоо түүний эдийн засаг, банк, санхүү, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвар, мэргэжлийн ёс зүй, ажлын

²⁰¹ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай. 1992. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=365>.

²⁰² Шүүхийн тухай хууль. 2021. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106892006021>.

²⁰³ Прокурорын тухай. 2017. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12702>.

²⁰⁴ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай. 1992. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=9546>.

²⁰⁵ Төв банк/монголбанк/-ны тухай. 1996. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=483>.

		туршлагыг харгалзана. Хуульд тусгайлан шаардлага тавиагүй.
	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай ²⁰⁶	11 дүгээр зүйл.Хорооны дарга, гишүүн, түүнийг томилох 11.6.Хорооны дарга, гишүүн нь эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, ял шийтгүүлж байгаагүй, Монгол Улсын иргэн байна.
	Статистикийн тухай ²⁰⁷	13 ¹ дүгээр зүйл.Үндэсний статистикийн хорооны удирдлага 13 ¹ .2.Үндэсний статистикийн хорооны дарга, дэд даргыг томилохдоо түүний эдийн засаг, статистик, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвар, мэргэжлийн ёс зүй, ажлын туршлагыг харгалзана. Хуульд тусгайлан шаардлага тавиагүй.
	Сонгуулийн төв байгууллагын тухай ²⁰⁸	4 дүгээр зүйл.Хорооны гишүүнд нэр дэвшүүлэх, томилох журам 4.2.Хорооны гишүүний тавыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, хоёрыг Монгол Улсын Ерөнхийлөгч, хоёрыг Улсын дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонгол хийж зургаан жилийн хугацаагаар томилно. Харилцан адилгүй шаардлага тавигдахаар байна.
	Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай ²⁰⁹	2 дугаар зүйл.Комиссын гишүүнд нэр дэвшүүлэх, томилох 12.2.Комиссын гишүүнд нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан 35 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна: 12.2.1.хууль зүйн өндөр мэргэшилтэй; 12.2.2.хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилласан туршлагатай. Хуульд тусгайлан шаардлага тавиагүй.
	Монгол Улсын шүүхийн тухай ²¹⁰	76 дугаар зүйл.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа 76.3. ... шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүн нь ... эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна. 95 дугаар зүйл.Сахилгын хороо 95.3. ... шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүн нь ... эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна.
	Төрийн аудитын тухай ²¹¹	26 дугаар зүйл.Төрийн аудитын байгууллагын албан хаагчид тавих шаардлага 26.1.Төрийн аудитын байгууллагын албан

²⁰⁶ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай. 2005. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=446>.

²⁰⁷ Статистикийн тухай. 1997. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=461>.

²⁰⁸ Сонгуулийн төв байгууллагын тухай. 2006. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=459>.

²⁰⁹ Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай. 2020. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15152>.

²¹⁰ Монгол Улсын шүүхийн тухай. 2021. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106892006021>.

²¹¹ Төрийн аудитын тухай. 2020. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15357>.

		хаагчаар Төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан хаагчид тавих нийтлэг шаардлагыг хангасан, төрийн аудитын байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшсэн иргэнийг ажиллуулна.
	Авлигын эсрэг хууль ²¹²	19 дүгээр зүйл. Авлигатай тэмцэх газрын албан хаагчид тавигдах шаардлага 19.1. Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалд мэргэжлийн болон зохих нөхцөл, шалгуурыг хангасан, авлига, албан тушаалын хэргээр шалгагдаж сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй иргэнийг томилно.
	Цагдаагийн албаны тухай ²¹³	66 дугаар зүйл. Цагдаагийн албан тушаалд тавигдах шаардлага 66.2. Цагдаагийн албан тушаалд анх томилохдоо гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй, ... Монгол Улсын иргэнийг хүсэлтийг нь үндэслэн шалгуур хангасан байдлаар нь эрэмбэлэн шалгаруулж томилно.
	Цэргийн албаны тухай ²¹⁴	19 дүгээр зүйл. Цэргийн жинхэнэ алба хаах болзол 19.2. Офицер, ахлагч нь дараахь шалгуур үзүүлэлтийг хангасан байна: Хуульд тусгайлан шаардлага тавиагүй.
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай ²¹⁵	270 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, түүнд тавигдах шаардлага 270.3.... гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэнийг авч ажиллуулна.
	Шүүхийн шинжилгээний тухай ²¹⁶	41 дүгээр зүйл. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан 41.2. Шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтнээр ял шийтгэлгүй, шинжилгээний чиглэлээр мэргэшсэн Монгол Улсын иргэнийг томилно.
	Тагнуулын байгууллагын тухай ²¹⁷	17 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын албан хаагч 17.2. Тагнуулын ажилтны албан тушаалд иргэнийг судлах, сонгон шалгаруулах, туршилтын хугацаагаар ажиллуулах журмыг Тагнуулын ерөнхий газрын даргын саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд батална. Журмаар зохицуулна. Хуульд тусгайлан шаардлага тавиагүй.
	Төрийн тусгай хамгаалалтын тухай ²¹⁸	13 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч 2. Төрийн тусгай хамгаалалтын албанд 20 нас хүрсэн, эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага хангасан, зохих боловсрол, ажлын туршлагатай, ял шийтгэлгүй, Монгол Улсын иргэнийг ажиллуулна.

²¹² Авлигын эсрэг хууль. 2006. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=8928>.

²¹³ Цагдаагийн албаны тухай хууль. 2017. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12469>.

²¹⁴ Цэргийн албаны тухай. 2016. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12124>.

²¹⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12701>.

²¹⁶ Шүүхийн шинжилгээний тухай хууль. 2009. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=88>.

²¹⁷ Тагнуулын байгууллагын тухай. 1999. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=468>.

²¹⁸ Төрийн тусгай хамгаалалтын тухай. 1995. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=499>.

	Дипломат албаны тухай ²¹⁹	15 дугаар зүйл. Дипломат албан тушаал эрхлэх болзол Хуульд тусгайлан шаардлага тавиагүй.
--	--------------------------------------	---

Эдгээр алба нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг алба тул тусгайлан шаардлага тавьж болох зохицуулалтыг Төрийн албаны тухай хуулиар зөвшөөрчээ. Гэвч төрийн тусгай албаны шаардлагыг хуулиар тогтоохдоо “гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх” шаардлагыг янз бүрийн нэр томъёогоор тодорхойлох, журмаар тодорхойлох зэрэг байна. Тухайлбал,

- эрүүгийн ял шийтгэлгүй,
- эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй,
- гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдож байгаагүй,
- ял шийтгүүлж байгаагүй,
- гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй,
- ял шийтгэлгүй зэрэг.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгч гишүүнд тавигдах шаардлагад “сахилгын шийтгэлгүй” байх гэсэн шалгуурыг тавьсан байна.

Эндээс үзвэл, эрүүгийн хариуцлагын болон сахилгын шийтгэлийн эрх зүйн үр дагавар нь төрийн зарим тусгай албанд орж ажиллах эрхийг хязгаарлаж байгаа нь төрийн тусгай чиг үүрэгтэй уялдаж хууль зүйн хариуцлага эргэлт буцалтгүй байх зарчим буюу хууль зүйн хариуцлагын арга хэмжээ үр нөлөөтэй байх гэсэн агуулгаар илэрхийлэгдэж байгаа ч тухайн хүний бусад эрх хязгаарлагдахгүй юм. Энэ нь нэг зөрчилд нэг шийтгэл гэсэн хууль зүйн хариуцлагын шударга ёсны зарчмыг хангаж өөр бусад эрх зүйн үр дагаврыг үүсгэхгүй гэсэн агуулгаар тайлбарлагдана.

Захиргааны хариуцлага. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинээр батлагдан гарсан Зөрчлийн тухай хуулиар²²⁰ албан тушаалтан зөрчлийн сУБъект байх зохицуулалтыг хассан. Энэ нь захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг захиргаанаас өөрөө батлахын зэрэгцээ уг шийдвэр болон төрийн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хэм хэмжээ тогтоосон хууль, бусад шийдвэрийн хэрэгжилтийг хангах үүргийг захиргаа өөрөө хүлээдэгтэй холбоотой. Ер нь захиргаа өөрийн тогтоосон хэм хэмжээний актыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд л захиргааны хариуцлага хүлээлгэдэг, захиргаа албан тушаалтандаа сахилгын хариуцлага хүлээлгэдэг байх үзэл баримтлал нь зүй ёсны шаардлагад нийцнэ.

Эд хөрөнгийн хариуцлага. Төрийн албан хаагчаас хөдөлмөрийн харилцаанд оролцох явцад өөрийн хууль бус үйлдэл (эс үйлдэхүй)-ээр төрийн байгууллагад учруулсан эд хөрөнгийн хохирлыг хуульд заасан үндэслэл журмаар нөхөн төлөх хууль зүйн үүрэг буюу шаардлага, хязгаарлалтын арга хэмжээг эд хөрөнгийн хариуцлага гэнэ.²²¹ Эд хөрөнгийн хариуцлагыг учруулсан хохирлыг нөхөн төлүүлж байгаа хэмжээг нь харгалзан эд хөрөнгийн бүрэн хариуцлага, эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага, эд хөрөнгийн өсгөн нэмэгдүүлсэн хариуцлага гэж ангилах бөгөөд энэ хариуцлага нь эрүүгийн, сахилгын хариуцлага хүлээлгэснээс үл хамааран хэрэгждэг онцлогтой тул давхардсан шийтгэл гэж үзэхгүй бөгөөд харин ч шударга ёсны зарчимд нийцсэн, эрх зүй зөрчсөн үйлдлийн эрх зүйн үр дагавар юм.

²¹⁹ Дипломат албаны тухай. 2000. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=246>.

²²⁰ Зөрчлийн тухай хуулийн 2.3.4. Төрийн албан хаагчийн хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуульд заасан зөрчлийн шинжтэй бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Төрийн албан хаагчийн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоогүй зөрчилд энэ хуульд заасан нийтлэг журмаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12695>.

²²¹ Баасан, Л. Монгол Улсын Хөдөлмөрийн эрх зүй (Тусгай анги). УБ. 2000. 156 дахь тал.

Хохирлыг нөхөн төлөх хариуцлагын тухайд төрийн албан хаагч эрхэлсэн ажил үүргээ гүйцэтгэж байхдаа өөрийн буруугаас иргэдэд учруулсан хохирлыг арилгах үйл ажиллагаа юм. Төрийн захирамжилсан арга хэмжээний улмаас иргэний эрх зөрчигдсөн бол уг зөрчигдсөн эрх нь хохирлыг барагдуулснаар анхныхаа байдалд эргэн очих ёстой болдог нь хууль ёсны шаардлага юм. Эрх зүйн онолын хувьд төр нь өөрийн албан хаагчийн буруутай хууль бус үйл ажиллагааны хариуцлагыг эхний ээлжинд хүлээх нь зүй ёсны асуудал. Төрийн албаны хариуцлагад зөвхөн хохирлыг барагдуулах эсвэл мөнгөн төлбөр төлөх бус харин хууль бус ажиллагаанаас өмнөх байдлыг сэргээх үйл ажиллагаа багтана. Энэ хариуцлага нь эд хөрөнгийн хариуцлагын нэгэн адил эрүүгийн, сахилгын хариуцлага хүлээлгэснээс үл хамааран хэрэгждэг онцлогтой тул давхардсан шийтгэл гэж үзэхгүй бөгөөд ял, шийтгэлийн эрх зүйн үр дагавар биш эрх зүй зөрчсөн үйлдлийн эрх зүйн үр дагавар юм.

Сахилгын хариуцлага нь хууль зүйн хариуцлагын нэг төрөл бөгөөд энэ талаар доктор (Sc.D) Л.Баасан "Хөдөлмөрийн сахилга зөрчсөн буруутай ажилтнуудад байгууллагын захиргаа, эсвэл тэдгээрийг удирдах дээд шатны эрх бүхий албан тушаалтнуудаас хүлээлгэх төрийн албадлагын төрөл, хэлбэрийг сахилгын хариуцлага²²² гэнэ" гэж тодорхойлжээ.

Энэ тодорхойлолтоос үзвэл сахилгын хариуцлагыг зөвхөн хөдөлмөрийн гэрээгээр хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд оролцогчдод хамааруулан тодорхойлсон байна.

Харин төрийн тусгай албан хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага нь дан ганц хөдөлмөрийн сахилгаас гадна албаны онцлогтой уялдуулан хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, заавар, дүрмээр тогтоогдсон албан хаагчийн үүрэг, ёс зүй, хориглох хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд тухайн байгууллагын захиргаа, эсвэл тэдгээрийг удирдах дээд шатны эрх бүхий албан тушаалтнуудаас хүлээлгэх хууль зүйн албадлага байна.

Өөрөөр хэлбэл төрийн үйлчилгээний албан хаагчдад сахилгын хариуцлага хүлээлгэх харилцаа нь хөдөлмөрийн эрх зүй буюу хувийн эрх зүйн зохицуулах зүйл байдаг бол төрийн тусгай албан хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага нь мэргэжлийн болон албаны эрх ашгийн шаардлагаас хамаарч өргөн агуулгаар тодорхойлогдож, захиргааны эрх зүй дэх төрийн албаны эрх зүй хэмээх институтын зохицуулалтад хамаарна.

Төрийн албан хаагчид хүлээлгэж буй сахилгын хариуцлага хууль зүйн хариуцлагын нэг төрөл болохын хувьд нэг талаас хөдөлмөрийн болон албаны сахилгыг зөрчихгүй байх "сахилгатай байдал", нөгөө талаас хөдөлмөрийн болон албаны сахилгыг зөрчсөний төлөө хүлээх шийтгэл, түүнтэй холбогдон гарах үр дагаврыг илэрхийлнэ.

Төрийн үйлчилгээний албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах харилцааг Хөдөлмөрийн тухай хууль болон тухайн байгууллагын дотоод журмаар, төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах харилцааг Төрийн албаны тухай хууль болон түүнд нийцүүлэн Засгийн газраас тогтоосон "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"²²³, "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам"²²⁴-аар зохицуулдаг бол төрийн тусгай албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах харилцааг Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмаар зохицуулна.

Хууль зүйн хариуцлага нь нийтлэг шинж, зорилго, зарчмын хүрээнд хэрэгжих шаардлагын үүднээс эрүүгийн хариуцлага дахь "ялтай байдал" хэмээх ойлголтыг

²²² Мөн тэнд. 153 дахь тал

²²³ Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралт.

²²⁴ Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам. Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 36/32 дугаар хамтарсан тушаалын хавсралт.

хүний эрхийн зарчим, хууль зүйн хариуцлагын мөн чанарыг илэрхийлэгч хууль ёсны зарчим, шударга ёсны зарчим, ялгавартай хандах зарчимд нийцүүлэн “халсан” байхад төрийн албан дахь сахилгын хариуцлага, ялангуяа шийтгэлийн эрх зүйн үр дагаварын зохицуулалт хэвээр хадгалагдаж байна.

Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-д зааснаар “төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно”, Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журмын 3.11 дэх хэсэгт “сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн хугацаа өнгөрч энэ хугацаанд дахин зөрчил гаргаагүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно” гэснээс үзвэл “сахилгын шийтгэлтэй” байдал гэсэн ойлголт байгааг илэрхийлж байгаа ба энэ заалт нь салбарын хууль, дүрэм, журмуудад нийтлэг байдлаар тусгагдсан байна. Тухайлбал, сахилгын шийтгэлгүйд тооцох үндэслэлийг прокурор нь гаргасан зөрчлөө бүрэн засч, үүрэгт ажлаа зохих ёсоор хэрэгжүүлж, шийтгэл оногдуулснаас хойш 6 сарын хугацаа өнгөрсөн бол дээд шатны прокурор уг шийтгэлийг сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусахаас өмнө сахилгын шийтгэл хүлээсэн прокурорын хүсэлт, сахилгын шийтгэлийг хугацааны өмнө арилгуулах тухай доод шатны прокурорын саналыг тус тус үндэслэн сахилгын шийтгэлгүйд тооцож болно²²⁵ гэж заасан бол Авлигатай тэмцэх газрын алба хаагчид сануулах, цалин бууруулах сахилгын шийтгэл ногдуулснаас хойш 8 сарын хугацаанд, онцгой нөхцлийн нэмэгдэл хасах, албан тушаал бууруулах шийтгэлийг ногдуулснаас хойш 1 жилийн хугацаанд дахин зөрчил гаргаагүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно гэж заасан байна. Албан тушаал бууруулах шийтгэлийн үр дагавар арилсан ч өмнөх албан тушаалд тавих үндэслэл болохгүй гэж заасан байна. Цэргийн сахилгын дүрэмд шийтгэлийн хугацаанд албан үүрэг биелүүлэхдээ онцгой амжилт гаргаж, сайшаал хүртсэн цэргийн алба хаагчийн сахилгын шийтгэлийг хүчингүйд тооцно гэж заасан нь сахилгын шийтгэлтэй байдал хугацаанаас өмнө дуусгавар болох сахилгын хариуцлагын эерэг үр дагаврыг тодорхойлж байна. Дипломат ажилтны сахилгын дүрэм, Цэргийн сахилгын дүрэм, Тагнуулын ажилтны сахилгын дүрэм, Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагчийн сахилгын дүрэмд²²⁶ зааснаар сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа Төрийн албаны хуульд заасантай ижил байна.

Харин Шүүхийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсэгт “Шүүгчид зөвхөн энэ хуульд заасан үндэслэл, журмаар сахилгын шийтгэл оногдуулна” гээд “сахилгын шийтгэлтэй байх хугацааг зааж өгөөгүй²²⁷ нь хууль зүйн хариуцлагын шударга ёсны зарчимд нийцүүлсэн байна. Өөрөөр Төрийн албаны хуулийн “сахилгын шийтгэлтэй байх” заалт үйлчлэхгүй гэсэн үг юм.

Түүнчлэн, Төрийн албаны тухай хуульд сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэх шаардлагагүй бөгөөд сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулахыг хориглоно, Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журамд сахилгын нэг зөрчилд нэг төрлийн шийтгэл ногдуулах ба сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулж болохгүй, бусад дүрэм, журамд сахилгын нэг төрлийн зөрчилд сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулахгүй гэж заасан байна.

Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагчийн сахилгын дүрэм, Цэргийн сахилгын дүрэмд алба хаагчийн нэр хүндийг гутаах, дарамтлахыг хориглоно, гаргасан зөрчилдөө захиргааны шийтгэл хүлээсэн бол сахилгын шийтгэл давхардуулан хүлээлгэхгүй, цэргийн алба хаагчийн хувийн нэр хүндийг гутаах,

²²⁵ Прокурорын сахилгын дүрмийн 6.1, 2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар зарлигийн хавсралт. <https://old.legalinfo.mn/annex/details/11914?lawId=16527>.

²²⁶ Мөнхзул, Н. Төрийн тусгай албан хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага. Хавсралт 7. УБ., 2019.

²²⁷ Шүүхийн тухай хууль. 2021. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106892006021>.

ширүүн догшин бүдүүлгээр харьцах, хамт олноор нь залхаахыг хатуу хориглоно, гэж заасан нь шийтгэлийг давхардуулахгүй байх зохицуулалт боловч албан тушаалтанд захиргааны хариуцлага хүлээлгэх зарчмыг дэмжиж байгаа нь харагдаж байна. Харин Авлигатайтэмцэхгазрыналбанхаагчньсахилгын ба захиргааны зөрчил нэг дор гаргасан нөхцөлд тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан нь захиргааны шийтгэлээс чөлөөлөх үндэслэл болохгүй гэж заасан нь албан тушаалтанд захиргааны хариуцлага хүлээлгэх зарчмыг мөн л дэмжиж байгаа нь харагдаж байна. Эдгээр нь Төрийн албаны хууль, Зөрчлийн хуулийн үзэл баримтлал, хууль зүйн хариуцлагын шударга ёсны зарчим зөрчиж байгаа тул хуульд нийцүүлэх шаардлагатайг харуулж байна.

Практикт “сахилгын шийтгэл”-тэй хугацаанд хуулиар тодорхойлоогүй хязгаарлалтыг дотоод дүрэм, журмаар тодорхойлж, буруу практик бий болгон²²⁸ түүнийгээ “заншил байдлаар” нийтлэг хэрэглэж, сахилгын хариуцлагын сөрөг үр дагаврыг үүсгэж байна. Үүнд:

- гүйцэтгэлийн урамшуулах авахгүй байх
- бусад урамшуулалд хамрагдахгүй байх
- шагналд тодорхойлогдох эрх хасагдах
- албан тушаал ахих, нөөцөд орох эрх хязгаарлагдах
- гадаад, дотоодын сургалтад хамрагдах боломжийг хойшлуулах
- төрөл бүрийн шалгаруулалтад нэр дэвших, шалгарах боломжгүй болох
- Төрийн албан хаагчийн нийтлэг зарим баталгааг хязгаарлах зэрэг хуулиар зохицуулаагүй үр дагавар тодорхой хугацаанд тухайн шийтгүүлсэн алба хаагчид нэгэн зэрэг үйлчилж байгаа, эрх бүхий албан тушаалтан үзэмжээр шийдвэрлэх боломж олгож байгаа зэрэг нь хууль зүйн хариуцлагын “хууль дээдлэх зарчим”, “шударга ёсны зарчмыг” зөрчиж байна.

Харин нэг удаагийн үр дагаврыг шийтгэлтэй алба хаагчид үзүүлэх нь хууль зүйн хариуцлагын зорилгод нийцсэн нөлөөллийн арга хэмжээ гэсэн агуулгад нийцэх ба энэ зохицуулалтыг хуульчилснаар хууль зүйн хариуцлагын шударга ёсны зарчим хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл, эрх чөлөөнд суурилсан нийгэм бүр зайлшгүй эрх зүйт ёсыг²²⁹ шаардах бөгөөд эрх зүйт ёс хэрэгжсэнээр иргэн, төрийн байгууллага, албан тушаалтан хуульд захирагдаж хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдах үндэс бүрдэнэ.

Дүгнэлт

Хууль зүйн хариуцлага нь эрх зүйн салбарын онцлогийг үл харгалзан эрх зүйн дэг журмыг хамгаалах, хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх, цээрлүүлэх зэрэг зорилгыг агуулах ч эрх зүйн зөрчлийн төрлөөс хамаарч шийтгэлийн хэмжээ хязгаар ялгамжтай бөгөөд гаргасан зөрчил оногдуулах шийтгэл тохирох нь хууль зүйн хариуцлагын мөн чанарыг илэрхийлдэг.

Энэ утгаараа эрүүгийн хариуцлага нь ... үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байх, бусдад халдаан хэрэглэхгүй байх, нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулах²³⁰ шударга ёсны зарчмыг баримталж “ялтай байдал” гэсэн ойлголтыг халсан байна. Энэ утгаараа төрийн албанд орох боломжийг нээсэн зохицуулалтыг Төрийн албаны хуульд оруулж өгсөн нь хүний эрхийг хангах, хууль зүйн хариуцлагын мөн чанарыг илэрхийлсэн дэвшилтэт зохицуулалт болсон байна.

Захиргааны хариуцлагыг иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэдэг байх, захиргаа албан тушаалтандаа сахилгын хариуцлага хүлээлгэдэг байх үзэл баримтлал нь зүй

²²⁸ Нямсүрэн, Ч. Цагдаагийн албан хаагчдад хүлээлгэх сахилгын хариуцлага, түүний үр нөлөө //Багш, сонсогч, оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл. 1999

²²⁹ Jeremy Waldron. Is the rule of law an Essentially Contested concept in Florida?, Law and Philosophy 21, №2. 2002. page 137.

²³⁰ Жанцан, С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (ерөнхий ба тусгай анги). УБ., 2012. 190, 203 дахь тал.

ёсны шаардлагад нийцэж байна. Эд хөрөнгийн хариуцлага, хохирол нөхөн төлөх хариуцлагын хувьд эрүүгийн, сахилгын хариуцлага хүлээлгэснээс үл хамааран хэрэгждэг онцлогтой тул давхардсан шийтгэл гэж үзэхгүй бөгөөд харин ч шударга ёсны зарчимд нийцсэн, эрх зүй зөрчсөн үйлдлийн эрх зүйн үр дагавар юм.

Харин сахилгын зөрчил нь нийгмийн хор аюулын хувьд гэмт хэргээс ямагт бага байх тул Төрийн албаны хууль дахь хүний эрх зүйн байдлыг дордуулсан “шийтгэлтэй байдал” гэсэн ойлголтыг хууль зүйн хариуцлагын шударга ёсны зарчимд нийцүүлэн “халах” буюу 48 дугаар зүйлийн 48.7 дахь “Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно” гэсэн заалтыг хүчингүй болгож, сахилгын шийтгэл оногдуулсан эрх бүхий албан тушаалтны шийдвэр гарсан даруйдаа үйлчлээд цаашид төрийн албан хаагчийн хууль ёсны эрх ашиг сонирхолд дахин сөрөг үр дагавар үүсгэдэггүй (Ногдуулсан сахилгын шийтгэл биелэгдсэнээс хойш дахин сөрөг үр дагавар дагуулахгүй) байхаар зохицуулах нь төрийн алба хаагчийн эрхийг хангаж, хууль зүйн хариуцлагын шударга ёсны зарчим, хууль дээдлэх зарчимд нийцэх юм.

Ашигласан материал

Ном сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээл

- Мөнхзул, Н. Төрийн тусгай албан хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага. УБ. 2019.
- Нямсүрэн, Ч. Эрх зүйн ерөнхий онол: үндсэн ойлголт, тулгамдсан асуудал. УБ. 2010.
- Нямсүрэн, Ч. Цагдаагийн албан хаагчдад хүлээлгэх сахилгын хариуцлага, түүний үр нөлөө //Багш, сонсогч, оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл. 1999.
- Жанцан, С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (ерөнхий ба тусгай анги). УБ. 2012.
- Гантөмөр, Г. нар. Эрүүгийн эрх зүй: ерөнхий анги. УБ. 2020.
- Баасан, Л. Монгол Улсын Хөдөлмөрийн эрх зүй (Тусгай анги). УБ. 2000.

Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. УБ. 1992. №1.
- Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга). Төрийн мэдээлэл. УБ. 2016. №7.
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай. 1992. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=365>.
- Шүүхийн тухай хууль. 2021. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106892006021>.
- Прокурорын тухай. 2017. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12702>.
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай. 1992. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=9546>.
- Төв банк/монголбанк/-ны тухай. 1996. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=483>.
- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай. 2005. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=446>.
- Статистикийн тухай. 1997. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=461>.
- Сонгуулийн төв байгууллагын тухай. 2006. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=459>.
- Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай. 2020. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15152>.
- Монгол Улсын шүүхийн тухай. 2021. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106892006021>.
- Төрийн аудитын тухай. 2020. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15357>.
- Авлигын эсрэг хууль. 2006. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=8928>.

- Цагдаагийн албаны тухай хууль. 2017.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=12469>.
- Цэргийн албаны тухай. 2016. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12124>.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=12701>.
- Шүүхийн шинжилгээний тухай хууль. 2009.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=88>.
- Тагнуулын байгууллагын тухай.1999. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=468>.
- Төрийн тусгай хамгаалалтын тухай. 1995.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=499>.
- Дипломат албаны тухай. 2000. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=246>.
- Зөрчлийн тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12695>.
- Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралт.
- Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам. Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 36/32 дугаар хамтарсан тушаалын хавсралт.
- Прокурорын сахилгын дүрмийн 6.1, 2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар зарлигийн хавсралт.
<https://old.legalinfo.mn/annex/details/11914?lawId=16527>.
- Шүүхийн тухай хууль. 2021.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106892006021>.

Гадаад эх сурвалж

- Jeremy Waldron. Is the rule of law an Essentially Contested concept in Florida?, Law and Philosophy 21, №2. 2002. page 137.

МОНГОЛ УЛС ДАХЬ ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ЧИГ ХАНДЛАГА

OLD AGE PENSION REFORM AND TRENDS IN MONGOLIA

Ц.Мөнхдэлгэр

ДХИС-ийн докторант

Munkhdelger C.

Research doctorate (Ph.D), University of Internal Affairs of Mongolia

Хураангуй: 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулиар нийгмийн амьдралын бүхий л харилцааг шинэчлэн зохицуулсаны нэг хэлбэр бол улсын төсвөөс санхүүждэг тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хамгааллын тогтолцоог халж, нийгмийн хамгаалалын шинэ тогтолцоог бүрдүүлэн, түүний эрх зүйн орчинг бий болгосон явдал мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу 1991 онд Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай, 1993 онд Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг тус тус баталж, нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмжийн бие даасан тогтолцоо бий болгох бодит нөхцлийг бүрдүүлсэн. Улмаар 1994 онд Нийгмийн даатгалын багц хуулиудыг тус тус баталжээ. Ийнхүү Монгол Улсад 1995 оноос Нийгмийн даатгалын багц хууль үйлчилж өнөөг хүртэл мөрдөгдсөөр байна. Судалгаанаас үзэхэд, Монгол Улсын иргэдийн дундаж наслалт сүүлийн үед нэмэгдэж, тэтгэврийн насны хүмүүсийн тооны өсөлт, тэтгэврийн өсөлтийн нэмэгдэл, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн өмнөх насны хүмүүсийн харьцааны өөрчлөлт, ажилгүйдэл, өвчлөл, осол гэмтэл зэрэг нь нийгмийн даатгалын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна. Үндэсний статистикийн хорооны хүн ам ба ажиллах хүчний тоон мэдээллээс үзэхэд, 1990-ээд оны эхэн үеэс хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд 1.4 болж буурсан бол 2000-2010 онд дунджаар 1.5 хувь болжээ. Сүүлийн 10 жилд нийт хүн амын тоо 16,1 хувиар өссөн бол ахмад настны тоо 21.9 хувиар буюу илүү хурдацтай өсөж, үүний улмаас хөдөлмөрийн нөөцийн өсөлт буурах хандлага ажиглагдаж эхлээд байгаа бөгөөд энэ хандлага ойрын 10 гаруй жилд хадгалагдах төлөвтэй байна. Тодруулбал, 2021 оны байдлаар өндөр насны тэтгэврийн хүмүүсийн тоо 341.480 болон өсч, 15 ба түүнээс дээш насны хөдөлмөрийн насны хүмүүсийн тоо 1.2 сая байгаагаас 1.1 сая нь ажиллагчид байна.²³¹ Судалгаа, тооцооллоос үзэхэд өндөр насны тэтгэвэр авагчдын тоо 2025 онд 2020 оныхоос 80-аад мянгаар өсөж, 400.0 мянга болох бөгөөд 2030 онд 500 гаруй мянга, 2045 онд 810 гаруй мянгад хүрэх, мөн 2020 оны байдлаар 10 шимтгэл төлөгчид 5 тэтгэвэр авагч ногдож байгаа бол энэ үзүүлэлт 2030 онд 7, 2040 онд 8, 2080 он гэхэд 10 болох хэтийн тооцоолол байна.²³² Дээрх нөхцөл байдлууд нь Монгол Улс дахь өндөр насны тэтгэврийн эрх зүйн зохицуулалтыг дэлхийн чиг хандлагад нийцүүлэн зайлшгүй шинэчлэх шаардлагатайг харуулж байна.

Abstract: the Constitution adopted in 1992 at the beginning of Mongolia's transition to the market is a form of reform of all relations of social life, including the abolition of the state budget-funded pension, benefits and social protection system and the establishment of a new social protection system. In accordance with the Constitution, the law on social insurance contributions in 1991 and the law on Civil health insurance in 1993 created real conditions for the establishment of an independent system of social insurance and pension benefits, and in 1994 a package of social insurance laws was adopted. Thus, a social insurance law has been in place in Mongolia since 1995. According to the study, the recent increase in the life expectancy of Mongolian citizens, increase in the number of people of retirement age, increase in pension growth, changes in the ratio of people of working and pre-working age, unemployment, illness and injuries, etc., indicate the need to improve the

²³¹ Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал. Үндэсний статистикийн хороо. УБ. 2021.

²³² Мөн тэнд.

legal regulation of social insurance. According to population and workforce data from the National Statistical Office, since the early 1990s, the average annual population growth rate has decreased to 1.4 percent, and from 2000 to 2010, it has averaged 1.5 percent. In the last 10 years, the total population has grown by 16.1 percent, while the elderly population has grown by 21.9 percent or more rapidly, resulting in a downward trend in labor resources, and this trend is expected to persist over the next 10 years. In particular, as of 2021, the number of old-age pensioners has increased to 341,480, and the number of working-age people aged 15 and over is 1,2 million, of which 1,1 million are employees. According to studies and estimates, the number of old-age pensioners will increase in 2025 by 80 thousand compared to 2020 by 400.0 thousand, in 2030 by more than 500 thousand, in 2045 by more than 810 thousand, and in 2020 by 10 contributions payers by 5 pensioners, this figure is projected to be 2030 by 7, in 2040 by 8 and in 2080 by 100. The above circumstances indicate that the legal regulation of old age pension in Mongolia needs to be updated in line with global trends.


Түлхүүр үгс: Зохицуулалт, нийгмийн даатгал, өндөр насны тэтгэвэр, тогтолцоо, эрх зүйн шинэчлэл.

Keywords: Regulation, Social Security, old age pension, system, legal reform.

УИХ-аас 1994 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг баталснаар нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэл, хугацаа, жил, шимтгэл төлсөн цалинтай уялдуулан тэтгэвэр тогтоодог “цалинд жишсэн”, шимтгэлд суурилсан тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлсэн.

1990 оны үеийн эдийн засгийн шилжилтийн явцад тэтгэвэр, нийгмийн хамгааллын тогтолцоонд хамрагдах ажиллах хүчний тоо эрс буурч, харин тэтгэвэр тогтоолгох эрх нь үүссэн өндөр настнуудын тоо ихээхэн нэмэгдсэн байна. 1994 оны хууль батлагдсан үеэс тэтгэврийн өнөөгийн тогтолцоонд даатгуулагчдын төлсөн шимтгэлийн хэмжээ нь уг сангаас төлөх тэтгэврийн зардлыг нөхөхөд үргэлж хангалтгүй байсан тул тэтгэврийн даатгалын сангийн жил бүрийн алдагдлыг улсын төсвийн татаасаар нөхөж иржээ.

График №1. Нийгмийн даатгалын санд төрөөс олгож буй татаас




2008 онд нийт шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 19 хувиас 14 хувь болгон бууруулснаар тэтгэврийн сангийн алдагдлын хэмжээ ихээхэн нэмэгджээ. Үүний үр дүнд улсын төсвийн татаас нь жилийн нийт тэтгэврийн зардлын 1/3 орчмыг бүрдүүлэх болсон. УИХ-аас 1995 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийг баталснаар 1960 оноос өмнө төрсөн иргэний тэтгэврийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай” хуулиар, 1960 оноос хойш төрсөн иргэний тэтгэврийг “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль”-иар зохицуулалт хийгдэхээр болсон. Эдгээр хууль нь тэтгэвэр тогтоох харилцааг зохицуулсан хууль юм. “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай” хуульд зааснаар

тэтгэврийг сүүлийн 20 жилийн доторх хамгийн өндөр, дараалсан долоон жилийн дундаж цалингаас 45 хувиар бодно. “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” хуулиар тэтгэвэр тогтоох бол нэрийн дансанд нь хичнээн хэмжээний орлого бүртгэгдсэн байна, түүнээс тэтгэврийг тогтооно. Одоогоор 1960 оноос хойш төрсөн 1.3 сая иргэн идэвхтэй, идэвхгүй байдлаар нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаагаас идэвхтэй буюу тогтмол шимтгэл төлдөг 200 мянга гаруй иргэн байгаа бөгөөд шимтгэлээ байнга төлж хүүг тооцож байгаа²³³. Монгол улсад 2015 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” хуулинд нэмэлт, өөрчлөлтийг оруулснаар даатгуулагчид сонголт хийх боломжийг олгосон байна. Энэ хуулиар тэтгэврийн даатгалд даатгуулсан 1960 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн иргэнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх, уг дансны эхний үлдэгдэл, даатгуулагчийн төлсөн шимтгэл, хүүг тооцох, нэрийн данснаас тэтгэвэр тогтоон олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байсан бол УИХ-ын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого /2015-2030/-”-д нэрийн дансны тогтолцоонд үндэслэн тэтгэвэр тогтоох Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн (13 ГАГ-2019/09-ГА) даатгуулагчийн хугацааг 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн иргэн болгон өөрчилсөн байна.

1960 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш төрсөн, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн даатгуулагч нэрийн дансны аргаар эсвэл Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан нөхцлөөс сонголтоо хийж, тэтгэвэр тогтоолгох боломжтой болсон. Уг хуулиар тэтгэвэр тогтоох аргыг өөрчилсөн хэрэг болохоос тэтгэвэрийн тогтолцоог өөрчлөөгүй. Одоогийн орлогоороо зарлагаа нөхдөг тогтолцоогоор тэтгэвэрт гарахдаа шимтгэл төлсөн 20 жилийн дараалсан таван (одоо 7 жил) жилийн цалингийн дунджаар тэтгэврийн хэмжээг тогтоодог бөгөөд 20 жил ажилласан бол 45 хувь, түүнээс илүү ажилласан жил тутамд 1.5 хувиар өсгөж боддог.

График №2. Монгол Улсын хүн ам зүйн төсөөлөл



Нийгмийн даатгалыг шинэчлэх хууль эрх зүйн үндэслэл нь “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого” /2015-2030/ зэрэг баримт бичигт нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох талаар дэвшүүлсэн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор нийгмийн даатгалын багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулах шаардлагатай болсон.

²³³ Нийгмийн даатгал, халамж. Үндэсний статистикийн хороо. УБ. 2017.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Монгол Улс нь олон давхаргат тэтгэврийн тогтолцоотой байхаар тусгаж, нэгдүгээр давхарга буюу суурь тэтгэвэр, хоёрдугаар давхарга буюу тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, гуравдугаар давхарга буюу хувийн нэмэлт тэтгэвэр гэсэн гурван давхаргаас бүрдэнэ. Суурь тэтгэврийг улсын төсөв, газрын хэвлийн баялгийн үр өгөөжөөс санхүүжүүлнэ. Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг өсгөх зохицуулалтын хүрээнд олон жил шимтгэл төлөхийг урамшуулж, 30 жил шимтгэл төлсөн иргэний өндөр насны тэтгэврийг хуулийн төсөлд тусгаснаар 70 хувь, харин 40 жил шимтгэл төлсөн бол 80 хувь болж нэмэгдэнэ. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус секторт ажиллагсад тэтгэврийн даатгалд “сайн дураар” хамрагдах хуулийн зохицуулалттай тул тэд ажиллаж байгаа үедээ даатгалаас зайлсхийж, алсдаа төрийн нийгмийн халамжийн сангийн ачааллыг нэмэгдүүлэх нэг үндэс болдог. Иймээс тэднийг тэтгэврийн даатгалд заавал хамруулах эрх зүйн зохицуулалтыг зайлшгүй бий болгох шаардлага өнөө үед тулгарч буй тул малчдын нийгмийн даатгалд хамралтыг нэмэгдүүлж, улсын төсвийн ачааллыг бууруулах чиглэлээр шинэ хуулийн төсөлд малчдын төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг төрөөс, 50 хувийг малчин өөрөө төлөхөөр зохицуулан, шимтгэл төлөлтийг урамшуулах бодлого баримталжээ. Мөн Засгийн газар “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай” хуулийн төслийг шинээр боловсруулсан. Энэ хуулийн төслийн зорилт нь хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэх, хувийн нэмэлт тэтгэврийн хуримтлал үүсгэх, тэтгэврийн хуримтлалаас хөрөнгө оруулалт хийх, хувийн нэмэлт тэтгэвэр олгох, өвлүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт тавих, талуудын эрх ашгийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад чиглэгдэнэ. Хувийн нэмэлт тэтгэвэр нь сайн дурын байх, шимтгэлд суурилсан, бүрэн хуримтлалын байх, үйл ажиллагаа ил тод байх, санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байдлыг хангасан, өвлөгддөг байх зарчимд тулгуурлана. Иргэд сайн дурын үндсэн дээр нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдаж, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврээс гадна нэмэлт тэтгэвэр авах харилцааг энэ хуулиар зохицуулах юм. Анх 2009 онд хувийн тэтгэврийн тогтолцоог бий болгох чиглэлд хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн барьж байсан ч тухайн үед дэмжигдээгүй. Мөн УИХ-ын гишүүн Н.Учрал нарын таван гишүүний өргөн барьсан Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслийг 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр УИХ-аар хэлэлцсэн боловч батлахаас татгалзсан. Энэхүү хуулийн төсөлд даатгуулагч буюу иргэн нь тэтгэврийн даатгалын санд төлж буй шимтгэлээс 2 хувь, ажил олгогч нь 2 хувь, нийт 4 хувийг өөрийн сонгосон хувийн тэтгэврийн санд төлж болохоор тусгасаныг Монгол Улсын Засгийн газар хүлээн зөвшөөрөөгүй байна. Уг хуулийн төслийг баталснаар иргэнд ирээдүйд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах, орлогын хангалттай эх үүсвэртэй болох боломж бүрдэхээс гадна санхүү, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх урт хугацааны сан бий болох, хувийн тэтгэврийн сангууд бий болсноор санхүүгийн салбарт шинээр ажлын байр бий болох зэрэг олон талын ач холбогдолтой гэж хууль санаачлагчид үзсэн.

Улсын хэмжээнд 2020 оны байдлаар ажилтны цалингийн дундаж хэмжээ 1,269.1 мянган төгрөг, Монгол улсад нийт 341480 хүн өндөр насны тэтгэвэр авч байгаа бөгөөд тэтгэврийн дундаж хэмжээ 409.0 мянган төгрөг, цалинтай харьцуулахад ойролцоогоор 34.5 хувь болж байна.²³⁴ Гэтэл хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын сангаас авах тэтгэвэр нь дээрх 34.5 хувийг өсгөх боломжтой. Тухайн нэмэлт тэтгэвэр нь төрөөс бус хувийн хэвшлийн даатгалын компаниудаас гарах ба ахмад настны амьдралын баталгаа, санхүүгийн боломж, нөхцлийг сайжруулах бүрэн боломжтой гэж судлаачид үзэж байна. Түүнчлэн, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, хувийн хэвшлийн оролцоог хангах, төрийн ачааллыг багасгах, ажилтан


²³⁴ Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал. Үндэсний статистикийн хороо. УБ. 2021.

болон ажил олгогчийн оролцоог дэмжих зэрэг харилцааг зохицуулах эрх зүйн орчин зайлшгүй шаардлагатай юм. Өндөр цалин, орлоготой иргэд орлогоосоо даатгалын шимтгэлээ төлөөд тэтгэвэрт гарсан үедээ өндөр тэтгэвэр авах хүсэлтэй тохиолдолд төр суурь тогтолцоогоо хадгалаад тухайн хүн нэмэлтээр хувийн тэтгэврийн даатгалд хамрагдах, тэтгэвэрт гарсан хойноо өндөр тэтгэвэр авах боломжтой болно. Энэ нь урт хугацаанд одоогийн тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг бууруулах, зохистой түвшинд барих, төсөвт ирж буй ачааллыг багасгах юм.

Монгол Улсад тэтгэврийн нөөц сангийн эрх зүйн орчинг бий болгож, 2016 онд УИХ-аас “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай” хуулийг баталж, ирээдүйн өсөн нэмэгдэх тэтгэврийн сангийн дарамтыг хөнгөлөхийн тулд шинээр нөөц сан байгуулахаар тусгасан. Энэ сан нь нийгмийн даатгалын сангаас тусдаа байх ба ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуульд зааснаар Монгол банк үйл ажиллагааг нь удирдахаар хуулиар зохицуулагдсан. Харин сангийн зориулалт нь орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн хөнгөлөлт үзүүлэхэд шаардагдах зардлын ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны орлогоос санхүүжүүлэн зарцуулах, ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас барьцаалсан зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх, ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны бүртгэл, төлбөр тооцоотой холбоотой шимтгэл, хураамж төлөх, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тогтолцоог хагас болон бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх тохиолдолд шаардагдах шилжилтийн зардлыг сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхэд чиглэгдэнэ гэж хуульчилжээ. Гэвч уг хуулийн хэрэгжих хугацааг 2019, 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэхээр хойшлуулж, улмаар 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцжээ.

Монгол Улсын хэмжээнд 2021 оны байдлаар өндөр насны тэтгэврийн хүмүүсийн тоо 353,775 цэргийн тэтгэврийн 19,709 нийт 460,562 болон өсжээ.²³⁵

График №3. 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагч (тоогоор)



Хүснэгт №1. Тэтгэвэр авагчдын тоо, мянган хүн

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Тэтгэвэр авагчид	345,8	387,3	376,9	417,4	431,3	417,4	437,1	460,562
Өндөр насны тэтгэвэр	242,5	268,4	269,0	307,5	308,9	307,5	332,9	353,775
Цэргийн тэтгэвэр	14,6	15,4	15,3	18,6	18,9	18,6	19,1	19,709

Нийт иргэдийн хөдөлмөр эрхлэлт өсч ажиллагсадын тоо, цалин, түүнтэй адилтгах орлогын хэмжээ нэмэгдэхийн хэрээр нийгмийн даатгалын сангийн хуримтлал өсч, хөдөлмөр эрхлэлт буурах үед нийгмийн даатгалын сангийн зардал нэмэгддэг. Үүний улмаас “Хуримтлалын сан”-г бий болгох шаардлага үүсдэг байна. “Хуримтлалын сан” гэдэг нь нийгмийн даатгалын сангийн хөрөнгө болон тэтгэвэрийн

²³⁵ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 2021.

шимтгэлийн нэрийн дансны орлогыг нэмэгдүүлэх зорилгоор нөөцөлсөн мөнгөн хөрөнгийг²³⁶ хэлнэ. Хуримтлалын сангийн хөрөнгийг Засгийн газрын бонд болон Монгол банкнаас гаргасан үнэт цаас худалдан авах, арилжааны банкинд байршуулах замаар нэмэгдүүлж болох бөгөөд худалдан авах хөрөнгийн хэмжээг нийгмийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусгаж, УИХ баталдаг.²³⁷ Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг арилжааны банкинд байршуулах хэмжээг санхүүгийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монгол банк, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл хамтран тогтооно.²³⁸

Нийгмийн даатгалын сангийн гол цөм бүрэлдэхүүн хэсэг бол тэтгэвэрийн даатгалын сан (pension insurance fund) юм. Тэтгэврийн сангийн алдагдлын нэг шалтгаан нь тус сангийн хөрөнгөд менежмент хийж өсгөх эрх зүйн орчин байхгүйтэй холбоотой гэж үздэг. “Хамтын тэтгэврийн тухай” хуулийг 2014 оны 1 дүгээр сард УИХ-д өргөн барьж бүтэн нэг жил хэлэлцүүлсний эцэст буюу 2015 оны 12 дугаар сард батлуулсан. Ингээд 2017 оны 1 дүгээр сараас тус хуулийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн боловч зургаан сарын дараа сонгууль болж улмаар шинээр байгуулагдсан УИХ уг хуулийг хүчингүй болгожээ. 2021 оны 3 дугаар сарын 22-нд Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, А.Адъяасүрэн нар “Хамтын тэтгэврийн тухай” хуулийн төслийг Улсын Их Хуралд дахин хэлэлцүүлэхээр өргөн барьсан. Дэлхийн олон улсад тэтгэврийг өвлүүлэх эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Нийгмийн даатгалын багц хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Засгийн газраар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барьсан. Нийгмийн даатгалын хуулиуд 1995 оноос хэрэгжиж эхэлснээс хойш 26 жилийн хугацаанд 30 гаруй удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Түүнчлэн, ковидын цар тахлын үед аж ахуйн нэгж, даатгуулагчид шимтгэлийн чөлөөлөлт, хөнгөлөлтийг үзүүлсэн нь ажил олгогчид санхүүгийн дэмжлэг болж, ажлын байраа хадгалахад мөн иргэдэд шимтгэл төлсөн хугацаа тасрахгүй байх боломжийг бүрдүүлсэн чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд нийгмийн даатгалын тогтолцоо, зарчим, төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, нийгмийн даатгалд даатгуулах, шимтгэл төлөх, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих болон сангийн хөрөнгө оруулалтын удирдлага, мэдээллийн нэгдсэн сан, тэтгэврийн даатгалын нэрийн дансыг бүртгэх, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх ажлыг эхлүүлэх, шимтгэлийн өр, хөөн хэлэлцэх хугацааг тогтоох сангийн эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий мэргэжлийн хороодыг ажиллуулах зэрэг зохицуулалтыг тусгасан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, тэтгэврийн ердийн насанд хүрсэн тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр олгох, тэтгэврийг жил бүр хэрэглээний үнийн өсөлтөөр нэмэгдүүлэх, тэтгэвэр бодох аргачлалд өөрчлөлт оруулан илүү олон жил шимтгэл төлснийг урамшуулах, тэтгэврийн ердийн наснаас хойш тэтгэвэр тогтоолговол тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэн тооцдог болгох зэрэг зохицуулалтыг тусгасан. Энэхүү хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн эрх хэвээр хадгалагдаж, эрх ашиг нь зөрчигдөхгүй юм.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд даатгуулагчийг хөдөлмөрлөж, цалин орлоготой байх үедээ нэмэлт тэтгэврийн даатгалд даатгуулж, ирээдүйд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх, тэтгэврийн хуримтлал үүсгэх, тэтгэврийн хуримтлалаас хөрөнгө оруулалт хийх, нэмэлт тэтгэвэр олгох, өвлүүлэх,

²³⁶ Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хууль. 1.2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг.

²³⁷ Мөн тэнд. 2.11 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг.

²³⁸ Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хууль. 2.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг.

хяналт тавих, талуудын эрх ашгийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахаар тусгажээ.

Дүгнэлт

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулиар улсын төсвөөс санхүүждэг тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хамгааллын тогтолцоог халж, нийгмийн хамгаалалын шинэ тогтолцоог бүрдүүлэн, түүний эрх зүйн орчинг бий болгож, 1991 онд Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай, 1993 онд Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг тус тус баталж, нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмжийн бие даасан тогтолцоо бий болгох бодит нөхцөлийг бүрдүүлж, улмаар 1994 онд Нийгмийн даатгалын багц хуулиудыг баталсан.

Монгол Улсын иргэдийн дундаж наслалт, тэтгэвэр авч амьдрах хугацаа, одоогийн байгаагаас цаашид нэмэгдэхийн хэрээр нийгмийн даатгалын болон тэтгэврийн даатгалын сан, төсөв хязгаарлагдмал байдалд хүрэх ирээдүйн төлөв ажиглагдах болов. Судалгаанаас үзэхэд 2021 оны байдлаар улсын хэмжээнд 467,9 мянган хүн нийгмийн даатгалын сангаас ямар нэгэн тэтгэвэр тэтгэмжийн хэлбэрээр 2,071,154 төгрөгийн эд мөнгөний үйлчилгээнд хамрагдаж байна.²³⁹ Дундаж наслалт нэмэгдэж, өндөр насны тэтгэвэр авагчдын тоо жил бүр өсөн, нийгмийн даатгалын сангийн зардалд төсвөөс ихээхэн хэмжээний татаас өгч буй зэрэг нь тэтгэврийн шинэчлэлийг эхлүүлж дэлхийн бусад орнуудын жишгээр нэн даруй олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бүхий эрх зүйн шинэчлэл шаардлагатайг харуулж байна. Иймд хувийн нэмэлт тэтгэврийн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг яаралтай хэлэлцэн батлуулаж олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, тэтгэврийн ердийн насанд хүрсэн тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр олгох, тэтгэврийг жил бүр хэрэглээний үнийн өсөлтөөр нэмэгдүүлэх, тэтгэвэр бодох аргачлалд өөрчлөлт оруулан илүү олон жил шимтгэл төлснийг урамшуулах, ирээдүйд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх, тэтгэврийн хуримтлал үүсгэх, тэтгэврийн хуримтлалаас хөрөнгө оруулалт хийх, нэмэлт тэтгэвэр олгох, өвлүүлэх боломжтой болгох зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992
2. Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хууль. 1994
3. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал. Үндэсний статистикийн хороо. УБ. 2021.
4. Нийгмийн даатгал, халамж. Үндэсний статистикийн хороо. УБ. 2017.
5. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 2021.
6. Үндэсний статистикийн хорооны хүн ам ба ажиллах хүчний тоон мэдээлэл. 2021.

²³⁹ Үндэсний статистикийн хорооны хүн ам ба ажиллах хүчний тоон мэдээлэл. 2021.

ПРОГРАММНЫЕ ИНФОРМАЦИОННЫЕ ПРОДУКТЫ КАК ИНСТРУМЕНТ УНИФИКАЦИИ И ОПТИМИЗАЦИИ ЮРИДИЧЕСКИХ ТЕКСТОВ

SOFTWARE INFORMATION PRODUCTS AS A TOOL FOR UNIFICATION AND OPTIMIZATION OF LEGAL TEXTS

Макович Г. В.

Профессор кафедры иностранных языков Уральского юридического института МВД России, доктор филологических наук, профессор

Makovich G. V.

Professor of the Department of Foreign Languages of the Ural Law Institute of the Ministry of Internal Affairs of Russia, Doctor of Philology, Professor

Аннотация: В статье изучаются возможности программных информационных продуктов для анализа юридической текстовой информации. Задачей автоматизированной обработки текстов с помощью информационных продуктов является поиск и интерпретация правовой информации. Также в статье показано, что автоматизированная обработка информации позволяет выявлять и закреплять для последующего употребления в юридической практике стандартные модели выражения правовых смыслов. В статье показано, как происходит маркировка текста, его обработка и как формируется семантико-синтаксическая инфраструктура юридических текстов.

Abstract: The article examines the possibilities of software information products for the analysis of legal textual information. The task of automated text processing using information products is the search and interpretation of legal information. The article also shows that automated information processing makes it possible to identify and consolidate standard models of expression of legal meanings for subsequent use in legal practice. The article shows how the text is marked, processed, and how the semantic and syntactic infrastructure of legal texts is formed.

Ключевые слова: Лексико-семантические шаблоны, правовые Big Data, семантико-синтаксическая инфраструктура юридических текстов, синтаксические шаблоны.

Keywords: Lexical and semantic templates, legal Big Data, semantic and syntactic infrastructure of legal texts, syntactic templates.

В юридическом дискурсе проявляются особенности использования языка права в профессионально значимых ситуациях общения. В основе дискурса лежит ситуационная модель общения, она актуализирует юридические тексты применительно к ситуации. Исходный текст трансформируется и приобретает веер реализаций, включая реализации в различных жанровых и поджанровых формах. Юридический дискурс представляет собой текст права в динамике, в процессе толкования и разъяснения.

Дискурс реализует профессиональный тезаурус в речевой деятельности. Базовый слагаемый дискурса являются терминология Ядро юридического дискурса составляют тематические фреймы и лингвокогнитивные модели, которые проявляют правовые концепты.

Задачей является создание семантического инструментария для поиска и интерпретации правовой информации и стандартных моделей выражения юридических смыслов. Обработка текстов одной предметной области позволит сформировать семантико-синтаксическую инфраструктуру юридических текстов.

Эта задача может быть решена путем применения технологии «больших данных», Big Data. Эта технология активно внедряется в разные сферы профессиональной деятельности, основанные на знаниях, и используется для сбора информации о сложных объектах и всестороннего анализа этой информации.

Возможности программных информационных продуктов и, в частности, Big Data, для анализа текстовой информации изучаются в работах А.А.Хорошилова²⁴⁰, О.Н.Пошатаева²⁴¹, Ю.М.Богданова²⁴², А.В.Старовойтова, Р.А.Субхангулова²⁴³, А.А.Филиппова. Потенциал Big Data в сфере права изучается в работах В.Д.Чуракова²⁴⁴, И.И. Черных²⁴⁵, Е.В. Булгаковой²⁴⁶, И.И.Черных считает, что возможности информационных технологий, в ряду которых и Big Data, способны существенно повысить объективность оценки существующего уровня правового регулирования и на следующем этапе проектировать модели правовых средств²⁴⁷.

Процесс информатизации юридической деятельности, который является базой для внедрения Big Data и других программных информационных продуктов, интенсивно развивается. Правовая информация размещается на сайтах государственных органов власти, персональная информация в системах учетов, российские суды размещают на сайтах свои решения, существует сайт-агрегатор судебных и нормативных актов Российской Федерации СудАкт (<https://sudact.ru>), аналитическая система судебной практики «Сутяжник» (<http://sutyazhnik.garant.ru>) и др.

В целом накоплен значительный материал, который может быть обработан под решение различных задач, в том числе и под лингвистическую задачу унификации и оптимизации структуры юридических текстов разных типов, устных и письменных, их синтаксического и лексического наполнения. Поскольку юридический текст, с одной стороны, определяет, «задает» процедуры и правила, применяемые при разрешении споров и иных юридических дел, а с другой стороны, отражает фактическое состояние практики правоприменения, то лингво-юридический анализ массивов Big Data позволит стандартизировать юридический текст.

К примеру, стоит задача обеспечения терминологического единообразия в практике законодательства, что позволит повысить четкость правоприменения. Также первоочередной является работа по выявлению точности юридического текста и обеспечению этой точности.

Другая важная задача – это унификация процедур, применяемых при разрешении дел в судопроизводстве. Лингво-юридический аспект этой задачи состоит в выявлении облигаторных и вариативных блоков в протоколах судебных заседаний по идентичным делам, четких стандартизированных формулировок, представляющих фактологическую составляющую ситуации и квалификации ситуации и ее компонентов. Коммуникативные блоки высказываний стандартизированной структуры являются производными от процессуальной

²⁴⁰ Хорошилов А.А., Пошатаев О.Н. Методы анализа текстов в технологиях Big Data || Электронные библиотеки: перспективные методы и технологии, электронные коллекции. Труды XV Всероссийской научной конференции RCDL'2013. 2013. С. 30-37.

²⁴¹ Там же.

²⁴² Богданов Ю.М., Пошатаев О.Н., Старовойтов А.В., Хорошилов А.А. Принципы создания высокопроизводительных систем обработки и анализа текстовой информации// Информатизация и связь. 2013. № 3. С. 148-155.

²⁴³ Субхангулов Р.А., Филиппов А.А. Онтологически-ориентированная система интеллектуального анализа технических документов// Четырнадцатая национальная конференция по искусственному интеллекту с международным участием. КИИ-2014. Труды конференции. 2014. С. 228-236.

²⁴⁴ Чураков В.Д. Big Data и юриспруденция: на одном ли мы пути? //Право и информация: вопросы теории и практики: Сборник материалов международной научно-практической конференции Вып. 7. - СПб. : Президентская библиотека имени Б.Н. Ельцина, 2018. - С. 136-143.

²⁴⁵ Черных И.И. Правовое прогнозирование в сфере гражданского судопроизводства в условиях развития информационных технологий// Актуальные проблемы российского права. -2019.- №6. - С.58-72.

²⁴⁶ Булгакова Е.В. Методы анализа больших данных в решении юридических задач//Право и информация: вопросы теории и практики: Сборник материалов международной научно-практической конференции. - СПб, 2017. - С.90-96.

²⁴⁷ Там же. С. 61.

стороны судопроизводства. Выявление и фиксирование таких стандартизированных блоков позволит оптимизировать судопроизводство.

Для решения задачи формирования терминологического единообразия и точности в законодательной практике используется метод оценки качества стиля нормативно-правового документа. В ключевых позициях законодательного акта, должны находиться именно термины, лексемы, соответствующие критериям и требованиям, предъявляемым к терминологическим единицам. Термин употребляется для наименования понятия, он обладает содержательной точностью и имеет дефиницию, однозначен, его значение не зависит от контекста. Термины надо отличать от смежных лингвистических явлений, не обладающих всем набором необходимых признаков.

Юридическая терминосистема включает в себя корпус «эталонных» единиц, и любой юридический текст из корпуса текстов в Big Data сопоставляется с «эталонными» носителями юридических смыслов. В терминосистемах «эталонными» являются базовые термины, обозначающие базовые понятия права, а также ядерные термины, называющие основные правовые понятия внутри группы базовых: административное правонарушение, кассационная жалоба, юридический прецедент, состав правонарушения и др.

Также специального анализа требуют составные термины, включающие в себя несколько компонентов и обозначающие сложные понятия, поскольку при сочетаемости компонентов часто происходят их семантические трансформации: общедозволительный тип правового регулирования, объективно противоправное деяние, сознательно-волевой характер права и др.

Лингво-юридический анализ текста в прикладной лингвистике осуществляется с использованием многочисленных программных средств. К примеру, применяются универсальные программы GATE и Ant, так и специализированные, создающиеся в каждом конкретном случае под определенный заказ для решения ведомственных, отраслевых задач разрабатываются специализированные программные продукты.

Статистика, полученная в результате разметки корпуса юридических текстов в соответствии с маркерами терминосистемы, позволит сделать вывод о встречаемости критериев точности и единообразности юридических текстов и значимости данных критериев в оценке текста. Эта информация даёт возможность определять уровень качества правового текста, формировать рекомендации по его улучшению, моделировать оптимальные блоки для использования в юридических текстах.

Чтобы реализовать указанные функции в автоматическом режиме в рамках Big Data с использованием возможностей специализированного программного продукта, требуется специальная лингвистическая работа по структурированию юридических терминосистем. Каждая из них является многоуровневой и иерархической, с многочисленными связями по смежности.

Маркирование юридической терминосистемы по максимально возможному набору признаков позволяет произвести точную разметку корпуса юридических текстов и оценить их лингво-юридические свойства. Статистика, полученная в результате разметки корпуса текстов позволит определить уровень качества правового текста и разработать рекомендации по его улучшению.

Аналогичное маркирование правового текста следует производить для оценки его синтаксической простоты и стандартизованности структурных единиц, сложных синтаксических целых, коммуникативных блоков высказывания. В основе этой работы лежит выявление в массивах текстов «эталонных» стандартизированных синтаксических целых, которые можно соотнести 1) с конкретными видами текста, к примеру, исковое заявление, судебное решение, постановление и др., 2) со структурными частями текста, например: изложение фактов, квалификация ситуации и ее компонентов и др. В автоматическом режиме корпус текстов в Big Data маркируется на основе сопоставления с «эталоном».

Результаты позволяют выявлять уровень качества правового текста и предложить пути нормативной трансформации и оптимизации правового текста.

Все описанные процессы должны привести к формированию автоматизированной платформы создания юридических текстов разных видов. Сервис должен быть ориентирован на выполнение пользователем нескольких функциональных ролей. Одну из ролей позволит реализовать режим «Проверка», дающий возможность пользователю загрузить документ и по итогам маркирования текста произвести его редактирование путем выбора соответствий из базы «эталонных» конструкций и «эталонных» терминов. Другим режимом работы сервиса должен быть режим «Создание», позволяющий из готовых структурных единиц, из лексико-синтаксических шаблонов смоделировать правовой текст определенного вида.

Формирование правовых Big Data позволяет разрабатывать и применять системы для обработки корпусов текстов, которые ориентированы на профессионалов в области права, решать прикладные проблемы унификации юридического текста, оптимизации его создания и, как следствие, повышение качества правоприменения.

Список использованной литературы

1. Хорошилов А.А., Пошатаев О.Н. Методы анализа текстов в технологиях Big Data || Электронные библиотеки: перспективные методы и технологии, электронные коллекции. Труды XV Всероссийской научной конференции RCDL'2013. 2013. С. 30-37.
2. Богданов Ю.М., Пошатаев О.Н., Старовойтов А.В., Хорошилов А.А. Принципы создания высокопроизводительных систем обработки и анализа текстовой информации// Информатизация и связь. 2013. № 3. С. 148-155.
3. Субхангулов Р.А., Филиппов А.А. Онтологически-ориентированная система интеллектуального анализа технических документов// Четырнадцатая национальная конференция по искусственному интеллекту с международным участием. КИИ-2014. Труды конференции. 2014. С. 228-236.
4. Черных И.И. Правовое прогнозирование в сфере гражданского судопроизводства в условиях развития информационных технологий// Актуальные проблемы российского права. -2019.- №6. - С.58-72.
5. Булгакова Е.В. Методы анализа больших данных в решении юридических задач//Право и информация: вопросы теории и практики: Сборник материалов международной научно-практической конференции. - СПб, 2017. - С.90-96.
6. Чураков В.Д. Big Data и юриспруденция: на одном ли мы пути? //Право и информация: вопросы теории и практики: Сборник материалов международной научно-практической конференции Вып. 7. - СПб. : Президентская библиотека имени Б.Н. Ельцина, 2018. - С. 136-143.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУСГАЙ ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ, АНХААРАХ АСУУДАЛ

IMPLEMENTATION AND ISSUES OF THE SPECIAL REQUIREMENTS FOR STATE BUDGET SUSTAINABILITY

С.Жанхор

БХИС-ийн докторант

Jankhor S.

Researcher doctoral candidate of Mongolian National Defence University

Хураангуй: Төсвийн тогтвортой байдлыг тусгай шаардлагын хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, төсвийн тогтвортой байдлыг хангах олон улсын туршлага, түүнийг нэвтрүүлэх боломжийг авч үзсэн.

Түлхүүр үгс: Төсөв, төсвийн тогтвортой байдал, нэгдсэн төсөв, төсвийн орлого, төсвийн зарлага, төсвийн тодотгол, дотоодын нийт бүтээгдэхүүн.

Монгол Улсын төсвийн эрх зүйн орчинд хийсэн нэг шинэчлэл бол 2010 онд УИХ-аас Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталж, төсвийн дүрмийг олон улсын туршлага, өөрийн орны онцлогт нийцүүлэн төсвийн орлого, зарлагын тэнцлийг зохистой харьцаагаар тодорхойлж, төсвийн тогтвортой байдлыг хангах, энэ хүрээнд төсвийн тусгай шаардлага тогтоох, төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих, эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн үндэс тавигдсан.

Тус хуулиар нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн, төсвийн богино, дунд, урт хугацааны бодлого, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг тодорхойлоход баримтлах, зохистой үзүүлэлтийн түвшин, харьцаа, хязгаарлалтыг тогтоосон бөгөөд төсвийн алдагдал, зарцуулалт, Засгийн газрын өрийн хязгаарыг тогтоох замаар төсвийн сахилга батыг дээшлүүлэх зохицуулалтыг тодорхойлж, төсвийн шийдвэр гаргалт дахь улс төрийн нөлөөллийг хязгаарлахад чиглэсэн тоон хязгаарлалт тогтоосон нь эдийн засгийн аюулгүй байдлын хувьд төдийгүй Монгол Улсын тогтвортой хөгжлийн үндэс болох чухал эрх зүйн баримт бичиг болсон.

Тус хуулиар хуулиар төсвийн тусгай шаардлагуудыг дараах байдлаар тогтоосон:

1. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;
2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;
3. Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;
4. Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх.²⁴⁸

Энэ хуулийн хувьд төсвийн удирдлагын зарчим, тусгай шаардлагын хүрээнд төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх асуудлыг тусгаж өгсөн бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш өнөөдрийг хүртэлх 13 жилийн хугацаанд 13 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, 12 зүйл, заалтыг шинээр нэмж, 6 зүйл, заалтыг хүчингүй болгож, 29 зүйл, заалтад өөрчлөлт оруулсан байна.

Энэ нь хууль тогтоомж тогтвортой, тодорхой байх зарчмын шаардлагыг зөрчсөнөөс гадна хуулийн үзэл баримтлал буюу зорилгоос гажих нөхцөл байдлыг бий

²⁴⁸ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2010 он, №30

болгосон ба ингэснээр эдийн засгийн аюулгүй байдлыг төсвийн эрх зүйн зохицуулалтаар хангахад ач холбогдол бүхий төсвийн тусгай шаардлагуудын хэрэгжих боломжийг хязгаарласан зохицуулалтууд оруулж иржээ. Тухайлбал,

1.Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-т заасан “Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох” тусгай шаардлагын хувьд: Тэнцвэржүүлсэн төсөв нь амжилттай хэрэгжүүлж чадвал эдийн засгийг тогтворжуулдаг, ЗГ илүү, хэрэггүй зардал гаргахаас сэргийлдэг давуу талтай боловч эдийн засгийн хямралыг зөөллөх боломжгүйгээс гадна хөгжил буурай орнуудад хэрэгжүүлэх боломж тааруу, нийгмийн халамж үзүүлэх боломжийг хязгаарлаж байдгаараа сул талтай юм.

Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцож ирсэн байдлыг Сангийн яамнаас авсан статистик мэдээлэлд²⁴⁹ үндэслэн хүснэгтээр харуулбал:

Нэгдсэн төсвийн тэнцлийн үзүүлэлт

Улсын дүн Хэмжих нэгж: сая төг	2017	2018	2019	2020	2021
Орлого	7,274,861.6	9,225,947.4	10,905,510.8	9,421,647.2	12,689,377.0
Зарлага	9,017,318.6	9,22,928.5	11,661,701.3	13,960,787.5	15,598,129.8
Тэнцэл	-1,742,456.9	3,019.0	-756,190.4	-4,539,140.3	-2,908,752.8

Хүснэгтэлсэн мэдээллээс харахад 2017 онд төсвийн тэнцэл 1,742,456.9 сая төгрөгний, 2019 онд 756,190.4 сая төгрөгний, 2021 онд 2,908,752.8 сая төгрөгний алдагдалтай гарсан байх бөгөөд алдагдал байнга давтагдаж байгаа нь эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх талтай.

2.Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т “**нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх**” нь төсвийн тусгай шаардлагын нэг байхаар заасан. Энэ нь De Paoli-²⁵⁰ийн тодорхойлсончлон өрийн хямралын үед илэрдэг нийтлэг шинжийн босго оноог ашигласан, эдийн засгийн аюулгүй байдлын үүднээс харвал нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэлд босго тогтоосон нь хөрөнгийн урсгалын хяналтын эерэг нөлөөлөл бий болгосон ач холбогдолтой байна.

Гэвч тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтад “Энэ хуулийн 6.1.2-т заасан төсвийн тусгай шаардлагыг:

- 2015.01.20-нд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 2018 оны төсвийн жилээс,
- 2016.09.09-нд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 2020 оны төсвийн жилээс,
- 2017.04.14-нд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 2023 оны төсвийн жилээс,
- 2021.07.07-нд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 2025 оны төсвийн жилээс

дагаж мөрдөхөөр” давтамжийн хувьд 4 удаа өөрчилж, хугацааны хувьд үйлчлэх хугацааг 15 жилээр хойшлуулж төсвийн тусгай шаардлагыг хангах боломжийг хязгаарласан байна.

Мөн энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлсэн нэмэлт, өөрчлөлтийг дараах байдлаар 3 удаа оруулсан.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг өөрчилж ирсэн байдал

²⁴⁹ https://www.1212.mn/mn/statistic/statcate/573058/table-view/DT_NSO_0800_001V1

²⁵⁰ De Paoli, B, Hoggarth, G and Saporta, V 2009, “Output costs of sovereign crises: some empirical estimates”, Working Paper no. 362, The Bank of England.


Огноо	Хуульчилсан хувь	сунгасан жил	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
2015 01.20.	2%	4	5%	4%	3%	2%							
2017 04.14.		7			10,4 %	9,5%	6,9%	5,1%	3,6%	2,8%	2,0%		
2021 07.07.		5			10,4 %	9,5%	6,9%	12,5 %	8,8%	5,1%	3,6%	2,8%	2,0%

Хуулийн энэ өөрчлөлт нь нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоож, төсвийн тусгай шаардлагууд нэгэн зэрэг хангагдсан байх хуулийн зорилго, шаардлагыг зөрчсөн зохицуулалтууд оруулж ирснийг харуулж байна.

Монгол Улсын сүүлийн 15 жилийн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хувь хэмжээг авч үзвэл 2005, 2006, 2007, 2010, 2013, 2019 онуудад хуульд заасан хувь хэмжээний дотор байсан бөгөөд бусад 9 жилд 3,9-15,5 хүртэл хувиар алдагдалтай гарч иржээ. Үүнийг зургаар харуулбал:

Төсвийн алдагдал (сүүлийн 15 жилээр)

Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь, 2005 –2021 он



Эндээс үзэхэд, харвал, нийт төсвийн тэлэх бодлогын нөлөөгөөр төсвийн алдагдал, Засгийн газрын өр үлэмж нэмэгдэж, гадаад валютын цэвэр нөөц сөрөг түвшинд хүрч, сонгуулийн өмнө Засгийн газрын том дүнтэй зардлууд гарсан нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, зэрэглэл тогтоогч байгууллагуудад цочрол болж иржээ. Тухайлбал, төсвийн зарлага ба эргэн төлөгдөх цэвэр зээлийн ДНБ-нд эзлэх хувь 2016 онд түүхэн дээд утга болох 39.7 хувьд хүрч, төсвийн орлого бага байснаас төсвийн алдагдал ДНБ-ий 15.3 хувьд хүрсэн байна.

3.Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т *“тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх”* төсвийн тусгай шаардлагыг хуульчилсан боловч хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтад *“Энэ хуулийн 6.1.3-т заасан төсвийн тусгай шаардлагыг 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 2017 оны төсвийн жилээс дагаж мөрдөхөөр”* зааж мөн л хэрэгжилтийг хойшлуулж иржээ.

4.Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасан *“Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 70 хувиас хэтрэхгүй байх”* шаардлагыг хангаж ирсэн байдал.

Хуульд заасан энэхүү тусгай шаардлага нь анх улсын өр нь ДНБ-ий 40 хувиас хэтрэхгүй байхаар тогтоосон. Гэвч манай улс тус хуульд оруулсан 3 удаагийн нэмэлт өөрчлөлтөөр хувь хэмжээг 88,0 хувь хүртэл нэмэгдүүлэн тогтоож, өнөөдөр 70 хувиас хэтрэхгүй байхаар хуульчилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Засгийн өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг хэтрүүлэхгүй байх босгыг өөрчилсөн байдал

2015.01.20-ны өөрчлөлт		2016.09.09-ны өөрчлөлт		2021.07.07-ны өөрчлөлт	
2015	58,3%	2015	58,3%	2015	58,3%
2016	55,0%	2016	88,0%	2016	88,0%
2017	50,0%	2017	85,0%	2017	85,0%
2018	40,0%	2018	80,0%	2018	80,0%
		2019	75,0%	2019	75,0%
		2020	70,0%	2020	70,0%
		2021	60,0%	2021	70,0%
				2022	70,0%
				2023	66,0%
				2024	60,0%

Ингэснээр үйлчлэх хугацааг 4 удаа 15 жилээр, өрийн бүтцийг өөрчлөн хасах замаар, хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар өрийг нэмэгдүүлж, маш өндөр эрсдлийг бодитойгоор бий болгосон.

Мөн тус хуульд 2015.02.18-нд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр *“6.2.Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаар нь уул уурхайн салбарын хуулийн этгээдэд Засгийн газар хувь нийлүүлсэн хөрөнгө оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгаанд хамаарахгүй.”*, 6.3.Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарт *Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг оруулж тооцохгүй.”* гэж өөрчилсөн.

Мөн 2015.05.21-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Засгийн газрын өрийн хязгаар нь *“эрчим хүч, төмөр зам”*-ын салбарын хуулийн этгээдэд Засгийн газар

хувь нийлүүлсэн хөрөнгө оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгаанд хамаарахгүй гэсэн нэсэлтүүд оруулах замаар Засгийн газрын өрийн агуулгаас хасалт хийсэн байна.

Мөн 2015.02.18-нд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт "8.2.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-д заасан тусгай шаардлагыг энэ хуулийн 8.1-д зааснаас гадна Засгийн газрын гадаад өрийн багц дахь дийлэнх хувь хэмжээг эзэлж байгаа үндэсний мөнгөн тэмдэгттэй харьцах гадаад валютын Монголбанкнаас зарласан тухайн оны эцсийн албан ханш нь өмнөх оны мөн үеийн албан ханшаас 15 хувь ба түүнээс дээш хувиар өссөн тохиолдолд түр хугацаагаар түдгэлзүүлж болно." гэж Төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг түр хугацаагаар түдгэлзүүлэх үндэслэл нэмж хуульчилсан байна.

Дээрх зохицуулалтуудыг нэгтгэн дүгнэвэл, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар төсвийн тусгай шаардлагуудыг тогтоож хэрэгжүүлэх харилцааг зохицуулж байна.

Энэ хуульд Монгол Улсын төсвийн хүрээнд а) орлогын, б) тэнцлийн, в) зардлын, г) өрийн дүрмүүд тодорхой хэмжээнд тусгасан гэж үзэж болохоор байгаа ч хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн үлдэгдлийг тогтоосон төсвийн тусгай шаардлагыг **нэгдүгээрт**, хувь хэмжээгээр, **хоёрдугаарт**, дагаж мөрдөх хугацаагаар нь, **гуравдугаарт**, улсын өрийн хувь хэмжээнд тоон хязгаар тогтоож байсан зохицуулалтыг Засгийн газрын өр хэмээн явцуу агуулгаар тодорхойлж, улмаар Засгийн газрын өрд хамаарах бүрэлдэхүүнээс зарим өрийг хасаж тооцох агуулгаар, **дөрөвдүгээрт**, удаа дараа өөрчилж, өрийн хэмжээг хянах боломжийг алдагдуулах, улсын төсвийн төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг түр хугацаагаар түдгэлзүүлэх үндэслэл нэмэх замаар төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх эрсдлийг хуулиар дэмжсэн нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж иржээ.

Энэ нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын төсөв санхүүгийн салбарын аюулгүй байдлын үндсийг тодорхойлсон эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбарыг төлөвшүүлэх, Засгийн газрын авах зээл нь бодит эдийн засгийн салбарт чиглэгдэх бөгөөд эдийн засгийн аюулгүй байдлыг хангасан, зохистой харьцаанд байлгах шаардлагыг зөрчсөн болохыг харуулж байна.

Мөн төсвийн процесс дахь оролцогчид буюу УИХ, Засгийн газрын зүгээс сонгуулийн амлалтаа биелүүлэх, үр ашиггүй зардлыг төсөвлөх замаар төсвийн зардлыг дур мэдэн нэмж, эрх зүйн шаардлагыг удаа дараа өөрчилж ирсэн нь төсвийн харилцаан дахь улс төрийн оролцоо өндөр байгааг харуулж байна.

Засгийн газрын өрийн өнөөдрийн статистикийг хүснэгтээр харуулбал:

Засгийн газрын өрийн статистик
(Санхүүгийн салбарын өр ороогүй дүнгээр)

	2021.У4	ДНБ-д эзлэх хувь	2022.У2	ДНБ-д эзлэх хувь
I.Засгийн газрын өр	26,918.1	62.6%	28,508.8	59.9%
Төв Засгийн газрын өр	25,350.6	58.9%	28,904.7	60.8%
Орон Нутгийн өр	17.2	0.0%	21.0	0.0%
Засгийн газрын баталгаа	876.5	2.0%	735.1	1.5%
Барих-Шилжүүлэх концессын үлдэгдэл	673.9	1.6%	489.9	1.0%

II.Төрийн өмч, төрийн өмч давамгайлсан санхүүгийн бус салбарын байгууллагуудын өр	5,734.5	13.3%	6,803.5	14.3%
Үүнээс:				
Гадаад			5,049.9	10.6%
Богино хугацаат өр			2,779.9	5.8%
Урт хугацаат өр			2,270.0	4.8%
Дотоод			1,753.5	3.7%
Богино хугацаат өр			601.5	1.3%
Урт хугацаат өр			1,152.0	2.4%
Улсын секторын өр (I+II)	32,652.6	75.9%	*35,312.3	74.3%

Эндээс харвал, улсын секторын өрийн хэмжээ 2021 оны 4 дүгээр улиралд 75.9% хувь байсан бол 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 74.3% хувь, Засгийн газрын өрийн хэмжээ 2021 оны 4 дүгээр улиралд 62.6% хувь байсан бол 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 59.9% хувь байна.²⁵¹

ОУВС-аас буурай хөгжилтэй улсуудын эдийн засгийн аюулгүй байдлын эрсдлийн үл хүлцэх (сэрэмжлэх) түвшингийн дээд хязгаарыг Засгийн газрын өрийн 40 хувиас хэтрэхгүй байхаар тогтоосон бөгөөд манай улсын Засгийн газрын өрийн хэмжээ дээрх түвшингээс даруй 19,9 хувиар хэтэрсэн нь дефолт зарлах хэмжээнээс хол давж, эдийн засгийн аюулгүй байдалд аюул занал бодитой учирсныг харуулж байна.

Нөгөө талаар өрийн дүн мэдээ, статистикийг өөр өөр үзүүлэлт, аргачлалаар гаргаж ирсэн нь өрийн статистикт дүн шинжилгээ хийхэд зарим талаараа хүндрэлтэй байсныг онцлохын зэрэгцээ энэ нь ил тод, ойлгомжтой байдлыг алдагдуулж байгааг харуулж байна.

Дүгнэлт

Манай улсад төсөв-санхүүгийн бодлого нь тогтсон дүрэмгүй хэрэгжиж байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн "Төсвийн тусгай шаардлага"-ын заалтыг хэрэгжүүлэхгүй, тухайн үеийн нөхцөл байдалд тохируулан төсвийг өөрчилж ирсэн нь дунд хугацааны төлөвлөлтийн үр дүнг бууруулж байна.

Монгол Улсын төсвийн харилцааны эрх зүйн орчин тогтворгүй байгаа бөгөөд үүнээс шалтгаалан төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, төсвийн тогтвортой байдал алдагдах нөхцөл бүрдэж байна.

Дээрх тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх явцад эрх зүй, зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх нь Монгол Улсын төсвийн цаашлаад эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур болсон суурь үзүүлэлтүүд үл хүлцэх эрсдэлийн түвшинд хүрэхээс сэргийлж "болзошгүй аюул, сорилтыг бодитой тодорхойлж, тэдгээрийг гэтлэн давахад хязгаарлагдмал нөөц, боломжийг үр дүнтэй дайчлана" гэсэн Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим бидитоор хэрэгжих боломжтойг гэж үзэж байна.Үүнд:

Нэгдүгээрт, Улсын төсөв, санхүүгийн бодлого улс төрийн институцээс хамааралтай, "нөлөөнд нь өртөж" байгааг хязгаарлахын тулд эх газрын Европын улс орнууд болон ЭЗХАХБ-ын гишүүн Азийн улс орнуудын адил төсвийн эрх зүйн орчинд

²⁵¹ Сангийн яамны статистик мэдээ, 2022

байвал зохих, төсвийн дүрмийн хязгаарлалтыг гагцхүү Үндсэн хуулийн түвшинд тодорхойлох боломж байна;

Тиймээс төсөв, санхүүгийн шийдвэр гаргалтын дүрмийг тэр дундаа төсөв алдагдалгүй байх хязгаарыг Монгол Улсын эрх зүйн тогтолцооны үндэс болсон Үндсэн хуульд зааж өгөх нь зүйтэй.

Ингэхдээ олон улсын сайн туршлагын дагуу Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7-д “УИХ төсөв батлахдаа төсвийн тэнцлийн алдагдлыг ДНБ-ий 2,0 хувиас хэтрүүлэхгүй” 38 дугаар зүйлд “Засгийн газар өөрийн бүрэн эрхийн хугацаанд төсвийн тэнцвэртэй байдлыг хангана” гэж хуульчилж заах;

Төсөв, санхүүгийн шийдвэр гаргалтад тэнцвэртэй байдлыг хангах шаардлагын хүрээнд Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, өрийн дарамтыг бууруулах, эрх баригчийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор өрийн дээд хязгаарыг тогтоосон болон үе шаттай бууруулахаар заасан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шаардлагыг мөн олон улсын сайн туршлагын дагуу Үндсэн хуулийн 25 зүйлд “2020 он гэхэд төсвийн алдагдалгүй болохоор зааж, улмаар нийт ДНБ-ий 74,3%-тай тэнцээд буй өрийн хэмжээг бууруулж, 2024 оноос болон цаашид ДНБ-ий 60 хувиас илүү гаргахгүй байх” заалтыг нэмэлт оруулах байдлаар шийдэх;

*Хоёрдугаар*т, Төсвийг хариуцлагатай байх, бодитой төлөвлөдөг байх, төсвийн төлөвлөлтийг ил тод болгох улмаар төсвийг төлөвлөхөд нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийг арилгах арга хэмжээг олон улсын туршлагад үндэслэн Монгол Улсын Үндсэн хуульд дараах зохицуулалтыг тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

- Парламентын гишүүдээс санал болгож буй төсвийн өөрчлөлт нь төсвийн орлого буурах, эс бөгөөс зарлагын бодит өсөлт, нэр төрөл нэмэгдэхэд хүргэх үр дагавартай тохиолдолд тэрхүү саналыг хүлээн авахыг хориглох,
- Нэмэлт зээллэг авалгүйгээр төсвийн орлого зарлагын тэнцвэрт байдлыг хангах үүргийг УИХ-д үүрэг болгох.

Ингэснээр Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасан суурь зарчмууд хангагдана гэж харж байна.

Хэрэв ийм зохицуулалт хийж чадваас эдийн засгийн аюулгүй байдлын “эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтлана” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх суурь нөхцөл бүрдүүлэх болно. Улмаар “Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбар төлөвших нөхцөл бүрдэнэ” гэж үзэж байна.

Ашигласан материал

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992
- Төсвийн тухай хууль, 1992, 2011
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010
- Өрийн удирдлагын тухай хууль, 2015
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол
- Төсвийн тухай хуулийн үзэл баримтлал, 2010

Ном, сурах бичиг, гарын авлага:

- Энхчимэг.Д, Мөнх-Оргил.Т, Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга зам онол, арга зүй, туршлага, шинжилгээ, боломж, УБ.,2021
- Ган-Очир.Д, Эдийн засгийн аюулгүй байдлын шинжилгээнд анхаарах

асуудал: Онол, арга зүйн тойм, Стратеги судалгаа сэтгүүл, №83/2022

- Лүндэндорж.Н, Сайнхишиг.Ж, Үндсэн хуулийн эдийн засгийн үзэл баримтлалын үүднээс Монгол Улсын Үндсэн хуулийг шинжлэх нь, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2015-04 /№54/
- Buchanan, J.M, The Domain of Constitutional Economics Constitutional Political Economy, 1990
- *De Paoli. B, Hoggarth.G and Saporta V, "Output costs of sovereign crises: some empirical estimates" Working Paper no. 362, The Bank of England, 2009*

МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

MONGOLIA AND ALL FRIENDLY CHINESE PEOPLE ANALYSIS OF RESULTS IN HIGHER EDUCATION SYSTEMS

Ц.Түвшинбаяр

ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, цагдаагийн дэслэгч

Tuwshinbayar Ts.

Teacher of the Department of Social Sciences, School of Law and Social Sciences, University of Internal Affairs, police lieutenant

Хураангуй: Монгол улсын хөгжлийн гарц нь чанартай боловсролд тулгуурласан мэдлэгтэй боловсон хүн бэлтгэн, тэдгээр мэдлэг чадвартай иргэд нь улсын хөгжлийн чиг баримжааг тодорхойлох, хөгжлийг шинэ шатанд гаргах чухал хүчин зүйл болохоос гадна боловсрол нь иргэн бүрийн насан туршийн амьдралын чанарыг дэмжин баталгаажуулахад оршино. Ардчилсан төр оршин тогтнох чухал тулгуур бол боловсролтой иргэд мөн бөгөөд иргэн бүрийн чинээлэг амьдралын баталгаа нь чанартай боловсрол эзэмших явдал юм.

Монгол улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дээд боловсролын тогтолцоо, дээд боловсролын орчны харьцуулсан судалгаа-S.W.O.T шинжилгээ хийж, харьцуулан судлахыг зорилго.

Abstract: The way forward for Mongolia's development is to prepare knowledgeable people based on quality education, and those knowledgeable citizens will be an important factor in determining the direction of the country's development and bringing development to a new level, and education will support and ensure the quality of life of every citizen throughout their lives. An important pillar for the existence of a democratic state is an educated citizenry, and the guarantee of a prosperous life for every citizen is the acquisition of quality education.

This paper briefly comparing of Mongolia and China's higher education system, higher education environment and made S.W.O.T. analysis. In order to achieve the research goal, we have proposed following objectives.

Түлхүүр үгс: Боловсролын тогтолцоо, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дээд боловсролын орчны судалгаа, дээд боловсрол, Монгол Улсын дээд боловсролын орчны харьцуулсан судалгаа.

Keywords: Education system, study of the higher education environment in the people's Republic of China, comparative study of higher education and higher education environment in Mongolia.

Монгол улсын дээд боловсролын тогтолцоо, онцлог

Их, дээд сургуулиуд нь аливаа улс орны ирээдүйн удирдагчдыг бэлтгэн, эдийн засгийн өсөлтийн суурь болсон техникийн болоод удирдлагын өндөр чадварыг бий болгодог. Эдгээр байгууллагуудыг гүйцэтгэдэг чухал гурван үүрэг нь сургах, нийгэмд үйлчлэх, судалгаа шинжилгээ хөгжлийн ажил байдаг. Технологийн асар хурдтай өөрчлөлт, даяаршлын эрин үед дээд боловсролын байгууллагын гүйцэтгэж буй үүрэг нэн чухал бөгөөд тэд бүс нутгийн хөгжлийг дэмжин, үндэсний хөгжлийн механизмын чухал хэсэг болдог.

Хүснэгт №1. Монгол улсын боловсролын тогтолцоо²⁵²

Докторын зэрэг (3 жил)
Магистрын зэрэг (2 жил)

²⁵² Азийн хөгжлийн банк. Монгол Улсын Боловсролын салбар дахь үйл ажиллагааны танилцуулга. 2016.

Бакалаврын зэрэг (4-5 жил)	Дунд шатны мэргэжлийн сургалт (1.5-3 жил)
Ахлах сургууль (3 жил)	Анхан шатны мэргэжлийн сургалт (2.5 жил)
Дунд сургууль (4 жил)	
Бага сургууль (5 жил)	
Цэцэрлэг	

БНМАУ-д 1990 оны байдлаар насанд хүрсэн хүмүүсийн 96 хувь нь бичиг үсэгтэй, бага сургуулийн элсэлт нь 98 хувь, үүнээс дунд сургууль 85 хувь, мэргэжлийн болон дээд сургууль 15 хувьтай, насанд хүрсэн хүн амын 7.5 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байсан нь тухайн үеийн “орлого” багатай улс орнуудын боловсролтой харьцуулахад туйлын өндөр байжээ.²⁵³

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дээд боловсролын тогтолцоо, онцлог

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (Цаашид – БНХАУ гэх)-д 1896 онд анхны их дээд сургуулийг байгуулснаар БНХАУ-д дээд боловсрол олгож эхэлжээ.²⁵⁴ 1949 онд БНХАУ-ын дээд боловсрол барууны их сургуулийн загвараар хөгжиж ирсэн байна. БНХАУ-ын боловсролын тогтолцоо нь элит сонгон шалгаруулалтын бүтэц дээр суурилдаг байсан бөгөөд дээд боловсролтой коллежийн насны хүн амын эзлэх хувь 1.4 байсан бол 2019 онд ойролцоогоор 20% болтлоо өссөн байна.

Хүснэгт №2. БНХАУ-ын боловсролын тогтолцоо

1	Дээд боловсрол	Докторын зэрэг (3 жил)
2		Магистрын зэрэг (3 жил)
3		Бакалаврын зэрэг (4 жил)
4	Бүрэн дунд боловсрол	Ахлах сургууль (3 жил)
5		Дунд сургууль (3 жил)
6		Бага сургууль (6 жил)
7	Цэцэрлэг	

Боловсролын тогтолцооны хөгжил нь одоогийн өөрчлөгдөж буй эдийн засгийн хэрэгцээ шаардлагад тохирсон олон тооны мэргэжилтнүүд болон ур чадвартай ажилтан бэлтгэх бололцоог олгож буй. Боловсорсон ажиллах хүчний нийлүүлэлт нь Хятадын өсөлтийг хүчтэй дэмжиж байгаа нь маргашгүй үнэн. Хятадын боловсрол нь төр болон хувийн хэвшилд зөвхөн том бизнесийн боломж биш юм.

Монгол, БНХАУ-ын дээд боловсролын байгууллагын орчны харьцуулсан (S.W.O.T анализ) судалгаа

²⁵³ Монгол Улсын Их сургууль “Дээд боловсролын эрэлт нийлүүлэлтийн шинжилгээ”. Судалгааны тайлан. 2013.

²⁵⁴ <http://educhina.mn>.

Хүснэгт №3. Монгол Улсын дээд боловсролын орчны судалгаа



Давуу тал: Боловсролын судалгааны дагнасан Боловсролын хүрээлэн нь 60 жилийн турш тогтвортой үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд судалгаанд суурилсан дээд боловсролын хөтөлбөр боловсруулахад анхааран ажиллаж байна. Монгол улсын дээд боловсролын салбарын хөгжлийн бодлого нь “Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030”, “ Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, “ Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого”-той уялдаж, мэдлэгт суурилсан нийгмийг байгуулах, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, хүмүүсийн амьдралыг дээшлүүлэх, нийгмийн тэгш байдлыг баталгаажуулахад тусалж чадах дээд боловсролын үр дүнтэй тогтолцоог бий болгохыг зорьж байна.

Сул тал: Дээд боловсролын байгууллагууд ихээхэн өргөжсөн ч дийлэнх нь Улаанбаатарт үйл ажиллагаа явуулдаг тул бүс нутгийн хөгжилд төдийлөн их хувь нэмэр оруулж чадаагүй байна. Засгийн газрын өмнө тулгамдаж байгаа нэг чухал асуудал бол боловсролын чанарын магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх, ингэхдээ хөдөлмөрийн зах зээлтэй уялдах уялдаа холбоог сайжруулах, магадлан итгэмжлэлийн шалгууруудыг тогтооход олон улсын жишиг үзүүлэлтүүдийг харгалзан авч үзэх, зайны болон гадаадын сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, мөн урамшуулал болон хариуцлагын тогтолцоог эргэн харах, оюутнуудыг сургуулиуд болон хичээлийн хөтөлбөрүүдийн чанарын талаарх бодитой мэдээллээр хангах шаардлагатай.

Боломж: Боловсрол Үндэсний хөтөлбөр (2010-2021)-ийн 4 дэх бүлгийн Стратегийн зорилт 2-ийн хүрээнд “ Бүх түвшний боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг суралцагчийн хэрэгцээ, нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох” гэж заагаад уг зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний 7-д “ Боловсролын хөгжлийн бодлого, шинэчлэлийн онол, арга зүйн судалгааны чадавхийг нэмэгдүүлж боловсролын шинэчлэлийн санаачилгыг дэмжинэ” гээд ингэхдээ судалгаа хийх чадавхыг нэмэгдүүлэх, боловсролын Үндэсний ба орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг байгууллага, нийгмийн институтын үүрэг, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно гэсэн нь Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхийн тулд авч явуулах арга хэмжээ зааж боломжийг нэмэгдүүлж байна.²⁵⁵

²⁵⁵ Боловсрол үндэсний хөтөлбөр. 2010-2021.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)-ний 1.1-д боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ гэж заасан нь тус салбарын судалгаа, арга зүйн байгууллагад тэргүүлэх боломжийг олгож байна.

Аюул: Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт хэрэгцээнд нийцсэн ур чадварыг нийлүүлж чадахгүй байна. Бага зардалтай, чанар муутай энэ тогтолцоо нь оршин тогтнохын тулд олон тооны оюутан элсүүлэн авдаг нь зах зээлийн эрэлт хэрэгцээнээс хэтэрсэн, чанар муутай, ажлын байртай болох магадлал бүрхэг төгсөгчдийг гаргаж байна.

Хүснэгт №4. БНХАУ-ын дээд боловсролын орчны судалгаа

Давуу тал	Сул тал
- Хангалттай хүний нөөц - Харьцангуй дэвшилтэт технологи - Нэр хүндтэй улсын их сургуулиудтай - Дэд бүтцийн хөгжил тогтвортой, сайн	- Зарим салбарт өндөр чадвартай боловсон хүчний дутагдал - Олон улсын түвшний дэвшилтэт технологийн дутагдал - мэдээлэл технологийн дэд бүтцийн харьцангуй сул
БНХАУ-ын Дээд боловсролын байгууллага	
Боломж	Аюул
- Дотоодын өргөн уудам зах зээл - Боловсролын салбарын шинэчлэл	- Менежментийн хуучинсаг хэв загвар - Бусад салбарын өрсөлдөөн

Давуу тал: БНХАУ-ын их, дээд сургуулиуд нь технологи, нэр хүнд, хүний нөөц болон харилцаа холбооны нөөцөөр элбэг. Хятад улсын их, дээд сургуулиуд өөрийн харьяа фирмүүдийг байгуулах хандлагатай бөгөөд энэ нь 1985 онд сургалт, судалгааны салбарыг дэмжих зорилгоор Засгийн газраас шинжлэх ухаан, технологийн салбарт зарцуулах төсвийг огцом нэмэгдүүлсэнтэй холбоотой юм. Мөн түүнчлэн, олон жилийн түүхтэй анхны гэгд²⁵⁶х их, дээд сургуулиуд судалгааны томоохон бааз, өндөр ур чадвар бүхий салбар сургууль, суралцагчидтай байх нь өрсөлдөөний хамгийн гол хүчин зүйл хэмээн үздэг байна. Мөн хятадын философи 6-р зуунаас үүсэлтэй гэгддэг Күнзийн сургаалд тулгуурлан хөгжиж иржээ бөгөөд олон улсын боловсролын шинэчлэлийг өөрийн улсын онцлогт тохируулан боловсролын салбарын дэд бүтцээ бий болгосноор асар богино хугацаанд өнөөдөр дэлхийд өрсөлдөхүйц боловсон хүчин бэлтгэн гаргах чадвартай, дэлхийд чансаагаараа дээгүүрт ордог их дээд сургуулиудтай болсон байна.

Сул тал: Хятад улс даяар 2000 гаруй их, дээд сургууль үйл ажиллагаа явуулдагас зөвхөн 2% орчим нь л дэлхийн шилдэг их сургуулийн тоонд багтаж буй нь өрсөлдөх чадвар сул, чанар муу төрийн өмчийн болоод хувийн сургуулиуд олон байгааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл нийслэл болон томоохон хотууд хийгээд орон нутаг дахь их, дээд сургуулиудын чанарын ялгаа асар их зөрүүтэй байна. Ийм учир зарим салбарт өндөр мэргэшсэн боловсон хүчний дутагдал байх хандлагатай.

Боломж: БНХАУ-ын хувьд хамгийн их хүн амтай улсын хувьд боловсролын байгууллагад дотооддоо томоохон зах зээлийн дээр 1999 оноос тус улсын Засгийн газар их сургуулийн боловсролын байгууллагууд олноор идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломж нээгдэж, өрсөлдөөний хэмжээ нэмэгдэн боловсролын чанар сайжрах боломжтой. Мөн төрөөс хэрэгжүүлж буй аливаа тэтгэлгийн хөтөлбөрүүд нь гадны улсын оюутан тухайн улсыг сонгон суралцахад түлхэц болж байна.

²⁵⁶ Стратегийн судалгааны хүрээлэн. Стратегийн судалгаа сэтгүүл. УБ. 2022.

Аюул: Боловсролын байгууллагын менежмент болон их, дээд сургуулийн гол үйл ажиллагаа болох сургалт болон судалгаа гэсэн менежментийн хоёр систем байна. Энэхүү хоёр системээр Бээжингийн их сургууль болон Цинхуа их сургууль үйл ажиллагаагаа явуулдаг. Цинхуа их сургууль болон тус сургуулийн адил менежментийн системтэй сургуулиуд шууд бус менежментийн тогтолцоог хэрэгжүүлж байгаа нь хариуцлагын тогтолцоог илүү сайжруулснаас гадна бусад салбартай өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх давуу талтай боловч Хятадын ихэнх их сургуулиуд Бээжингийн их сургуулийн адилаар дотооддоо удирдах системийг баримталж байна.

Дүгнэлт

Манай орны хувьд бусад улс орны боловсролын хөгжлийн туршлагыг судалж турших, өөрийн нөхцөлд тохируулан нутагшуулах замаар дээд боловсролын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх н хөгжлийн нэн тулгамдсан шаардлага болж байна. Энэхүү тулгамдсан асуудлуудыг шийдэхэд их сургуулиуд хоорондоо хамтран ажиллах, харилцан туршлагаа хуваалцах нээлттэй орчин, нөхцөл бүрдүүлэх нь чухал юм. Олон улсын туршлагаас харвал өөрийн орны хөгжлийн онцлогт тохирсон боловсролын болон инновацын тогтолцоог төлөвшүүлэн, ур чадвартай хүний нөөцийг бэлтгэж, өндөр технологийн судалгааг хөгжүүлэн, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлснээр нийгэм эдийн засгийн хөгжилд нь богино хугацаанд ахиц дэвшил гарч байна.

Санал

Дээрх харьцуулсан судалгаанд үндэслэн, дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Хувийн их, дээд боловсролын чанар, өрсөлдөх чадварыг сайжруулах тал дээр бодлогоор дэмжих. Энэ нь улсын их сургуулиудад төвлөрөөд буй хэт их ачааллыг багасгах;
- Орон нутгийн салбар сургуулиудын тоог нэмэгдүүлснээр нийслэлийн хэт төвлөрөлтийг бууруулах.

Ашигласан материал

1. Азийн хөгжлийн банк. Монгол Улсын Боловсролын салбар дахь үйл ажиллагааны танилцуулга. 2016.
2. Монгол Улсын Их сургууль “Дээд боловсролын эрэлт нийлүүлэлтийн шинжилгээ”. Судалгааны тайлан. 2013.
3. Боловсрол үндэсний хөтөлбөр. 2010-2021.
4. Стратегийн судалгааны хүрээлэн. Стратегийн судалгаа сэтгүүл. УБ. 2022. Интернет эх сурвалж
5. <http://educchina.mn>.